



ОЮУНЛАГ БҮТЭЭЛЧ СЭТГЭЛГЭЭНИЙ ТӨЛӨӨ

ЦАЦ

СУРГАЛТ, СУДАЛГАА,
АРГА ЗҮЙН УЛИРАЛ
ТУТМЫН СЭТГҮҮЛ

2019 №13/36/

- » **Батлан хамгаалахын менежментийн асуудалд**
- » **Сэтгэл зүйн хангалтын сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээ**
- » **ХХ зууны монгол цэргийн гарамгай жанжин-ардын Хатанбаатар С.Магсаржав**



ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛИАС ЭРХЛЭН ГАРГАВ





ОЮУНЛАГ БҮТЭЭЛЧ СЭТГЭЛГЭЭНИЙ ТӨЛӨӨ

СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч:

Хурандаа Л.Батцэнгэл ҮБХИС-ийн Эрдэм шинжилгээ, нийгмийн түншлэлийн асуудал хариуцсан дэд захирал, доктор (Sc.D), профессор

Хариуцлагатай нарийн бичгийн дарга:

Дэд хурандаа Л.Баяр БХЭШХ-ийн ЭШ-ний ажилтан, доктор (Ph.D)

Редакцийн гишүүд:

Хурандаа Д.Мөнх-Очир "Аюулгүй байдал судлал" хүрээлэнгийн ахлах судлаач

Бригадын генерал Ж.Бадамбазар ЗХЖШ-ын орлогч дарга
Хурандаа Б.Мөнхсайхан БХЭШХ-ийн захирал, доктор (Ph.D), профессор

Хурандаа Б.Өлзийхуяг ҮБХИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацын хэлтсийн дарга, доктор (Sc.D), профессор

Ш.Паламдорж БХЭШХ-ийн ЭШ-ний тэргүүлэх ажилтан, доктор (Sc.D), профессор

Д.Мягмар Гео бодлого судлалын хүрээлэнгийн захирал, доктор (Sc.D), профессор

Хурандаа Н.Анаргул ШШГЕГ-ын эмнэлгийн дарга, доктор (Sc.D), профессор

Техник редакцийн гишүүд:

Д.Насанжаргал Дизайнер

Редакцийн хаяг:

Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, БНМАУ-ын баатар

Д.Нянтайсурэнгийн гудамж, 16 дугаар хороо, Улаанхуаран

Утас: 976 11 480177

Факс: 976 11 480172

Шуудангийн хайрцаг: 13300

Веб хаяг: www.mndu.gov.mn

Цахим шуудан: news@mndu.gov.mn

Олон улсын индекс: ISSN 2313-8076

Эрхлэх байгууллага: Монгол Улсын Үндэсний Батлан хамгаалахын их сургууль

Хэвлэх үйлдвэр: ҮБХИС-ийн Хэвлэх үйлдвэр



FOR INTELLECTUAL AND CREATIVE THINKING

EDITORIAL BOARD

Editor-In-Chief

Col Battsgengel.L Deputy Director for Research and social partnership Prof. (Sc.D)

Deputy Editor-In Chief

LTC Bayar.L Scientist for IDS (Ph.D)

Editorial Panel

Col Munkh-Ochir.D	Senior researcher of Security Study Institute
Major general Badambazar.J	Deputy Chief of General Staff, Mongolian Armed Forces
Col Munkhsaikhan.B	Director of Institute for Defense Studies of MNDU, Prof. (Ph.D)
Col Ulziikhuyag.B	Chief of Research and Innovation Department Prof. (Sc.D)
Palamdorj.Sh	Research officer of the Institute for Defense Studies of MNDU, Prof. (Sc.D)
Myagmar.D	Director of Mongolian Institute for Geopolitical Studies Prof. (Sc.D)
Col Anargul.N	Medical director of General Executive Agency of Court Decision, Prof. (Sc.D)

Technical Editor

Nasanjargal.D Designer, Illustrator

Address:

Mongolian National Defense University
Nyantaisuren Street, Bayanzurkh District, Ulaanbaatar, Mongolia, 13300

Phone: 976 11 480177

Fax: 976 11 480172

Mail box: 13300

Website: www.mndu.gov.mn

E-mail: news@mndu.gov.mn

ISSN: 2313-8076

Host: Mongolian National Defense University

Published by: Defense Press



ҮНДЭСНИЙ БАТЛАН
ХАМГААЛАХЫН
ИХ СУРГУУЛИАС
ЭРХЛЭН ГАРГАВ.

2019
№13/36/

СУРГАЛТ,
СУДАЛГАА, АРГА
ЗҮЙН УЛИРАЛ
ТҮТМЫН
СЭТГҮҮЛ

ДУГААРЫН ТОВЧООН

Батлан хамгаалах бодлого, зорилт:

Ш.Паламдорж, П.Цэдэв: Батлан хамгаалах салбарт тулгарч болзошгүй эрсдэлт хүчин зүйлсийг тодруулах асуудалд ...	6
Д.Баасандамба: Батлан хамгаалах салбарын эрсдэлийн удирдлагын зарим асуудал	14
Б.Содбилиг: Батлан хамгаалах төлөвлөлтийн талаарх олон улсын туршлага	21

Аюулгүй байдал:

Б.Нэргүй: Европын орнуудын аюулгүй байдлыг хангах тогтолцоо ба иргэний нийгэм	28
---	----

Судалгаа, сургалт шинжилгээ:

М.Золзаяа: Тайван цагт кибер батлан хамгаалах тогтолцоог бүрдүүлэх арга зам	35
Н.Мөнх-Эрдэнэ: Цэргийн зориулалттай радиостанцын сургалтын програмыг загварчилах нь	49
Юу Жяжүнь, Ву Шижинь: Хуучирсан үг хэллэгийн утга, найруулга	57

Цэргийн хэрэг:

Б.Энхбат: Тэнцвэргүй дайны онол, хүчин зүйлс ба чиг хандлага	69
--	----

Зэвсэг, техник:

Ц.Батбаяр: Агаарын целийн мэдээллийн боловсруулалтанд орчин үеийн программыг ашиглах нь	77
Ч.Бямбацэрэн: Хээрийн нөхцөлд суудлын автомашины автомат хурдны хайрцагны шингэн солих зөөврийн багаж	80

Түүх-сургамж:

Лха.Баяр: Холбооны цэргийг бэхжүүлэхэд С.Гангаанямын гүйцэтгэсэн үүрэг	83
Х.Орхончимэг: Монгол Улсын маршал Г.Дэмидийн цэргийн боловсрол сургалтыг хөгжүүлэхэд гүйцэтгэсэн үүрэг	89
Э.Цэгмэд: Морьтон дайчдын туг	99



БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРТ ТУЛГАРЧ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛСИЙГ ТОДРУУЛАХ АСУУДАЛД

Ш.ПАЛАМДОРЖ /БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, ШУ-ны доктор, профессор/

П.ЦЭДЭВ /Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор, профессор/

Түлхүүр үг: Эрсдэл, эрсдлийн удирдлага, менежмент, батлан хамгаалах бодлого, гадаад, дотоод хүчин зүйл

Key words: Risk, risk management, defense policy, internal, external factor

Улс орныг батлан хамгаалах асуудал үндэсний аюулгүй байдлыг хангахтай салшгүй холбоотой нэгдмэл зүйл юм. Аливаа байгууллага, хүний амьдралд таагүй үйл явдлаар дүүрэн байх бөгөөд энэ нь эрсдэл хэмээх ойлголтыг гаргаж ирснээр хүн төрөлхтөн аливаа боломжийг тооцоолон бодож, таагүй үйл явдлыг урьдчилан харж чаддаг болсон юм.

Эрсдэл бол аюул, занал, тэдгээрийн үр дагавар-хохирлоор илэрхийлэгдэх, харилцан хамаарлыг харуулсан шинжлэх ухааны нэр томьёо юм. Эрсдэлийг сүйрэл, үхэлтэй адилтгах, эсвэл аюулын зэрэглэлтэй адилтган ойлгох явдал практикт ажиглагддаг. Хэдийгээр эрсдэл нь эдгээрийг өөртөө шингээсэн нэр томьёо мөн боловч, ялгаатай учир эрсдэлийн тухай, түүний агуулга, утгын талаар эхлээд зөв ойлголттой болсон байх нь нэн чухал юм.

Аливаа юмс, үзэгдлийн талаар ойлголт, нэр томьёо, үзэл баримтлал мүү, мэдлэггүй байх нь түүний мөн чанарын талаар төсөөлөлгүй байдлыг үүсгэдэг ба асуудлыг хэлэлцэхэд "амаа мэдэхгүй мал" шиг хандлага гаргахад хүргэдэг. Эрсдэлийн тухай нэр томьёо, үзэл баримтлал гэсэн хийсвэр үг хэллэг, ойлголтыг бид ашиглаж байна. Эрсдэлийг тайлбарлахад мөн л хийсвэр үг хэллэг ашиглана. Тодруулж хэлбэл, эрсдэлийн тухай ойлголтыг тайлбарлаж, тодорхойлох нь хэцүү хүнд асуудал юм. Эрсдэл бол хэд хэдэн нөхцөл, хүчин зүйлсийн хамаарлыг илэрхийлсэн функцияг учраас ойлгоход улам ч хүнд бэрхшээлтэй юм.

Эрсдэл хэмээх ойлголтыг олон янзаар

тодорхойлсон байдаг бөгөөд энд хамгийн өргөн хэрэглэгддэг тодорхойлолтыг авч үзвэл: Тодорхойгүй байдаас үүсэх хүсээгүй үр дүн буюу хийсвэр ойлголтыг эрсдэл гэнэ. Өөрөөр хэлбэл, эрсдэл бол үзэгдэж, харагддаггүй бөгөөд хүний оюун ухааны тооцоолон бодох хийсвэр ойлголт юм. Эрсдэл гэдэг нь:

- Тодорхойгүй мэдээллээр шийдвэр гаргах нөхцөл байдал;
- Үүсч болзошгүй алдагдалтай холбоотой тодорхойгүй байдал;
- Эрсдэл = эрсдэл тохиох магадлал, эрсдэл учирснаас гарах үр дагаварын хамаарал.

Эрсдэл нь амьдралд байнга тохиолдож байдаг. Шинжлэх ухаан техникийн ололт амжилт нь хөгжлийг бий болгодог төдийгүй эрсдэлийг байнга төрүүлдэг. Жишээ нь: цөмийн урвал нь үй олноор хөнөөх зэвсгийг бий болгож, дэлбэрэлт, гал түймэрийн хохирлыг үүсгэж байдаг бол төрөл бүрийн химийн бодис, хорт нэгдлүүд нь мөн л хүнийг хордуулах химийн зэвсгийг бий болгодог.

Эрсдэлийн тухай авч үзвэл, энэ нь бидний эргэн тойронд байж, байнга өөрчлөгдөн бидний амьдралын нэг хэсэг болон оршдог. Тиймээс хүн түүнээс зайлсхийхийг эрмэлздэг ба түүний аль болох бага түвшинд байлгахыг хүсэх нь зүй ёсны асуудал юм. Эрсдэл гарцаагүй гарахад нөлөөлдөг хүчин зүйлсэд эдийн засгийн байдал, улс төрийн тогтвортой байдал, иргэдийн сэтгэлзүйн хүчин зүйл, нийгмийн байдал, хууль эрхзүйн орчин зэрэг хүчин зүйлс багтдаг.

Эрсдэлийн удирдлага гэж юуг



хэлж байна вэ? Гэдэг асуулт зүй ёсоор тавигддаг. Хэдийгээр эрсдэл гэдэг ойлголт аль эрт байсан боловч "Эрсдэлийн удирдлага" гэдэг ойлголт нь 1929 оноос жинхэнэ утгаараа үүссэн гэж үздэг. Учир нь 1929 оны их хямралын тэр үеэс банк болон санхүүгийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, төр санхүүгийн болон эдийн засгийн хямрлаас сургамж аван ирээдүйн тодорхойгүй байдлаас үүсэх алдагдлыг даван туулах нөөц бололцоотой байхыг эрмэлзэг болсон. Энэ л үеэс тодорхойгүй байдлыг хохирол багатай даван туулах эрмэлзэл доор эрсдэл, эрсдэлийн удирдлагын тухай ойлголт үүсч бий болон хөгжсөөр иржээ.

Аливаа байгууллага эрсдэлийн менежментийн стратеги төлөвлөгөөтэй ажиллавал үр дүнд хүрнэ. Аль ч байгууллагын хувьд эрсдэлийн менежмент нь нарийн, дэс дараатай арга хэмжээнээс бүрдэх бөгөөд тэр нь эрсдэл болон түүний үр дагаварыг сайтар олж харах, зөв холбоос, шийдвэр гаргахад тус дөхөмтэй болно.

Эрсдэлийн менежмент: Тухайн байгууллагын ажлын үр нөлөө, үр ашгийг тоон үзүүлэлтээр харуулж чадах учир гаалийн байгууллагын хувьд түүнийг байгууллагын дотоод философи болгон батлах нь чухал юм. Эрсдэлийн менежментийг гар, эсхүл автомат ажиллагаатай ямар ч байгууллага тактикийн болон стратегийн зорилтын үүднээс хэрэгжүүлж болно. Мөн шийдвэр гаргах олон төрлийн тохиолдолд түүнийг ашиглаж болно.

Эрсдэлийн удирдлага гэсэн нэр томьёоны утга учрыг бас ойлгох хэрэгтэй болж байна. Удирдлага гэж юуг хэлээд байнаа? Төрийн удирдлагыг: бодлого тодорхойлох, хууль тогтоох, бодлогыг хууль эрх зүйн дагуу хэрэгжүүлэхэд хяналт тавих, гэж ойлгох уу? Аль эсвэл гүйцэтгэх засаглалыг ойлгох уу? Эсвэл засаглалын гурван салаа бүрийг нэгтгэж, эсвэл салгаж ойлгох уу?

Бидний ойлгож буйгаар, эдгээрийн цогц нэгдлийг төрийн удирдлага гэж үзэж байна. Улс төрийн удирдлага (төрийн удирдлага), захиргааны удирдлага хоёрыг ялан салгаж ойлгож байхаар "Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс"-т заасан юм.

Судлаач бид урьд өмнө "Монгол Улсын стратегийн эрсдэлийн судалгаа: үнэлгээ ба таамаглал"¹ гэсэн судалгааны ажлыг явуулсан юм. Үүгээр бид улс төр, эдийн засаг, нийгмийн салбар дахь стратегийн эрсдэлийг таамаглах судалгааг өөрийн оронд анх удаа хийсэн бөгөөд чухамхүү дээр дурдсан хүрээнд стратегийн эрсдэлийн үүсэл, өرنэлт нь эрчимтэй явагдаж байгаа учраас тэдгээрийг судлах зорилго тавьсан байна.

Батлан хамгаалах салбарын эрсдэлийн удирдлагын асуудал нь стратегийн эрсдэлтэй холбоотой бөгөөд урд өмнөх судалгааны ажлын үргэлжлэл ч байж болох талтай юм. Батлан хамгаалах салбарын удирдлагын тогтолцоонд эрсдэлийн асуудлыг тусгаснаар эрсдэлийн удирдлага явагдана. Батлан хамгаалах салбарын удирдлагад эрсдэлийн асуудлыг тусгахын өмнө энэ салбарт тохиолдож болзошгүй эрсдэлийг ойлгох учиртай.

Батлан хамгаалах салбарт тохиолдож болзошгүй эрсдэлт хүчин зүйлсийг тайван цагт гадаад, дотоодоос хамааралтай гэж хоёр хуваан үзэж болно. Гадаадаас хамаарах хүчин зүйлс нь: өнөө үеийн олон улсын байдал, даяаршлын үзэгдэл, цэрэг-стратегийн цагийн байдал, хойд, урд хөршүүдийн цэрэг-улстериийн бодлого, үйл ажиллагаа зэргээс хамааралтай. Харин дотоодоос хамаарах хүчин зүйлс нь: дотоод дахь улс төр, нийгэм, эдийн засаг, худалдаа үйлчилгээний суурь бүтэц, батлан хамгаалах чадавх, Зэвсэгт хүчний байгуулалт, байлдааны бэлэн байдал зэргээс хамааралтай байна. Энэ нь "батлан хамгаалах үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг бөгөөд

¹ Монгол Улсын стратегийн эрсдэлийн судалгаа: (үнэлгээ ба таамаглал). УБ., 2012 он. 150х;



Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хил хязгаарын халдашгүй дархан байдлыг хангах, хамгаалах зорилго бүхий улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, цэргийн арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх нэгдмэл удирдлага, зохион байгуулалт, зохицуулалтын цогц мөн"².

Батлан хамгаалах салбарт тохиолдож болзошгүй гадаадаас хамаарах эрсдэл нь улс орны үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалд хамаарах учир үндэсний язгуур ашиг, сонирхлыг хөндсөн асуудал мөн юм.

"Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй байдал болон бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдэл, үндсэн хуульт байгууллын аюулгүй байдал, эдийн засгийн бие даасан байдал, экологийн тэнцвэрт хөгжил багтана"³ гэсэн заалт нь дээрхийн баталгаа болж байна. Үүн дотроос "Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нэгдмэл байдлыг хамгаалан бататгах нь үндэсний аюулгүй байдлыг хангах анхдагч нөхцөл мөн"⁴ гэсэн нь аюулгүй байдлыг хангахдаа чухамхүү улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нэгдмэл байдлыг бататгахад тэргүүлэх ач холбогдол өгч байгаагийн илрэл юм. Чухамхүү үүнд л манай судалгаа чиглэх болж байна.

Гадаадаас хамаарах хүчин зүйлс нь өнөө үеийн олон улсын байдал, даяаршлын үзэгдэл, бус нутгийн цэрэг-улс төрийн байдал, хойд, урд хөршүүдийн цэрэг-улстөрийн бодлого, үйл ажиллагаа байхыг өмнө дурдсанаас гаргалгаа хийхэд, тэдгээрийн онцлог шинжийг илэрхийлж болох юм.

Дэлхийн улс орнуудын зэвсэгт хүчиний

байлдааны зэвсэглэл, цэргийн техникт гарч буй технологийн асар хурдацтай эдүгээгийн дэвшил, цэргийн удирдлагын бүх салбарт нэвтэрч буй холбоо, мэдээлийн өндөр хүчин чадалтай автоматжуулалт нь цэргийн хэрэгт хувьсгал, өөрчлөлтийг дагуулж байна. Үүний зэрэгцээ үй олноор хөнөөх болон өндөр чадавхтай зэвсэг, баллистик пуужингийн технологийг зээмших, дамжуулах, шинэ төрлийн зэвсэг бүтээх үйл явц даяаршлын энэ эрин үед идэвхижих хандлага ажиглагдах болов.

Сүүлийн жилүүдэд дэлхийн янз бурийн бус нутагт төрөл бурийн сэдэлтэй зэвсэгт мөргөлдөөн, байлдааны ажиллагааны давтамж, хамрах хүрээ өргөжин, олон улсын терроризмын гэмт үйлдлүүд газар авч, түүний зохион байгуулалт, арга хэлбэр нь улам нарийн болж, улмаар тухайн бус нутгийн тогтвортой байдлыг алдагдуулахад хүрч болзошгүй хэмжээнд хүргэх боллоо. Нөгөө төлөөр дэлхийн эдийн засагт учирч буй бэрхшээл, хямрал, экологийн эрсдэл болон элдэв халдварт өвчний тархалт зэрэг нь бус нутаг, улс орныг хамарсан хямралт байдалд хүргэх магадлалыг өсгөж байна. Энэ бүхэн улс орнуудын батлан хамгаалах бодлогод хүчтэй нөлөөлж, түүнийг шинэчлэх үндэс нь болж, улс орноо хамгаалах чадавхаа нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлагыг нөхцөлдүүлэх болов. Ийм шинэ нөхцөл байдал нь улс орнуудын батлан хамгаалах бодлогод дараах байдлаар⁵ нөлөөлж байна.

Нэгд, дайн, зэвсэгт мөргөлдөөний шинж чанар, агуулгын өөрчлөлт, цэргийн техникийн үсрэнгүй хөгжил нь цэргийн хэрэгт асар их хувьсалыг бий болгож, аливаа их, бага цэргийн ажиллагаанд хөнөөлийн чадавх өндөртэй зэвсэглэл, техникийг ашиглаж байгаа нь түүний нөлөөлөл, хөнөөлийн царааг ихэсгэх болсон нь түүнээс хамгаалах чадавхыг

² Монгол Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолын хавсралт. Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс;

³ Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. 1.1.2. заалт;

⁴ Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. 1.1.3.заалт;

⁵ "Батлан хамгаалах бодлого", Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлүүдийн эмхтгэл., УБ., 2014., т.21;



нэмэгдүүлэх чиглэлд батлан хамгаалах бодлогыг боловсронгуй болгох шаардлагыг бий болгож байна.

Хоёрт, бүх нийтийн дайны тухай ойлголт "хүйтэн дайн"-тай хамт алслан холдсон хэдий ч, өнөөгийн нөхцөл олон улсын терроризм, бус нутгийн болон орон нутгийн шинжтэй дайн, байлдааны аюул хүрээ, хязгаараа тэлэх болсон энэ үед улс орон бүрийн уг аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний эцсийн үр дүн нь өөрийн батлан хамгаалах чадавхаа нэмэгдүүлэх зорилтоо итгэлцлийг бэхжүүлэхдэд чиглэсэн улс төр-дипломатын идэвхтэй үйл ажиллагаатай хослуулан явуулснаар хэмжигдэх болов.

Гуравт, орчин үеийн нөхцөл байдлын өрнөл нь аль ч улс орны "эх нутгийн" аюулгүй байдлыг хангах арга хэмжээнд бус нутгийн тогтвортой байдлыг хангах нийтлэг үйл явц хүчтэй нөлөөлөх болсныг харуулж байна⁶. Энэ нь улс орнуудын батлан хамгаалах бодлогын шинэчлэлт нь бус нутгийн аюулгүй байдлыг хангах үйл явцтай салшгүй харилцан хамааралтай болохыг нотолж, энэ үйл явцын чиг хандлагатай уялдуулан авч үзэх шаардлагын чухал болохыг харуулж байна.

Дөрөвт, үндэстэн дамнасан гэмт хэргүүд, шашин, ашиг сонирхол, байр суурийн төлөөх тэмцэл зэрэг улс орны дотоодын зөрчлүүдэд гадаадын ижил сонирхлын бүлэглэлүүдийн оролцоо илт нэмэгдэж байгаа нь учирч болох аюул,

эрсдлийг үлэмж өсгөх болж, үүний эсрэг чиглэсэн хүчтэй бодлогыг тодорхойлон хэрэгжүүлэхдэд цэргийн хүчний оролцооны үүргийг нэмэгдүүлэх хандлагыг ихэсгэв.

Тавд, аливаа халуун цэгүүдэд болж буй хямралыг зохицуулах, байдлыг тогтвортжуулах, сэргөлдөгч талуудыг эвлэрэлд хүргэхэд олон улсын байгууллагуудын хүчин чармайлт, түүний дотор НҮБ-ын гүйцэтгэх үүрэг илт өсч, энэ үйл явцад "цэнхэр дуулгатан"-уудын оруулах хувь нэмэр нэмэгдэв. Түүнчлэн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн урьдчилан сэргийлэх дипломатын аргын үр нөлөө илт дээшилж, түүнд "цэргийнхэн"-ий гүйцэтгэх үүрэг үлэмж нэмэгдэх болов.

Зургаад, дэлхийн цаг уурын болон экологийн өөрчлөлтөөс үүдэлтэй байгалийн гамшиг гарах давтамж ихсэж, түүнээс учрах хохирол жилээс жилд нэмэгдэж, үндэсний болоод бус нутгийн хямрал гарах үндсийг бий болгох магадлалыг ихэсгэх болсон нь цэргийн хүчийг түүний хор хохирлыг арилгах, гамшигт нэрвэгдэгсдэд туслах арга хэмжээнд татан оролцуулах хүрээг ихэсгэх болов. Эдгээр нь улс орнуудын батлан хамгаалах бодлогод хүчтэй нөлөөлөх болж, өөрчлөн шинэчлэх төлөв, хандлагыг тодорхойлох боллоо.

Манай улсын гадаад бодлого дахь хоёр талын найрсаг харилцааны шатлалыг эрдэмтэн Б.Лхагвагийн судлан тогтоосон байдлаар дараах хүснэгтээр үзүүлэв.

Гадаад бодлого дахь хоёр талын найрсаг харилцааны шатлал

Стратегийн түншлэлийн харилцаа	Стратегийн түншлэлийн харилцаа	Улсын нэр	Онууд
		ОХУ Япон Энэтхэг	2009 2010 2015
	Стратегийн иж бүрэн түншлэлийн харилцаа	БНХАУ	2014
Иж бүрэн түншлэлийн харилцаа	Иж бүрэн түншлэлийн харилцаа	БНСУ ХБНГУ Турк	2018
Өргөтгөсөн түншлэлийн харилцаа	Өргөтгөсөн иж бүрэн түншлэлийн харилцаа	АНУ	2018
	Өргөтгөсөн түншлэлийн харилцаа	Канад Австрали Казакстан	2004 2007 2007

⁶ Дашзэвэг Д, Батлан хамгаалах стратеги, 2018, 309 тал



Хүснэгтээс харахад манай орны гадаад харилцаа нь стратегийн, иж бүрэн, өргөтгөсөн түншлэлийн гэсэн гурван харилцааны 10 гаруй улс орнуудын хооронд идэвхтэй явагдаж байна.

Манай улс нь ОХУ, БНХАУ гэсэн хоёр их хөршийн дунд оршиж байдаг онцлогтой орон билээ. Хоёр их хөрш минь жилээс жилд хүчирхэгжиж улам хөгжих байна. Улс орнууд хүчирхэг байх тусмаа түрэмгийг байдаг гэсэн сургамж байдаг.

ОХУ-ын Улс төр, цэрэг дайны судалгааны хүрээлэнгийн орлогч захирал Александр Храмчихин манай орны тухай бичихдээ⁷ "...хэрэв боломж гарвал Бээжин Монголоос тусгаар тогтнолыг нь булаан авна. Асар том газар нутагтай (1,56 сая кв. км, дэлхийд 18-т орно), маш бага хүн амтай (дэлхийд 140-т орно) энэ орон Хятадын түрэмгийлээс өөрийгөө хамгаалах ямар ч боломж байхгүй. Энэ түрэмгийллийг зөвхөн Орос улс л зайлцуулж байгаа билээ" гэжээ. Судлаач цааш нь "ЗХУ задарсны дараа Монгол Улс Барууны орнуудтай харилцаагаа идэвхтэй хөгжүүлж, Зэвсэгт хүчин нь НҮБ-ын энхийг сахиулах олон ажиллагаанд оролцон, Монгол цэрэг, офицерууд маш сайн үнэлгээ аваад байгаа. Гэхдээ ингэлээ гээд тэд Хятадын армид эсэргүүцэл үзүүлж чадна гэсэн үг биш, Барууны орнууд ч Монголын тусгаар тогтнолын баталгаа болж чадахгүй. Яагаад гэвэл, нэгдүгээрт газар зүйн байдал байна. Монгол далайд гарцгүй, зөвхөн Орос, Хятадтай хиллэдэг. Тиймээс гадаадын ямар нэг орны цэрэг Монголын нутагт орохын тулд доод тал нь Оросоос зөвшөөрөл авах хэрэгтэй. Алс Дорнод дахь Оросын агаараас хамгаалах систем олон "цоорхой"-той ч манай нутаг дээгүүр нууцаар нисэхээс америкчууд ч айна. Хоёрдугаарт европ, япончууд битгий хэл америкчууд ямар ч байдал үүссэн гэсэн Монголын төлөө Хятадтай байлдахгүй" гэж бичсэн байдаг. Улмаар "Сүүлийн үед Улаанбаатар үүнийг ойлгож эхэлж байх шиг байна. Москва

ч гэсэн саяханаас Монгол гэдэг орон дэлхийд байдгийг санаж эхэллээ. Орос Монголд бага ч гэсэн анхаарал хандуулж, Монголын армийн хэт хуучирсан зэвсэглэлийг шинэчлэхээр шийдсэн" гээд манай Зэвсэгт хүчний бүтэц, техникийн тоог бичжээ.

Өнөө үеийн олон улсын байдлаас үүдэлтэй батлан хамгаалах салбарт тохиолдож болзошгүй эрсдэл нь дэлхий дахинь болон бус нутгийн, манай хойд, урд хөршүүдийн цэргийн аюулгүй байдалд нөлөөлж, түүнээс сэргийлэх, хамгаалах бодлого, үйл ажиллагааг удирдах, хэрэгжүүлэх арга хэрэгслийг сайжруулахыг нөхцөлдүүлж байна.

Дэлхийн улс орнуудын зэвсэгт хүчний байлдааны зэвсэглэл, цэргийн техникт гарч буй технологийн асар хурдацтай эдүгээгийн дэвшил, цэргийн удирдлагын бүх салбарт нэвтэрч буй холбоо, мэдээллийн өндөр хүчин чадалтай автоматжуулалт нь цэргийн хэрэгт хувьсгал, өөрчлөлтийг дагуулж байна. Үүний зэрэгцээ үй олноор хөнөөх болон өндөр чадавхтай зэвсэг, баллистик пуужингийн технологийг эзэмших, дамжуулах үйл явц даяаршлын энэ эрин үед идэвхжих хандлага ажиглагдах болов.

Сүүлийн жилүүдэд дэлхийн янз бүрийн бус нутагт төрөл бүрийн сэдэлтэй зэвсэгт мөргөлдөөн, байлдааны ажиллагааны давтамж, хамрах хүрээ өргөжин, олон улсын терроризмын гэмт үйлдлүүд газар авч, түүний зохион байгуулалт, арга хэлбэр нь улам нарийн болж, улмаар тухайн бус нутгийн тогтвортой байдлыг алдагдуулахад хүрч болзошгүй хэмжээнд хүргэх боллоо. Нөгөө талаар дэлхийн эдийн засагт учирч буй бэрхшээл, хямрал, экологийн эрсдэл болон элдэв халдварт өвчний тархалт зэрэг нь бус нутаг, улс орныг хамарсан хямралт байдалд хүргэх магадлалыг өсгөж байна. Энэ бүхэн улс орнуудын батлан хамгаалах бодлогод хүчтэй нөлөөлж, түүнийг шинэчлэх үндэс нь болж, улс орноо хамгаалах чадавхаа

⁷ Оросын www.rusplt.ru цахим хуудаст "Почему россии выгодно защищать монголию"



нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлагыг нөхцөлдүүлэх болов.

Улс орны аюулгүй байдлын гол зангилаа асуудал нь батлан хамгаалах бодлого, түүнийг хэрэгжүүлэх тогтолцоогоор дамжин шийдвэрлэгдэж байdag зүй тогтолтой. Батлан хамгаалах бодлого бол аливаа улсын төрийн бодлогын нэг онцгой төрөл бөгөөд үндэсний аюулгүй байдлаа хангах хүрээнд улс орноо аливаа халдлагаас хамгаалах, түүний бэлтгэлийг хангах үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон төрийн бодлого⁸ юм.

Монгол Улсын хувьд батлан хамгаалах бодлого нь **нэгд**, "Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс" гэсэн төрийн бодлогын баримт бичгээр, **хоёрт**, батлан хамгаалах бодлогыг тодорхойлж буй хуулидаар илэрхийлгэгдэж байна.

Монгол Улс дэлхийн хамтын нийгэмлэгийн бүрэн эрхт гишүүний хувьд "**НҮБ-ын ажиллагаанд дэмжлэг, сайн санааны тусламж үзүүлэх, зуучлах, эвлэрүүлэх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх**"-ээ "Төрийн цэргийн бодлогын үндэс"-ээрээ илэрхийлэхийн хамт бие даасан гадаад бодлогоо туштай баримтлан "**Монгол Улсын тусгаар тогтол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд цэргийн аюул, заналхийлэл учруулсан буюу учрах нь бодитой болсноос бусад тохиолдолд цэргийн аливаа эвсэл, холбоонд элсэхгүй**" гэдгээ гадаад ертөнцөд мэдэгдэв. Үндсэн хуулийнхаа заалтын дагуу "**Монгол Улсын хуульгүйгээр гадаадын цэргийн хүчинийг өөрийн нутаг дэвсгэрт нэвтрүүлэхгүй, байрлуулахгүй, дамжин өнгөрүүлэхгүй**" байх бодлогыг чанд

баримтлах"-аа энэ баримт бичгээрээ дахин баталгаажуулсан байна. Монгол Улсын эх орноо батлан хамгаалах улс төрийн бодлого дараах тулгуурт үндэслэж байгаа юм. **Нэгдүгээрт**, хоёр хөршийн дунд оршдог, эдийн засаг, цэргийн хүч чадлын хувьд эн тэнцвэргүй улсын хувьд аюулгүй байдлаа улс төр-дипломатын аргаар хангах зарчим баримтлах нь манай улсын хувьд хамгийн оновчтой арга зам болж байна. **Хоёрдугаарт**, ОХУ, БНХАУ гэсэн хоёр хөрштэйгээ тэнцвэртэй харьцаж, өргөн хүрээтэй хамтын ажиллагаа хөгжүүлэх нь манай улсын гадаад бодлогын эн тэргүүний зорилт мөн болно. **Гуравдугаарт**, улс орныхоо аюулгүй байдал, хөгжилд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлийг сааруулах, даван туулах "гуравдагч хөрш"-ийн бодлого манай улсын геостратегийн байршилаас урган гарч байна. Товчоор улс орноо батлан хамгаалах манай улсын улс төрийн бодлогын тулгуур үндэс нь **нэгд**, улс төр-дипломатын арга, **хоёрт**, хоёр хөршөө чухалчлах бодлого, **гуравт**, гуравдагч хөршийн бодлого мөн болно.


Батлан хамгаалах салбарын үйл ажиллагаанд нөлөөлж болох хүчин зүйлсийг дотоод, гадаад гэж хоёр ангилан 1 дүгээр зургаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Зургаас үндэслэн батлан хамгаалах салбарын үйл ажиллагаанд нөлөөлж болох эрсдэлт хүчин зүйлсийн талаар асуумж гаргаж, хэрэглэгчийн судалгаагааг БХЯ, ЗХЖШ болон түүний харья хот, хөдөөгийн 10 шахам анги, салбар, байгууллагын 250 гаруй цэргийн болон энгийн алба хаагчдын дунд явуулж, дүнг SPSS программаар боловсруулан гаргасан дүнг дараагийн сэтгүүлд тавигдах болно.

⁸ Батлан хамгаалах стратеги, цэргийн удирдлагын үндсэн асуудал. Эрдэм шинжилгээний ажлын тайлан. БХЭШХ. УБ., 2008., -160х;



Зураг 1.

Батлан хамгаалах салбарын ўйл ажиллагаанд нөлөөлж болох хүчин зүйлс

**Ашигласан материал:**

1. Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992 он;
2. Монгол Улсын "Батлан хамгаалах тухай" хууль. "Төрийн мэдээлэл" сэтгүүл. УБ., 2016 он;
3. Монгол Улсын Дайны байдлын тухай хууль.
4. Монгол Улсын Дайчилгааны тухай хууль.
5. Монгол Улсын "Гадаадын цэргийн хүчнийг байрлуулах, дамжин өнгөрүүлэх тухай" хууль.
6. Монгол Улсын "Гамшгаас хамгаалах тухай" хууль.
7. Монгол Улсын "Зэвсэгт хүчний тухай" хууль. "Төрийн мэдээлэл" сэтгүүл. УБ., 2016. №36.
8. Монгол Улсын "Терроризмтой тэмцэх тухай" хууль.
9. Монгол Улсын "Цэргийн албаны тухай" хууль. "Төрийн мэдээлэл" эмхэтгэл. УБ., 2016. №36(945).
10. Монгол Улсын "Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай" хууль.
11. "Батлан хамгаалах хууль, тогтоомжийн эмхэтгэл". III дахь хэвлэл. УБ., 2004.
12. Монгол Улсын "Батлан хамгаалах бодлогын үндэс". "Төрийн мэдээлэл" сэтгүүл. УБ., 2015.
13. Монгол Улсын "Орон нутгийн хамгаалалтын талаар төрөөс баримтлах бодлого". УБ., 2006.
14. Монгол Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс" баримт бичиг. 2015.
15. Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэм. Олон улсын шүүхийн дүрэм. УБ., 1996.
16. "Төрийн цэргийн байгууллагын хөгжлийн стратеги-2030" (Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 127 дугаар тогтоол). УБ., 2017.
17. Дашзэвэг Д, Паламдорж Ш, Батлан хамгаалах стратеги, 2018, 309 тал
18. "Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоо судалгаа 2017" , УБ,
19. MNS IEC 31010:2017 Эрсдэлийн менежмент.Эрсдэлийн менежментийн арга
20. IEC 61511, Ажиллагааны аюулгүй байдал – Үйлдвэрлэлийн салбарын үйл явцын аюулгүй ажиллагааны тогтолцоо
21. IEC 61882, Аюул ба ажиллах боломжийн судалгаа (HAZOP судалгаа) – Хэрэглэх заавар
22. ISO/IEC Guide 51, Аюулгүй байдлын асуудлууд – Стандартад тэдгээрийг тусгах заавар
23. IEC 60300-3-11, Найдвартай байдлын менежмент– Хэсэг 3-11: хэрэглэх заавар – Найдвартай ажиллагаанд үндэслэсэн үйлчилгээ
24. IEC 61649, Вейбуул шинжилгээ
25. IEC 61078, Найдвартай байдлын шинжилгээний арга – Найдвартай ажиллагааны диаграмм ба Булен арга
26. IEC 61165, Марковын аргын хэрэглээ
27. ISO/IEC 15909 (бүх хэсэг), Программ хангамж ба системийн инженерчлэл – Өндөр түвшний Петри сүлжээ



БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЗАРИМ АСУУДАЛ

Д.БААСАНДАМБА /УБХИС-ийн Сургалт, цэргийн алба хариуцсан
тэргүүн дэд захирал, хурандаа/

Түлхүүр үг: Цэргийн анги, байгууллага, удирдлагын баримт бичиг

Key words: Military unit, organization, command, document

Байгууллагын удирдлагын арга барил, чиг хандлага, хэв шинж, арга хэрэгсэл эрчимтэй хувьсан өөрчлөгдж, олон улсын төдийгүй үндэсний түвшинд улс төр, эдийн засаг, төрийн захирагаа, цэрэг, батлан хамгаалах салбарын удирдлагын зохион байгуулалт, бүтэц, арга барилд үр дүн, гүйцэтгэлд суурилсан, эрсдэлийн удирдлагад тулгуурласан, ухаалаг "инноваци"-ийг нэвтрүүлэх чиг хандлага давамгайлах боллоо.

Монгол Улсын батлан хамгаалах тогтолцооны шинэчлэл, мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчинийг хөгжүүлэх зорилтын тэргүүлэх чиглэлд цэргийн захирагааны болон мэргэжлийн удирдлагын арга зүй, зохион байгуулалтыг хөгжүүлэх асуудал зүй ёсоор багтаж байна.

Дээр дурьдсан удирдлагын хөгжлийн чиг хандлагуудаас батлан салбарын онцлог, тулгамдсан зорилттой уялдуулан эрсдлийн удирдлагын асуудлыг судлан үзэх, түүнийг нэвтрүүлэх боломжийг эрэлхийлэх нь олон улсын нийтлэг жишигт дүйцсэн хэрэг болно гэж үзсэн.

Эрсдэлийн удирдлагын онол, арга зүй 2000 оноос улс орнуудын батлан хамгаалахын салбар, Зэвсэгт хүчинд нь хурдацтай нэвтэрч эхэлсэн. Учир нь глобалчлал, аюулгүй байдлын орчин, уламжлалт бус аюул занал, эдийн засаг, нийгэм, улс төрийн өөрчлөлт, хөгжжих байгаа орнуудын эдийн засгийн ээдрээтэй байдал, өрсөлдөөн зэргээс шалтгаалан нийгэм, үйлдвэрлэл, эдийн засгийн зэрэг орчинд бий болсон шууд ба шууд бус эрсдэлийн хамрах цар хүрээ байнга өөрчлөгдж, эдгээр нь тухайн

улс орны үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого, номлолын хэрэгжилтэд шууд ба дам нөлөөллийг үзүүлэх болсон.

Батлан хамгаалах салбар, зэвсэгт хүчин дэх эрсдлийн удирдлага нь хөгжлийн эхний шатандаа цэргийн байгууллага, цэргийн алба хаагчдын өдөр тутмын үүрэг гүйцэтгэлт, байлдааны ажиллагааны явцад үүсч болзошгүй дайчдын амь нас, эрүүл мэнд хохирох, зэвсэглэл, техник жагсаалаас гарах зэрэг байлдааны ба байлдааны бусэрсдлээс сэргийлж, цэргийн удирдлагын шийдвэр гаргах, цэргийн ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, эсрэг талаасаа илт давуу байдлыг олж авахад чиглэгдэж байсан бол өнөө үед илүү өргөн хүрээнд, харьцангуй дээд түвшинд буюу улс орны аюулгүй байдал, батлан хамгаалах үйл ажиллагааны эдийн засаг, нийгэм, улс төр, техник, технологийн хүчин зүйлсийг тооцсон стратегийн бодлого, төлөвлөлтийн салшгүй хэсэг болж хөгжсөн.

Иймд батлан хамгаалах зорилтыг хангахын тулд аюулгүй байдлын орчны өөрчлөлтөөс бий болж байгаа эрсдэлийг цаг алдалгүй тооцон удирдаж, тогтмол шинэчлэлт, тохируулгыг хийх шаардлагатай байгаа учраас орчин үеийн эрсдэлийн удирдлагын арга барилыг эзэмшиж, батлан хамгаалах үйл ажиллагаа, цэргийн хэрэгт нэвтрүүлэх зайлшгүй хэрэгтэй.

Эрсдэлийн удирдлага гэж байгууллага ба түүний нөөцийн удирдлагын тодорхой бус байдлуудыг тодорхойлж, шаардлагатай арга хэмжээ авах дүн



шинжилгээ ба удирдахуйн үйл явц юм гэсэн тодорхойлолтод үндэслэн Батлан хамгаалах эрсдлийн удирдлага гэж батлан хамгаалах үйл ажиллагаанд¹ учирч болзошгүй үйл явдал буюу нөхцөл байдлыг тодорхойлох, үнэлэх, удирдах ба хянах үйл явц гэж тодорхойлж болох юм.

Батлан хамгаалах салбарын эрсдэлийн үнэлгээг хийхийн гол ач холбогдол нь:

- батлан хамгаалах бодлогын зорилтод үзүүлэх болзошгүй нөлөөллийг шийдвэр гаргагч, төлөвлөлтийн нэгжид ойлгуулах;
- шийдвэр гаргагчдыг эрсдэлийн үнэлгээнд тулгуурласан мэдээллээр хангах;
- эрсдэлийг тогтоож, хариу арга хэмжээний хувилбараас оновчтой сонголт хийхэд дэмжлэг үзүүлэх;
- байгууллага ба тогтолцоонд байгаа сөрөг нөлөөлөл, нөхцөл болон эрсдэлийг үсгэж буй хүчин зүйлийг тодорхойлох;
- эрсдэл болон тодорхой бус байдлын талаар мэдээлэл солилцох;
- тулгамдсан асуудлыг ач холбогдоор нь эрэмбэлэхэд дэмжлэг үзүүлэх;
- эрсдэлийн дараах шинжилгээнд үндэслэн түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих;
- урьдчилан тодорхойлогдсон шалгуртай харьцуулан эрсдэлийг зөвшөөрч болох эсэх талаар дүгнэлт гаргахад мэдээллээр хангах зэрэгт оршино.

Өнөөдөр төр, хувийн хэвшлийн байгууллагуудын бүх шатны удирдлагын үйл ажиллагаанд оновчтой зохион байгуулалтыг бий болгох, зардлыг бууруулж, үр ашгийг нэмэгдүүлэх, эрсдлийг даван туулах чадавхийг бүрдүүлэх зэрэг чухал шаардлагууд тулгарч байна. Нийгмийн бүхий л салбарын үйл

ажиллагааны ололт, амжилтыг эрсдлийн удирдлагагүйгээр төсөөлөх аргагүй тийм цаг үед бид амьдарч байгаа бөгөөд эрсдлийн удирдлагын гол үүрэг нь нийгэм, эдийн засаг, улс төр, хүрээлэн буй орчны шууд ба шууд бус нөлөөгөөр үүсч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэрхшээл, хүндрэл үүссэн үед нөхцөл байдлыг залан жолоодох чадавхийг бүрдүүлэхэд чиглэгддэг.

Аливаа байгууллага нийгмийн, хүрээлэн буй орчны, технологийн, аюулгүй байдал, хамгаалалтын, санхүү эдийн засгийн талаар тавьсан зорилтдоо хүрэх үйл явцыг тодорхой бус болгодог дотоод, гадаад хүчин зүйл, нөлөөлөлтэй тулгарч байдаг. Байгууллагын үйл ажиллагааны энэхүү тодорхой бус байдлын үр дагаврыг "эрсдэл" гэж үздэг ба байгууллагын бүхий л үйл ажиллагаа эрсдлийг дагуулдаг ажээ.

Орчин үед байгууллагууд өөрийн онцлог, чадамжид нийцүүлэн зохион хэмжээнд эрсдлээ удирдаж байгаа боловч эрсдлийн удирдлагыг илүү үр нөлөөтэй хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага тулгарсаар байна. Тухайлбал, бизнес эрхлэгчийн хувьд бизнесийн ашиг, орлогод тулхүү анхаарч хөрөнгө оруулах шийдвэрээ гаргаж, өдөр тутмын үйл ажиллагаагаа удирдан ажилладаг хэдий ч тэр бүр ирээдүйд нөлөөлөх хүчин зүйл, саад бэршээлийг тооцож чаддаггүйгээс болж нэг мэдэхэд томоохон тулгамдсан асуудалд ордог. Нөгөөтэйгүүр ирээдүйд учирч болох эрсдэлийг урьдчилан харж шийдвэрлэх, эрсдэлийг удирдах төлөвлөгөө, хяналт, гүйцэтгэлийн иж бүрэн тогтолцоо байдаггүйгээс орлого буурах, алдагдалд орох, бизнесийн үйл ажиллагаагаа зогсоох хүртэлх асуудал тулгарсаар байна.

Эрсдэл гэдэг нь ирээдүйд тохиолдох тодорхой бус байдал бөгөөд тодорхой хугацаа өнгөрөхөд бий болох үр

¹ Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс. Батлан хамгаалах үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг бөгөөд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хил хязгаарын халдашгүй дархан байдлыг хангах, хамгаалах зорилго бүхий улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, цэргийн арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх нэгдмэл удирдлага, зохион байгуулалт, зохицуулалтын цогц мөн.



дагаварыг хэлдэг ажээ. Хувь хүн, байгууллага, бизнесийн салбар, нийгэм, улс оронд ирээдүйд юу тохиолдохыг шууд тодорхойлж чадахгүй, гэхдээ таамаглаж болно. Таамаглал нь хэр бодитой болохыг тохиолдож болох магадалын түвшингээр л илэрхийлж чадна. Ирээдүйд болох үйл явдал нь хувь хүн, байгууллагын удирдлага, нэгжийн түвшинд шийдвэр гаргах албан тушаалтан ямар шийдвэр гаргаж, хэрхэн удирдаж ажилласанаар тодорхойлогддог байна.

Олон улсын болон Монгол Улсын эрсдэлийн удирдлагын стандартууд батлагдан мөрдөгдөөд багагүй хугацаа өнгөрч байна. Жишээлбэл, Монгол Улсын "Эрсдлийн удирдлага. Зарчим ба заавар" MNS ISO 31000:2011 стандарт нь эрсдлийн удирдлагын зарчим, ерөнхий арга зүйн зааврыг тусгасан бөгөөд байгууллагад засаглал, стратеги ба төлөвлөлт, удирдлага, үйл явц, бодлого, үнэ цэнэ, соёлын талаарх эрсдлийн удирдлагын үйл явцыг уялдуулах зорилго бүхий эрсдлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх болон байнга сайжруулахад зөвлөмж болох зорилготойгоор боловсруулагдсан бөгөөд энэ нь аливаа төрлийн эрсдлийг дэс дараалалтай, ил тод, итгэлтэй удирдах арга зүйг хангах зориулалтай.

Монгол Улсын Зэвсэгт хүчний хувьд эрсдлийн удирдлагын өөрийн гэсэн онцлог хэв шинжтэй үйл ажиллагааг цэргийн албаны хүрээнд зохион байгуулж ирсэн бөгөөд энэ нь цэргийн дүрэм, цэргийн албаны удирдлагын баримт бичгүүд болон байлдааны дүрэм, заавруудад тусгалаа олсон байдаг. Тухайлбал, цэргийн албыг анги, салбаруудын байлдааны бэлэн байдал, дүрмээр тогтоосон дэг журам, сахилгыг чанд сахиулах, зэвсэг техник, эд аж ахуйг найдвартай хамгаалах, цэргийн алба хаагчдын өдөр тутмын амьдрал, үйл ажиллагааны хэвийн нөхцлийг хангахад чиглүүлж, цэргийн мэргэжлийн дээд удирдлагын заавар, анги, нэгтгэлийн штабын төлөвлөлт, захирагчийн шийдвэрээр батлагдан хэрэгжиж байдаг

эрсдлийн удирдлагын хэв маягийг агуулсан тогтолцоо гэж үзэж болно.

2003 оноос цэргийн албаны аюулгүй байдал гэсэн ойлголт Зэвсэгт хүчний практикт нэвтэрч эхэлсэн бөгөөд үүнийг судлаачид Зэвсэгт хүчний үйл ажиллагааны явцад үүсч болзошгүй аюул занал, сөрөг нөлөөллөөс ЦАХ, ард иргэд, байгаль орчны хамгаалагдсан байдал гэж тодорхойлсон болно.

2002 оноос Зэвсэгт хүчинд хэрэгжүүлсэн "Зэвсэгт хүчний цэргийн анги, байгууллагуудын аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө" боловсруулах ЗХЖШ-ын даргын оперативын удирдамж нь өнөөдрийг хүртэл цэргийн нэгтгэл, анги, байгууллагуудын тайван цагийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийн үнэлгээнд тулгуурласан төлөвлөлт болж ирсэн.

Уг төлөвлөлтийн баримт бичгийн хүрээнд цэргийн нэгтгэл, анги, байгууллагууд дараах эрсдэлийн төрөл, зүйлүүдийг судалж, аюулгүй байдлыг хангах буюу эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг төлөвлөж байна. Үүнд:

- тухайн цэргийн нэгтгэл, анги, байгууллагууд байрлаж буй орон нутгийн физик газар зүй, цаг уурын онцлог, үзүүлэх нөлөөлөл, болзошгүй гамшиг, гамшигийн үр дагавар;
- орон нутгийн нийгэм, эдийн засаг, хүн ам, тэдгээрээс цэргийн анги, байгууллага, түүний объект, цэргийн алба хаагчдад үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл (цэргийн зориулалттай зэвсэг, техник, материал хэрэгсэл алдагдах, цэргийн анги, байгууллагын эсрэг халдлага, дайралт, хорлон сүйтгэх болон алан хядах ажиллагаа явагдах Г.М);
- орон нутгийн дэд бүтэц, үйлдвэрлэл, тэдгээрээс цэргийн анги, байгууллага, түүний объект, цэргийн алба хаагчдад үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл



(үйлдвэрлэлийн осол, техникийн осол, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх үйлдвэрлэл, техникт ашиглагдаж буй химийн хорт бодисын тархалт г.м);

Түүнчлэн цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагаас НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд цэргийн баг, салбар, цэргийн алба хаагчдыг оролцуулахдаа ЗХЖШ-ын холбогдох газар, хэлтэсүүд тухайн ажиллагааны газар орон, орон нутаг дахь цэрэг, улс төр, эдийн засаг, хүн ам, байgal цаг уур, цэргийн мөргөлдөөний шинж чанарт үнэлгээ хийж, учирч болзошгүй байлдааны ба байлдааны бус хохиролоос урьдчилан сэргийлэх, шаардлагатай үед өөрийн цэргийн баг, салбар, цэргийн алба хаагчдыг хамгаалахтай уялдсан хариу арга хэмжээний хувилбааруудыг боловсруулж ирсэн. Үүний хүрээнд НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй болон гүйцэтгэхээр ажиллагааны өмнөх сургалт бэлтгэл гарсан цэргийн баг, салбуруудад урьдчилсан заавар, зөвлөмж, ажиллагааны удирдамжуудыг тогтмол хүргүүлж хэвшсэн нь ажиллагааны газар орон дээр учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах гол нөхцөлийн нэг болж чадсан.

Цэргийн баг, салбуруудад хүргэж буй эрсдэлийн үнэлгээнд сууринсан заавар, зөвлөмж, ажиллагааны удирдамжуудыг авч үзүүлэв:

- тухайн ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн цэргийн баг салбар, цэргийн алба хаагчдын "Ажиллагааны дараах туршлага, сургамж"-ийн тайланд үндэслэсэн заавар, зөвлөмж, ажиллагааны удирдамж;
- тухайн ажиллагааны явагдах газар орон дээр цэрэг илгээхийн өмнөх ажлын хэсэг, судалгааны багийн тайлан, үнэлгээнд тайланд үндэслэсэн заавар, зөвлөмж, ажиллагааны удирдамж;
- тухайн ажиллагааны газар орон, орон нутаг дахь цэрэг, улс төр,

эдийн засаг, хүн ам, байgal цаг уур, цэргийн мөргөлдөөний шинж чанарт хийсэн үнэлгээнд үндэслэсэн урьдчилсан заавар, зөвлөмж, ажиллагааны удирдамжууд;

- тухайн ажиллагааны газар орон, орон нутаг дахь хүн амын өвчлөл, тархац, байgal цаг уурын өөрчлөлт, цагийн байдлын өөрчлөлтийн дараах бэлэн байдлын болон аюулгүй байдлын зэргүүдийг өндөржүүлэхтэй холбогдсон заавар, зөвлөмж, ажиллагааны удирдамж гэж ангилан авч үзэж болох юм.

Тухайн ажиллагааны газар орон, орон нутаг дахь хүн амын өвчлөл, цар тархац, байgal цаг уурын өөрчлөлт, цагийн байдлын өөрчлөлтийн (эрсдэлийн) үнэлгээнд үндэслэн БХЯ, ЗХЖШ-аас дараагийн цэргийн баг, салбар илгээхдээ сургалт, бэлтгэл, нөхөн хангалт, материал, техникийн хангалтыг зохион байгуулахтай холбогдсон асуудлуудад тодотгол хийж, эрсдэл давтагдахгүй байх, түүнээс урьдчилан сэргийлэх, бууруулах гол арга хэмжээнүүдийг хэрэгжүүлдэг.

Дээрх арга хэмжээнүүд нь тодорхой хэмжээгээр эрсдлийн удирдлагын олон улсын практик, өөрсдийн туршлага, сургамжид тулгуурласан цаашид батлан хамгаалах салбарын хэмжээнд эрсдлийн удирдлагыг нэвтрүүлэхэд загвар болохуйц туршлага гэж үзэж байна.

Гэвч цэргийн албаны үйл ажиллагаанд эрсдлийн үнэлгээ, нөхцөл байдлын шинжилгээ, эрсдлийг удирдах төлөвлөлт зэрэг чухал асуудлуудыг орхигдуулж байгаа нь тайван болон байлдааны цагийн анги, нэгтгэлүүдийн үйл ажиллагааны явц дахь байлдааны ба байлдааны бус хохирол, эрсдлийн талаар урьдчилан сайтар судлах, эрсдэл гарахаас урдчилан сэргийлэх, төлөвлөх, сөрөг үр дагаврыг арилгах арга хэмжээг урдчилан авах, цэргийн хөдөлмөрийн хэвийн нөхцлийг хангах урьдчилсан нөхцлийг бүрэн бүрдүүлж чадахгүй гэж үзээд Зэвсэгт хүчний цэргийн албаны удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалт, хяналтын процесст эрсдлийн



удирдлагын дараах үндсэн үйл ажиллагааг нэвтрүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

1. Эрсдэлийг тооцох
2. Эрсдэлийг шинжлэх (учир шалтгааныг тогтоох)
3. Эрсдэлийг төлөвлөх (зайлсхийх буюу учрах хор нөлөөг бууруулах төлөвлөгөөг боловсруулах)
4. Эрсдэлийг хянах
5. Эрсдлийг удирдах

Эрсдлийн үйл ажиллагааны энэхүү загварчлалыг байлдааны ажиллагаа, энхийг дэмжих ажиллагаа, өдөр тутмын цэргийн алба, сургалт бэлтгэл, аж ахуйн ажил хийгээд анги, нэгтгэлийн үйл ажиллагааны урт, дунд болон ойрын хугацааны төлөвлөлтөд нэвтрүүлснээр гарч болох эрсдэл, хохирол, үйл ажиллагааны догондлыг арилгах, төсөв, санхүүг үр ашигтай зарцуулах, хөрөнгө оруулалтыг тогтвортой нэмэгдүүлэхэд ихэхэн чухал үр нөлөөтэй.

Тэгэхээр эрсдлийн удирдлага нь дан ганц цэргийн сахилга, дэг журмыг хангах, ердийн ба байлдааны (цэргийн ажиллагааны) хохирлоос урьдчилан сэргийлэхээс гадна нийгэм, хүрээлэн буй орчин, технологи, хүний нөөц, аюулгүй байдал, хамгаалалт, цэргийн хангарт, үйлчилгээ, эдийн засгийн арга хэмжээний бодлого, зорилтод нөлөөлнө.

Ингэснээр эрсдлийн удирдлага нь цаашид гарч болох ээрэг, сөрөг нөхцөл байдал, тэдгээрийн магадлал болон байгууллагын үйл ажиллагааны зорилтын хэрэгжилтэд нөлөөлөх үр нөлөөг авч үзэж, цэргийн бүх шатны удирдлагаас оновчтой шийдвэр гаргахад тусална.

Эрсдлийн удирдлагын үйл явцад дараах уялдаа холбоотой, дэс дараалалтай аргыг хэрэглэнэ. Үүнд:

- үйл явцын турш харилцах ба зөвлөлдөх;
- аливаа үйл ажиллагаа, үйл явц, ажил үйлчилгээ, бүтээгдэхүүнд хамаарах эрсдлийг тодорхойлох, шинжлэх, дүгнэх, арга хэмжээ авах нөхцөл байдлыг тодорхойлох;
- эрсдэлд хяналт ба үзлэг хийх;

➤ үр дүнг зохих байдлаар тайлагнах ба бүртгэх.

Эрсдлийн үнэлгээ бол эрсдлийн удирдлагын нэг хэсэг бөгөөд эрсдлүүд нь зорилтод хэрхэн нөлөөлж буйг тодорхойлох, цаашид эрсдлийн эсрэг хариу арга хэмжээ авах шаардлагатай эсэхийг шийдвэрлэхийн өмнө эрсдлийн үр дагавар ба магадлалыг шинжлэх зохион байгуулалттай бүтэц юм (хүснэгт-1).

Эрсдлийн үнэлгээ нь дараах үндсэн асуултад хариу өгнө. Үүнд:

- юу, яагаад тохиолдож болох вэ?
- ямар үр дагавар гарах вэ?
- цаашид эрсдэл гарч болзошгүй ямар нөхцөл байна вэ?
- эрсдлийн үр дагаварыг арилгах буюу эрсдлийн магадлалыг багасгах хүчин зүйлүүд байна уу?
- эрсдлийн түвшинг хүлээн зөвшөөрч болох эсэх болон цаашид эрсдлийн арга хэмжээ авах шаардлагатай юу?

Магадлал, аюулын зэрэглэлд

үндэслэсэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрсдлийн матриц

		Аюулын зэрэглэл				Аль насанд аюултай д
Магадлал	Ховор 1	Бага гамтал/ Нэвтрүүлэгүй	Дунд эзэргийн/ Аюулгүй	Хохирлын уригтгүй в	Хохиротой г	
		Хэт бага	Хэт бага	Хэт бага	Багавтар	Дунд эзэрг
	Бараг угүй 2	Маш бага	Багавтар	Багавтар	Дунд эзэрг	Их
	Магадгүй 3	Багавтар	Багавтар	Дунд эзэрг	Их	Маш их
	Бараг 4	Дунд эзэрг	Дунд эзэрг	Их	Маш их	Хэт их
	Баталгаатай 5	Дунд эзэрг	Их	Маш их	Хэт их	Хэт их

Зэвсэгт хүчиний хэмжээнд гарч буй осол, зөрчил, үйл ажиллагааны догондол, захиргаа, санхүүгийн тулгамдсан асуудал нь зарим талаараа эрсдлийн удирдлага дутагдж байгааг харуулж байна.

АНУ-ын зэвсэгт хүчин дэх эрсдлийн удирдлагыг "FM5-19 Composite risk management" баримт бичгээр зохицуулдаг бөгөөд цэргийн анги, салбарын ажиллагааны төлөвлөлтөд "Risk assessment matrix" буюу эрсдлийн үнэлгээний матриц"-ийг боловсруулан хэрэглэдэг байна.

Харин ОХУ-ын Батлан хамгаалах



яамнаас 1997 онд "ОХУ-ын Зэвсэгт хүчний цэргийн албаны аюулгүй байдлын үзэл баримтлал" баримт бичгийг боловсруулан гаргаж, Зэвсэгт хүчний үйл ажиллагааны явцад үүсч болзошгүй аюул занал, сөрөг нөлөөллөөс ЦАХ, ард иргэд, байгаль орчныг хамгаалах арга зам, зарчим, чиг үүргүүдийг тодорхойлсон бөгөөд цэргийн дүрэм, цэргийн албаны заавруудаар эрсдлийн удирдлагын асуудлыг тусган шийдвэрлэж байна. Гэхдээ тэд эрсдэл гэхээсээ илүүтэйгээр "Цэргийн албаны аюулгүй байдал" гэсэн ойлголтыг өргөн хэрэглэж байгаа бөгөөд энэ нь өөртөө цэргийн хөдөлмөр, цэргийн өдөр тумын үйл ажиллагааны явцад учирч болзошгүй хор хохиролоос урьдчилан сэргийлэх асуудлыг авч үздэг байна.

Цэргийн үйл ажиллагааны явцад учирч болох эрсдлийн дараах төрлүүд байж болох юм. Үүнд:

- Технологийн
- Хүний нөөцийн
- Зохион байгуулт, хяналт, үнэлгээний
- Эдийн засгийн
- Байгаль орчны

Монгол Улсын Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын тайван цагийн үйл ажиллагаанд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн удирдлагын системд хэрэглэдэг

"учир шалтгаан ба үр нөлөөний дүн шинжилгээ", "аюул, эрсдлийн дүн шинжилгээ"-ний арга, хэрэгсэлүүдийг өөрийн онцлогт нийцүүлэн хэрэглэх бүрэн боломжтой юм.

Гэхдээ энд анхаарвал зохих нэг зүйл нь цэргийн нэгтгэл, ангийн эрсдлийн үнэлгээнд тэдгээрийн гүйцэтгэж байгаа үүрэг, цагийн байдлын онцлогоос хамаарч **тайван цагийн ба байлдааны ажиллагааны (дайны бус цэргийн ажиллагааны)** гэсэн зааг ялгаатай аргачлал гарч ирэх боломжтой.

Учир нь ердийн хөдөлмөрийн харилцаа (тайван цагийн сургалт, цэргийн алба, аж ахуй, бүтээн байгуулалт, санхүү г.м)-н дахь эрсдэлийн үнэлгээ нь бизнес, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн удирдлагын системд хэрэглэдэг аргачлалаар хийгдэх боломжтой бол байлдааны ажиллагааны үед захирагч, штабаас цагийн байдлыг тогтоох аргачлал (Байлдааны дүрэмд засан аргачлалд үндэслэн)-ын дагуу эсрэг талын нөлөөлөл, байgal орчин, бэлэн байдал, бүх талын хангарт зэрэг хүчин зүйлүүдийн шинжилгээ, үнэлгээний үндсэн дээр боловсруулагдана (хүснэгт-2).

Ийнхүү эрсдлийн удирдлагын дотоод, гадаадын туршилагад үндэслэн цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний дараах

2012 онд Монгол Улсын Зэвсэгт хүчинээс Афганистан улсад үүрэг гүйцэтгэж байсан цэргийн багуудын эрсдлийн тойм үнэлгээ


Ажиллагааны бус, бааз	Аюулгүй байдлын зэрэглэл	Халдлага гарах магадлал	Эрсдэл
Кабул хот, Афганистан улс дахь АНУ-ын тэргүүлсэн "Тогтвортой эрх чөлөө" ажиллагаа, "Эггерс" бааз	Өндөр хохиролтой /амь насанд аюултай/	Тогтмол халдлага гардаг	Маш их
Кабул хот, Афганистан улс дахь НАТО-ын тэргүүлсэн "ISAF" ажиллагаа, "КАИА" бааз	Дунд зэргийн хохиролтой /амь насанд аюултай/	Ye ye халдлага гардаг.	Их
Мазар-Э Шариф хот, "ISAF"-ийн Умард командалын хариуцлагын бус, "Мармал" бааз	Бага хохиролтой /амь насанд аюултай/	Ховор	Дунд зэрэг

АНУ-ын Зэвсэгт хүчиний эрсдэлийн үнэлгээний матриц

Аюултай байдлын зэрэглэл		Магадлал				
		Байнга A	Болзошгүй B	Заримдаа C	Хааяа D	Бараг үгүй E
Аюултай	I	E	E	H	H	M
Хүрцадмал	II	E	H	H	M	L
Бага	III	H	M	M	L	L
Маш бага	IV	M	L	L	L	L
E-маш их, H-их, M-дунд зэрэг, L- сул						



**АНУ-ЫН ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АНГИ, САЛБАРЫНАЖИЛЛАГААНЫ
ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХҮЧИН ЗҮЙЛС**



чиглэлүүдийг дэвшүүлж байна. Тухайлбал,

1. Эрсдэлийн удирдлагын асуудлыг судлан Зэвсэгт хүчний үйл ажиллагаанд хэрэгжүүлэх загварчлалыг бий болгох, "Эрсдэлийн удирдлага - Эрсдэлийн үнэлгээний арга, MNS ISO 31010 : 2011" үндэсний стандартыг мөрдөх;

2. Цэргийн дүрэм, цэргийн алба зохион байгуулах зааварт эрсдэлийн удирдлагын асуудлыг тусгайлан зүйл, заалт болгон тусгах;

3. Зэвсэгт хүчний үндсэн үүргээ биелүүлэх болон бусад чиг үүргүүдийг биелүүлэх үед хэрэгжүүлэх эрсдэлийн удирдлагын асуудлыг тусгайлан авч үзэх;

4. Нэгтгэл, ангиудад эрсдэлийг тооцож, шинжлэх, эрсдэлийг төлөвлөх, хянах бие даасан механизмиг бүрдүүлэх;

5. Зэвсэгт хүчний хяналт, шалгалт, үнэлгээний асуудал хариуцсан нэгжийн чиг үүрэгт нэгтгэл, ангиудын эрсдэлийн удирдлагын төлөвлөлт, хэрэгжилтэд үнэлгээ, шинжилгээ хийх статусыг бий болгох;

6. Эрсдэлийн удирдлагын сургалтыг БХИС-ийг түшиглэн зохион байгуулах, Зэвсэгт хүчний эрсдэлийн удирдлага, эрсдэлийн удирдагын асуудлаар судалгаа, шинжилгээний ажил зохион байгуулах.

Ашигласан материал:

1. Б.Эрдэнэцогт "Цэргийн албаны аюулгүй байдлыг хангах нь"
2. Б.Түмэн "Цэргийн албаны аюулгүй байдлыг хангах тогтолцоо"
3. "Концепция безопасности военной службы в ВС РФ", 1997 г
4. Д.Ганбаяр, "Эрсдэл, эрсдэлийн удирдлагын тогтолцоо", <http://frc.mn/finmarisks/2013/images/stories/2013/slide/Ganbayar.pdf>
5. Эрсдлийн удирдлага - Эрсдлийн үнэлгээний арга, MNS ISO 31010 : 2011
6. Б.Мөнхзаяа, Эрсдэл ба эрсдэлийн удирдлагын <http://mongolianeconomy.mn>
7. Эрсдлийн үнэлгээний загвар, <http://www.cbm-hse.com/mn>
8. Headquarters Department of the Army, Washington, DC, July 2006 FM 5-19 (FM 100-14), Composite Risk Management, 2006



БАТЛАН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨЛТИЙН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

Б.СОДБИЛЭГ /БХЭШХ-ийн Батлан хамгаалахын дүн шинжилгээний төвийн ЭША, дэд хурандaa/

Түлхүүр үрг: Батлан хамгаалах төсөв, төсвийн хяналт, төсөв боловсруулах, Батлан хамгаалах нөөц, Батлан хамгаалахын төлөвлөлт, батлан хамгаалахын менежмент, төсөв, батлан хамгаалах чадавх, стратеги

Key words: Defense budget, Budget oversight, Budget Formulation, Defense resource, Defense planning, defense management, budget, defense capabilities, strategy

Энэ өгүүлэлд Монгол Улстай нэлээд шалгуураар ижил төстэй Бүгд найрамдах Эстон Улсын Үндэсний батлан хамгаалах хөгжлийн төлөвлөлтийг бусад орнуудын батлан хамгаалах төлөвлөлттэй харьцуулан судлахыг зорив.

Батлан хамгаалахын төлөвлөлт нь Зэвсэгт хүчин аюулгүй байдлын зорилтуудаа хангах бодлого, хүч хэрэгслийн төлөвлөлт, нөөцийн хуваарилалтын цогц асуудал юм. Үндэсний аюулгүй байдлын орчныг хангахаас авахуулаад оперативын төлөвлөлт хүртэл цэргийн хүчнийг хэрэгцээтэй үед хэрэглэх батлан хамгаалах төлөвлөлтийн өөр өөр түвшин байдаг байна. Эдгээр олон түвшинд төлөвлөлтийг тухайн цагийн байдалд тохируулан төлөвлөх нь чухал байдаг.

Эстон улсын хувьд Засгийн газар нь 2013 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр ирэх 10 жилд тус улсын батлан хамгаалах зорилтуудыг ажил хэрэг болгох батлан хамгаалахын төлөвлөлтийг зохицуулах Үндэсний батлан хамгаалахын хөгжлийн төлөвлөгөө (ҮБХХТ)-г баталжээ.

Эстони улсын Үндэсний батлан хамгаалахын хөгжлийн шинэ төлөвлөгөө нь:

- Онолын хэсэг
- ҮБХХТ-нд үзүүлсэн эдийн засгийн нөлөөлөл
- 2013-2022 онуудын хөгжлийн төлөвлөлт
- ҮБХХТ-ийн жил жилийн төсвийг тодорхойлох
- Төлөвлөлтийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, хянах, үр дүнг гэсэн бүтэцтэй

байна.

Онолын хэсэгт иргэний нийгэм, батлан хамгаалах төсөв, иргэн цэргийн харилцаа, хамтын ажиллагааны талаар авч үзсэн байна. Мөн батлан хамгаалахын төлөвлөлт ямар ч үед ил тод байхын чухлыг онцолж, ил тод нээлттэй байх, нууцыг хадгалах хоёрын хоорондын зааг ялгааг тодорхой харуулахыг зорьсон нь онцлог болсон байна.

ҮБХХТ-ийг боловсруулахдаа анхаарч авч үзсэн хамгийн чухал хүчин зүйл нь эдийн засгийн макро түвшний үндсэн үзүүлэлтүүд байсан. Эдгээрт:

- Үндэсний тооцооны систем (Үнэ, Баланс, Ангилал)
- Дотоодын нийт бүтээгдэхүүн (Экспорт, Импорт, гадаадын хөрөнгө оруулалт г.м)
- Үндэсний нийт орлого зэргийг тооцож багтаасан байна.

Эдийн засгийн нөлөөллийг судалсны дараа 2013-2022 он хүртэлх ерөнхий төлөвлөлтөө жил тус бүрээр нь төлөвлөлт болгон задалж дараагийн хэсэг болгон оруулжээ.

Жил бүрийн төлөвлөлтийг гүйцэтгэхэд шаардлагатай төсвийг нарийн тооцсон, ингэж тооцохдоо дээр дурдсан эдийн засгийн үзүүлэлтүүдийн нөлөөг авч үзсэн нь төлөвлөлтийг бодитой болгож чадсан байна.

Хамгийн сүүлийн хэсэгт төлөвлөлтийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж гүйцэтгэлд нь хяналт тавих, үр дүнг нь үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг тус тус оруулж өгчээ.



Ер нь ихэнх улс орнууд батлан хамгаалах төлөвлөлтийг 4 жилийн үечлэлтэй хийдэг хандлага байна. Эстон улсын хувьд олон улсад үүсээд байгаа нөхцөл байдалтай уялдуулан өөрийн хүч, нөөц бололцоонд тулгуурласан 4 жил тутамд тодотгол хийх 10 жилийн хугацаатай үндэсний батлан хамгаалахыг хөгжүүлэх төлөвлөлтийг боловсруулсан байна.

Энэ төлөвлөлтийг Эстоны батлан хамгаалах яам Эстонийн батлан хамгаалах хүчинүүдтэй хамтран бусад институциудын оролцоотойгоор боловсруулжээ. Тус баримт бичиг нь гүйцэтгэх засаглал /Засгийн газар/-ын бие даан боловсруулсан баримт бичиг тул парламентийн нөлөө ороогүй байна. Парламент нь зөвхөн үндэсний батлан хамгаалах хорооны түвшинд зөвлөх үүрэгтэйгээр оролцсон байна.

Дээрх төлөвлөлтийн баримт бичгийн агуулгад батлан хамгаалахын төлөвлөлтийг сайжруулах 4 чиглэлийг тодорхойлохыг эрмэлзэн байна. Үүнд:

1. Батлан хамгаалах төлөвлөлт нь "улс орны эрх ашгийн үүднээс" гэдэг тодотголын доор хийгддэг учраас олон нийтийн эсэргүүцэлтэй төдийлөн тулгардаггүй,

2. Үндэсний аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн байдаг учраас татвар төлөгчид төлөвлөлтийг хэрэгжүүлэхээс татгалзахгүй,

3. Батлан хамгаалах төлөвлөлтүүдийн санхүүжилтийг тодорхой, ил тод болгосон нь олон нийтэд ямар ч эргэлзээ төрүүлэхгүй болсон,

4. Батлан хамгаалах төлөвлөлт нь иргэний нийгмийн ашиг сонирхлыг давхар агуулсан байдаг.

Судалгааны ажлын бас нэг чухал ач холбогдол нь ардчилсан нийгэм дэх батлан хамгаалах төлөвлөлтийн онолыг боловсруулсанд оршино.

Цэргийн болон иргэний байгууллагуудын удирдлагуудын хоорондын харилцааны онцлогоос хамааран Батлан хамгаалах төлөвлөлт нь парламент болон

засгийн эрх баригчид, олон нийтийн ардчилсан хяналтын доор хийгдэх ёстой гэж үздэг. Гэхдээ үүнийг хатуу чанга хяналт гэж ойлгохгүйгээр улс орны цэргийн болон улс төрийн удирдлагуудын хоорондын харилцааны гүүр хэмээн ойлгох ёстой гэж тус төвийнхэн үздэг юм.

Нөгөө талаас парламент нь Засгийн газрын шийдвэрийг хянан нягталдаг байх ёстой. Энэ нь батлан хамгаалах төлөвлөлттэй холбоотой Засгийн газрын хариуцлагыг өндөржүүлэх хүчин зүйл болдог. Ийм учраас батлан хамгаалах төлөвлөлтийн бодлогын болон санхүүгийн хариуцлага нь Засгийн газарт бүрэн оногдож байдаг ба батлан хамгаалахын санхүүгийн төлөвлөлт нь бусад энгийн байгуулагуудынхаас харьцангуй төвөгтэй байдаг. Энэ утгаараа санхүүгийн хариуцлага нь зэвсэгт хүчинд тавих иргэний хяналтын гол хөшүүрэг болдог. Ийм учраас санхүүгийн шийдвэр нь батлан хамгаалах салбарын хөгжлийн гол хүчин зүйл гэж үзэж болох юм.

Төсвийн онолоор хэдийгээр санхүүгийн шийдэл нь хариуцлагын тогтолцооны суурь боловч санхүүжилтийн ил тод байдалгүйгээр бүрэн шийдвэрэхгүй юм.

Батлан хамгаалахын төсөв нь батлан хамгаалахын стратегийн гол хөшүүрэг нь болдог хэдий ч тодорхой мэдээллэлтэйгээр хэрэгжиж байх ёстой. Тийм учраас хариуцлагын болон ил тод байдлын асуудал нь батлан хамгаалахын төлөвлөлтийн гол үзүүлэлт юм. Яагаад гэвэл ардчилсан нийгэмд татвар төлөгчид батлан хамгаалах төсвийн төлөвлөлтийн ил тод байдалд анхаарлаа хандуулдаг учраас олон нийтэд хэрэгцээтэй байгаа мэдээллийг орхигдуулж, нуух шаардлагагүй юм. Ийм учраас санхүүгийн төлөвлөлт нь хууль, эрх зүйн хувьд чухал үндэслэлтэй байх ёстой бөгөөд хуулиар тогтоосон төлөвлөлт түүний хэрэгжүүлэлт хоёрын хооронд ямар нэгэн зөрүү гарах учиргүй юм. Хэрвээ ямарваа нэгэн зөрчил гарсан тохиолдолд дунд хугацааны болон урт хугацааны төлөвлөлтуүдийг хийхэд хүндрэл үүсэхээс гадна татвар төлөгчдөд



хардлага төрүүлдэг.

Ер нь батлан хамгаалах төлөвлөлтөнд иргэдийн оролцоо зайлшгүй байх ёстай. Учир нь:

- засгийн газар нь сонгогчид болон татвар төлөгчдийн өмнө хариуцлага хүлээдэг,
- иргэний нийгмийн байгууллагууд нь батлан хамгаалах төлөвлөлтөнд шууд болон шууд бусаар оролцож байдаг юм.

Иймд ил тод байдал чухал байр суурь эзэлж байдаг бөгөөд ил тод байдалгүйгээр батлан хамгаалах салбар хэзээ ч олон нийтийн дэмжлэг авахгүй. Засгийн эрхэнд байгаа албан тушаалтнууд нууц мэдээллтэй шууд харьцах эрхтэй байдаг бол олон нийт болон иргэний нийгмийн төлөөллүүдэд тус эрх нээгддэггүй тул тэд нээлттэй мэдээллийг шаардаж байдаг байна. Тийм учраас ил тод байдал хариуцлагын тогтолцоо хоёр салшгүй холбоотой зүйл байдаг бөгөөд батлан хамгаалах төлөвлөлт амжилттай болохын үндэс суурь гол тулах цэг болж байдаг байна.

Үг судалгааны ажлыг онолын болон эмпирик аргуудыг ашиглан хийсэн байна. Онолын хэсгийг иргэн-цэргийн харилцааны онол, төсвийн онол, иргэний нийгмийн санал бодлыг үнэлэхэд хэрэглэсэн бол, эмпирик аргыг ҮБХХТ-ийн бүрэн шинжилгээг хийхэд хэрэглэсэн байна. Гэхдээ онол, эмпирик дүгнэлтийн арга хоёр нь хоёулаа бусад ижил төстэй баримт бичгүүдийг шинжлэх сонгодог жишиг болсон юм.

Эстоны ҮБХХТ нь төсвийн болзошгүй хязгаарлалт, аюулгүй байдлын өөрчлөлтийн хэтийн төлөвийг тооцсон байна.

Тагнуулын болон кибер хамгаалалтын систем, хэрэгслийн тасралтгүй, найдвартай ажиллагаа нь батлан хамгаалах язгуур ашиг сонирхол хэдий ч санхүүгийн нөхцөл байдал хүндэрч, төсөв танагдахаар болбол гарах үр дүнг тооцоогүй байна.

Мөн аюулгүй байдлыг хангах үүднээс төлөвлөлтийн бүх элементүүдэд дүн

шинжилгээ хийх шаардлагыг хангаж чадахгүй байна. Яагаад гэвэл тус баримт бичгийг боловсруулах ажлыг засгийн газар дангаараа гүйцэтгэнээр олон нийтийн санал бодол, шүүмжлэх боломжийг хаасан талтай байна. Энэ нь уг төлөвлөлтийн ил тод байдлыг үгүй болгож, хариуцлагын тогтолцоог бүдэгруулэх байдал ажиглагдаж байна.

Түүнээс гадна уг бичиг баримтын төгсгөлд "хэрэгжүүлэх төлөвлөгөө нь 2013 оны дөрөвдүгээр сард батлагдана" гэж бичсэн боловч олон нийтийн хэрэгслээр энэ талаар ямар ч мэдээлэл гаргаагүй юм. Түүнчлэн зарим нэгэн өгүүлбэрүүд тодорхой тайлбар шаардах болсон. Тухайлбал, 17 дугаар параграфад "албаны төгс байдлыг хангах үүднээс зарим шатанд хүнд суртлыг хүлээн зөвшөөрөх болно" гэж бичсэн боловч зарим шат гэдэгт ямар албан тушаалыг хамруулах, хэдий хугацааны дараагаас ийнхүү хүнд суртлыг хүлээн зөвшөөрөх тухай тодорхой дурдаагүй байна.

Мөн санхүүгийн төлөвлөлтийн асуудлууд Үндэсний аюулгүй байдалд шууд аюул учруулахгүй гэж үзсэн учраас 196 параграфад заасан цэргийн баазыг сайжруулах төслийн санхүүжилтийн талаар олон нийтэд нээлттэй мэдээлэх ёстай байлаа. Гэтэл тэгээгүй учраас олон нийтэд хардлага төрүүлэх магадлал бий болжээ. Татвар төлөгчид ямар төсөлд чухам хэдий хэмжээний мөнгө зарагдаж байгааг мэдэхээс гадна, батлан хамгаалах салбарыг хөгжүүлэхийн ач холбогдлыг мэдэж байх нь Батлан хамгаалах салбар ард түмний харилцан ойлголцлыг бэхжүүлдэг.

Эстон улсын ҮБХХТ-нд ил тод байдал, хариуцлагын тогтолцооны наад захын стандартыг хангаж чадаагүй байна. Ер нь амьдрал дээр батлан хамгаалах төлөвлөлтийг хийхэд ил тод байдал болон хариуцлагын тогтолцооны шаардлагыг хангах нь хамгийн чухал юм.

Бусадорнуудынхувьд батлан хамгаалах төлөвлөлтүүд нь тодорхой сорилтуудтай тулгарч байсан нь олон улс орнуудын



батлан хамгаалахын төлөвлөлтүүдийг харьцуулсан судалгаанаас тодорхой харагддаг.

Тухайлбал энэ хэсэгт Дани, Финланд, Норвеги, Шведээс гадна Эстони улстай соёл иргэншлийн хувьд төстэй Европ тивийн цөмийн зэвсэг бүхий Англи өмнөд Европт стратегийн өндөр ач холбогдол бүхий Испани, тэрчлэн АНУ, Австрали, Шинэ Зеланд зэрэг улсуудын батлан хамгаалах төлөвлөлтүүдийг харьцуулан үзсэн болно.

Харьцуулалтанд орж байгаа улсуудаас Испани улсаас бусад улсын батлан хамгаалахын төлөвлөлтийн бичиг баримтууд эдийн засгийн хямралын дараа бичигдсэн байна. Харин Испани улсын түүнээс өмнө бичигдсэн учраас санхүүгийн асуудалд анхаарал хандуулжээ.

Австрали улс 2012 оны 12 дугаар сараас 2013 оны 2 дугаар сарын хооронд Австралийн БХЯ-аас батлан хамгаалахын төлөвлөлт хийх асуудлаар иргэний нийгмийн болон олон нийтийн 107-н хурал цуглаан, чуулган, санал асуулга явуулсан байна. Энэхүү баримт бичиг гарснаас хойш ч гэсэн олон нийтийн зүгээс уг баримт бичгийн талаар санал бодлоо илэрхийлэх асуудлыг нээлттэй үлдээсэн байна. Австралийн энэ ил тод байдал нь олон улсад үлгэр жишээ болохуйц шинж төлөв юм.

Австралийн батлан хамгаалахын төлөвлөлтийн баримт бичиг нь эхнээсээ авахуулаад агуулгын дэлгэрэнгүй мэдээлэлтэй бусад улсуудын батлан хамгаалах төлөвлөлтийн баримт бичгүүдээс эшлэл авсан онцлогтой байна.

Австралийн батлан хамгаалах хүчин төлөв байдлын үнэлгээний дараа энэхүү баримт бичиг нь Австрали улс өөрсдийн батлан хамгаалах хүч, хүч хэрэгслийн газар зүйн байрлалыг хэрхэн өөрчилж сайжруулах талаар тодорхой тайлбарласан ба бүхэл бүтэн бүлгийг Австрали улсын зүгээс олон улсын хэрэгт хэрхэн оролцох /эвсэл, холбоо, хамтын ажиллагаа, хамтарсан төсөл гэх мэт/ талаар тайлбарласан байна.

"Ирээдүйн хүчнийг хөгжүүлэх нь" гэсэн бүлэгт ирэх жилүүдэд шаардагдах хүч хэрэгслүүдийн талаар дурдахдаа эдгээр хүч хэрэгслүүд нь зөвхөн үндэсний батлан хамгаалахад төдийгүй улс үндэстний хэмжээнд хэрхэн чухал болохыг нарийвчлан тайлбарлаж өгчээ. Шумбагч онгоцуудыг худалдан авах төсөлд л гэхэд одоогоор яг юу хийгдсэн, юу хийгдээгүй байгаа, юу хийх хэрэгтэй байгаа, яагаад гэдгийг нарийвчлан тайлбарлаж өгсөн байна.

Уг баримт бичигт Австралийн батлан хамгаалах салбарын өөрчлөлтийн явцыг дурдсан байна. Энэ өөрчлөлтийн хүрээнд ил тод байдал хариуцлагын тогтолцоог сайжруулахын тулд батлан хамгаалахын төслүүдийг шалгаруулах шинэ тогтолцоог хэрхэн бий болгож хэрэгжүүлэхэд анхаарал хандуулсан байна.

Энэхүү баримт бичгийн жижиг дутагдалтай тал нь батлан хамгаалахын төсвийн шинэ моделийг бий болгохыг зорьж байгаа ч олон жилийн төсвийн мэдээллийг оруулж чадаагүй явдал юм.

Гэсэн хэдий ч Австрали улс энэ дутагдлаа нөхөх зорилгоор өөр нэг чухал баримт бичгийг боловсруулаад байгаа нь "Батлан хамгаалах хүч хэрэгслийн төлөвлөгөө" юм. Энэ бичиг баримт нь зөвхөн батлан хамгаалах салбарын худалдаа үйлдвэрлэлийн асуудалд төвлөрсөн нь бусад орны ижил төстэй бичиг баримтуудаас ялгаатай юм.

"Батлан хамгаалах хүч хэрэгслийн төлөвлөгөө" нь 4 жилийн өмнө батлагдсан байх ёстойгоор хуульчлагдсан. Батлан хамгаалахыг хөгжүүлэх төслүүдийн жагсаалтыг тус төлөвлөгөөнд тусгаж батлан хамгаалахын материал хэрэгслийн байгууллагуудад хэчнээн хэмжээний төсөв шаардлагатай байгаа тодорхой зааж өгдөг. Төсөл бүрийн батлагдах болон эхэлж, дуусах хугацаа нь тодорхой байж гарах үр дүнг үнэлэхэд тодорхой байх ёстой. 2006 оны Батлан хамгаалах хүч хэрэгслийн төлөвлөгөөнд шаардагдах хөрөнгийн жагсаалтыг 20-30 сая, 250-350 сая, 2.5-3.5 тэрбум гэсэн ангиллаар гаргаж байсан бол



одоогийн төлөвлөгөөндөө үнийн дүнгийн жагсаалтанд анхаарал хандуулаагүй харин худалдан авах хүч хэрэгслийг төрөл зориулалтаар нь ангилсан жагсаалтыг гаргахад гол анхаарал хандуулсан байна. Энэ нь тус улсын эдийн засгийн чадавхитай холбоотой болох нь харагдаж байна.

Одоогийн батлан хамгаалах чадавхийн төлөвлөгөөний бас нэг онцлог нь гэвэл төсөл бүрийг хариуцсан албан тушаалтан бүрт холбогдох мэдээллийг тодорхой зааж өгснөөр олон нийтийн зүгээс төлөвлөгөөний талаар лавлагаа авах, гүйцэтгэлийг хянах механизм бүрдүүлэх боломж олгосон байна.

Дани улсын энэ төрлийн баримт бичиг нь "Данийн батлан хамгаалах гэрээ" юм. Тус гэрээг 2013-2017 оны хооронд 4 жилийн хугацаанд хүчинтэй байхаар баталсан. Уг баримт бичгийг парламентийн удирдлага дор хийсэн нь гүйцэтгэх засаглалаас хараат бус болсон талтай байна.

Бүтцийн хувьд Данийн энэ баримт ил тод байдлын шаардлагыг хангасан харагдаж байна. Батлан хамгаалах төсөв, санхүүжилтийн үр нөлөөтэй байдал зэрэг батлан хамгаалах төсвийн чиглэл бүрийг хамарсан бүлгүүд нь бүгд тодорхой цэгцтэй мэдээллийг агуулсан байна. Түүнээс гадна энэ баримт бичиг нь нийт 4 жилийн санхүүгийн орлого, зарлагын мэдээллийг тодорхой агуулж үйл ажиллагааны болон урсгал зардлын жагсаалтыг харуулсан хавсралтуудтай байна. Энэ баримт бичиг нь улс орны санхүүгийн нөхцөл байдлыг тооцоолж боломжтой бодитой нөхцөл байдалд тулгуурласан гэж үзэж болохоор байна.

Ийм нарийвчилсан төлөвлөлт нь санхүүгийн хариуцлагыг хатуу чанд тогтоосноороо хэрэгжилтийн явцад дүн шинжилгээ хийх хяналт тавих боломжийг бүрдүүлсэн байна. Санхүүгийн энэ ил тод байдлаас гадна төслүүдийг хэрэгжүүлэх хугацаануудыг тодорхой зааснаараа онцлог болжээ.

Түүнээс гадна энэхүү төлөвлөгөө нь цэргийн анги салбаруудыг тоог

хорогдуулах, бусад ижил төрлийн анги салбаруудтай нийлүүлэх зэрэг асуудлуудыг тодорхой заасан байна.

Финляндын Аюулгүй байдал батлан хамгаалах бодлогын талаарх Засгийн газрын 2012 оны мэдээлэл нь батлан хамгаалахын хөгжлийн тухай эхний бүлгээс авахуулаад батлан хамгаалахын хөгжлийн ерөнхий зорилтууд болон батлан хамгаалах чадавхийн хүчин зүйлүүдийг тодорхой тусгасан байна.

Мөн батлан хамгаалах чадавхaa дээшлүүлэх зорилгоор олон улсын батлан хамгаалах хүчиний ач холбогдлыг өндөрт авч үзээд гадаадын орнуудын зэвсэгт хүчинүүдтэй хамтын ажиллагаа хөгжүүлэх талаар тодорхой зааж өгсөн онцлогтой байна. Түүнээс гадна батлан хамгаалах хүчиний салбар бүрийн тухай мэдээллийг нарийвчлан оруулсан байна.

Гэхдээ Финляндын энэхүү баримт бичиг цөөхөн тооны тухайлсан төслүүдийг хамарсан онцлогтой байна. Энэ баримт бичигт төрлийн цэрэг бүр 2008 онд хэдэн байлдааны ангиудтай байсан 2015 он гэхэд хэдэн анги нэгтгэлтэй байхыг графикаар тодорхой харуулсан байна. Энэ нь иргэдэд өөрчлөн байгуулалт хэрхэн явагдаж байгааг ил тод харуулах хэрэгсэл болсон байна. Иймэрхүү графикчилсан мэдээллийг мөн тайван цагийн анги нэгтгэлүүдийн талаар ч бас харуулсан байна. Эцэст нь энэ баримт бичиг Финляндын батлан хамгаалах хүч хэрэгслүүд дунд болон урт хугацааны төлөвлөлтийн явцад нэлээд хэмжээний хөрөнгө шаардлагатайг тэмдэглээд, харин 2015 оны эцэс гэхэд энэ зардал буурч, цаашид 2016-2020 онуудын батлан хамгаалах төсвийн талаар тодорхой харуулсан онцлогтой байна.

Шинэ Зеландын 2010 онд бичигдсэн цагаан номноос харахад тус улсын батлан хамгаалах төлөвлөлт хамгийн урт хугацааг буюу 25 жилийг хамарсан бичиг баримт болсон байна. Ийм удаан хугацааг хамарснаараа батлан хамгаалахын хөгжлийн ерөнхий чиг шугамыг заахаас нарийвчлан тодорхойлох



аргагүйд хүргэж байгаа юм. Гэсэн хэдий ч энэ бичиг баримт нь бусад орнуудын батлан хамгаалах төлөвлөлтийн адилаар ил тод байдал, хариуцлагын тогтолцоог тусгасан байна.

Уг баримт бичигтээ язгуур сонирхлоо тод тусгаж, тагнуул туршуулын чадавхийг сайжруулахын тулд далаин эрэг хавийн эргүүлийн нисдэг тэрэг, сансрын зураг авалтын хиймэл дагуул зэргийг худалдан авах талаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээ нь иргэдийнхээ зүгээс ихээхэн дэмжлэг хүлээдэг байна.

Норвеги улс зэвсэгт хүчиний худалдаа үйлдвэрлэлийн албан баримт бичгүүдэд гол анхаарлаа хандуулсан байна.

Норвегийн баримт бичиг нь төлөвлөлтийн хугацааг 4 жилийн үе шатанд хувааж үе шат бүрт батлан хамгаалахын язгуур ашиг сонирхлыг тодорхойлсон байна. Түүнээс гадна бүх хөрөнгө оруулалтыг 6 категорит хувааж, категори бүрийн жил тутмын төсвийг тусгаж өгчээ. Түүнээс гадна энэхүү баримт бичиг нь дараах 5 категорийн мэдээллийг маш нарийн мэдээллийн системтэйгээр харуулж өгсөн байна. Үүнд:

- Зорилго
- Хамрах хүрээ
- Зорилт
- Үнэ
- Холбоо барих хаяг зэргийг ил тод харуулсан байна.

Испани улсын төлөвлөлт бол удаан хугацааны төлөвлөлтийг байнга, ялангуяа засгийн газар солигдох бүрт тодотгож байдгаараа онцлогтой юм. Испаний хамгийн сүүлд төлөвлөлтөө 2000-аад оны эхээр боловсруулсан байна. Түүнээс гадна батлан хамгаалах төлөвлөлт нь өнгөрсөн жилүүдэд хэчинээн зардал гаргасныг гол төлөв тусгасан байdag байна.

Нөгөөтэйгүүр энэхүү баримт бичгийн "батлан хамгаалах салбарын сэргээн сайжруулалт" нэртэй бүлэгт төрлийн цэрэг бүрт хэрэгжүүлэх томоохон төслүүдийг төлөвлөж, язгуур сонирхлыг тодорхойлж байdag байна. Түүнээс гадна энэхүү баримт бичигт оруулах өөрчлөлт бүрийг сайтар

хэлэлцэн холбогдох хууль тогтоомжийн байгууллагуудаар шүүн тунгаалгаж байдаг байна. Иймд ил тод байдлын шаардлагыг зохих хэмжээгээр хангаж байдаг гэсэн дүгнэлт хийж болохоор байна.

Шведийн цагаан номноос авч үзэхэд батлан хамгаалах төлөвлөлтийн баримт бичгээ Британи, Дани, Эстони зэрэг улсуудынхтай адил таван жилийн хүрээг хамарсан байдлаар төлөвлөдөг байна. Тус баримт бичиг нийт 8 бүлэгт хуваагдаж, тэдний дотор дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр нь дангаараа бие даасан нэг бүлэг болсон байна. Баримт бичиг нь агуулгын маш ойлгомжтой танилцуулгатай байна. Уг баримт бичгийн ээрэг тал нь гэвэл хариуцлагын тогтолцоог сайтар тодорхойлж өгсөнд оршиж байгаа юм.

Шведийн зэвсэгт хүчин 2009 онд хугацаат цэргийн албанаас сайн дурын цэргийн тогтолцоонд шилжиж эхэлснээс хойш бүтцийн томоохон өөрчлөлтүүдийг хамарсан байна. Гэвч энэ өөрчлөлтийг хийх тодорхой хугацаа зааж өгөөгүй байна. Энэ баримт бичиг нь шинэ зэвсэг техникийг худалдан авахыг урьтал болгоогүй бүтцийн өөрчлөлтийг л голчлон хөндсөн байна. Энэ нь мэдээж тус улсын аюулгүй байдлын гадаад орчны нөхцөл байдалтай шууд холбоотой. Швед улс бол хүн амьдрахад ээлтэй, дэлхийн хамгийн тайван улсуудын тэргүүн эгнээнд байдаг юм.

Төлөвлөлтийн санхүүгийн асуудлууд зөвхөн ганцхан хэсэгт төвлөрүүлэгдсэн ба өнгөрсөн өөрчлөлтийн төсвийн тойм гүйцэтгэл нь дунд хугацааны хөгжлийн хөтөлбөрийн бүлэгт тусгагдсан байдаг. Тодорхой төслийн бүлгүүдийг "Томруулах шил" /Zooming in/-ний арга барилаар бичсэн байна. Эхлээд төслүүдийн ерөнхий дүр зургийг танилцуулж, дараагаар нь бага багаар задлан нарийвчилсан мэдээлэл хүртэл тайлбарласан байдаг. Үүний адилаар цэргийн төлөвлөлтүүдийг стратегийн түвшний төлөвлөлтөөр эхэлж тактикийн түвшний асуудал руу шилжүүлэх дарааллаар боловсруулсан байна.

Харьцуулсан байдлаас үзвэл, Эстоны



Үндэсний Батлан хамгаалах Хөгжлийн Төлөвлөгөө (ҮБХХТ) нь батлан хамгаалах төлөвлөлтийн ихэнх суурь зарчмуудыг тусгасан баримт бичиг болсон нь харагдаж байна. Эстоны баримт бичиг нь БХЯ-ныхаа зүгээс дөрвөн жилд нэг удаа дүгнэж байх бололцоо олгодог сайн тал ажиглагдаж байна. Түүнээс гадна энэ төлөвлөгөө нь жил бүр шинэчилж болох олон жилийн төсвийн төлөвлөлт, Австрали, Их Британи зэрэг улсуудын төлөвлөлтөнд тусгагдаагүй нарийвчилсан мэдээллийг тусгасан өвөрмөц баримт бичиг болсон гэж үзэж болно.

Дээр дурдсан улсууд батлан хамгаалах төлөвлөлтийн хувьд улс бүр өөр өөрсдийн онцлогт тохирсон, шаардлагаа хангасан төлөвлөлтийн бичиг баримт

боловсруулсан гэж үзэх үндэстэй байна.

Санхүүгийн асуудлын хувьд Дани, Норвеги улсууд маш тодорхой төлөвлөлт хийсэн боловч, Австралийн төлөвлөлт дэх үнийн дүнгээр нь ангилж харуулсан байдал өвөрмөц байна. Австрали, Финланд, Испани, Шинэ Зеланд улсууд агуулгын тодорхой жагсаалт гаргасан нь уншигчдад хайж байгаа мэдээллээ чөлөөтэй олох боломжийг олгосон бол, Норвеги, Испани, Их Британи улсууд графикчилсан мэдээллэл ихээр оруулсан нь бас нэг давуу тал болсон байна.

Австрали улсын төлөвлөлт нь төлөвлөлтийн өмнө болон дараа нь ч гэсэн олон нийтийн оролцоог дээдлэсн ил тод байдлын шалгуурыг хангасан төлөвлөлт болсон гэж үзэж болно.

Ашигласан материал:

1. Analytic Architecture for Capabilities-Based Planning, Mission-System Analysis, and Transformation, Paul K. Davis (monograph)[2]
2. Richmond M. Lloyd, et al., Strategy and Force Planning, (Newport, RI: Naval War College, 1997, Pg 3
3. Planning, RANDMR2.4-1513
4. C.Kelley, P. Davis, B. Bennett, E. Harris, R. Hundley, E. Larson, R. Mesic, and M. Miller, Metrics for the quadrennial defense review's operational goals (Santa Monica, CA: RAND National Defense Research Institute, 2003);
5. Salvatore Schiavo-Campo and Daniel Tommasi, "The Budget Preparation Process," Asian Development Bank
6. Antonio Marquina, "Spanish Foreign and Defense Policy Since Democratization," in Kenneth Maxwell, ed. Spanish Foreign and Defense Policy. (Boulder: Westview Press Inc., 1991),
7. "Which program did we mean in 'Program Budgeting', " The Rand Corporation David Novick
8. Paul.L. Gerhardt. CUSTOMER SERVICE IN RETAIL, 2003
9. NATO Basic Texts: Partnership Action Plan on Defence Institution Building(PAB-DIB) www.nato.int/docu/basictxt/b040607e.htm



ЕВРОПЫН ОРНУУДЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТОГТОЛЦОО БА ИРГЭНИЙ НИЙГЭМ

Б.НЭРГҮЙ /УБХИС-ийн БХЭШХ-ийн ЭША, докторант, хошууч/

Түлхүүр үг: Аюулгүй байдал, хамтын аюулгүй байдал, иргэний нийгэм, социологи, иргэний нийгмийн засаглал, geopolitiek, олон нийт, хөгжил, ардчилал, үндэсний ашиг сонирхол, нийгмийн хөдөлгөөн.

Key words: Security, global security, civil society, sociology, civil society governance, geopolitics, public, development, democracy, national interests, social movement.

Товч: Энэ өгүүлэлд аюулгүй байдлын асуудлаар иргэний нийгэм ба төрийн харилцааны европын туршлагыг шинжлэн үзэв. Ингэхдээ Европын орнуудын аюулгүй байдлыг хангах механизмын улс төрийн өвөрмөц нөхцөл байдал, батжин тогтсон ардчилсан хэм хэмжээ, дэг журамд голлон анхаарсан болно.

Орчин үед дэлхий нийтийн эдийн засаг ба нийгмийн (социал) бодит байдал, аюулгүй байдлыг хангах интернациональ (глобал) асуудлыг шийдвэрлэхэд улс орнуудын идэвхтэй оролцоо нь иргэний нийгэм болон төрийг улс төрийн бодлого, хандлагаас ангид байх боломжгүй болохыг харуулж байна.

Аливаа орны үндэсний аюулгүй байдлын тогтолцооны бурдэл, түүнд хамрагдаж буй иргэний нийгмийн талаарх олон улсын туршлага, сургамж нь аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд ихээхэн тус дэвтэй бөгөөд иргэдийн хамгаалагдсан байдлыг илүү чанаржуулах үр нөлөөтэй юм.

Европын орнуудад "аюулгүй байдал" хэмээх нэр томъёог авч үзэхдээ милитарист хандлага тал нь бага, социал шинж рүүгээ тулхүү хандаж ирсэн байдаг. Тэдгээр орнуудад дээрх нэр томъёоны хүрээнд терроризмыг эсэргүүцэх, гадаад хил хязгаараа бэхжүүлэх, зэвсэгт хүчин болон тусгай албадыг санхүүжүүлэх асуудлыг хамааруулан үзэхийн дээр аюулгүй байдлын социал (нийгмийн) тал дээр ихээхэн ач холбогдол өгч ирсэн байдаг. Тухайлбал Европ болон АНУ-д өдөр тутмын аюул осол, эрсдэл ба аюул

заналыг *social security* гэж нэрлэдэг, түүнд гэмт хэрэг, экологи, халдварт өвчин, хар тамхи, тэрчлэн угсаатан хоорондын харилцааг багтаан үздэг байна.

Их Британи, Дани, Швед, Норвеги зэрэг орнуудад ХХ зууны сүүлчээр түгэн дэлгэрэх болсон "энхийн судалгаа" хэмээх сургуулийг баримтлагчид securitization хэмээх нэр томъёог өргөнөөр хэрэглэх болжээ. Энэ үгийн утга нь аюулгүй байдал судлалын социал (нийгмийн) мөн чанар гэж үздэг. Энэ утгаараа тодорхой хамтын нийгмлэгт зориулсан аюулгүй байдлыг хангах оновчтой тогтолцоог бий болгохын тулд хэлэлцүүлэг, олонх, иргэний нийгмийн оролцоо шаардлагатай. Үүнийг зохион байгуулах нь нийгэм, улс төрийн чухал үйл явц мөн. Цаашлаад нийгэм дэх сөрөг хандлагын талаар олон нийтийн хэлэлцүүлэг, маргаан явуулах ёстой бөгөөд үүний үндсэн зорилт бол нийгмийн зөрчилдөөнт болон тайван байдал ба зохицлыг бий болгоход оршино. Нийтийн хэлэлцүүлгийн өөр нэг зорилт бол аюулгүй байдлыг хангах асуудлаар нийгэмд гарч буй сөрөг үзэгдэл, элдэв төсөөлөл, гажуудлыг саармагжуулахад чиглэсэн үндэслэлтэй, нотолгоо бүхий үйл ажиллагаа явуулахад оршино.

Улс төр судлалын үүднээс үзвэл securitization нь өөртөө ардчиллын үлэмж боломжийг агуулж, төрийн бус байгууллага ба хараат бус шинжээчдийг аюулгүй байдлын талаарх улс төрийн хэлэлцүүлэгт оролцуулах нь уламжлалт төр эрх зүйн онолоос хальсан ойлголт юм. Энэхүү иргэний нийгмийн оролцооны нэг чиглэл нь төрийн монопол байдлыг



хязгаарлах, шударга, тэгш байдлыг бий болгох явдал. Өрнөдийн судалгаа шинжилгээнд энхийн цагт парадигмын нэн чухал өөрчлөлт гарсан нь ихэвчлэн геополитикийн түвшин дэх дипломат арга замыг хамаарч байна. Энэ нь аюул, занал, эрсдэл, өдөөн хатгалтын асуудлыг цэргийн хүчин зүйлээр шийдвэрлэхээс илүүтэйгээр гадаад бодлого, дипломат харилцаанд тулгуурлан шийдвэрлэж, уламжлалт аюулын талаарх геополитикийн ойлголт хандлагын ач холбогдлыг багасгаж байна.

Аюулгүй байдлыг хангах асуудлаарх орчин үеийн ойлголтыг авч үзвэл өвөрмөц маягийн "аюулгүй байдлын хамтын нийгэмлэг" (*security communities*)-ийг аюул, заналын эсрэг үйлчлэх босоо тогтолцоо болон хэлбэрээр нь төдийгүй орон нутгийн зарчмаар хөвтээ тогтолцооны түвшинд бүрдүүлэхэд оршино. Аюулгүй байдлыг хангах тогтолцоог ийнхүү бүсчилснээр иргэний нийгмийн институтуудийн оролцоог чухалчилж байгаа хэрэг юм. Судалгаанаас үзвэл "зөвлөн аюул занал"-ын үзэл баримтлалын Норвегийн онолч Й.Галтунг¹ өөрийн бүтээлүүдээ улс орнууд өөрсдийн аюулгүй байдлыг хангахын тулд заавал эвсэл холбоо байгуулах гэлгүй иргэний нийгэм болон төр хамтран ажиллах шаардлагатай болохыг чухалчилсан байdag.

Мөн аюулгүй байдлын судалгаа, улс төрийн бодлогод үндэстэн хоорондын харилцаа, яриа хэлцэл, эдийн засаг, хил хязгаарын хамгаалагдсан байдал, гэмт хэрэгтэй хийх тэмцэл, авилгалын түвшинг бууруулах зэрэгт илүүтэй анхаарах хэрэгтэй гэж үздэг. Үндэсний аюулгүй байдлын тогтолцоон дахь иргэний нийгмийн институтийн тоо үлээмж их бөгөөд тухайн иргэнээс эхлээд сүм хийд, төрийн бус байгууллага, холбоод болон үндэстэн дамнасан санхүү, аж үйлдвэрийн корпораци хүртэл хамруулан үзэх хэрэгтэй².

Европын ардчилал, улс төрийн уламжлалд аюулгүй байдлын салбар дах төр ба иргэний нийгмийн харилцааны асуудал ийнхүү ихээхэн чухлаар тавигдаж байна. Европын төрийн бодлогын социал загварт иргэний ашиг сонирхол эн тэргүүнд тавигддаг бол харин нийгмийн (үндэсний) аюулгүй байдал эв нэгдэл ба түншлэлийн зарчим дээр суурилдаг байна. Энэ нь үндэсний аюулгүй байдлын төлөө хувь хүн, нийгэм ба төр ижил тэгш хариуцлага хүлээнэ гэсэн үг юм.

Европод болж байдаг аюулгүй байдлын талаарх янз бүрийн (төрөл бүрийн) хурал, семинарт хүчний байгууллага ба төрийн бүтцийн ажилтнууд маш цөөн оролцож байгаа нь анзарагддаг байна. Үндсэндээ аюулгүй байдлын эрсдэл, аюул заналыг гаргахгүй байх дам арга хэмжээнүүд болон тэдгээрийн эсрэг ажиллагааны асуудлууд зөвхөн төрийн зарим байгууллагуудын төдийгүй иргэн бүрийн хэрэг болохыг ухамсарлан ойлгосон зарим идэвхтэй иргэд, иргэний нийгмийн төлөөллийн илэрхийлэл түгээмэл ажиглагддаг байна. Энэ бол Европын иргэдийн төрд итгэх итгэлийг илтгэсэн үзүүлэлтийн нэг юм.

Жишээ нь тогтвортой эдийн засагтай, эрх зүйн өндөр ухамсар бүхий ардчилсан орон болох Герман оронд цагдаа нар өөрийн үйл ажиллагаагаа иргэдийн дийлэнх олонхийн дэмжлэгтэйгээр гүйцэтгэдэг байна. 2013-2017 оны дундажаар Германы хүн амын 74% нь цагдаад итгэж байв. Гэтэл эмч болон сувилагч нарт итгэх итгэл үүнээс дээгүүр байв. Хачирхалтай нь итгэлийн ийм шаталаар авч үзэхэд Өрнөдийн уламжлалт институт болох сүм хийд ба үйлдвэрчний эвлэлийн өмнө цагдаа эрэмбэлэгдсэн байна. Гэтэл телевиз болон шоу бизнесийн одууд энэ санал асуулгаар дөнгөж 20 дугаар байранд жагсан үзүүлэлтэй байна. Германд сүүлийн 50 жил орчимд төр болон түүний

¹ Johan Galtung. Small Group Theory and the Theory of International Relations. A Study In Isomorphism // New Approaches to International Relations / ed. by M. Kaplan. - N. Y., 1968. 270-295 тал

² Научно-образовательный форум по международным отношениям [Электронный ресурс]. – URL: <http://www.obraforum.ru/book/chapter1.htm> (дата обращения: 07.08.2013).



цэргийн бүтэц ба тусгай албад засаглалын хувьд хүчээр биш харин зохицол ба хамтын ажиллагаагаар дамжуулан сөрөг хүчиний идэвхтэй байр суурийг илэрхийлж байна. Үүний жишээ бол цагдаагийн өдөр тутмын дүрэмт хувцасны өөрчлөлт харуулж байгаа төдийгүй иргэний нийгмийн институтуудтэй "шинэ" харилцаа тогтоосон төдийгүй төрийн зохих албаны олон тооны зурагт хуудас хэвлэн сурталчилж байсан юм. Тэдгээрт: "бид аюулгүй байдалд амьдрахыг хүсэж байна!", "Зарим нь элсэнд толгойгоо нууж байхад, бид толгойгоо өндөрт өргөнө!", "Таны цагдаа!", "Бид аюулгүй байдалд байна!", "Зөвлөгөө: үнэ төлбөргүй, чанартай, шуурхай!" зэрэг уриалга бичигдсэн байдаг ажээ. Энэ мэтчилэн ухуулга сурталчилгааны бүхэл бүтэн үйлдвэрлэл, цэргийн алба хаагчид ба ажилтнуудын албаны философи бүтээгддэг бөгөөд байнга шинэчлэгдэн төлжиж, цаг ямагт хөгжиж байна.

Өнөө цагийн ийм хандлага өөрийн зорилгодоо хүрсэн бөгөөд ажиллагаа явуулах болон албадлагын өргөн эрх мэдлийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагуудын илэрхий сурдуулсэн (заналхийлсэн) хаяглал төдийлөн сөргөөр нөлөөлөөгүй ба германы нийгэм хуульд үйлчлэгчдийг нэг тийм "хүчиний" механизм гэж харахгүй байгаа юм. Ийм нөхцөл байдлыг германы хууль тогтоогчид болон эрдэмтэд идэвхтэй дэмжжээ.

Үүнээс гадна аюулгүй байдлыг хангах талаарх үйл ажиллагааны тухай үзэл баримтлал зохих ёсны социал (нийгмийн) технологид суурилдаг. Түүний мөн чанар нь "Бид аюулгүй байдлыг хангах үүрэгтэй, учир нь үүнийг биднээр хамгаалулж буй нийгэм хүсч байна" гэж томъёологддог. Социумын идэвхжилтийг зөвхөн иргэний хяналт төдийгүй хууль сахиулах байгууллагууд, зэвсэгт хүчин болон тусгай албадын ажлыг иргэний хяналт, оролцогоор бэхжүүлж байх ёстой.

Дээр дурдсан технологийг германы академиудад мөрддөг ба иргэний нийгмийн төлөөлөл оролцсон шинжлэх

ухаан, онол, практикийн хурал, семинар зэрэг бусад арга хэмжээнд удирдлага болгож байдаг. Тэдгээрийг боловсролын практик нийгэм-мэргэжлийн шаардлагыг боловсруулж тодотгох, удирдлагын баримт бичигт зохих өөрчлөлт ба тодотгол хийхийн тулд зохион байгуулдаг байна. Шинжлэх ухаан ба сурган хүмүүжүүлэх бүрэлдэхүүний дийлэнх болох иргэний их дээд сургуулийн багш нар, офицерууд зөвхөн тусгай хичээлүүдийг зааж, явцуу мэргэжлийн дасгал сургуулитыг явуулдаг. Өрнөд Европын олон орны цэргийн академиудад захирлын албан тушаалыг улс төрийнх гэж үздэг. Тиймээс уг албан тушаалд парламентад олонх болсон намын улс төрчийг томилдог байна. Захиргааны дур зоргын үйл ажиллагаа болон боловсон хүчиний (хүний нөөцийн) бодлогод субъективизм гарахаас сэргийлэх зорилгоор офицерүүн албан тушаалын томилгоог олон нийтийн байгууллагууд (зөвлөл)-тай зөвшилцөх ба ихэнхдээ тэдгээрийн санаачилгад тулгуурлан хийдэг байна.

Өрнөд Европын орнуудад асуудлыг мөрдөн шалгах хараат бус комиссыг түүний дотор аюулгүй байдлын хүрээнд байгуулж ажиллуулдаг практик өргөнөөр хэрэглэгддэг. Тэдгээрийг парламент, төрийн засаглал, олон нийтийн байгууллага зэргээс байгуулж болдог. Комиссууд нь өөрийн ажлаа уламжлалт хууль зүйн ойлголтын дагуу мөрдөн шалгах аргаар бус төрийн институтуудийн дотор бугласан дутагдал доголдлыг илрүүлэх замаар хэрэгжүүлдэг байна. Энэ үйл ажиллагааны үндсэн зорилго бол практик ажлын явцад илрүүлсэн дутагдал доголдлыг арилгах талаар зөвлөмж боловсруулахад оршино. Хараат бус комиссууд нь бие даан гэм буруутныг хариуцлага хүлээлгэх болон хууль зүйн хувьд мөрдөн шалгаж, тодорхой этгээдийг шийтгэх эрх хэмжээ байдаггүй.

Эдгээр институтуудийн эрх хэмжээний хүрээ хязгаарт гол төлөв аль нэг институтийн албан үүргийн алдагдалд ерөнхий мониторинг хийх, мэдээлэл



ба баримт бичиг шаардах, гэрчийн этгээдүүдийн санал асуулга ба байцаалт авах, хамтарсан хурлын сонсгол, хэлэлцүүлэг хийх, нийтлэг санал болол болон зөвлөмж боловсруулах асуудал багтах ба тэдгээр нь судалж буй асуудлын талаар боловсруулах тайлангийн үндэс болдог байна.

Янз бүрийн төр улсуудад хараат бус комиссууд өөр өөрсдийн өвөрмөц онцлогтой байдаг. Гэхдээ хэд хэдэн нийтлэг онцлог буй. Үүнд:

- Хэрэв комиссыг төрийн эрх бүхий байгууллагаас бүрдүүлсэн бол тэр нь төрийн ямар ч түвшинд захирагддаггүй ба өөрийн эрх хэмжээг хараат бус байдлаар хэрэгжүүлдэг;
- Санхүүжилтийг хатуу тогтоосон нийлбэрээр төсвийн хөрөнгөнөөс хийнэ;
- Мандатад ажлын цаг, эрх хэмжээний объект-субъектийн хүрээ, асуудал, оролцогч этгээдүүд, байгууллагууд тодорхойлогоно;
- Бүх үйл ажиллагаа нийтийн шинжтэй;
- Боловсруулсан санал, зөвлөмж, ажиглалт, сануулгыг хэрэгжүүлэх ажлыг өөрийн эрх мэдлийн хүрээнд комиссыг томилсон байгууллага гүйцэтгэнэ.

Хараат бус комиссыг байгуулах үндсэн зорилго бол түүний асуудлыг сайтар мэддэг, нэр хүндтэй мэргэжилтнүүдээр бүрдүүлэх явдал юм. Харин аюулгүй байдлын асуудлын тухайд бол энэ комисст хуучин өндөр албан тушаалд ажиллаж байсан цэргийнхэн, хууль сахиулах байгууллагын эсхүл тусгай албадын ажилтнууд болон янз бүрийн улс төрийн намын төлөөлөл ба хуульчдыг оруулж болдог байна.

Уг комисс нь өөрийн үйл ажиллагаанд тухайн судалж буй институтийн дотор ажилладаг, байгууллагынхаа соготой тал, гэм буруутай этгээдүүдийг мэддэг, ёс суртахууны хувьд эл байдалтай зохицдоггүй, мөрдөн шалгах ажиллагаатай

хамтран ажиллахаар сэтгэл шулуудсан сайн дурын мэдээлэгчдэд тулгуурладаг. Ийм ажилтнууд нь өөрийнхөө өгсөн мэдээллийн сөрөг үр дагаврыг төлөөлж байгаа тул европын орнуудад хууль зүйн хувьд тэднийг хангалттай сайн хамгаалсан байдаг.

Онолын асуудлыг шинжлээд хэлэхэд европын орнуудад иргэний нийгэм нэг талаасаа салан тусгаарлагчдын хохирогч, мөн тэдгээртэй хийх тэмцлийн арга хэлбэрийн золиос болдог субъект-объектын байр суурийн онцлогийг ойлгох хэрэгтэй. АНУ ба Израилийн дараа Европын орнууд терроризмтай тэмцэх тухай хууль тогтоомжоо чангатгаж байна. Үүний зэрэгцээ зарим санал санаачилгүүд нь шууд утгаараа Дундад зуун руу эргэн буцах хандлага ажиглагдах болов. 2007 оны 7 сард Лондонгийн метронд болсон дэлбэрэлтийн дараа парламентын хэлэлцүүлэгт хуулийн төсөл оруулсан бөгөөд түүнд террорист ажиллагаанд сэжиглэгдэж буй этгээдийг тамлан зовоох аргын хэрэглэж болохоор тусгасан байна. Британий олон нийт болон шинжээчид мөрдөн шалгах ажиллагаанд тэр тусмаа үндэсний аюулгүй байдлын эрх ашиг хөндөгдсөн байлаа ч гэсэн хүчирхийллийн арга хэлбэрийг хориглосон олон улсын эрх зүйн үндсэн хэм хэмжээг хамгаалан зогсож чадсан юм. Энэ тохиолдолд иргэд эрх баригчдыг терроризмын эсрэг зогсох чадваргүй хэмээн буруутгаж, нийгмийн гишүүдийн эрх, эрх чөлөөнд заналхийлж хэрхэвч болохгүй болохыг тэмдэглээд, цаашдаа өөр илүү оновчтой ба үр дүнтэй арга хандлагыг хэрэглэх нь зохистой гэж үзжээ.

Ардчилсан орнууд дахь иргэний нийгэм терроризмын эсрэг арга хэмжээ хэрэгжүүлэхдээ мэдээж хэрэг өөрөө өөртөө хяналт тавих шаардлагатай гэдгийг ойлгож байгаа. Гэхдээ иргэний нийгэм нь хүний эрх, эрх чөлөөг хангах талаасаа төрийн хяналтын субъект болдог онцлогтой. Үүгээр дамжуулан нийгмийн байгууламжийн баталгаа байх өөрийн нэг үндсэн үүргээ иргэний нийгэм биелүүлдэг.



Үүний зэрэгцээ ардчилсан нийгэмд террорист аюул заналаас хамгаалахын сацуу иргэдийн эрхийг хамгаалах талаар санаа тавих шаардлагатай болдог.

Өрнөдийн орнуудын терроризмын эсрэг тогтолцоонд олон нийтийн хараат бус мэдээллийн хэрэгсэл болох иргэний нийгмийн институт хоёрдмол байр суурьтай байдаг. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагаан дахь диалектик зөрчил нь террорист аюул заналыг урьдчилан сэргийлэх чанартай тул террорист үйл ажиллагааны улмаас хүн амын дунд айдас ба сандралыг (энэ нь террористуудын үндсэн зорилго байдаг) төрүүлэхтэй нийцэмжгүй байдал үүсдэг. Тиймээс европын зарим оронд салан тусгаарлах илрэлтэй холбоотой зарим асуудлыг нийтэд дэлгэрүүлэх тал дээр мэдээллийн аюулгүй байдлын нэг бүрдэл хэсэгт хамааруулан тодорхой хязгаар тавьдаг байна. Энэ талаас нь авч үзвэл ардчилсан орон бүр уг хэлэх, хэвлэн нийтлэх, мэдээллийг түгээх, эрх чөлөө болон тэдгээрийг хянах ба хэмжээ хязгаар тогтоо шаардлагын хооронд тэнцвэртэй харьцаа барих хэрэгтэй болдог.

Терроризм өөрийн мөн чанарын хувьд улс төрийн үзэгдэл учраас иргэний нийгэмд засаглалын чадваргүй ба сул талыг харуулж, иргэний нийгэм ба засаглалын хоорондын хамтын ажиллагаа, зөвшилцлийн үндсийг нураахыг эрмэлздэг. Энэ нь эргээд улс төр, сэтгэл зүйн зөрчилдөөний шинжтэй болж хувирдаг. Энэ тохиолдолд эсрэг этгээдээ сэтгэл зүйн хувьд давамгайлах нь тэдний үйл ажиллагааны тулгуур болдог байна. Европ дахь иргэний нийгмийн нэг институт болох шашны байгууллагын уламжлалт хүчтэй байр суурь хүн амын эв нэгдлийг хангахад дөхөм үзүүлдгээрээ үндэсний аюулгүй байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Өнөө үед шашин сүм хийдийн чухал (хэрэгцээтэй) тал нь аюулгүй байдлын асуудлын эргэн тойронд иргэдийн аюултай талцлыг үүсгэхгүй, террористуудын ухамсыг саармагжуулах хялбар дөхөм

арга хэлбэрийг олж, терроризмын хохирогч, түүнд өртөгч этгээд, ойр дотныхноо алдсан хүмүүсийг сэтгэл зүйн арга хэрэгслээр нөхөн сэргээхэд оршиж байна.

Сүүлийн хорин жилд нэгдсэн Европ хамтын аюулгүй байдлын цогц асуудалтай тулгараад байгаа бөгөөд энэ салбарт төрийн оролцоо улам бүр хумигдах болжээ. Үүнд:

- Нөөцийг бэлтгэн нийлүүлэгчдээс эрчим хүчиний хамаарлтай байгаа нь түүнийг багасгах зах зээлийн механизмыг төгөлдөржүүлэх, өөр сонголттой эх үүсвэрийг эрэлхийлэх шаардлага бий болов;
- Тивийн экологи муудаж байгаа нь олон нийтийн (нийгмийн) савалгааг урьдчилан тодорхойлж, "ногоонтон"-ны нэр хүндийг өсгэн, төрийн болон орон нутгийн парламентад тэдний төлөөллийг нэмэгдүүлэх хандлага ажиглагдаж байна;
- 2008-2009 оны дэлхийн эдийн засгийн хямралевропын санхүүгийн тогтолцооны хөдөлбөргүй байдлыг бусниулж, дэлхийн эдийн засгаас хэт хамаарлтай болгон, олон нийтийн санал бодлын нөлөөлөл дор аюулгүй байдлын бүхэл бүтэн салбаруудын зах зээлийн механизм юуны өмнө төрийн ашиг сонирхлыг бус харин өрсөлдөөний үр ашиг ба үнийн бодлогын чанараараа улам бүр арилжааны болж хөрвөх чадвартай;

Хуучин ЗСБНХУ-ын орнуудад "өнгөт" хувьсгал, Хойд Африкийн болон Ойрхи Дорнодын эрх баригчдын халаа солиог дагуулсан иргэний дайн, Газрын дундад тэнгисийн зүүн хойд хэсгийн улс төрийн тогтвортгүй байдал зэрэг бол Европын холбоонд геополитикийн шууд аюул занал учруулж, АНУ-ын бус нутагт баримтлах улс төрийн бодлогын дэмжлэгийг хүлээж ирсэн, төвийг сахисан дэглэмүүдэд найдвар хүлээлгэсэн европын дипломатын сүйрлийг харуулав.



Дээр дурдсан учир шалтгаан болон аюулгүй байдлын обьектуудын орон зай, нутаг дэвсгэрийн болон үндэстэн дамнасан шинж төлөв нь аюулгүй байдлыг хангах талаарх судалгааг чанаржуулан өргөтгөхийг шаардаж байгаа юм. Өнөө үед европын эрдэмтэд, судлаачид хэд хэдэн үзэл баримтлалыг боловсруулаад байгаа бөгөөд тэдгээрт үндэсний болон хамтын аюулгүй байдлын тогтолцоо бий болгохыг санал болгосон байна.

Үндэстэн дамнасан сүлжээний онолыг американын улс төр судлаач Р.Кеохана и Дж. Ная нар бүтээлүүддээ үргэлжлүүлж байгаа бөгөөд тэр нь "үндэстэн төр дамнасан ментализм" (*transgovernmentalism*)³-ийн онолд үндэслэгдэг байна. Уг онолын агуулга нь аюулгүй байдлын асуудлыг шийдвэрлэхэд иргэний нийгмийг идэвхжүүлэх бус харин засгийн газрын дэд нэгжүүдийг байгуулан, тэдгээрийн хооронд зайлшгүй шаардлагатай харилцааг тогтооход төвлөрдөг байна. Ингэхдээ тэдгээр нь хоорондоо бие биенээсээ үл хамаарч, гүйцэтгэх засаглалын зүгээс аливаа хяналтгүй байх учиртай⁴.

Дараагийн үзэл баримтлал нь иргэдийг хамгаалах үндсэн субъект бол төр байдаг гэсэн уламжлалт реалист ойлголтоос ялгаатай нь "аюулгүй байдлын салбар дахь шүүмжлэлт судалгаа" (*Critical Security Studies*) нэрийн дор шинжлэх ухааны эргэлтэд орж ирсэн юм. Америкийн сургуулийн шүүмжлэлийн зангилаа цэг нь юуны өмнө аюулгүй байдлын тогтолцоонд цэргийн хүчиний давамгайллыг үгүйсгэн, эдийн засаг, нийгэм, экологийн тал дээр төвлөрүүлдэгт байгаа юм.

1990-ээд оны эхээр франкфуртын (Т.Адорно, Ю.Хабермас зэрэг), боловсруулалт дээр тулгуурлан К.Бут

"дарлалаас ангижруулах" (*emancipatory theory*) онолыг дэвшүүлэв. Уг онол нь бүхэлдээ Уэльсийн сургуулийг хөгжүүлсэн ба түүнд "хүч", "дэг журам" уламжлалт ухагдахуунууд хуучирч үеэ өнгөрөөсөн гэж үзээд, нэг обьектын аюулгүй байдал гэдэг бол ямагт нөгөөгийн хамгаалагдаагүй байдал гэжээ. Тиймээс аюулгүй байдлын өргөн хүрээний чиглэлд судалгаа хийж, түүний төвд төрийг бус харин хувь хүнийг тавихыг ойлгоход оршино. 2007 онд К.Бут өөрийн суурь бүтээл "*Theory of World Security*"-ээ олон нийтэд толилуулсан байна. Өнөө үед уг онол дарлалаас ангижруулах онолын гол шугам гэж тооцогддог. Тэрхүү онолын үндсэн үзэл санаа нь ертөнцийн "космополитизм" ба ардчилалд тулгуурласан аюулгүй байдлын дэлхий дахини тогтолцоог бий болгоход оршино. Үүнийг "дайн ба хувьсгал"-ын замаар хэрэгжүүлэх боломжгүй⁵.

Нэгдсэн Европ дэлхий даяар бусад орнуудаас олон талаар ялгаатай аюулгүй байдлын асуудлаар иргэний нийгэмтэй харилцах арга замыг хэрэгжүүлж байдаг. 1952 онд байгуулагдсан ардчиллын үндэстэн дамнасан төлөөллийн хэлбэр болсон Европарламент угтаа европын иргэний нийгмийн идэвхтэй, нэр хүнд бүхий институт юм. Түүний эрх хэмжээ хангалттай өргөн хүрээтэй тогтоогдсон байдаг. Тухайлбал Европын комисст хяналт тавих, хууль тогтоомжийн хяналт, европын аюулгүй байдлын улс төрийн бодлогын хүрээний санхүүжилтэд хяналт тавих зэрэг эрх хэмжээг эдэлдэг байна. Түүнээс гадна европын парламентын гишүүд мөрдөн шалгах болон хяналт шалгалт хийх үүрэгтэй байдаг. Өнөө үед уг байгууллагын бүрэлдэхүүнд оролцогч орнуудын улс төрийн намуудын 751

³ Simon Hollis. The necessity of protection: Transgovernmental networks and EU security governance [Электронный ресурс] // Cooperation and Conflict. - 2010. - Vol. 45, issue 3. - P. 312-330. - URL: http://journals.ohiolink.edu/ejc/article.cgi?issn=00108367&issue=v45i0003&article=312_tnoptnaesg (дата обращения: 19.08.2013).

⁴ Rita Floyd & Stuart Croft. European non-traditional security theory. EU GRASP Working Paper N1, February 2010. Seventh Framework Programme [Электронный ресурс]. - URL: <http://www.eugrasp.eu/wp1-european-non-traditional-security-theory-by-rita-floyd-stuart-croft> (дата обращения: 19.08.2013).

⁵ Rita Floyd & Stuart Croft. European non-traditional security theory. EU GRASP Working Paper N1, February 2010. Seventh Framework Programme [Электронный ресурс]. - URL: <http://www.eugrasp.eu/wp1-european-non-traditional-security-theory-by-rita-floyd-stuart-croft> (дата обращения: 19.08.2013).



төлөөлөгч ба хэд хэдэн нам төлөөлөл ордог байна⁶.

Өrnөd Европын орнуудын үндэсний парламентын үйл ажиллагааны хувьд иргэний нийгэм ба засаглалын байгууллагуудын хооронд зуучлах үүрэг илэрхий хардаж байдаг. Европын орнуудад парламент нь аюулгүй байдлыг хангах чухал асуудлаар нийтийн хэлэлцүүлэг явуулах хамгийн тохиromжтой газар юм. Үүний зэрэгцээ олон оронд парламентын хяналт чанарын өндөр түвшинд хүрсэн байдгаас хяналтын

үүрэг нь хууль тогтоогчдын үүргээс давах тохиопдол их ажээ.

Товч дүгнэлт болгоход аюулгүй байдлын асуудлаар төрөөс иргэний нийгэмтэй харилцах харилцаа европын орнуудад өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой байдаг. Гэхдээ эдийн засгийн боломж, аюул занал, үндэсний эрмэлзэл зэргээс үл хамааран бүх л ардчилсан орнуудад иргэний нийгэм аюулгүй байдлыг хангах чухал субъект болж байдаг.

Ашигласан материал:

1. Allgemeine Strukturen der deutschen Polizei. - Deutsche Hochschule der Polizei, 6 - .2013 s.
2. Johan Galtung. Small Group Theory and the Theory of International Relations. A Study In isomorthism // New Approaches to International Relations / ed. by M. Kaplan. - N. Y., .1968 324 - p.
3. Simon Hollis. The necessity of protection: Transgovernmental networks and EU security governance [Электронный ресурс] // Cooperation and Conflict. - 2010. - Vol. 45, issue 3. - P. 330-312. - URL: http://journals.ohiolink.edu/ejc/article.cgi?issn=00108367&issue=v45i0003&article=312_tnoptnaesg (дата обращения: 19.08.2013).
4. Rita Floyd & Stuart Croft. European non-traditional security theory. EU GRASP Working Paper No1, February 2010. Seventh Framework Programme [Электронный ресурс]. - URL: <http://www.eugrasp.eu/wp-1european-non-traditional-security-theory-by-rita-floyd-stuart-croft> (дата обращения: 19.08.2013).
5. Гасанов К. Современные европейские теории и концепции национальной безопасности [Электронный ресурс]. – URL: <http://www.csef.ru/index.php/ru/politica-i-geopolitica/project/-500nastoyashchee-i-budushchее-evropy/-1stati/4624> (дата обращения: 19.08.2013).
6. Европейский парламент [Электронный ресурс]. – URL: http://www.wikipedia.org/wiki/Европейский_парламент (дата обращения: 20.08.2013).
7. Научно-образовательный форум по международным отношениям [Электронный ресурс]. – URL: <http://www.obraforum.ru/book/chapter1.htm/> (дата обращения: 07.08.2013).

⁶ Европейский парламент [Электронный ресурс]. – URL: http://www.wikipedia.org/wiki/Европейский_парламент (дата обращения: 20.08.2013).



ТАЙВАН ЦАГТ КИБЕР БАТЛАН ХАМГААЛАХ ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЭХ АРГА ЗАМ

М.ЗОЛЗАЯА /УБХИС, ЦНС, ЦХКАБТ-ийн дарга, хурандаа/

Түлхүүр үг: Кибер орон зай, кибер домэйн, кибер хүчин, кибер цэрэг, сүлжээний тусгай ажиллагаа, мэдээлэл цуглувалт, кибер аюулгүй байдал, кибер аюулгүй байдлын төв.

Key words: Cyber space, cyber domain, cyber force, cyber soldier network special operation, collect information, cyber security, cyber security center

Оршил. Тайван цагт болон аливаа түрэмгийллийн үед "улсын зэвсэгт хүчин бол кибер батлан хамгаалах үндэсний тогтолцоог бүрдүүлэх үндсэн субъект" [i] гэж үзэж, кибер хүчнийг бүрдүүлэх, стратеги, оператив-стратегийн түвшинд кибер тэмцэл явуулах арга замыг тодорхойлох, кибер орон зай, түүний гол домэйн болсон мэдээлэл холбооны нэгдмэл орон зайг цогцоор ашиглах номлол, үзэл баримтлалыг боловсруулах зэрэг шаардлага үүссэн. Гэтэл манай улсын хувьд кибер аюулгүй байдлыг хангах онол, арга зүйн судалгаа хийгдээгүй, нэр томъёоллын хувьд төлөвшөөгүй, туршлага, сургамж хуримтлаагүй, эх хэл дээр бичигдсэн мэдээлэл хомс байна.

Тиймээс "Тайван цагт кибер батлан хамгаалах тогтолцоог бүрдүүлэх арга зам" сэдэв нь кибер орон зайг тэмцлийн 5 дахь талбар болгох, тайван цагт кибер батлан хамгаалах тогтолцоог бүрдүүлэх, түрэмгийллийн эсрэг кибер тэмцэл явуулах арга замуудыг тодорхойлоход чухал ач холбогдолтой "хамгийн хүнд, тулгамдсан, цоошинэ, зайлшгүй судлах, өргөн хүрээтэй судлагдахуун" гэж үзэж байна.

Кибер орон зай бол тэмцлийн 5 дахь талбар

Агаар, сансар, газар, тэнгисийн орон зайд явагдах цэргийн ажиллагааг кибер орон зайн домейнуудтай холбож өгснөөрөө үндэсний батлан хамгаалах бодлогыг, гол гол стратегийг, зэвсэгт тэмцлийн үйл явцыг, зэвсэглэл, техникийн хөгжлийг, улсын болон цэргийн нөөцийг,

төсөв санхүүг бүрэн хяналтандада авч, тэмцэлдэгч талын кибер орон зайд чөлөөтэй маневр хийж, зайнас удирдах зориулалт бүхий "тэмцлийн шинэ 5 дахь талбар"-ыг бий болгож байна.


Орчин үеийн дайн нь газар, агаар, тэнгис, сансрын орон зайд ерөнхий цэргийн, танкийн, агаараас эсэргүүцэх операци зэрэг зэвсэгт хүчний төрлийн цэргийн оролцоотойгоор, давших, хориглох, сөрөх давших операци гэх зэрэг цэргийн ажиллагааны төрлөөр, стратегийн, фронтын, армиин операци зэрэг зорилго, масштабаар явуулдаг байсан бол Зураг 1-д харуулсан 5 дахь орон зай буюу "кибер орон зай"-д "кибер тэмцэл"-ийг дангаар нь, эсвэл бусад орон зайн операцитай хослуулан кибер дайны хэлбэрээр кибер зэвсэг ашиглан явуулах нь "цэргийн урлаг судлал"-д гарч буй онцлох хувьсал юм.

"Кибер орон зай" гэдэг нэр томъёолыг анхудаа 1984 онд сэтгэн бодогч Вильям Гиббсон "дэлхий нийтийг хамарсан олон хэрэглэгчтэй виртуаль орчин" гэж төсөөлж, өөрийн "Нейромант" романдаа дүрслэн байдаг.

"Кибер орон зай" тодорхойлолт, түүний үйлчлэх хүрээний талаар маш олон эх сурвалж байдаг тул зарим нэгийг нь жишээ болговол:

- АНУ-ын Агаарын цэргийн "Кибер орон зай дахь операци" нэртэй баримт бичигт "кибер орон зай" гэдэг нэр томъёоллыг "интернет, харилцаа холбооны сүлжээ, компьютерын систем процессор

[1]. М.Золзаяа Кибер халдлага довтолгооноос хамгаалах судалгаа., Төслийн тайлан., 2017 он. 9-6 х



Зураг 1. Кибер орон зай бол тэмцлийн 5 дахь талбар

болон контроллеруудыг багтаасан дэд бүтэц болон мэдээллийн технологийн хоорондын харилцан хамаарал бүхий нэгдлийг илэрхийлсэн мэдээллийн орон зайн доторх кибер домэйн" гэж тодорхойлжээ [ii].

- Кибер орон зай гэдэг нь хүмүүс хоорондын мэдээлэл солилцох явцад хүний оюун санаанд нөлөөлөл үзүүлэхтэй холбогдон үүсч болох хүн, техникийн харилцааны нэгдэл.
- Английн ерөнхий сайд Гордон Браун "Бид үндэснийхээ аюулгүй байдал, үнэт зүйл, хөгжил цэцэглэлтээ XIX зуунд далайгаар, XX зуунд агаараар хамгаалдаг байсан бол ХХI зуунд бид кибер орон зайгаа хамгаалах ёстой болж байна".
- Пентагоны шинжээч Р.Банкер "цэргийн ажиллагааны театрыг уламжлалт (газар, агаар, тэнгис, сансар) болон кибер орон зайн гэсэн хоёр бүрдэл хэсэг".

Эдгээр тодорхойлолтоос нэгтгэн дүгнэхэд улс орны болон цэргийн удирдлага кибер орон зай дахь тэмцлийг уламжлалт 4 орон зайд явуулахаас гадна, кибер орон зайд "тэмцлийн 5 дахь

талбар" болохыг онцлон тэмдэглэжээ.

Кибер орон зай бол олон давхартаг бүтэцтэй, тэдгээр нь маш нарийн уялдаа холбоо, харилцан хамааралтай учраас "кибер тэмцэл"-ийн үр дүнд хэрхэн нөлөөлөх талаар судлан үзэхэд дэлхийн газар зүйн байрлалын аль ч хэсэгт цэрэг, зэвсгийн удирдлагын систем, тэдгээрийг хооронд нь холбосон мэдээлэл, холбооны систем, сүлжээний интерфейс холболтыг "кибер домэйн" [iii] гэж нэрлэх ба энэ нь хэрэглэгч, компьютер, систем, түүний програм, өгөгдөл, мэдээллийн физик болон логик уялдаа холбоог харуулдаг. Кибер домэйн нь сүлжээнд холбогдсон компютераас хамаагүй их тоон угтатай бөгөөд домэйн нь компьютерт холбогдсон физик системээс бүрддэг.

Кибер домэйн нь **нэгд**, хэрэглэгчтэй, **хоёрт**, тэднийг техник хэрэгслийн интерфэйстэй, **гуравт**, интерфейсээр дамжин техник, програм хангамж, системийн логиктой, **дөрөвт**, логик угтатай өгөгдөл, холбоо мэдээллийн сүлжээ, системтэй, **тавд**, газар зүйн байрлалын хувьд улс орон, бус нутагтай техникийн зарчмаар байгуулалтыг үүсгэж, харилцан холбогдсон кибер орон зайн давхаргуудын нийлмэл цогц [iv] гэдгийг

- [2]. Joint Publication 12-3 (R). Cyberspace Operations., Cyberspace., 2013 он. 18-16x
- [3]. <https://www.usna.edu/CyberDept/sy110/lec/crsIntro/lec.html-Cyber Battlefield/Introduction to the Cyber Domain>.
- [4]. FM12-3. Cyberspace and electronic warfare operations. Cyberspace and the information environment., Cyberspace layers., 2017 он. 24-22x.



Хүснэгт 1. Кибер орон зайн давхарга

	Хэрэглэгч нь кибер домэйныг удирдах, хэрэглэх хүмүүс.
	Интерфейс нь хэрэглэгчийг кибер домэйн дахь бусад бүрэлдэхүүн хэсгүүдтэй харилцан холбож ажилладаг техник, програм хангамжууд.
	Логик давхарга нь кибер домэйнд дотор хадгалагдаж байгаа эсвэл боловсруулагдаж байгаа тоон өгөгдлүүд. (виртуаль орон зайд)
	Физик давхарга нь систем, сүлжээнд хадгалсан мэдээлэл, өгөгдлүүдийг дамжуулахад зориулагдсан мэдээлэл холбооны сүлжээ, төхөөрөмжүүдийн нэгдэл, системүүд.
	Газар зүйн байрлал нь хэрэглэгч, систем, эсвэл мэдээлэл дамжих зам, орц, гарц. Газар зүйн байршил нь байгалийн хил хязгаар, геополитикийн хил хязгаар болох улс орныг ялгах зориулалттай тусгаарлах шугам, тэдгээрийн байршил.

Хүснэгт 1-ээр харуулав.

Хэрэглэгч, интерфейс, логик болон физик давхарга, газар зүйн байрлал хоорондын харилцан уялдааг тодорхойлдог бөгөөд эдгээр нь дээрээсээ дооших эсвэл доороосоо дээших давхрагатайгаа харилцан холболт үүсгэдэг. Кибер домэйн нь улс орныг бүхэлд нь хамардаг учраас ажиллагааны талбар, ажиллагааны болон хариуцлагын бүсүүдэд хуваарилагдаж, сүлжээг физик болон логик зарчимаар байгуулж, хүн техникийн харилцан холбоо, тэдгээрийн хооронд үүсэх интерфейсийг кибер орон зайд дахь давхарга бүр дээр авч үздэг.

Улс орнууд зэвсэгт тэмцлийг харилцан уялдаа бүхий ажиллагааны дөрвөн талбар дээр явуулж, хүчний, байрлалын, шийдвэрийн, мэдээллийн, ухамсар сэтгэлгээний давуу талыг олж авна[в] гэдгийг Зураг 2-оор [v] харууллаа.

1. Бодит ажиллагааны талбар бол байлдааны ажиллагааны театр буюу тэнгис далай, хуурай газар, агаар, сансрын орон зайд хиймэл дагуул, байлдааны нэгж, дэлхийн болон улс орны компьютер, мэдээллийн сүлжээг дэлгэн байгуулах бодит ажиллагааны орон зайд бөгөөд хүчний болон байрлалын давуу талтай байх боломжтой.

2. Мэдээллийн ажиллагааны талбар

Бол мэдээллийг олзлох, боловсруулах, хуваарилах орон зайд, мэдээлэл, мэдээллийн дэд бүтэц, мэдээллийг цуглуулах, бий болгох, тархаах, ашиглах үйл явцыг хэрэгжүүлэгч субъект болно. Энэ талбар нь эдийн засаг, улс төр, батлан хамгаалах болон бусад үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүнд идэвхтэй нөлөөлдөг. Энэ талбар нь дайн, зэвсэгт тэмцлийн бүх үе шаттай нягт холбогддог, ажиллагааны тэргүүлэх талбар бөгөөд мэдээллийн давуу талыг бий болгодог.


3. Танин мэдэхүйн ажиллагааны талбар

Бол цэрэг дайчдын ухамсар, сэтгэл зүйн орон зайд юм. Дайн байлдаан, зэвсэгт тэмцлийн ялалт амжилт нь энэ талбар дээр өрнөдөг. Ялангуяа танин мэдэхүйн талбар бол захирагчийн баримтлах ажиллагааны бодлого, номпол, үзэл баримтлал, тактик, арга техник, үйл ажиллагаатай нягт холбоотой ба ухамсар, сэтгэлгээнээс хамаардаг.

4. Нийгмийн ажиллагааны талбар

Бол дэлхийн мэдээллийн сүлжээнд холбогдсон хүн бүр харилцан ажиллах орон зайд юм. Энд түүх, соёл, урлаг, шашны үнэ цэнэ, сэтгэл санааны байдал, ёс зүйн онцлогийг нээн харуулж

[5]. http://www.ofc.osd.mil/library/library_files/document_387_NCW_Book_LowRes.pdf.



Зураг 2. Кибер орон зайн дахь ажиллагааны талбарууд

хүмүүсийн хоорондын харилцааг харуулдаг. Нийгмийн ажиллагааны талбарын эерэг тал нь хүн өөрөө нийгмийн харилцааг удирддаг гол субъект нь бөгөөд тухайн улс орны дэд бүтцийн боломжийг ашиглах чадварыг эзэмшсэн байдгаараа онцлог бөгөөд нэгдсэн шийдвэрийн давуу байдлыг дэмждэгт оршино. Эдгээр давуу талууд нь агаар, сансар, газар, тэнгис болон кибер орон зайд явагдах тэмцлийн бодлого, түүний шийдвэр гаргалт, технологи, түүний ажиллагааны арга, нэвтрэх боломж, хурд, түүнийг хэрэгжүүлэх хүчиний чадавхаар тодорхойлогдоно.

Ажиллагааны талбар дээр хүн бүр өөрийн гэсэн кибер орон зйттай, улс бүр кибер тэмцэл явуулах ажиллагааны хариуцлагын бүсүүдтэй байна гэдгийг

зураг 3-аар харуулав.

Улс орон бүр өөрийн болон бусдын эжиллагааны хариуцлагын бүсэд тэмцлийг зохион байгуулж, явуулахад "мэдээлэл, колбооны нэгдмэл орон зай" онцгой үүрэгтэй. Мэдээлэл, холбооны нэгдмэл эрон зай гэдгийг кибер орон зайн бүх давхаргуудад мэдээллийн нөөцийг бүрдүүлэх, хэрэглэх, хамгаалах ерөнхий журмаар зохицуулагдсан, мэдээллийг илэрхийлэх нэгдсэн стандарттай нийцсэн, сүлжээнд хандах эрх нь баталгаажсан, сүлжих, замчлах, үйлчилгээний эрхүүд нь элгогдсон мэдээлэл, холбооны систем, сүлжээний техник технологи, програм хангамжийн нэгдмэл орчин [vi] гэж ойлгож болно.

Дэлхийн болон бус нутгийн хэмжээний холбоо, мэдээллийн нэгдмэл орон зай нь кибер тэмцлийг явуулах үндсэн талбар болохын хувьд "тусгай зориулалтын сүлжээ"-г дэлгэн байгуулж, автомат болон зайнаас удирдах ажиллагааны горимуудтой холбоо, автоматжуулсан системүүд, радиоэлектрон тэмцлийн болон тагнуулын цогцолборууд, төрөл бүрийн зориулалтын роботжуулсан техник, нисгэгчгүй нисэх аппаратыг удирдаж, зэвсэглэл техникийн, мэдрэгч - хүлээн авагчийн болон цэргийн технологийн давуу байдлыг удирдлагын сүлжээ, хөнөөлийн хэрэгслийн сүлжээ, мэдээллийн сүлжээгээр харуулахад чиглэгдэж байна.

Кибер орон зайл кибер тэмцэлд хэрэглэхийн эцсийн зорилго бол мэдээллээр давамгайлан, чөлөөтэй



Зураг 3. Кибер ажиллагааны хариуцлагын бус

[6]. https://en.wikipedia.org/wiki/Global_Information_Grid



маневрлаж, кибер зэвсэг ашиглан цохилт өгөх явдал юм^[vii].

Кибер орон зайд мэдээллээр давамгайлах нь тэмцэлдэгч талд ижил тэнцүү ажиллагаа явуулах боломжуудыг олгохгүй байхад, чөлөөтэй маневрлах нь өөрийн болон тэмцэлдэгч талын тусгай зориулалтын сүлжээг операцийн зорилгод ашиглах боломжтой байлгахад, кибер зэвсэг ашиглан цохилт өгөх нь тэмцэлдэгч талаа бүрэн хяналтандaa байлгаж, чөлөөтэй удирдахад оршиж байна.

Төр болон цэргийн удирдлага сайтар боловсорсон кибер хүч, арга технологи, зөв бодлого, оновчтой шийдвэрээр хэрэгзэтэй, ач холбогдолтой, үнэ цэнэтэй мэдээллийг үндэсний баялаг болгосноор кибер орон зайд мэдээллийн давамгайлалтай болж ингэснээрээ үндэснийхээ аюулгүй байдлын гадаад дотоод орчныг баталгаажуулах боломж бүрдэнэ гэж дүгнэж болно.

Хоёр. Тайван цагт кибер батлан хамгаалах тогтолцоог бүрдүүлэх арга зам

Кибер аюулгүй байдлын цагийн байдал минут секундээр өөрчлөгдөж, кибер аюулгүй байдлыг стандарт аргаар хангах боломжгүй боллоо; кибер довтолгоог зохион байгуулалттай, тодорхой зорилготой, төр, тагнуулын байгууллагын оролцоотой хийх боллоо; интернэтэд холбогдсон л бол кибер халдлагын бай болох нь тодорхой боллоо; кибер зэвсэг хэрэгсэл улам боловсронгуй болж байна; улс орнууд нөхцөл байдалдаа тохируулан бодлого, стратеги, эрх зүйгээ өөрчилж байна; кибер аюулгүй байдлаа хангах зорилгоор их хэмжээний төсвийг боловсон хүчин бэлтгэх, техник, технологи бий болгоход ихээхэн хүч зарцуулж байна^[viii]. Тиймээс л улс орнууд "кибер аюулгүй байдлыг хангах үндсэн арга зам

бол улс орны батлан хамгаалах хүчин чадлаа нэмэгдүүлэх зорилготой кибер батлан хамгаалах тогтолцоо бүрдүүлэх явдал юм" үзэж, түүнийг хэрэгжилтийг хангах кибер бодлого, стратеги, үзэл баримтлалуудыг боловсруулан гаргаж, батлан хамгаалах салбарын үндсэн зэвсэглэл техникийг холбоо, мэдээллийн технологиудтай хослуулан ашиглахад чиглэсэн арга хэмжээнүүдийг цогцоор шийдэх арга замуудыг тодорхойлж байна.

Кибер батлан хамгаалах тогтолцоо гэдгийг кибер орон зайд өөрийн улс орны ашиг сонирхлыг хамгаалахад чиглэсэн зохион байгуулалттай арга хэмжээний нэгдэл.

Улс орны кибер батлан хамгаалах арга хэмжээнд кибер бүтээн байгуулалт; интернетийн эрх чөлөө; оюуны өмчийн хамгаалалт; интернет засаглал; цахим мэдээллийн нууцлал аюулгүй байдал; байгууллага хоорондын хамтын ажиллагаа; мэдээллийг хамtran эзэмшилт; кибер тэмцэл явуулах арга хэрэгсэл; терроризм, кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэрэгслүүд зэрэг багтдаг. Энэ чиглэлд улс орнууд түүний дотор АНУ, Герман, Европын холбоо, НАТО болон бусад улс орнууд хамtran ажиллаж, өргөн цар хүрээтэй судалгааг явуулж байна. Үүнд:

- төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд үндэсний кибер орон зайдгаа сайжруулахад чиглэсэн нэгдмэл ойлголтыг бий болгох;
- улс хоорондын хамтын ажиллагаа ба мэдээллийг хамtran эзэмших^[ix];
- кибер стратеги болон бодлогыг хөгжүүлэх;
- кибер гэмт хэргийг илрүүлэх ба тэмцэх;
- үндэсний гол дэд бүтцийг хамгаалахад зорилготой кибер аюулгүй байдлын төлөв байдлыг тодорхойлох, хөгжүүлэх;
- кибер довтолгоог илрүүлэх болон

[7]. FM12-3. Cyberspace and electronic warfare operations. Operations and the Cyberspace Domain., 2017 он. 15-13х.

[8]. Төрийн холбооны газрын ерөнхий инженер Ширбазар.С. "Мэдээллийн аюулгүй байдлын Монгол Улс болон олон улс дахь нөхцөл байдал" ЭШХ-ын илтэл. 2014

[9]. Йоханнесбургийн зарчим "Үндэсний аюулгүй байдал, Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө болон мэдээлэл хүртэх тухай". Лондон, 1995



- хор уршигийг бууруулахад хамтын ажиллагааны арга хэмжээнүүдийг танин тогтоох;
- мэдээллийн болон кибер технологийн хувийн секторын үүргийг нэмэгдүүлэх гэх мэт.

Кибер батлан хамгаалах тогтолцоо нь **нэгдгүүрээрт**, кибер орон зайд кибер хүчээр кибер дайныг явуулах кибер стратегийн үндсийг бүрдүүлэх; **хоёрдугаарт**, кибер болон мэдээллийн дайн, тэдгээрийн аюулгүй байдлын хоорондын ялгааг таних; **гуравдугаарт**, кибер халдлага, довтолгооны үед учрах аюулыг ойлгох, кибер эмзэг байдлыг ашиглан кибер халдлага, довтолгоог явуулах арга замуудад сонголт хийх; **дөрөвдүүрээрт**, кибер довтолгоонд хариу өгөх кибер хүч, хэрэгслийг бий болгоход оршино.

Кибер батлан хамгаалах аюулгүй, найдвартай, уян хатан тогтолцоог бүрдүүлэхийн тулд Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн Газар, хууль, шүүх, тагнуул, дотоод хэрэг, батлан хамгаалах, аюулгүй байдлын, олон нийтийн болон хувийн хэвшлийн байгууллагуудыг үүрэгжүүлэх, кибер хамтын ажиллагаагаа нэгтгэх, кибер хамгаалалтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, хууль эрх зүй, бодлого, технологийг боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэх, кибер халдлага, довтолгоо, түүний учруулах аюулын эсрэг тэмцэх чадамжтай кибер ажиллагааны нэгжүүдийг шинээр байгуулах, төлөвшүүлэх, кибер ажиллагааны бодит өмнөх сургамжуудаас суралцах, олон улсын байгууллагуудтай мэдээлэл солилцох хамтран ажиллах, өндөр мэргэжсэн боловсон хүчинүүдийг сургах, хүч хэрэгслийг болзошгүй ажиллагаанд бэлэн байлгах, кибераюулгүй байдлыг хангах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх арга замуудыг тодорхойлох шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Кибер аюулгүй байдлыг хангахад үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд кибер орон зайгаа хамгаалах, Үндэсний

стратегийг бодлоготойгоор хөгжүүлэх, хангах, кибер аюул заналаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, илрүүлэх, хариу өгөх, сэргээн босгоход чиглэсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үүрэг, хариуцлагууд ногдох болсон

Улс орон, байгууллага, хувь хүний мэдээлэл оршиж байгаа кибер орон зайд хамгаалахын тулд бодлого, үзэл баримтлал, стратеги, тэмцэл явуулах болон хамгаалах арга замуудыг судлан өөрийн улс орныг кибер түрэмгийллэс хамгаалах арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг хангах, боломжит арга, хэрэгслүүдийг бий болгох явдал улс орнуудын нэн тулгамдсан зорилт болж байна.

Кибер аюулгүй байдлын стратегитай улс орнуудын 133 буюу 67% нь түүний дотор үндэсний стратеги - 36, иргэн цэргийн - 8, иргэний - 66, зөвхөн цэргийн - 23, бодлого, стратегиа сонгоогүй-64 буюу 33% нь байна. Манай улсын хувьд кибер аюулгүй байдлын бодлого, стратегиа сонгоогүй байгаа нь цэргийн түрэмгийллийн үед кибер тэмцэл явуулах боломж, кибер аюулгүй байдлаа хангах шалгуур, шаардлагыг үнэлэхэд ч хүндрэлтэй нөхцөл байдалтай байна гэж дүгнэж байна.

Үндэсний кибер стратеги бол зарчмын хувьд эрсдэлд сууринласан, ирээдүйд чиглэсэн, урьдчилан таамагласан, практикаар шалгагдсан, харилцан хамааралтай байх ёстой гэдэг ч гадаадын зарим улсын бодлого, стратеги, кибер халдлага довтолгооны туршлага, сургамжаас хараад улс төрийн сэдэл, зорилготой халдлага, довтолгоо 80 орчим хувийг эзэлж байна. Энэ байдлаас дүгнэлт хийхэд нийгмийн ажиллагааны талбарт зонхилох хандлага байгааг илтгэж байна.

Улс орны мэдээллийн дэд бүтэц бол үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах тогтолцооны үндсэн объект бөгөөд түүний чухал бүрэлдэхүүн хэсэг нь мэдээлэл, холбооны техник, технологи юм. Өнөөдөр дэлхийн улсууд мэдээлэл, холбооны технологийг үндэсний



хэмжээний ашиг сонирхлын хэрэгсэл болгож кибер орон зайд мэдээллээр давамгайлах, үнэ цэнэтэй мэдээллийг эзэмших, сүлжээнд төвлөрсөн ажиллагааг зайнас хэрэгжүүлэх, кибер хамгаалах хэрэгсэл болгохи н зэрэгцээ шаардлагатай тохиолдолд кибер тэмцлийн хэрэгсэл болгон ашиглаж байгаа нь даян дэлхийн, улс үндэстний гол чухал дэд бүтцэд шинэ төрлийн аюулыг бий болгож байна[х].

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд "Мэдээллийн салбарт үндэсний ашиг сонирхлыг хамгаалах, төр, иргэн, хувийн хэвшил, хувь хүний мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулах нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэс мөн"[xi] гэж тодорхойлсон нь улс орон, тэр тусмаа батлан хамгаалах салбарт мэдээллийн аюулгүй байдлыг хангах, кибер довтолгооноос урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариу арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг хангах онц чухал үүрэг тавигдаж байна. Гадаад, дотоодын хэд хэдэн байгууллагын судалгаанд Монгол Улсыг кибер халдлага, довтолгоонд өртөх магадлалтай, мэдээллийн систем нь эмзэг өртөмтгийг байдалтай" [xii] гэж дүгнэжээ.

Улсын батлан хамгаалах салбарын кибер аюулгүй байдал эмзэг өртөмтгийг байгаа нь аюулгүй байдлаа хангах бодлого дутмаг, кибер аюулгүй байдлыг хангахад чиглэсэнурьдчилан сэргийлэх, хоршгийг бууруулах, хариу өгөх, сэргээн босгоход чиглэсэн бодлого байхгүй, бүтэц, зохион байгуулалтын нэгжүүдийг бий болгосон ч үйл ажиллагаа нь тогтвортжуулаагүй; довтолгоо, хамгаалалтын техник, технологи, програм хангамж байхгүй; мэргэжилтэн дутмаг, сургагдаагүй, кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа нь цоо шинээр яригдаж байгаатай шууд холбоотой.

Кибер аюулгүй байдлын үнэлгээг

тогтоож, индексжүүлэх зорилгоор **Нэг.** кибер аюулгүй байдлын талбарт эрх зүйн хэм хэмжээ, тэдгээрийн биелэлт; **Хоёр.** техникийн арга хэмжээ, түүний хэрэгжилтийг холбогдох арга хэрэгслээр хангах; **Гурав.** кибер аюулгүй байдлын талбар дахь зохион байгуулалтын арга хэмжээ; **Дөрөв.** кибер аюулгүй байдлын чадавхийн хөгжүүлэлт; **Тав.** кибер аюулгүй байдлын олон улсын хамтын ажиллагаа, түүний хэрэгжилт [xiii] гэсэн 5 шалгуур үзүүлэлтээр улс орнуудыг 2018 онд үнэлхэд кибер аюулгүй байдлын индексээрээ 0.22 байж, 104 дүгээр байр эзэлсэн байна.

Үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах чадавхыг нэмэгдүүлэх зорилготой кибер аюулгүй байдлын урьдчилан сэргийлэх, хамгаалах, хор уршгийг бууруулах, хариу үйлдэл хийх, сэргээн босгох гэсэн кибер батлан хамгаалах тогтолцооны 5 цогц арга хэмжээг хэрэгжүүлэх явдал юм. Үүнд:

Нэг. Кибер халдлагас "Урьдчилан сэргийлэх" арга хэмжээ нь иргэдэд кибер аюулгүй байдлын тухай мэдлэг, боловсрол олгох, байгууллага, хүний үнэ цэнэтэй мэдээлэл, түүний орших системийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа.

Хоёр. Кибер халдлагас "Хамгаалах" арга хэмжээ нь холбоо, мэдээллийн систем, түүнд орших мэдээллийн баталгаат байдлыг хангахад чиглэсэн хамгаалалтын аргуудыг өөрийн онцлогт тохируулан хэрэглэх замаар хэрэглэгчийн, хэрэглээний програмын, өгөгдлийн сангийн, сүлжээний, үйлдлийн системийн, физик түвшинд хянах, хамгаалах, удирдах үйл ажиллагаа.

Гурав. Кибер халдлагын "Хор уршгийг бууруулах" арга хэмжээ нь эмзэг байдлыг тогтоох, аудит хийх, халдлагыг таслан зогсоох, системийн тухай мэдлэгийг олгох, эрсдлийн үнэлгээг гаргах, халдлагын шинж чанарыг танин

-
- [10]. Johnson T. (ed.). Cyber-Security: Protecting Critical Infrastructures from Cyber Attack and Cyber Warfare
 - [11]. Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.6
 - [12]. Касперский лабораторийн тайлангаас
 - [13]. Hacking the Pentagon., "Concordium" journal of European security and Defence issues., volume 9., issue 2018., page 61-60



тогоох, эсрэг талаас үзүүлэх нөлөөллийг бууруулахад чиглэсэн арга хэмжээ.

Дөрөв. Кибер халдлагад "Хариу өгөх" арга хэмжээ нь довтлох ажиллагаа бөгөөд халдлагын эх булгуудыг тогооход чиглэсэн чадавхийг бий болгох, үүрэг хариуцлагыг тухайн нөхцөл байдалд нийцүүлэх, уян хатан, халдлагад хариу өгөх чадвартай бүтцийн нэгжүүдийг хүчээр зохион байгуулахад чиглэгдсэн арга хэмжээ.

Тав. Кибер хамгаалалтыг "Сэргээн босгох" арга хэмжээ нь өмнөх халдлага, довтолгооны үр дүнгээс суралцаж, өөрийн системийн хамгаалалтыг үр дүнтэй болгоход чиглэгдсэн арга хэмжээ.

Кибер батлан хамгаалах чиглэлийн 5 гол арга хэмжээг хэрэгжүүлэх арга замыг зөв зохион байгуулж, кибер аюулгүй байдлын хууль, эрх зүй, ажиллагааны бодлого, хамгаалалтын техник, технологийг чангатгах нь кибер батлан хамгаалах аюулгүй, найдвартай, уян хатан тогтолцоог бүрдүүлэхэд дахин давтагдашгүй ач холбогдолтой юм.

Кибер аюулгүй байдлыг хангахад зөвхөн хамгаалах арга хэмжээг хориглох ажиллагаагаар хэрэгжүүлээд зогсохгүй, довтолгооны хувилбаруудыг давших кибер ажиллагаагаар хэрэгжүүлэх боломжтой. Монгол Улсын Батлан хамгаалах салбарт "кибер батлан хамгаалах тогтолцоог бодлого, эрх зүйн хүрээнд; бүтэц, зохион байгуулалтаар; үйл ажиллагаагаар; техник, технологиор хангах арга хэмжээний нэгдэл" гэж тооцоолж байна.

2.1. Кибер батлан хамгаалах арга хэмжээг бодлого, эрх зүйн хүрээнд хангах арга зам

Кибер батлан хамгаалах арга хэмжээг бодлого, эрх зүйн хүрээнд хангах арга зам нь Монгол Улсын хууль, эрх зүйн, кибер аюулгүй байдлын талаар төрөөс баримтлах бодлого стратегийг батлан хамгаалах салбарын алсын хараа, стратегийн бодлого, төлөвлөгөөтэй нийцүүлэх замаар кибер аюулгүй байдлыг хангах арга хэрэгсэл, механизмуудыг

тодорхойлох чиглэсэн үйл ажиллагааны нэгдэл юм.

Батлан хамгаалах салбарт мөрдөх кибер аюулгүй байдлын хууль, эрх зүйн орчинд дун шинжилгээ хийж үзэхэд Монгол Улсын кибер аюулгүй байдлыг хангахтай холбоотой хууль, эрх зүйн орчин бүрэлдэн тогоогүй энэ цаг үед Батлан хамгаалахын сайдын 2014 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн А/30 дугаар тушаалаар "Монгол Улсын Батлан хамгаалахын салбарт Кибер аюулгүй байдлыг хангах талаар баримтлах бодлого" баримт бичиг батласан нь салбарын кибер аюулгүй байдлын бодлого, эрх зүйн орчин, үйл ажиллагааг шинчлэхэд чиглэсэн гол ажил болсон. Тийм хэдий ч Монгол Улсад "Мэдээллийн аюулгүй байдлын тухай", "Кибер аюулгүй байдлын тухай" гол хуулийг батлаагүй, мэдээллийн болон кибер аюулгүй байдлын бодлогын баримт бичгүүдийг боловсруулах шатандаа байгаа нь "эрх зүйн орчин бүрдээгүй байна" гэж дүгнэхээр байна.

Энэхүү арга хэмжээний хүрээнд хэд хэдэн зорилт дэвшигдэж байна. Үүнд:

- Кибер аюулгүй байдлын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага, кибер аюулгүй байдлыг хэрхэн хангах талаар бусад улсуудынхтай харьцуулсан судалгаа хийх;
- Монгол Улсын кибер аюулгүй байдлын өнөөгийн байдал болон эрх зүйн орчныг шинжлэх;
- Монгол Улсын хуулиуд болон батлан хамгаалахын багц хуулиудад "кибер батлан хамгаалах тогтолцоог бүрдүүлэх" зүйл заалтуудыг тусгах;
- Батлан хамгаалах салбарт кибер аюулгүй байдлыг хангах арга зам болон шинэ технологи нэвтрүүлэх боломжийг судлан зөвлөмж, үндэслэл боловсруулах;
- Батлан хамгаалах салбарт кибер аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий нэгжийн бүтэц, техник, технологи, програм хангамж, үйл ажиллагааны талаар санал



боловсруулах гэх мэт.

Кибер орон зайд улс орноо батлан хамгаалах чадавхыг бүрдүүлэхэд стратегийн бодлогын дараах зорилтуудаар кибер аюулгүй байдал хангагдана. Үүнд:

- 1) Кибер орон зайд үйл ажиллагаа явуулах хүч хэрэгсэл, чадавхыг бүрдүүлэх, бий, түүнийг хэрэглэхэд бэлтгэх;
- 2) Батлан хамгаалах сүлжээг хамгаалах, мэдээллийн аюулгүй байдал, нууцлалыг хангах, кибер халдлага довтолгооны улмаас үүсэх эрсдлийн хор уршгийг бууруулах;
- 3) Өөрийн улс орны мэдээллийн гол дэд бүтцүүдийн амин чухал ашиг сонирхлыг кибер халдлага, дотолгооноос хамгаалах бэлтгэлтэй байх;
- 4) Кибер тэмцлийн үе шатуудад хэрэглэгдэх кибер батлан хамгаалах арга хэмжээний төлөвлөлт, ажиллагааны хувилбаруудыг боловсруулах, хэрэглэх арга замуудыг тодорхойлох;
- 5) Улс орнуудтай кибер батлан хамгаалах хамтын ажиллагааг өргөтгөх, бус нутагт тогтвортой кибер түншлэлийг бий болгох;

Кибер аюулгүй байдлыг стандартын түвшинд хангах арга зам бол удирдлагын болон техникийн стандартыг дагаж мөрдүүлэх замаар Монгол Улсад хүчин төгөлдөр хэрэгжиж буй холбогдох стандартуудыг үйл ажиллагаандаа удирдлага болгох нь зүйтэй.

Батлан хамгаалах салбарт хүлээгдэж буй нэн тэргүүнд шийдвэрлэх үүргүүд бол кибер орон зайн аюулгүй байдлын стратеги боловсруулан мөрдөх, цаашид стратегийг хэрэгжүүлэх мэргэжлийн зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийг байгуулах, тэдгээр нь үйл ажиллагаагаа хэвийн явуулах програм, техник, технологиудаар хангах, шаардлагдах санхүү, хөрөнгө оруулалтыг шийдвэрлэж өгөх, мэргэжлийн үндэсний боловсон хүчин бэлтгэх, гадаад улс орнуудтай кибер хамтын ажиллагаагаа бэхжүүлэх,

хэрэглэгдэх техник, технологийн шийдэл гаргах, харилцан нийцлийг хангах, сууринуулалт, ашиглалт, туршин хөгжүүлэлтийг системтэйгээр, үе шаттайгаар зохион байгуулах бодлого, эрх зүйн үндсийг бүрдүүлэх явдал юм.

2.2 Кибер батлан хамгаалах арга хэмжээг бүтэц, зохион байгуулалтаар хангах арга зам

Кибер батлан хамгаалах арга хэмжээг бүтэц, зохион байгуулалтаар хангах арга зам нь Батлан хамгаалах салбарын шаталсан бүтэц, зохион байгуулалтаар кибер аюулгүй байдлыг хангах цогц арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийг удирдах, гүйцэтгэлтэд хяналт тавихад чиглэсэн зохион байгуулалттай үйл ажиллагаа.

Кибер батлан хамгаалах бодлогын хэрэгжилтийг бүтэц, зохион байгуулалтаар хангах арга зам нь:

- "Тусгай зориулалтын сүлжээ"-нд тулгуурласан кибер хамгаалалт, тэмцэл явуулах үүрэг бүхий зохион байгуулалтын бүтцийн нэгжийг бий болгох;
- Батлан хамгаалах салбарын төсөвт кибер аюулгүй байдлыг хангах зориулалттай техник, технологи, програмуудыг шинэчлэх, албан ёсны лицензжүүлэхэд шаардлагатай байгаа төсөв, санхүүжилтийг нэн тэргүүнд шийдвэрлэх;
- Мэдээллийн технологийн, түүний дотор, кибер аюулгүй байдлын мэргэжилтэн, компьютерын сүлжээний инженер, техникч нарыг бэлтгэх сургалтын тогтолцоог боловсронгуй болгох;
- Кибер аюулгүй байдлын ажиллагааны болон сургалтын төвүүд байгуулах;
- Мэдээллийг хамтран эзэмших, хамгаалах зохистой тогтолцоотой болох;
- Кибер аюулгүй байдлын нэгдсэн бодлого, төлөвлөгөөг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх;



- Засгийн газрын агентлагууд, олон нийтийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын кибер хамтын ажиллагааг бэхжүүлэх зэрэг байж болох юм.[xiv]

Энэхүү арга замын агуулга нь кибер аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллага, зохион байгуулалтын нэгжийн үйл ажиллагаагаар кибер батлан хамгаалах арга хэмжээг хангуулах явдал юм. Батлан хамгаалах салбарт кибер аюулгүй байдлын бодлогыг хэрэгжүүлэх арга замууд тодорхойлоогүй, үйл ажиллагааг удирдан зохион байгуулах нэгжүүд удирдлагын түвшинд томилгоожоогүй, гүйцэтгэх үүрэг нь тодорхой биш, бодлогын хэрэгжилтэд шаардлагатай төсөв хөрөнгө төсөвлөгдөөгүй, хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн боловсруулагдаж байгаа, кибер аюулгүй байдлыг хангах талаар удирдлагын бүх шатанд онол, арга зүйн ойлголт хомс гэсэн дүгнэлт хийхэд хүргэж байна. Тиймээс гадаад улс орнуудын кибер аюулгүй байдлын байгуулалтын ерөнхий тогтолцооноос жишээ авахад дараах нийтлэг бүтэц, зохион байгуулалттайгаар үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг байна.

Кибер аюулгүй байдлын зохион байгуулалтын бүтцийн нэгж нь кибер батлан хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэгч хүн, технологи, үйл ажиллаааны нэгдэл бөгөөд сүлжээ, системийг халдлага, довтолгооноос хамгаалах, урьдчилан сэргийлэх, дүн шинжилгээ хийх, хариу өгөх, тайлagnah үүрэгтэйгээр зохион байгуулагдсан аюулгүй байдлын шинжээч нарын баг бүрдүүлэх хэрэгтэй байна.

Кибер аюулгүй байдлын зохион байгуулалтын бүтцийн нэгж нь зориулалтаараа, гүйцэтгэх үүргээрээ, үйл ажиллагаагаараа тодорхойлогдоно. Үүнд:

Нэг. Кибер аюулгүй байдлын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн техник, технологийн зориулалтаараа:

- Батлан хамгаалах салбарт кибер халдлага довтолгооноос болон үнэ цэнтэй мэдээллийг хамгаалах дэд бүтцийг бий болгох;
- сүлжээний болон хэрэглэгчийн лиценз бүхий үйлдлийн системтэй болох;
- системийн алдаа, эмзэг байдлыг засах, вирус, хорт кодуудын нэвтрэх магадлалыг бууруулах;
- халдлага, хандалтаас хамгаалах, урьдчилан сэргийлэх систем, галт хана, сүлжээний хандалтыг илрүүлэх IDS, халдлагыг зогсоох IPS системүүдээр хангагдах;
- шифрлэгдсэн тусгай сүлжээ / VPN/, тоон гарын үсгийн хэрэгсэл, криптографын 74 техник, үүлэн тооцоолол /Cloud Computing/-ын технологиудын хэрэгслүүдийг зориулалтаар нь ашиглахад чиглэгдэж байна.

Хоёр. Кибер аюулгүй байдлын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн гүйцэтгэх үүргээрээ:

- Кибер халдлагаас урьдчилан сэргийлэх, аюул, эрсдлийн үнэлгээ хийх, сүлжээ болон хостын алдаа, цоорхойг шинжлэх, скандах, таслан зогсоох арга хэмжээг авах, аюулгүй байдлын бодлого, журам, зөвлөмжүүдийг боловсруулах;
- Хяналт, илрүүлэлтийн үр дүнд бодит халдлагуудад дүн шинжилгээ хийх;
- Халдлагад өртсөн тохиолдолд нөөцийг дахин төлөвлөх, цагт нь хариу арга хэмжээг авах;
- Кибер аюулгүй байдлын төлөв, халдлага, халдагчийн шинж чанарыг холбогдох байгууллагад тайлagnah, үүсэн нөхцөл байдлыг мэдээлэх;
- Сүлжээний аюулгүй байдлын технологиудыг удирдах, засварлах, сэргээн босгох чадварыг бий болгох.

Гурав. Кибер аюулгүй байдлын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үйл ажиллагаагаараа:

[14]. Л.Оюунцэцэг "Батлан хамгаалах салбарын мэдээллийн нэгдсэн сүлжээний онол арга зүйн зарим асуудал" докторын ажил. 2010 он.



- Кибер аюулгүй байдлын нэгжүүд нь хэлтэс, төв, баг байж, тэдгээр нь удирдлагын дээд байгууллагуудад хэлтэс, төв, Зэвсэгт хүчний анги, салбаруудад багийн бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулах;
- Хэлтэс, төв, багийн бүтэц, зохион байгуулалт нь эрхэм зорилго, хариуцлага, үйл ажиллагааны хамрах хүрээ, тэргүүлэх чиглэл, гол хувилбар, загваруудыг тодорхойлох, аюулгүй байдлын бодлого, журам, дэгүүд, техник, технологийн орчин, ангилал, тэдгээрийн сонголт, харилцан ажиллагаа, хэрэглэгчдийн хандалт, гүйцэтгэх үүргүүд, төвийн ажилтнуудын ур чадвар, хариуцлага, хөдөлмөр зохион байгуулалтаас хамаарах;
- Кибер аюулгүй байдлын зохион байгуулалтын бүтцийн нэгж гэсэн ойлголт нь сүлжээний аюулгүй байдалтай шууд холбогдох, сүлжээний хамгаалалтын эсрэг хийгдэх хууль бус халдлага, довтолгоотой тэмцэх, сүлжээний аюулгүй байдлыг бодит цаг хугацаанд нь хангахад чиглэсэн хянах, дун шинжилгээ хийх, тайлгахаас таслан зогсоох, нөхөн сэргээх, тоон шинжилгээ хийх зэрэг зохион байгуулалттай үйл ажиллагааг удирдахад оршино.

Кибер аюулгүй байдлын зохион байгуулалтын бүтцийн нэгжийг байгуулах урьдчилсан нөхцөл нь үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чадамжтай хүний нөөц, хэрэглэгдэх техник, технологийн, эрсдлийн үнэлгээний, кибер аюулгүй байдлын стандартууд, кибер аюулгүй байдлын хөгжлийн чиг хандлагуудад хийгдсэн судалгаанд тулгуурласан төсөл, хөтөлбөр боловсруулахаас эхэнэг гэж дүгнэж байна.

2.3. Кибер батлан хамгаалах арга хэмжээг үйл ажиллагаагаар хангах арга зам

Кибер батлан хамгаалах арга хэмжээг

үйл ажиллагаагаар хангах арга зам нь батлан хамгаалах салбарын нэгдсэн сүлжээг кибер халдлага довтолгоонос хамгаалахад чиглэсэн систем хамгааллын бодлого, журам, програм, техникийг хэрэгжүүлэх, нийцлийг хангах цөгц арга хэмжээ.

Кибер аюулгүй байдлын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үйл ажиллагааны ерөнхий зарчим нь Кибер аюулгүй төвийн бүтэц, зохион байгуулалт дээр тулгуурлах нь зүйтэй.

Кибер аюулгүй байдлын зохион байгуулалтын нэгжүүд нь байгуулалтын хувьд кибер аюулгүй байдлыг хангах арга замуудыг тодорхойлох чадвартай хяналтын шинжээч, Халдлагад хариу үзүүлэгч, Тоон шинжээ, Тусгай шинжээч, Хорт кодын шинжээч, Тандан туршигч (Pentester), МАБ-ын мэргэжилтэн, Кибер аюулгүй байдлын менежер мэргэжилтнүүдээс бүрддэг.

Кибер аюулгүй байдлын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд нь аюулгүй байдлын тасралтгүй үйл ажиллагааг хангаж, байнгын хяналт хийх, халдлагад шуурхай хариу өгөхөд чухал ач холбогдолтой. Төв, нэгжүүдийн гол үүрэг нь бие бүрэлдхүүнд яаралтай тусламж үзүүлэхээс илүү аюулаас хамгаалахад чиглэгддэг ба байгууллагын аюулгүй байдлын тухай мэдээлэл, сүлжээний төхөөрөмж, төгсгөлийн хэрэгслүүд болон системийг хянах, илрүүлэх, тусгаарлах, удирдах үүрэг хариуцлага хүлээдэг.

Кибер аюулгүй байдлын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийг шинээр байгуулахын тулд эхний ээлжинд кибер аюулгүй байдалд эрсдлийн үнэлгээ хийхээс эхлэх хэрэгтэй.

Нэн тэргүүнд буюу нэгдэх арга хэмжээ нь салбарын холбоо, мэдээллийн суурь сүлжээ, түүний ачаалал, түүнд хэрэглэгдэж байгаа техник, технологи, үнэ цэнтэй, ач холбогдол бүхий мэдээллийг хэрхэн хамгаалах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд, аюулгүй байдлын бодлого чиглэл, одоогийн системд байгаа эмзэг байдлуудыг тогтоох ёстой.



Дараагийн хийх алхам буюу хоёр дахь арга хэмжээ нь аюулгүй байдлын цоорхойг илрүүлэх, эмзэг байдлыг таних тогтоож, батлан хамгаалах салбарын удирдлагын системийн тогтвортой байдлыг хангах явдал юм.

Кибер аюулгүй байдлын зохион байгуулалтын нэгжүүдийн удирдлага, аюулгүй байдлын мэргэжилтнүүд өөрийн байгууллагын кибер аюулыг урьдчилан мэдэж, кибер аюулгүй байдалд хамаарах гол үйл ажиллагааны мөн чанарыг мэдэж, эрсдлийн үнэлгээ[xv] буюу аудит хийхийн зэрэгцээ кибер аюулгүй байдлыг хангах хамгийн энгийн арга зам бол кибер халдлагаас урьдчилан сэргийлэх зөвлөмжийг олон нийтэд мэдүүлэх явдал юм[xvi]. Түүнээс гадна кибер боловсрол олгох, кибер аюулгүй байдлыг хангах нэгжүүд туршилт хийх болон сүлжээний аюулгүй байдлыг хангах төлөвлөгөөг боловсруулан баталгаажуулах нь кибер аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой байна.

2.4. Кибер батлан хамгаалах арга хэмжээг техник, технологиор хангах арга зам

Кибер батлан хамгаалах арга хэмжээг техник, технологиор хангах арга зам нь Батлан хамгаалах салбарын кибер аюулгүй байдлын бодлоготой уялсан, кибер батлан хамгаалах тогтолцооны арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дэмжсэн техник, технологиудыг нэвтрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа.

Кибер аюулгүй байдлыг хангах системийг хэрхэн зохион байгуулж, архитектурыг нь програм хангамжтайгаа хэрхэн уялдуулан зохицуулснаар кибер довтолгооноос хамгаалах нөхцөлийг бий болгож, техник, технологийн шийдлийг гаргасанаар дараах боломжуудыг бүрдэнэ. Үүнд:

- Програм болон техник хангамжаас

үүссэн аюулгүй байдлын дохиог (alert) бодит хугацаанд дүн шинжилгээ хийх;

- Вэбапплейкшн суурилсан халдлагыг илрүүлэх болон зогсоох;
- Сүлжээний гол серверүүд дээрх үйлдлийн системийн төлөв байдлын өөрчлөлт, тохиргооны файл, өгөгдлийн бүрэн бүтэн байдлын хяналт, сүлжээний үйл явцуудыг задлан шинжилж халдлагыг тодорхойлох;
- Гадаад, дотоод сүлжээний хооронд дамжигдах мэдээллийн урсгалыг зохицуулж, хянах, найдвартай аюулгүй байдлаар өгөглийг дамжуулах боломжтой байх;
- Сүлжээгээр дамжигдаж байгаа пакетад шинжилгээ хийн халдлагын шинж чанарыг мэдээллийн сантай харьцуулан халдлага мөн эсэхийг тодорхойлох боломжтой байх;
- Эмзэг байдлын үнэлгээ буюу компьютер, сүлжээнд алдаа цоорхой илрүүлэх, гарах үр дагаврыг тооцоолох, эрсдлийн зэргээр эрэмбэлэх боломжтой байх;

Кибер батлан хамгаалах арга хэмжээг техник, технологиор хангах арга зам бол үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах чадавхийг нэмэгдүүлэх зорилготой, мэдээлэл, холбооны дэвшилтэт техник, технологиудад тулгуурласан, олон зориулалт бүхий системүүдийн байгуулалт, үүрэг, зориулалт, үйл ажиллагааг нь нэгтгэх, боловсронгуй болгоход чиглэсэн онол-арга зүйн, техник-технологийн, математик-програмчлалын болон зохион байгуулалтын цогц арга хэмжээг өөртөө багтаасан кибер аюулгүй байдлыг хангах цогц систем юм. Тиймээс кибер аюулгүй байдлын болон үйл ажиллагааны менежментийн SIEM бүтээгдхүүн[xvii], аюулгүй байдлын нэгдсэн удирдлага - (UTM/USM), галт

-
- [15]. Стандартчлал хэмжил зүйн үндэсний төв - Мэдээллийн Технологи - Аюулгүй Байдлын Арга Техник - Мэдээллийн Аюулгүй Байдлын Эрсдлийн Удирдлага MNS 5929:2009
 - [16]. Тагнуулын Ерөнхий Газрын вэб хуудас - <http://www.gia.gov.mn>
 - [17]. Security information and event management https://en.wikipedia.org/wiki/Security_information_and_event_management



хана – Firewall[xviii], халдлага илрүүлэх систем (Intrusion Detection System (IDS) [xix], халдлага зогсоох систем - Intrusion Prevention System (IPS)[xx], вэбийн галт хана - Web Application Firewall (WAF) [xxi], эмзэг байдлын үнэлгээ (Vulnerability assessment)[xxii], нэвтрэх шалгалт (Penetration test) зэрэг програм техникийн боломжуудыг өөрийн улс, зэвсэгт хүчний кибер ажиллагааны бодлоготой уялдуулан зохион байгуулж хангах нь чухал ач холбогдолтой арга хэмжээний нэг болно.

Дүгнэлт. Кибер аюулгүй байдлыг өргөнутгаар нь авч үзвэлүндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах тогтолцооны чухал бүрэлдэхүүн [xxiii] хэсэг бөгөөд төр, нийгэм, цэргийн гол үүргийг болон улс орны эдийн засгийн шинэчлэлтийн өрсөлдөх чадварыг дэмждэг, төрийн, байгууллагын, хувь хүний мэдээллийн аюулгүй байдал, иргэдийн эрх чөлөөг хамгаалах замаар нийтлэг эрх, эрх чөлөөг баталгаажуулдаг, мэдээлэл, холбооны технологийн хэрэгслүүдийн аюулгүй хэрэглээг бий болгодог чухал судлagmaahuun юм.

Кибер батлан хамгаалах тогтолцоо бол "үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах чадавхыг нэмэгдүүлэх зорилготой, мэдээлэл, холбооны дэвшилтэт техник, технологиудад тулгуурласан, олон зориулалт бүхий системүүдийн байгуулалт, үүрэг, зориулалт, үйл ажиллагааг нь нэгтгэх, боловсронгуй болгоход чиглэсэн онол-арга зүйн, техник-технологийн, математик-програмчлалын болон зохион байгуулалтын цогц арга хэмжээнүүдийн нэгдэл юм" гэдгийг удирдлагын бүх шатанд ойлгож, "Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс" баримт бичгийн 8.3.7-д "Цэргийн удирдлага, холбоо, мэдээллийн хэрэгслийг шинэчилж, аюулгүй байдлыг хангах, кибер халдлагатай тэмцэх бүтэц бий болгох", мөн

8.3.13-д "батлан хамгаалах мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох"[xxiv] гэсэн заалтын хэрэгжилтийг хангах үүрэг Цэргийн удирдлагын дээд байгууллагад тавигджээ. Тиймээс батлан хамгаалах салбарт кибер аюулыг зөв тодорхойлон дүн шинжилгээ хийж, аюулгүй байдлыг эрх зүй, удирдлага-зохион байгуулалт, үйл ажиллагаа, програм, техник хангамжийн хүрээнд цогц байдлаар хангах нь зүйтэй.

"Цэргийн хүчний тоог ихэсгэхгүйгээр кибер хүчний тоог өндөр мэргэжсэн кибер цэргээр бүрдүүлж, тусгайлсан боловсруулсан ажиллагааны бодлогын хувилбаруудаар богино хугацаанд тэмцэлдэгч талын кибер орон зайн домэйнуудад нөлөөлөл үзүүлэхүйц "Кибер хүчин"-тэй болох нь улсыг батлан хамгаалах, аюулгүй байдлыг "кибер орон зайн"-даа хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд тэргүүн зэргийн ач холбогдолтой" гэж үзэж дараах 3 гол дүгнэлтийг хийж байна.

Дүгнэлт 1. Тайван цагт кибер батлан хамгаалах тогтолцоог бүрдүүлж, түрэмгийллийн үед хэрэглэх ажиллагааны бодлогын хувилбаруудыг боловсруулж, кибер тэмцэл явуулах бэлтгэлээ урьдчилан хангах;

Дүгнэлт 2. Кибер орон зайн кибер тэмцэл явуулахын тулд цэрэг, зэвсгийг уламжлалт орон зйтай хослуулан оновчтой байдлаар хэрэглэх, хамгаалахын тулд довтлох чадавхитай болох;

Дүгнэлт 3. Улсын болон цэргийн удирдлагын хэрэгцээ, шаардлагад нийцэн ажиллагааны үүргээр, байраар, хугацаагаар болон ажиллагааны горимоор зохицуулагдан нэгдсэн бодлого, төлөвлөгөөгөөр байнгын болон хээрийн удирдлагын байрууд дээр дэлгэгдэх зориулалттай "Тусгай зориулалтын сүлжээ"-тэй болох.

-
- [18]. Firewall (computing) [https://en.wikipedia.org/wiki/Firewall_\(computing\)](https://en.wikipedia.org/wiki/Firewall_(computing))
 - [19]. Intrusion Detection System https://en.wikipedia.org/wiki/Intrusion_detection_system
 - [20]. Intrusion Prevention System https://en.wikipedia.org/wiki/Intrusion_prevention_system
 - [21]. Web Application Firewall <https://www.owasp.org/index.php/>
 - [22]. <http://searchmidmarketsecurity.techtarget.com/definition/vulnerability-analysis>
 - [23]. "Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал" УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоол
 - [24]. "Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс" Соёмбо сонин 2015 он



"Кибер батлан хамгаалах тогтолцоо" бол өнөөдрөөс ирээдүй рүү "өргөн утгаараа" яригдах сэдэв бөгөөд кибер байдлыг хангах арга зам нь кибер батлан хамгаалах аюулгүй, найдвартай, уян хатан тогтолцоог бүрдүүлэх арга замуудыг тодорхойлоход эхлэх цэгийг заасан гэдгийг тэмдэглэн хэлье.

Ашигласан материал:

- [1]. М.Золзая Кибер халдлага довтолгооноос хамгаалах судалгаа., Төслийн тайлан., 2017 он. 9-6 х
- [2]. Joint Publication 12-3 (R). Cyberspace Operations., Cyberspace., 2013 он. 18-16x
- [3]. <https://www.usna.edu/CyberDept/sy110/lec/crsIntro/lec.html>-Cyber Battlefield/Introduction to the Cyber Domain.
- [4]. FM12-3. Cyberspace and electronic warfare operations. Cyberspace and the information environment., Cyberspace layers., 2017 он. 24-22x.
- [5]. http://www.oft.osd.mil/library/library_files/document_387_NCW_Book_LowRes.pdf.
- [6]. [https://en.wikipedia.org/wiki/ Global_Information_Grid](https://en.wikipedia.org/wiki/Global_Information_Grid)
- [7]. FM12-3. Cyberspace and electronic warfare operations. Operations and the Cyberspace Domain., 2017 он. 15-13x.
- [8]. Төрийн холбооны газрын ерөнхий инженер Ширбазар.С. "Мэдээллийн аюулгүй байдлын Монгол Улс болон олон улс дахь нөхцөл байдал" ЭШХ-ын илтгэл. 2014
- [9]. Йоханнесбургийн зарчим "Үндэсний аюулгүй байдал, Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө болон мэдээлэл хүртэх тухай". Лондон,1995
- [10]. Johnson T. (ed.). Cyber-Security: Protecting Critical Infrastructures from Cyber Attack and Cyber Warfare
- [11]. Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.6
- [12]. Касперский лабораторийн тайлангаас
- [13]. Hacking the Pentagon., "Concordium" journal of European security and Defence issues., volume 9., issue 2018., page 61-60
- [14]. Л.Оюунцэцэг "Батлан хамгаалах салбарын мэдээллийн нэгдсэн сүлжээний онол арга зүйн зарим асуудал" докторын ажил. 2010 он.
- [15]. Стандартчлал хэмжил зүйн үндэсний төв - Мэдээллийн Технологи - Аюулгүй Байдлын Арга Техник - Мэдээллийн Аюулгүй Байдлын Эрсдлийн Удирдлага MNS 5929:2009
- [16]. Тагнуулын Ерөнхий Газрын вэб хуудас - <http://www.gia.gov.mn>
- [17]. Security information and event management https://en.wikipedia.org/wiki/ Security_information_and_event_management
- [18]. Firewall (computing) [https://en.wikipedia.org/wiki/Firewall_\(computing\)](https://en.wikipedia.org/wiki/Firewall_(computing))
- [19]. Intrusion Detection System https://en.wikipedia.org/wiki/Intrusion_detection_system
- [20]. Intrusion Prevention System https://en.wikipedia.org/wiki/ Intrusion_prevention _system
- [21]. Web Application Firewall <https://www.owasp.org/index.php/>
- [22]. <http://searchmidmarketsecurity.techttarget.com/definition/vulnerability-analysis>
- [23]. "Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал" УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоол
- [24]. "Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс" Соёмбо сонин 2015 он



ЦЭРГИЙН ЗОРИУЛАЛТАЙ РАДИОСТАНЦЫН СУРГАЛТЫН ПРОГРАМЫГ ЗАГВАРЧИЛАХ НЬ

Н.МОНХ-ЭРДЭНЭ /УБХИС, Цэргийн нэгдсэн сургууль, Цэргийн холбоо,
кибер аюулгүй байдлын тэнхим, магистр, ахлах дэслэгч/

Түлхүүр үг: Мэдээллийн технологи, цахим сургалт, цэргийн сургалт, Storyline 360,
Радиостанц, цахим хэрэглэгдэхүүн

Key words: Information technology, cyber training, military training,
Storyline 360, radiostation, cyber equipments


Хураангуй. Өнөө үед мэдээлэл, холбооны технологи (МХТ)-ийг боловсролын салбарт хэрэглэх асуудалд онцгой анхаарал хандуулж байна. Мэдээлэл, холбооны технологи гэсэн нэр томъёоны дотор радио, телевиз, төрөл бүрийн компьютер, интернет, интерактив самбар гээд олон төрлийн тоон төхөөрөмж, компьютерийн төрөл бүрийн програм хангамжийг ойлгож болно. Мэдээлийн технологи хурдацтай хөгжжих байгаа үед мэдээлэл, холбооны технологийг боловсролын салбарт ашиглаж боловсролын өөрчлөлт шинэчлэл хийж байгааг бид мэднэ.

Дэлхийн олон улс орон, олон улсын байгууллагууд энэ бодит байдалд дүгнэлт хийж, мэдээлэл, холбооны технологийг боловсролын салбарт үр өгөөжтэй нэвтрүүлэх чиглэлээр өргөн хүрээтэй судалгаа шинжилгээний ажлыг явуулж, асар их хөрөнгө оруулалт хийж байна. Хэдийгээр мэдээлэл, холбооны технологийг боловсролын салбарт нэвтрүүлсний үр өгөөжийг нүдэнд харагдтал тоо баримтаар үзүүлж чадахгүй байгаа хэдий ч энэ бол хамгийн үр өгөөжтэй хөрөнгө оруулалт гэдгийг бүх нийтээрээ хүлээн зөвшөөрч байгаа юм. Хамгийн гол нь мэдээлэл, холбооны технологийг боловсролд нэвтрүүлэхдээ юуны өмнө сургах арга барилын талаас нь онцгой анхаарч үзвээс үр дүн нь тодорхой болно.

Үндсэн хэсэг. Хүн аливаа мэдээллийг мэдрэхүйн эрхтэнүүдээрээ хүлээн авч түүнийг нь тархи боловсруулдаг. Хүний

мэдрэхүйн эрхтэнүүдийг аль болох бугдийг нь ашиглаж мэдээлэл цуглуулж чадвал тархины урт хугацааны ой санамжид тухайн мэдээлэл гүн бат хадгалагддаг.

Энэ онцлогт тохиуулан суралцах орчинд мэдээллийг технологийг ашиглан дуу, дүрс, зураг, анимешнтай З хэмжээст дүрс гэх мэт цахим хичээлийн хэрэглэгдэхүүний боловсруулж сургалтанд ашиглаж байна.



Зураг 1. Суралцах арга

Орчин цагийн боловсролын систем шинэ зууны дуудлагад бэлэн байхын тулд мэдээллийн технологийг ашиглахад чиглэсэн боловсролын системтэй байх шаардлага тавигдаж байгаа. Энэ систем нь уламжлалт сургалтын технологийг хөгжүүлэхийн зэрэгцээгээр боловсролын үйлчилгээ үзүүлэгч агентлагуудын сургалтын технологи ба Цахим сурх бичгүүдийг боловсруулах, сургалтын шинэ объектуудыг байгуулах, сургалтын материаллаг бааз, нээлттэй ба Цахим сургалтын орчинг бүрдүүлэх,



дэлгэрүүлэхэд чиглэсэн нийгмийн эрэлт хэрэгцээг бий болгох явдал юм.

Мэдээлэл холбооны технологийг цэргийн сургалтад хэрэглэх боломжууд

Хүн ам сийрэг суурьшдаг, газар нутаг томтой манай улсын хувьд улсынхаа хаа ч сурч, ажиллаж, амьдарч байгаагаас үл хамааран сурч боловсрох тэгш боломжийг хүн бүрт бий болгох, эх орондоо эзэмшсэн боловсрол нь дэлхийн аль ч улс оронд хөрвөдөг, хүлээн зөвшөөрөгдөг болох, боловсролыг экспортолдог, нөгөө талаас чанартай боловсролыг импортлодог орон болох зорилгыг Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгасан билээ.

Энэхүү зорилгыг хэрэгжүүлэхийн тулд нийт хүн амын мэдээллийн технологийн боловсролын түвшинг дэлхийн дундаж түвшинд хүрэх, хот, суурин газраас зайн сургалтанд оролцох боломжтой болгох, төрийн бүх шатны албан хаагчид, нийт хүн амын 80-аас доошгүй хувийг мэдээлэл холбооны технологийн анхан шатны боловсролтой (ICT literacy) болгох, сургалтын бүх шатанд Цахим сургуулийг өргөнөөр нэвтрүүлж, загвар сургуулийн 50-иас доошгүй хувийг Цахим сургууль болгох зэрэг чухал зорилтуудыг дэвшүүлсэн байна.

Цахим сургалт, боловсролын шинэ тогтолцоог Зэвсэгт хүчинд хөгжүүлэхийн тулд цэргийн нэгдсэн сургууль, ахлагчийн сургууль, анги салбаруудад мэдээллийн технологийн чиглэлээр хөрөнгө оруулах, улс орны болон Зэвсэгт хүчиний мэдээлэл, холбооны суурь сүлжээний боломжуудтай нийцэн Цахим сургалтын хөтөлбөр боловсруулах, анги салбаруудын интернет холболтын хурд багтаамжыг нэмэгдүүлэх, мэдээллийн технологийн хэрэгслүүдийг сургалтанд ашиглах болон Цахим сургалтын материал бэлтгэхэд нь зориулан иж бүрэн техник хэрэгслээр хангах, нэг цэргийн алба хаагчдад ноогдох Цахим техникийн тоог нэмэгдүүлэх шаардлага урган гарч байна.

Цаашилбал

Зэвсэгт

хүчинд

ажиллаж мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийн тоог нэмэгдүүлэх, мэдлэг, чадварыг сайжруулах нь зүйтэй байна.

Мэдээллийн технологи, түүний дотор интернэтийн үсрэнгүй хөгжил хүн төрөлхтнийг бүтээлч болгох, түүний дотор сурах, сургах чиглэлд өргөжүүлж, хялбаршуулж буйгийн жишээ бол Цахим сургалт юм.

Боловсрол, мэдлэгийн эрэлт хэрэгцээ ч Цахим сургалтын хэлбэрээр нийлүүлэхийг шаардах болсон.

Цахим Сургалт нь уламжлалт танхимиын сургалтын технологиудыг гүйцээн баяжуулсан, ирээдүйд баримжаалсан мэдлэгт сууриссан сургалтын орчин үеийн арга хэлбэр болсон.

Зайн сургалтад ашиглахад хамгийн тохирсон боловсролын технологид:

- Видео лекц;
- Мультимедиа лекц болон мультимедиа лабораторын дадлага;
- Цахим мультимедиа сурах бичиг;
- Компьютерийн сургалт, хяналтын системүүд;
- Дууриалган үзүүлэх загварууд ба компьютерийн тренажерууд;
- Холбооны хэрэгслийг ашиглахтай холбогдсон зөвлөмжүүд болон туршилтууд;
- видео хурал зэрэг багтдаг.

Цахим сургалтын давуу тал нь суралцагч хичээлийн цаг болон хичээлийн байр танхимаас үл хамааран биеэ даан ажиллах боломжтой учраас суралцагчид аливаа сэдвийг сурах буюу эсвэл өргөжүүлэхийг хүссэн үедээ хаанаас ч компьютер дээрээ сурах боломж байгаад оршино. Цахим сургалт бол суралцагч танаас сурах арга барил, бие даан суралцах арга зүйн ноу хай, хувийн сахилга бат, хамтран суралцах ур чадвар зэргийг шаарддаг.

- Цэргийн сургалт бэлтгэлийн агуулгад Цахим сургалт жилээс жилд өсөн нэмэгдсээр байна.

Цахим сургалтын технологи ашиглан сургалт явуулж байгаа АНУ-ын



сургалтын иж бүрэн програм техникийн хэрэгслүүдийг ашигласан гурван жишээг дурдахад:

1. Цахим сургалтыг ашигласаны үр дүнд Ф-16 онгоцоор нэг цаг нисэхэд \$5,000 зарцуулж байсан бол дуuriалган үзүүлсэн тренежор ашигласнаар цагт 500 доллар



2. Танкийг нэг мил газар жолоодоход \$75 зарцуулж байсан бол дуuriалган үзүүлсэн тренежор ашигласнаар нэг мил газарт \$2.50 доллар зарцуулж байна.



3. Апаче нисдэгтэргийг оролцоогоор нэг цаг ажиллуулахад \$3,000 зарцуулж байсан бол дуuriалган

үзүүлсэн тренежор ашигласнаар нэг цагт \$70 доллар зарцуулж байна.



Цахим сургалт нь уламжлалт сургалтын танхимаас үнэтэй юм шиг харагдаж байгаа боловч сургалтад зарцуулах цагийг багасгаж, гүйцэтгэлийг сайжруулж байгаа хэрэг юм. Цахим сургалтыг зохион байгуулсанаараа уламжлалт сургалтад зарцуулж байсан цагаас 40 хувиар бага цаг зарцуулж байгааг олон улсын туршлагаар батлагдсан байна.

Манай Зэвсэгт хүчин бол олон жилийн турш ард түмэн, түүний дотор цэргийн алба хаагчдыг сурган хүмүүжүүлэх, тэдэнд боловсрол олгох, төлөвшүүлэхэд чухал байр суурь эзлэдэг төрийн цэргийн байгууллага байсаар байна.

Офицер, ахлагч, хугацаат цэргийн алба хаагчид мэдээлэл, харилцаа холбооны технологийн ололтыг ашиглан чөлөөтэй харилцаж, нийгмийн харилцаанд идэвхтэй эрх тэгш оролцон хэрэгтэй мэдлэг, чадвар, дадлагыг эзэмших хүртээмжтэй орчин, нөхцлийг бүрдүүлэх үүрэг Зэвсэгт хүчиний өмнө тавигдаж байна.

Цэргийн холбоог түүхэн үе шатаар нь авч үзвэл:

Байнгын бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийн түвшин бүрд мэдээлэл, харилцаа холбооны технологийн



Цэргийн холбооны түүхэн хөгжлийн үе шат



Зураг 2. Цэргийн холбооны түүхэн хөгжил

сургалтыг тэргүүлэх орнуудын зэвсэгт хүчинүүдийн жишигтэй уялдуулан зохион байгуулж, хэрэгжүүлэх уян хатан тогтолцоог бий болгох бодит алхамууд хийгдэж байгаа ч, цаашид Цахим сургалтын шинэ хөтөлбөр төлөвлөгөө, бодлого боловсруулах шаардлагууд байгаа нь харагдаж байна.

Цэргийн сургалт бэлтгэлийн үйл ажиллагаанд мэдээллийн технологийг нэвтрүүлэх, Цахим сургалтын тогтолцоог сургалтын үндсэн хэлбэр болгох үйл ажиллагааны дараах зорилтууд тусгагдах болно. Үүнд:

1. Цэргийн сургалт бэлтгэлийн зохион байгуулж явуулах Цахим тогтолцоог бий болгох:
 - Цэргийн сургалт бэлтгэлийн удирдлагын оновчтой, шуурхай шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх цэргийн боловсролын болон технологийн мэдээллийн сүлжээ, сан, мэдээллийн эрэлт-хайлтын тогтолцоог бүрдүүлж төлөвшүүлэх.
 - Цэргийн сургууль, коллеж анги, салбарын удирдлага, бүртгэлийн Цахим мэдээллийн системийг үүсгэж, суралцагчид хэрэгтэй мэдээллийг өөрсдөө олж авах боломжийг бүрдүүлэх.
 - Сурах бичиг, гарын авлага, сургалтын материалын Цахим бүтээлүүдийг бий болгох, Веб суурилсан

сургалтыг өргөнөөр ашиглах.

- Номын сангийн үйлчилгээг Цахим хэлбэрт оруулах.

2. Анги салбаруудын мэдээллийн технологийн дэд бүтцийг хөгжүүлэх :

- Эзэсэгт хүчиний анги салбаруудыг интернэтийн ашиглалтыг сайжруулж офицер, ахлагч нарт хүртээмжтэй болгох
- Цахим сургалтыг хөгжүүлэх чиглэлээр хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих
- Анги салбаруудын сургалтын танхимуудыг компьютержуулж, цэргийн алба хаагчдад ноогдох компьютерийн тоог нэмэгдүүлэх.
- Сургууль, тэнхим бүрд LED дэлгэц, проектор, сканнер, принтер, дэлгэц зэрэг мэдээлэл холбооны технологийн үндсэн хэрэгслээр тоноглогдсон кабинетийг байгуулах.
- Мэдээллийн технологи, тактик тусгай бэлтгэл, гадаад хэлний хичээлүүдийг Цахим-сургалтаар эзэмших бололцоог бүрдүүлэх зорилгоор эдгээр хичээлүүдийн кабинетуудыг интернетэд холбон, компьютер, мультимедиа сургалтын хэрэгслүүд, төхөөрөмжүүдээр хангах.
- Алслагдсан салбаруудтай богино хугацааны сургалт болон мэдээллийн үйлчилгээг үзүүлэх



хөдөлгөөнт холбооны техникуудээр дэмжлэг үзүүлэх

- Цэргийн анги бүр сургалтын Цахим шуудангийн хаяг, Вэб хуудастай болох арга хэмжээг шийдвэрлэх

3. Мэдээллийн технологийн хөгжлөөс мэдлэг, чадварын хувьд хоцрохгүйгээр өөрийгөө хөгжүүлэх чадвартай боловсон хүчинээр хангах бодлогын хүрээнд анги салбарын захирагч нарыг өөрийн мэдээллийн мэргэжилтнүүдийн мэдлэг чадварыг өсгөхөд дэмжлэг үзүүлэх, тухайн орон нутагт ажиллаж байгаа өндөр чадвартай мэргэжилтэнүүдээс дэмжлэг авах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх

4. Мэдээлэл, харилцаа холбооны технологийн мэдлэг, чадвар эзэмшүүлэхэд чиглэгдсэн сургалтыг суралцагчдын хэрэгцээ, сонирхолд тулгуурлан зохион байгуулах уян хатан тогтолцоог бий болгохын тулд офицер ахлагч нарын мэдээлэл, харилцаа холбооны технологийн тухай анхны төсөөлөл олгож сонирхлыг нь төрүүлэх арга хэлбэрүүдийг дэмжин ажиллах хэрэгтэй байна.

Их дээд сургуулийг цахим сургууль болгохын тулд эхний ээлжинд мэргэжлийн хичээл заадаг багш нар цахим хичээлийнхээ контентыг ерөнхий шаардлагад нийцүүлэн боловсруулан гаргах нь зүйтэй. Цахим сургалт нь уламжлалт сургалттай хосолж явагдвал илүү үр дүнтэй байна.

Цэргийн сургалт, боловсролын түвшинд мэдээлэл, харилцаа холбооны



технологийг ашиглаж шаардлагатай мэдээллээ хайж олж ашиглах, хэвлэн нийтлэх, харилцаа холбоо тогтооход интернет, цахим шууданг ашиглах зэрэг чадвар эзэмших боломжоор хангах, хамгийн өргөн хэрэглэж байгаа орчин үеийн хэрэглээний програмуудыг ашиглах мэдлэг, чадвар, дадлыг суралцагчид эзэмшижэд чиглэсэн сургалтыг зохион байгуулахад анги салбаруудын захирагч штаб, офицерүүдийн бүтээлч сэтгэлгээнээс ихэхэн хамаарч болно.

Цэргийн зориулалттай радиостанцуудын сургалтын програмыг загварчилж цахим мультимедиа хэлбэрт тусгай компьютерийн програм ашиглан боловсруулсанаар цэргийн холбооны мэргэжлээр суралцаж буй сонсогч оюутнуудад бодит техник хэрэгсэл дээр дадлага хийхэсээ өмнө тухайн загварчилсан програмаар суралцах нь дараах давуу талтай байна. Үүнд:

1. Сонсогч, суралцагч наарт байлдааны зэвсэг, техникийг компьютерийн програм ашиглан сургалт явуулсанаар хээрийн сургалт бэлтгэлд зарцуулагдах зардлыг тодорхой хувиар бууруулах.

2. Цэргийн радиостанцын ашиглалтын насхилт уртсах

3. Сонсогч оюутан цаг хугацаа, орон зайнаас үл хамааран бие даан суралцах

4. Өөрийн мэдлэг, чадвараа үнэлэж дүгнэлт хийх

5. Сургалын чанар үр дүн дээшлэх гэх мэт

Өнөөдөр дэлхийн зах зээлд өрсөлдөж буй цахим хичээлийн хэрэглэгдэхүүн боловсруулах зориулалт бүхий ашиглахад хялбар 2 компьютерийн програм хангамж Articulate 360 болон Adobe captivate гэсэн програмууд байна. Эдгэрээс Articulate 360 програмыг сонгон авч цэргийн зориулалттай Р-123M радиостанцын сургалтын програмыг загварчилж сургалтад ашиглан туршив. Цахим хичээл бэлтгэхэд зориулагдсан бусад програмууд нь хэрэглэгчээс мэргэжлийн чадвар шаарддаг бол "Articulate storyline" програм нь ашиглахад



хялбар байдаг онцлогтой. Articulate программын хувилбарууд нь тодорхой хугацаанд шинэчлэгдэн сайжирч байдаг бөгөөд сүүлсийн хувилбар нь "storyline 360" юм.



Зураг 4. Articulate программын хөгжил

Иргэний болон цэргийн сургалтын онцлог

Цэргийн сургуулийн сургалтны иргэний сургуулийн сургалттай харьцуулахад нэлээд онцлогтой боловч адил төстэй талууд байна. Техникийн чиглэлээр, ялангуяа холбоо мэдээллийн, авто,

инженер механикийн чиглэлээр сургалт явулахад, тухайлбал: ерөнхий суурь, мэргэжлийн суурь хичээлүүдийг заах үед хичээлийн агуулга нь иргэний сургуульд үздэг хичээлтэй ижилхэн байдаг. Энэ нь иргэний болон цэргийн байгууллагад ажиллах чадвартай мэргэжилтэн бэлтгэх үндэслэл болж байна.

Иймд гадаад, дотоодын ижил төстэй их, дээд сургуулийн багш нарын туршлагыг судлан сургалтад МТ-ийг ашиглах нь үр дүнтэй гэж үзэж оюутан, сонсогч нарт заагддаг зарим хичээлд компьютерийн төрөл бурийн програм ашиглан хичээл явуулах асуудлаар дараах үр дунд хүрэв.

P123M СУРГАЛТЫН ПРОГРАМ



ТЕХНИКИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭВШҮҮЛЭХ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ

- Технологийн карт №1
- Технологийн карт №2
- Технологийн карт №3
- Технологийн карт №4
- Технологийн карт №5
- Технологийн карт №6
- Технологийн карт №7

БҮЦДАХ



P-123М РАДИОСТАНЦ

Нүүр | Радио холбоо | Техникийн боломж | Дадлага | Серийн | Аюулгүй ажиллагаа

Радиостанцны тодорхойлол:
 Бага чадлын, ذات бөглийн давтамжийн хувиргаатай ижил хувиргаат радиостанцуудыг 24 цагийн турш ажиллахад хөйр талын наяддартай холбог хангийн чадваас гадна урзижин тохиргуулсан дөрвөн давтамжийн ал нийд ажиллагтаас яваад автоматаар тохиргуулдагна. Радиостанц нь ПМЗ-3 холбогчийн цахилгаван соронсон париринген нам омын ТА-56М телефонийн блузы танхимын малгайж ажиллахад зориулагдсан.



R-123M РАДИОСТАНЦЫН АЖИЛЛАХ ЧАДВАРЫГ ШАЛГАХ

Радиостанцыг ажилд балтгах
Хулзан авах горимд шалгах
Наэтруулхан горимд шалгах
Радиостанцны унтрах
БУЧАХ

Хулзан авах гармийд шалгах:
1. "ПРОМКОМСТ" баруулыг хамгийн чагтаа (баруун тийш эргүүлсэн) байдалд тавинаа. Баруулыг цагийн зүйний эсрэг эргүүлэхд шууважны хэмжээг багасгах ёстой.
2. "Фиксир чистоты-плавный поддиапазон" солилцсандаа "плавный диапазон-1" байдалд тавнаа.
3. "УСТАВНОВКА ЧИСТОТЫ" баруулыг эргүүлж, хулзан авчийн салбар хувьтай ажиллагааг сонсоно. Энэдээрдүйн хулзан авчийн танчмын магтайн телефонд хувийн шууваж эсүүдэй бусад радиостанцид ажиллагааг сонсогдоно.
4. Шууваж зарчмын ажиллах чадварыг шалтанаа: "шалтана" баруулыг цагийн зүйний эсрэг эргүүлэхд шууваж цагийн зүйний дагуу эргүүлэхд шууваж багаснаа.
5. "ФИКСИР ЧИСТОТЫ-ПЛАВНЫЙ ПОДДИАПАЗОН" дээрээсээ ажиллах чадварыг шалтанаа:

R-123M РАДИОСТАНЦ

(БАФ-М) антненны шүүлтүүрний блокоор хийх боломжтой.

- Цуг буюу гандцаараа ногян зэрэг ног төрлийн радиостанцийг дамжуулж дээр ажиллах
- Ног төрлийн радиостанцийг дамжуулж дээр дас дараалан ажиллах
- Цуг буюу гандцаараа ногян зэрэг ног төрлийн радиостанцийг хулзан авах дээр ажиллах
- Цуг буюу гандцаараа ногян зэрэг ног төрлийн радиостанцийг хулзан авах, дамжуулж дээр ажиллах

R-123M РАДИОСТАНЦ

Нүүр Радио хөлбоо Техникийн боломж Дадлгаа Сорил Агуултуу

ХОЛБООНЫ ТЕХНИК ХЭРЭГСЛИЙГ АЖИЛД БЭЛТГЭХ, АЛ

Нормативын нор	Хийж түрүүртэх агуулуд	Үндэслэлийн нийтийн						
R-123M радиостанцыг ажилд балтгах тохиурлах	<ul style="list-style-type: none"> - Гарцаа узлыг хийж, тэжээлэлтэй тохиурч хувьцайдыг шалгас; - Блондсон дамтамжийг ЗЛГ-ийн синожигсэн дутгаарт тайлж тохиурлах. 	<table border="1"> <tr> <td>Онц</td> <td>Сайн</td> <td>Дунд</td> </tr> <tr> <td>3 мин</td> <td>4 мин</td> <td>5 мин</td> </tr> </table>	Онц	Сайн	Дунд	3 мин	4 мин	5 мин
Онц	Сайн	Дунд						
3 мин	4 мин	5 мин						

Зураг 5. R-123m радиостанцын сургалтын програм

Дүгнэлт

- Сонсогч, суралцагч нарт байлдааны зэвсэг, техникийг компьютерийн програм ашиглан сургалт явуулсанаар хээрийн сургалт бэлтгэлд зарцуулагдах зардлыг тодорхой хувиар бууруулах боломжтой.
- Мэргэжлийн хүрэлцээ муутай ном сурах бичгийг цахим хэлбэрт шилжүүлсэнээр түүний хүртээмж дээшлэх боломжтой. (нууцын зэрэглэлтэй ном, сурах бичгээс бусад)
- Цэргийн сургалтад мэдээллийн технологийг ашигласнаар суралцагчид сурах үйлийн баримжааг зөв олж, өөртөө итгэлтэй болдог тул сурч мэдэх, бүтээх сонирхол дээшлэн цаашид сурах хэрэгцээгээ ухамсарлан ойлгодог юм байна гэсэн дүгнэлт хийж байна.
- Цаашид цэргийн мэргэжлийн багш нарын мэдээллийн технологийг

сургалтад ашиглах чадварыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах, түүнд зориулсан цахим хичээл боловсруулах арга зүйн заавар, зөвлөмж боловсруулан гаргах шаардлагатай байна.

- Сургалтад МТ-ийг ашиглах нь хэдийгээр үр дүнтэй боловч зарим үед суралцагчдад бэлэнчлэх сэтгэлгээг бий болгох хандлагатай байна. Энэ тохиолдолд загварчлах ажиллагааг сайтархийхтуршлагатай болсны дараа схемүүдийн хялбар төхөөрөмжийг угсуулах замаар онолын мэдлэгийг практикт хэрэглэх арга ухаанд сургах нь илүү үр дүнтэй болох нь судалгааны явцад ажиглагдав.
- Монгол Улсын Зэвсэгт хүчинд ашиглагдаж байгаа цэргийн холбооны техник хэргэслийг цахимжуулж сургалтад ашиглах боломж бүрдэнэ.



Ашигласан материал:

1. Батжаргал.А "Монгол Улсын боловсролын салбарт 2010 он хүртэлх хугацаанд Мэдээлэл, холбооны технологийг нэвтрүүлэх үндсэн чиглэл"-ийн хэрэгжилтийн байдалд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, цаашдын зорилт, МХТ-ийг сургалтад хэрэглэх нь ЭШХ-ын илтгэл, УБ, 2005
2. Эрдэнэчандмань.Ж "Цахим хичээл бэлтгэцгээ" УБ, 2013 он
3. Сувдмаа.Т "Цахим сургалт" УБ, 2005 он
4. Чулуунцэцг.Ч, Цолモンчимэг.Ч "Articulate Studio 09 програм өөрөө сурах бичиг" УБ, 2013 он
5. "Батлан Хамгаалахын Их Сургуулийг 2020-2010 он хүртэл хөгжүүлэх Мастер төлөвлөгөө" УБ, 2010 он
6. Монгол Улсын засгийн газраас хэрэгжүүлж буй "Бүх нийтийг компьютержуулах" үндэсний хөтөлбөр УБ, 2004
7. Монгол Улсын боловсролын салбарт 2010 он хүртэл хугацаанд Мэдээлэл, холбооны технологийг хөгжүүлэх үндсэн чиглэл
8. Равжаа.Б, Дорж.Л, Санжсүрэн.Д "Сургалтын технологийн шинэчлэл, эрдэм шинжилгээний арга зүй" УБ, 2007 он
9. Даваа.Ж, Сарантуяа.Г "Дээд сургуулийн сургалтын технологи" УБ, 2007 он
10. Баярмаа.Г "Мэдээлэл харилцааны технологийг химиин сургалтад хэрэглэх арга зүйн зарим асуудал" диссертаци УБ 2006 он
11. Уламбадрах.С, Соронзонболд.Т УБХИС-ийн "Багш, судлаачийн гарын авлага" УБ, 2008 он
12. Монгол Улсад Мэдээлэл, холбооны технологийг хөгжүүлэх "Электрон монгол" үндэсний хөтөлбөр www.pmis.gov.mn/cabinet/document/e_mongolia.doc
13. Алгаа.П "Зэвсэгт хүчиний офицер бэлтгэх сургалтын тогтолцоо, түүнийг боловсронгуй болгох арга зам" диссертаци УБ, 2003 он
14. Цэдэвсүрэн.Д "Сургалтын цахим хэрэглэгдэхүүн боловсруулах онол, арга зүй" УБ 2007
15. Монгол Улсын боловсролын салбарт 2010 он хүртэл хугацаанд Мэдээлэл, холбооны технологийг хөгжүүлэх үндсэн чиглэл
16. Баярмаа.Г "Интернет технологийг химиин сургалтанд хэрэглэх нь" ЕБС-ийн химиин багш нарт зориулсан гарын авлага
17. Мягмардорж.Б "Хичээлийн орчин үеийн технологи" багш нарын гарын авлага. УБ 2002 он
18. "Боловсрол судлал" сэтгүүл УБ 2008 он, А.Оронштейн. Телеконференц и компьютерконференц
19. Брисгина.О.Ф, Конструирование урока с использованием средств информационных технологий и образовательных электронных ресурсов (www.infojournal.ru)
20. Гильбух.Ю.З, Метод психологических тестов: сущность и значение, (Вопросы психологии, №2, 1986)
21. Даваа.Ж, Сарантуяа.Г "Дээд сургуулийн сургалтын технологи" УБ 2009
22. Беляевъ.А, Информационное взаимодействие-фактор личностного развития (Высшее образование в России, №7, 2005)

Интернетээс ашигласан материалууд

23. www.google.com
24. www.articulate.com
25. www.yahoo.com
26. www.yteach.com
27. www.e-learning.report.ru
28. Болорчимэг. Интернетийг хичээлийн үйл ажиллагаанд хэрэглэх нь www.mongoleducation.mn



ХУУЧИРСАН ҮГ ХЭЛЛЭГИЙН УТГА, НАЙРУУЛГА



ЮУ ЖЯЖУНЬ /УБХИС-ийн удирдахуйн ухааны магистрант,
ХАЧА-ийн дэслэгч/

БНХАУ-ын АЧА-ийн дэслэгч, Монгол, Англи хэлний орчуулагч мэргэжилтэй. Уран зохиол судалын бакалаврын зэрэгтэй, УБХИС-ийн удирдахуйн ухааны магистрант, "Зах хязгааргүй хамтарсан засаглалаар агаарын бохирдлыг бууруулах шаардлага, арга зам" сэдвээр судалгааны ажил хийж байна.



ВУ ШИЖИНЬ /УБХИС-ийн удирдахуйн ухааны магистрант,
ХАЧА-ийн дэслэгч/

БНХАУ-ын АЧА-ийн дэслэгч, салааны захирагч мэргэжилтэй. Уран зохиол судалын бакалаврын зэрэгтэй, УБХИС-ийн удирдахуйн ухааны магистрант, "Орон нутгийн хөгжилд тулгамдаж буй асуудал" сэдвээр сулалгааны ажил хийж байна.

Түлхүүр үг: ХУУЧ ҮГ (а. Эцэг өвгөдөөс уламжлагдан ирсэн сургаал үг б. Аман зохиолын нэг төрөл), ХУУЧИРСАН ҮГ (а. Тухайн ойлголт нь хэвээр боловч ойролцоо угтатай өөр үгэнд байраа тавьж, идэвхтэй чанараа алдсан үг б. Идэвхтэй хэрэглэгдэхээ больсон үг),

ҮГИЙН ХУУЧРАЛ, УТГЫН ХУУЧРАЛ...

Key words: TRADITIONAL WORD, OBSOLETE WORD, ODSOLETENESS, OUT OF DATE

ОРШИЛ

"Хууч үг хуучирдаггүй худгийн ёроол хатдаггүй"

(Монгол ардын зүйр цэцэн үгээс)

Орчин цагийн ярианы хэлэнд хэрэглэхээ болиод тухайн ард түмэн нь бараг ойлгохгүй болсон үг хэллэгийг хуучирсан үг гэдэг. Хувцас хуучирдаг, мэдлэг хуучирдагтай адил үг хуучирдаг, юм гэдэг хөгждөг, хувьсдаг, өөрчлөгддөг зүй тогтолтой ажээ.

Үг хэллэг хуучрахдаа:

а. Тухайн үгийг нэрлэж байсан юм нь үгүй болсонтой холбоотой. (Жишээ нь: нум сум, хөө хуяг дуулгатай холбоотой үг хэллэг)

б. Тухайн шалтгаанаар ойролцоо үгэнд шахагдан хэрэгцээнээс гардаг.

(Агсан авах - хүүтэй зээл авах, саатах-сүүх, залрах - явах)

Үг хуучрахдаа тэр үгийг илтгэж байгаа бүх утгаа хадгалж байна уу, эсвэл хагасыг нь хадгалж байна уу гэдгээс үгийн хуучрал, утгын хуучрал гэж хоёр ялгардаг. Жишээ нь: Гар-мутар, нүд-мэлмий, чих-сонор, хөл-бойв, үс-сэвлэг, бумба-хөх гм.

Утгын хуучрал гэдэг нь тэр үгийг хэрэглэж байгаа боловч утгын заримыг нь хэрэглэхээ больсныг хэлдэг.

"Хэрэг шийтгэх" гэдэг нь зохион байгуулах гэснээ болиод ял шийтгэх гэдэг нь үлджээ.

БИЧИХ ҮНДЭСЛЭЛ:

"Чоно өтлөвч ишгэндээ... ЦОРЖ өтлөвч ДОГЖИРТОО...", "Бой нь арилаагүй, борви нь тэнийгээгүй хүүхэд (гараас гараагүй, асаргаа, сувилгаа хэрэгтэй), морьтны хишиг явганд, МОЛОМОЫН хишиг ЧОЙНДОНД (молом *өрөөл*, чойндон *номт*) гэх мэт үг номд маш их тохиолдох тул монголын түүх, соёлыг зөв уншиж, ухаарахад хуучирсан үг хэллэгийн утгыг мэдэх нь нэн чухалтай гэж үзэн энэхүү өгүүллийг бичих болсон юм. Бид энэхүү өгүүлэлдээ монголын түүх, уран зохиол, сурх бичигт олонтоо гардаг үгсийн утгыг кирилл цагаан толгойн дэсээр жагсаан монголоор тайлбарлан, хятад ханз үсгээр хадаж орчуулан монгол бичигт хөрвүүлсэн нь цаашдын монгол хэл, соёл судлах судлаачдад эрх биш нэмэр болох нь лавтай хэмээн үзэж байна.



(ЦОРЖ-Хамбын орлогч бөгөөд хурлыг тэргүүлэн явуулах албан тушаалтан, ДОГЖИР- муу үйлийг буцаахад хэрэглэдэг гурилаар хийсэн хүн дурс бүхий балин, БАЛИН-Зуурсан арвайн гурил, Бой нь арилаагүйгараас гараагүй, асаргаа, сувилгаа)

АВИЛГА - Монгол улсын хууль тогтоомжид "хээл хахууль" гэсэн утгаар хэрэглэгддэг. Чингис хааны үед "Өнчдийг тэтгэх сан" гэж нэрлээд дайнд амь үрэгдэгсэд ба үгээгүй ядуучуудад тусламж болгон олгооор тогтоожээ. /Монголын түүхийн бага нэвтэрхий толь. УБ 1998. 8-р тал/, 贿赂，蒙古国法律中使用 "хээл хахууль" 一词，成吉思汗时期使用 "Өнчдийг тэтгэх сан" 一词。

АЛТАНГЭРЭЛ - Санскрид хэлээр бичигдсэн бурхны шажны нэгэн судар, 一种使用梵文撰写的佛教经书。

АЛТАН УЛС - Манж нарыг эрт цагт Зүрчид гэж нэрлэдэг байв. Зүрчид нар Хятадын зүүн хойт хэсэгт нутаглаж байв. Кидан гүрний захиргаанд байсан Зүрчид нар 1114 онд Киданы эсрэг тэмцэж умард Хятадыг эрхэндээ оруулан өөрийн улсаа Алтан улс гэж нэрлэжээ. 金朝，中国古代由契丹民族在东北地区建立的政权。

АЛТАН САВ - Θөд бологдын сүнсийг зөв замд оруулан, түргэн төрөл арилжуулахын тулд ном хуруулан, арга засал хийлгэх, зурхайн нэгэн чухал үйлдлийг "Алтан сав" нээх гэнэ. Алтан савыг тухайн хүний өөдөлсөн цаг мэнгээр нь үздэг. 人去世后，喇嘛探寻逝者灵魂仪式上所用的器皿。

АМБАН - Төлөөний Сайд гэсэн манж уг, 满语，正式任命前的代理官员。

АМСҮ - түр зуур амрах, 休息，小憩。

АЛГИНЧ - Манлайн харуулч, тагнагч хүн (МНТ 37,123,179,183...аяны цувааны манлайд алгинчлах, байлдаанд алгинчлах Ж.Б), 前哨，侦查兵。

АВШИГ /Самгард/ - Рашаанаар угаах, эрхийг олох зан үйл, сахил хүртэх, 梵语，古代印度统治者加冕的仪式。

АВГА - Монголын нэгэн овог аймаг. Хуучин Өвөр монголын Шилийн

голын 10 чуулганы харьят дөрвөн хушууны нэр. Авга нар нь Чингис хааны дүү Бэлгүйтэйн 17 дугаар үе Баясах бүргэд ноёны эзэмшил, 阿巴嘎，古代蒙古族部落，位于现内蒙古锡林郭勒地区。

АВИДАРМА - Бурхан багшийн сургаалийг гурван аймаг савд хуваасны нэг, 佛教学说，阐述认知规律和世间万物本质。

АГСАЛ ҮРЖИЛ - Θр төлөх баталгаа, 偿还债务的证明。

АГСАН АВАХ - Хүүтэй зээл авах, 获取有息贷款。

АГСАН ТАВИХ - Хүүтэй зээл тавих, 发放有息贷款。

АГСАРАХ - Албан тушаалаас огцрох, 辞职。

АГУУЧ - Холын бодолтой, өргөн мэдлэгтэй, 知识渊博。

АГЬ - Хаад ноёдын хүү, 阿哥。

АГРАМБА - тарнийн ухаанд мэргэшсэн хүнд олгох эрдмийн дээд зэрэг, бурхны шажинд хамгийн их эрдэмтэй ламыг нэрлэнэ, 佛教用语，对智者授予的最高称号。

АДАЛ МАЛ - Θөрийн мэдэлд байгаа мал, 自己的牲畜，财产。

АДАМ - Адгуу тэвдүү, 匆忙、急忙。

АДИС - Θршөөл, аврал бий гэж итгэн биеэ даатган сүсэглэх зан үйл, бурханд мөргөх, дээдийн номыг хүртэх, багшиг шүтэх журмыг "адистид" гэж санскритээр хэлдэг, 梵语，祷告。

АРХАД - Нисваанисыг тэвчсэн хүн, 罪人。

АСҮҮРЬ - Эх болсон б зүйл / адгус, бирд, асуурь, там, тэнгэр, хүн/-ийн нэг тэнгэр, тэнгэр газрын дундах 1 зүйл домгийн амьтан, 世界起源时产生六种生灵中的一个，一种神话动物。

АРВИС - тарни, шившлэг, 咒语。

АРВАН ЗАСГИЙН НААДАМ - Түшээт хан, Сэцэн хан хоёр Богдын их шавь нийлж, Богдын ордны өмнө жил бүр хийдэг наадам, 土谢图汗、车臣汗每年在伯格多宫前进行的那达慕。

АРУУХАН - 3ucs царай төгөлдөр, 外表美丽。

АРШ - Мэргэн, ном тарнийг тоонд



нь хүргэж уншин шашны зан үйл гүйцээсэн лам хүн, 形容有智慧、有修为的喇嘛。

АРАВНАЙЛАХ - ᠠᠷᠠᠪ'Neill Амилуулах гэсэн утгатай, 复活。

АРВАН ХАР НҮГЭЛ - ᠠᠷᠤᠸᠠᠨ ᠬᠤᠷ 1. Лүйжий лай буюу биеэр үйлдэх нүгэл а.сорог-жад-амь таслах б.гума-эс өгснийг авах в.лог-юм- буруу хурьцал. 2. Агийн намба ший буюу хэлээр үйлдэх нүгэл а. зумрай-худал хэлэх б.парам- хов хэлэх в. агчил-дэмий чалчих г. цэгзув-ширүүн харьцах 3. Иджий намба сүм буюу сэтгэлээр үйлдэх нүгэл а. Нод-сэм- хорон сэтгэл б. нав-сэм-шунал в.логда-буруу үзэл, 佛教用语，十宗罪。

АРВАН ЦАГААН БҮЯН - ᠠᠷᠤᠸᠠᠨ ᠪᠤᠶᠠᠨ/ ᠠᠷᠤᠸᠠᠨ ᠥᠤᠶ/ 1. ми жигвийн жамба буюу аюулгүй өглөг 2. жамба намсум буюу өглөг өгч баярлуулах 3.мажин лин буюу эс өгснийг тэвчих 4.лаг юм буюу буруу хурьцлыг тэвчих 5.зумрай буюу үнэнийг хэлэх 6.цэгзув буюу зөөлөн харьцах 7.парма буюу шударга байх 8.агчил буюу чалчихыг тэвчих 9.нав сэм буюу бусдыг хайлрах 10.ном сэм буюу хүнлэг сэтгэл, 佛教用语，十种福德。

АРИГ УС - ᠠᠷᠢᠭ ᠤᠰ ᠠᠮᠳᠠᠮᠳᠤ ᠨᠡᠮᠳᠤ ᠨᠡᠮᠳᠤ Чандмань өндөр, Цагаан үүр сумын нутгийг дамнан урсдаг голын нэр, 河流名称, 流经库苏古尔省昌德曼(Чандмань)山, 白巢(Цагаан үүр)县。

АЮУШ ХАДАГ - ᠠᠵᠤᠶᠱ ᠬᠤᠶᠱ Урт насын бэлгэдлийн эд, монголоор нас гэсэн утгатай бөгөөд өндөр настанд барьдаг заншилтай, 象征长寿的意义。

АХУ - ᠠᠬᠤ буй, бүхий, 具有。

БАЦАГ /МАЦАГ/ - ᠠᠴᠤᠭ ᠥᠯ хоолгүй, улаан идээг тэвчих, 佛教用语，指禁食肉食的行为。

БАНДИ - ᠠᠴᠤᠮ Magtaalch, дууч гэсэн утгатай самгард үг, 赞歌, 赞美之词。

БАНДИДА - ᠠᠴᠤᠮ/ ᠬᠤᠶᠱ Бурхан шашны 5 ухааны номд мэргшсэн хүнд олгох зэрэг цол (учир шалтгаан, дуун, хэлзүйн, урлахуйн, дотоод ухаан), 佛教用语，对于掌握“五种智慧”(5 ухаан)的人授予的称号。

БОГД ЗОНХОВ - ᠠᠴᠤᠮ/ ᠭᠤᠶᠱ /Лувсандагва-1357-1419/, 藏传佛教格鲁派创立者、佛教理论家罗桑扎巴。

БИРД - ᠠᠴᠤᠮ/ Гурван муу заяаны

хоёрдахь өлссөн чөтгөр. Шунал ихтэй учир сэтгэл ханахгүй зовлонгоор үргэлж зовно, 佛教用语，指因贪欲太多难以满足而内心倍受折磨的人。

БЭХИ, БӨӨТ - ᠠጀᠱ ᠥጀᠱ Бөөгийн шашны тэргүүн /Хабул хааны том хөвүүн Охинбархаг бөлгөө. Түүний хөвүүн Хутгту Жүрхи ажээ. Хутгту жүрхийн хөвүүн Сача бэхи, Тайчу хоёр. Тэд жүрхи овогтон болов/, 萨满教领袖。

БҮҮРЧ - ᠠጀᠱ/ ᠠጀᠱ Тогооч /Чингис, хаан болоод Өнгүр, Сүхэтуу чэрби, Хадаан-Далдуурхан гурав өгүүлрүүн: "Өглөөний зоогийг өнөд осолдохгүй, үдийн ундыг үүрд тасалдахгүй гүйцэтгэж байя" гэсэн тул БҮҮРЧ болгов МНТ 124-р зүйл/, 厨师。

БУДАНГҮЙ - ᠠጀᠱ/ ᠠጀᠱ мунхаг, харанхуй, 黑暗, 阴暗。

БУЛХАЛДАХ, БУЛХА БОЛОХ - ᠠጀᠱ/ ᠠጀᠱ байлдах, дайтах (Нууц товчоонд 23 удаа давтагдаг Ж. Б), 战斗, 战争。

БОДАНЧАР - ᠠጀᠱ/ Чингис хааны 13 дахь үеийн дээд овог /1. Бэртэ-чино, гэргий Гуа марал 2. Батцагаан 3. Тамача 4. Хоричар мэргэн 5.Уужим буурал 6.Саль-Хачау 7. Их нүдэн 8. Шинсочи 9.Харчу 10.Боржигидай мэргэн 11.Торголжин баян 12.Торголжин баяны хөвүүн Дува сохор, Добу мэргэн хоёр бүлгээ. 13.Добу мэргэнд үгүй болсны хойно түүний гэргий Алун-гуа бэлбэсэн бөгөөтөл Буха хатаги, Бухату салжи, Боданчар мунхаг нэртэй гурван хөвүүнийг төрүүлэв/, 成吉思汗前十三代先祖的姓氏。

БОДИЧАРИЯ-АВАДАРА - ᠠጀᠱ/ ᠠጀᠱ/ бодь мөрийн явдалд орохуй гэсэн утгатай санскрит үг, 梵语, 菩提道, 成佛的道路。

БОЙВ - ᠠጀᠱ/ Хөл, гутлын хүндэтгэл, 敬语, 意指脚、靴。

БОЙДОО - ᠠጀᠱ/ ноёдын дотоод сангийн эрхлэгч даамал, 官府中管理内部仓库的官员。

БӨӨГИЙН ТЭНГЭР - ᠠጀᠱ ᠨ/ ᠠጀᠱ/ Бөөгийн шашны ёсоор огторгуйд 99 тэнгэр буй. Барууны 55, зүүний 44 тэнгэр байдаг гэдэг. Барууны 55 тэнгэрийн ахлагч нь АТАА УЛААН ТЭНГЭР. Зүүний 44 тэнгэрийг хортой гэдэг, 萨满教认为，



长生天是99重天，左44天，右55天，右55天的首领叫阿塔赤天 (АТАА УЛААН ТЭНГЭР)

БЭЙЛ - 𠂇/ Манжийн хэтэрхий дөрвөн хэргээмийн 2-р зэрэг, 贝勒, 清朝爵位第二等级

БЭЙС - 𠂇/ Манжийн хэтэрхий дөрвөн хэргээмийн 3-р зэрэг, 贝子, 清朝爵位第三等级

ВАН - 𠂇/ Манжийн хэтэрхий дөрвөн хэргээмийн 1-р зэрэг, 亲王, 清朝爵位第一等级。

ВИНАЙ - 𠂇/ Номхтгол гэсэн утгатай самгард уг, 梵语, 意为保持平静的状态。

ГҮН - 𠂇/ Манжийн хэтэрхий дөрвөн хэргээмийн 4-р зэрэг, 公, 清朝爵位第四等级。

ГАВЖ - 𠂇/ Шашны эрдэм номын цол /Арван бэрх гол судрыг нэвтэрхий мэдсэн хүнд өгдөг эрдмийн зэрэг/, 藏传佛教对学者授予的等级。

ГЭЛЭН - 𠂇/ Шашны журмыг нарийн чанд дагах санваартан лам, сахилын дээд зэрэг, 格隆, 严守教规的喇嘛, 戒律的最高等级。

ГЭЦЭЛ - 𠂇/ Гэлэнгийн өмнөх сахил, 格策, 低于格隆的藏传佛教等级。

ГЭСГҮЙ - 𠂇/ Хүрээ хийдийн хурал номын үүрэг хүлээсэн албан тушаалтан, хуврагуудын захирагч, 主持宗教会议的人员。

ГЭВШ - 𠂇/ Буяны садан буюу багш, 老师。

ГЭНЭН - 𠂇/ Сахилын доод зэрэг, 格聂, 戒律的最低等级。

ГЭРЭГЭ - 𠂇/ Төрийн элчийг гэрчлэх тэмдэг, 国家使者的信物、证明。

ГЭНЭТГЭХ - 𠂇/ Гэнэдүүлэх (Ж. Б), 赶上、追上。

ГҮҮШ - 𠂇/ Шашин номын ёсыг эрхлэн хөтлөгч, номын эзэн /зарлиг, тарни, шаштири, ном зэргийг төрийн хаанд номлон авшиг авахуулагч/, 格西, 掌管宗教习俗规则的人。

ГҮНЖ - 𠂇/ Манжийн хааны охин, 格格, 满清王室的公主。

ГҮНЦЭГ - 𠂇/ Удийн хоол, 午饭。

ГАДААЛАХ - 𠂇/ Завсарлах / Тодруулсан угс нь хүндэтгэлийн утгатай

болжээ. Хүндэтгэлийн үгийг хүн өөртөө хэрэглэхгүй. Тухайлбал: "Асуултыг би болгооё" гэхгүй, "Асуултыг Та болгооно уу?" гэх нь зөв/ 休息。

ГАЛАВ - 𠂇/ Сав шимиийн ертөнцийн хөгжлийн тодорхой уед хамарагддаг нэгж хугацаа. Галавыг эринд хуваана, 纪元。

ГАЛБАРВААСАН МОД - 𠂇/Хүссэн бүхнийг биелүүлдэг диваажингийн 5 модны нэг, 实现所有愿望的五种天堂树中的一个。

ГАНЖУУР - 𠂇/Зарлигийн орчуулга/ 7 булэгтэй 108 боть зохиол, 《甘珠尔》。

ГӨӨГӨӨ - 𠂇/ Их ах гэсэн утгатай хятад уг, 汉语, 哥哥。

ДЭМЧ - 𠂇/Хутагтын шавь, 佛的弟子。

ДЭРЭЛГЭХ - 𠂇/ Дайсны жагсаалын хоёр үзүүрээс нь хөндрөн дайрах (Ж. Б), 战争中攻击敌人两翼战术。

ДАА - 𠂇/ Их, 汉语, 大。

ДАЦАН - 𠂇/ Шашны эрдэм суралгазар, 学习宗教知识的地方。

ДАНШИГ- 𠂇/ "Бат оршил" гэсэн утгатай. Богд хаанд урт наслахыг ерөөж өргөл барьц өргөж эрийн гурван наадам хийдэг ёс, 为了向伯格多汗乞求长命百岁而上贡并进行男子三项竞技的习俗。

ДАМДИНЧОЙЖОО - 𠂇/ Эрлэг номун хаан/-ы цамын гол дүр. Хорвоод шударга үнэнийг сахиулан буян нүглийг яланг салгагч шүүгч бурхан. 佛教对掌管真理判罚罪恶的神的称谓。

ДАНЖУУР - 𠂇/Шаштирын орчуулга/ 14 булэгтэй 212 боть зохиол, 《丹珠尔》。

ДОНИР - 𠂇/ шадар түшмэл, данс харгалзагч, 副职领导, 掌管财政者。

ДУЛЬТ - 𠂇/ дутуу, дулимаг, тааруу, 缺少。

ДҮНЖИНГАРАВ - 𠂇/ Газрын эзэн, 地主。

ДҮҮЖИН - 𠂇/ Есөн эрүүний нэг, 清朝时期蒙古地区九种刑罚之一

ЕСӨН ЭРҮҮ, 清朝时期蒙古地区九种刑罚

1. Банздах - 𠂇/50 хүртэл жанчина/, 打50大板。

2. Чавчирга буюу урт банз - 𠂇/60-аас эхлэн 100 хүртэл жанчина/, 打60-100大板。



3. Шаахай – ֆաم /2 хацарт 40 хүртэл цохино/, 掌嘴40次。

4. Хүлэх - ھەلە /нойтон дээсээр 2 гар хулнэ/, 用潮湿的绳子绑住受刑者双手。

5. Сараалж - ھەنچىرە /тахимд бөөрөнхий мод хийж 2 үзүүрт хүн гишгэнэ/, 受刑者跪下，两人将圆木压在并不断下压。

6. Дүүжин /эрхий хурууг нарийн олсоор уяж өлгөнө/, 将受刑者大拇指用细绳捆绑并吊起。

7. Хөшгүүр буюу хонгор азарга – ھەنچىرە /Урт модонд 4 нух хийж хөл гарыг оруулан хавчина/, 在长木头上打四个孔，把受刑人的手脚穿进去。

8. Төөнүүр - ھەنچىرە /Нуруу ба гуяны зузаан маханд хүж шатааж ноцож дуустал тулнэ/, 熏烤受刑人的背部或臀部直至烤焦。

9. Хавчуур - ھەنچىرە /эр хүний хурууг хавчиж арьс Mach, яс чөмгөнд хор болж үүрд тахир татуу болно/, 将男性的手指夹住直至坏死。

Энэхүү эрүүг давж гарвал ямар ч хүнд ялыг хэрэгсэхгүй болгодог ажээ.

ЕСӨН ИХ БЭЛГЭ - ھەنچىرە ھەنچىرە Монголын төрийн бэлгэ эрдэнэ, 蒙古国家的象征标志。

1. Хар сүлд - ھەنچىرە /бусдыг айлгахын бэлгэ, 黑纛。

2. Улаан бүрээ - ھەنچىرە /хамаг хүнддэхийн бэлгэ, 红号。

3. Алтан хор - ھەنچىرە /сум/ бие сахихын бэлгэ, 金箭。

4. Шар шүхэр - ھەنچىرە /олны өргөгдөхийн бэлгэ, 黄伞。

5. Алмаасан илд - ھەنچىرە / ھەنچىرە засаг явуулахын бэлгэ, 金刚剑。

6. Алтан эмээл - ھەنچىرە / ھەنچىرە явдлын бэлгэ, 金马鞍。

7. Исэр - ھەنچىرە суудлын бэлгэ, 筵子。

8. Түшиг сайт өрлөгүүд - ھەنچىرە ھەنچىرە 大元帅。

9. 9 гөхөлт цагаан сүлд - ھەنچىرە ھەنچىرە / Монгол Улс мандан бадрахын бэлгэдэл 九旗白纛。

ЖАВЗАНДАМБА - ھەنچىرە жинхэнэ нэр нь Агаанлуvsанчойжиннямданzan ванчуг. Энэ нь Монголоор Хэлний эрхэт, сайн оюут, номыг тэтгэгч, сургаал, эрх баялаг гэсэн утгатай ажээ. 哲布尊丹巴。

ЖАС - ھەنچىرە Олны өмч, 信徒向寺庙供奉的财产。

ЖАСАА - ھەنچىرە , Албаны газар, бурхнаа тахиж хишиг буянаа дуудуулах тахилга, 祈祷。

ЖАВТИЙ - ھەنچىرە Угаал үйлдэх зан үйл, 佛教用语，灌顶。

ЖАНЧ - ھەنچىرە Лам нарын хувцас, 喇嘛的服装。

ЖАЯГ- ھەنچىرە Ёс дүрэм, 规则、规矩。

ЖИН - ھەنچىرە 600 грамм, 重量的计量单位, 斤, 600克。

ЖИНС- ھەنچىرە Язгууртын малгайн оройн хэсэг, 顶珠。

ЖОНОН- ھەنچىرە Хааны алтан ургын ойрын удмын хүн, 和王室有亲戚关系的人。

ЖАНЧ - ھەنچىرە Хувцасны гадуурх нөмрөг, 风衣、斗篷。

ЖУРГААН - ھەنچىرە Цэргийн анги нэгтгэл, 军队单位。

ЖУУХ - ھەنچىرە Хааны зарлигийн бичгийн хүндэтгэл, 圣旨。

ЖИВЭР - ھەنچىرە Сахал, 胡子。

ЖУДИЙН ДАЦАН - ھەنچىرە / ھەنچىرە Гавж хүн 10-15 жил суралцаж, аграмба хэмээх эрдмийн цол хүртдэг. 得到 Гавж学位的喇嘛经过10至15年的学习，获颁 аграмба学位。

ЗАВА - ھەنچىرە / Иш үндэс гэсэн түвд үг. Дотоод 5 ухаанд гүнзгий мэргэшсэн хүнд олгох цол, 藏语，为掌握五种智慧的智者授予的称号，有根本之意。

ЗАЛАН - ھەنچىرە I Түшмэдийн хэргэм буюу мээрэнгийн туслах, зангиас нэг дэв илүү, 一种官衔。

ЗАЛАН - Jelea II Хошууны доторх цэрэг иргэний асуудал хариуцсан албан тушаал, 甲喇，又做扎兰，负责军民关系的官员。

ЗАНАБАЗАР - ھەنچىرە /1635-1723/ Монголын шарын шашны тэргүүн, төр соёлын зүтгэлтэн, 札纳巴札尔(1635-1723)蒙古黄教领袖。

ЗАМБУУТИВ - ھەنچىرە Энэтхэгийн замбуу модноос үүссэн нэр. 人间、人世。

ЗҮҮН ГАРЫН ХААНТ УЛС - ھەنچىرە / ھەنچىرە Баруун Монголын феодалын хаант улс, 准噶尔王国。

ЗАЙСАН - ھەنچىرە Манжийн үеийн ноёдын хэргэм, 清朝宰相。



ЗАНГИ - занги 150 цэргийн захирагч, 150个士兵组成单位的指挥官。

ЗАД - зад тэнгэр газар гэнэт хувирах, час бороо оруулах, шуурга шууруулах (Найманы Буйруг хан, Ойрдын Худуга бэхж хоёр задын аргыг мэдэх ажээ. Тэр хоёр зад барьтал мөн үүсгэсэн арга нь тэдэн дээр бууж балчигт гулгаж явах аргагүй болоход "Бидэнд тэнгэрийн хилэн болов" гээд бутран дутаажээ Монголын нууц товчоо 143-р зүйл), 天空突然变色，雨雪交加，狂风大作。

ЗОЧ - зоч Луийжинч лам, 诵经，驱邪的喇嘛。

ЗОНХОВ - зонхов Шашны их багш Лувсандаагын төрсөн газар, 罗桑扎巴的出生地。

ЗЭЭРЭМБЭ - зэрэмбэ Тооны ухааны дээд мэдлэг эзэмшсэн хүнд олгодог цол, 给数学家授予的最高称号。

ИЛДЭЧ - илдэч Монголын тулгар төр байгуулсны дараах цэргийн зохион байгуулалтын бүтэц /Алтанхуяг А. Туршуулч УБ. 2002 26-р тал/, 古代蒙古族建立国家后所设置的军队编制。

ИМХ - имх Эмх цэгц, журам, 秩序、制度。

ИДЭМ БЯРУУ - идэм бяруу -номхон, дөлгөөн, хөхүүл, 谦逊、稳重。

ЛАН - лан 10цэн 1 лан болно. 37,3 гр, 重量的计量单位，两，37.3克。

ЛАВРИН - лаврин Хутагт, хувилгаадын ямбаны орон сууц, 呼图克图、活佛的住所。

ЛХААРАМБА - лхарамба Шалгарсан лам нарт олгодог мяндаг, 为优秀的喇嘛授予的称号。

ЛҮН - лун Тарни унших зөвшөөрөл, эрх, 诵经的许可，权力。

ЛҮЙЖИН - луйжин Ухээрийн газар оршсон буг чөтгөрийг тонилгох зан үйл, 驱邪、驱魔。

ЛҮНДЭН - лунден Дээдсийн зарлиг, 祖训。

МАНАЛ - манал Эрүүл мэндийн бурхан, 佛教掌管健康的神佛。

МААРАМБА - марамба Мамба дацанд "Эмийн дөрвөн үндэс"-ийг судлан шалгарсан лам хүнд олгодог мяндаг, 在寺庙中研究“医学四大基础” (Эмийн дөрвөн

үндэс) 理论的喇嘛。

МАМБА - мамба Эмчлэхүй, 无法治愈的。

МАНЗШИР - манзшир Зөвлөн цогт, 精气神儿。

МАНГУД - мангуд Нирун аймгийн нэгтгэлд явсан эртний монгол аймаг. Дорнод аймгийн Халх гол сумын нутгаар мангуд овогтон нутаглаж байжээ, 古代蒙古部落名称，位于现东方省哈拉哈河一代。

МАНЖ ГО - манжго Зүүн хойт Хятадад Японы байгуулсан тоглоомын улс /1932-45/, 伪满洲国。

МАХБОД - махбод бодос /шороо, 乌斯, gal хийн язгуурын ерөнхий нэр/ Хар зурхайд /mod, gal, шороо, төмөр, us/, цагаан зурхайд /шороо, us, gal, хий, огторгуй/ багтана, 意为物质，在 Хар зурхай 中即为金、木、水、火、土，在 цагаан зурхай 中即为土、水、火、气。

МАХРАНЗ - махранз шашны ёсны үүд сахигч их хаан, 维护宗教规矩的掌权者。

МАЙЯА - майяа Бурхан багшийн эх, 佛祖的母亲。

МЭЭРЭН - мэрэн Ламын цол, хошууны санхүү, бичиг хэргийг эрхэлдэг албан тушаалтан, гутгаар дэв, 喇嘛的一种称谓，或者为在官府从事财政和文书工作的官员。

МИНДАГ - миндаг Эрдмийн зэрэгт хүрэгчид, 智者。

НАНЖВАНДАН - нанжвандан Нар сарны дурс бүхий хадаг, 有太阳和月亮形象的哈达。

НИРВААН - нирван Зовлонгоос ангижрах, 从苦难中脱离。

НИСВААНИС - иссан Уйлийн үр, атхаг муу сэтгэл, 佛教用语，指不好的行为。

НИСВААНИСЫН ТАВАН ХОР - иссанын таван хор /1.шунал 2.ур 3.мунхаг 4.атаа 5.омог/, 佛教中“五毒”：贪、嗔、痴、慢、疑。

НАЙДАНГҮЙ - наядангуй атаа, хорсол, 嫉妒。

НУГАН - нуган хөвгүүн, 男孩子。

НИГҮР - нигэр үүр, 脸。

НУУР БАЙРД БАЙЛДАХ - нур Байлдаанд нуур мэт өргөн дэлгэр байр эзлэн, нууранд юм живүүлэх адил дайсныг тал талаас нь бүслэн хааж, хэсэглэн цохих, 战斗中将敌人包围击破的



战术。

HYYP ДЭЭРЭЭС НЬ АСГАХ- **түүнчлэлийн тийрэл** Дайсны цэргийн тэргүүн эгнээний халз урдаас их хүчээр уулгалан довтлох, 战斗中朝敌人正前方猛攻的战术。

НОХОЙ ХЭРЭЛ ХЭРЭХ - **түүнчлэлийн тийрэл** Дайсныг өдөж хөдөлгөөд, дутаах дүр үзүүлэн, цэрэг агтыг нь сульдаан, буруулан дутааснаа эргэж ноцох гэх мэтээр нохой хэрэн хэсэн гүйх адил дайсныг туйлдаах арга. Өөрөөр хэлбэл хашир хүний башир арга, 战斗中使敌人疲于奔命的战术。

ОВООДОЙ - **түүнчлэлийн тийрэл** Малгай, 前额。

ОГТОРГҮЙ ЭРВЭЭЛЖЛҮҮЛЭХ - **түүнчлэлийн тийрэл** Дайсны анхаарлыг сарнилах, төөрөгдүүлэх, 战斗中分担敌人注意力的战术。

ОЛНОО ӨРГӨГДСӨН ОН - **түүнчлэлийн тийрэл** /1911-1924/, 共戴时期 (1911年至1924年)。

ОДБАГМЭД - **түүнчлэлийн тийрэл** /Цаглашгүй гэрэлт/ насан хутгийг хайлраж цаг бусын үхлээс гэтэлгэдэг бурхан, 佛教中让人从死亡中解脱出来的神。

ОЧИР - **түүр** Бат бэхийн бэлгэ тэмдэг, дан давхар хоёр янз байдгаас давхрыг нь "элдэв-очир" гэнэ. Очирыг аюул бүхнийг дарах бэлгэдлийн зүйл гэдэг. 佛教用语, 奥其尔, 意为可以避免一切灾祸的佛。

ОЧИРВААНЬ - **түүнчлэлийн тийрэл** Баруун мутартаянгыг бэлгэдсэн очир барьж, арслан, бар, баавгайг дагуулан хар хор, гай зэтгэрийг хааж, амар амгалан жаргаахын бэлгэдэл дүрээр цамын бужигт гардаг, 佛教用语, 奥其尔王, 象征着避免灾祸, 获得幸福的佛。

ОТОГ - **түүр** Нэгэн бүлэг айл өрхөөс үүссэн засаг захиргааны нэгж, 古代根据家庭人口数量划分的单位。

ОЛХИГЧИН - **түүнчлэлийн тийрэл** хов зөөгч, өв эвдэгч, 造谣者。

ОРВОН - **түүнчлэлийн тийрэл** Үндсээрээ байгаа дов сондуул, үндсээр нь сугалсан өвс, 根, 本。

ОРЧИХ - **түүнчлэлийн тийрэл** Эргэн тойрон хааж, тал талаас нь довтлох, 战斗中的围攻战术。

ОГЖАТГАХ - **түүнчлэлийн тийрэл** Ов хэрэглэн дайснаа цочир айлган самгардуулах (Галаар огжатгах), 战斗中突然惊吓敌人的战术。

ӨЛХӨГ - **түүнчлэлийн тийрэл** тоос, шороо, 沙尘。

ӨДӨЖ ХӨДӨЛГӨХ - **түүнчлэлийн тийрэл** Дутаах мэт дүр үзүүлэн хуурмагаар ухарч, хүчийг нь тарамдуулан отоонд оруулах, 战斗中佯装逃走, 突然回头进攻的战术。

РИНБҮҮЧИ - **түүнчлэлийн тийрэл** Эрдэмт хувилгаан, 藏传佛教中一种活佛的称谓。

САХИЛ - **түүнчлэлийн тийрэл** Сэтгэлийн сахилга /Сэтгэл сахилгатай бол бие сахилгатай/, 指人内心的敬畏, 品质。

САЦАЛ - **түүнчлэлийн тийрэл** Сүүн сацал тэнгэр бурхандаа өргөх, 蒙古人用奶敬天的习俗。

САРТУУЛ - **түүнчлэлийн тийрэл** Төв Азийн Иран хэлтнийг хэлдэг байсан бол хотон, уйгар, тангад зэргийг нийтэд нь нэрлэх болж, улмаар Дундад Азийн иргэд, худалдаачдыг нэрлэх болсон, 蒙古人对中亚地区维吾尔族、回族等民族的旧称。

СОЙВОН - **түүнчлэлийн тийрэл** Ноёдын бараа бологчдын ахлагч, 官员随从中的头目。

СЭВЛЭГ, ӨРӨВЛӨГ - **түүнчлэлийн тийрэл** Yc, 头发。

СОРОНЗОН ГҮР - **түүнчлэлийн тийрэл** Соронзон чулуу, 磁石。

СҮГЭР - **түүнчлэлийн тийрэл** Сургаал, 学说, 理论。

СӨГӨӨЖ - **түүнчлэлийн тийрэл** зэмлэх, буруушаах, 批评, 指责。

САМШААГААД - **түүнчлэлийн тийрэл** дарах, мөнөөх, 按压、另。

ТАЙЖ - **түүнчлэлийн тийрэл** Хааны хөвгүүн гэсэн хятад уг, 汉语, 贵族, 源于汉语太子一词。

ТАВНАН - **түүнчлэлийн тийрэл** Тайжийн охиныг эхнэр болгосон хүн, 出嫁成为妻子的贵族女儿。

ТАХИЛГА - **түүнчлэлийн тийрэл** Тахих үйлийн ерөнхий нэр, 祭祀, 祭拜。

ТАЙЛГА - **түүнчлэлийн тийрэл** Амьд амьтныг золиослох зан үйл, 祭品, 牺牲。

ТАХИЛЧ - **түүнчлэлийн тийрэл** Хийдийн лам нараас бурхан тахилын ажил эрхлэгч, 寺庙中负责祭拜工作的喇嘛。

ТАХАР - **түүнчлэлийн тийрэл** Хошуу тамгын газрын зарлага, томилох илгээх гэсэн утгатай манж уг. /Хууль зүйн яамны харьяа тахарын алба нь шүүх шүүгчийн аюулгүй байдлыг хангах, гэрч, хохирогчийг хамгаалах, яллагдагч, ялтныг хуяглан хүргэх, хуяглан харгалзах, оргон зайлсан яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах чиг үүрэгтэй агентлаг/, 满语, 塔哈尔, 指旗行政机构下达的命令。



ТАЛ БИЧЭЭЧ - тал үеийн туслах бичээч, 文秘，助手。

ТОНЬЮОҮКҮК - 646 он/Түрэгийн мэргэн сайдын дурсгалд зориулсан гэрэлт хөшөө Налайхаас зүүн урагш буй. 瞰欲谷之墓，瞰欲谷系后突厥汗国贵族。

ТОЙН - Тайжийн хүү, тайжийн хэргэм залгамжлаагүй лам болсон хүн, 贵族家庭中中出没有继承贵族位置，成为喇嘛的子嗣。

ТОРЛОГ - Нарийн хулс, бургасаар хийсэн мод, 用较细的树枝支撑的木棍

ТОЙРОХ - Ар хударгаар нь ороох, 战斗中采取迂回包围的战术。

ТАЙГАМ 1 - Сүрэг адуулах хүн, 牧马人。

ТАЙГАМ 2 - сахиул, 护卫，守卫。

ТАХАР - Хошуу тамгын албан зарлагын ажил хийдэг хүн, хууль сахиулагч, 地方行政机构工作人员，执法人员。

ТҮШЭЭ - Цэргийн онцгой гавьяатанд олгодог цол, 军队为特别功勋者授予的勋章。

ТОРГУУД - Торгон цэрэг, 禁卫军。

ТАРНИ - Сэтгэлийг ивээгч үг буюу жинхэнэ үг, сэтгэхүйн үг /Тарнийг эр эм, саармаг хэмээн ангилсан байх бөгөөд эр буюу арга талын тарни нь ХҮМ, эм буюу билиг тарни нь СҮҮХАА, саармаг буюу БОДИ тарни нь НАМО хэмээн төгсөх учиртай гэдэг. Тарни орон зайлгэвтэлдэг/, 梵文宗教著作。

ТИЙЗ - Мөнгөн гүйлгээнд хэрэглэж байсан цаасан тэмдэгт, 票。

ТҮВЭЛДЭХ - учран золгох, 约见。

ТЭЛЭРЧ - ухаарах, сэхээрэх, 启发。

ТЭНСЭН МЭД - сорьж шинжик мэдэх, 通过试验获得知识。

ТУРХАРУУ - турш, үргэлж, 时间副词，表示时间的持续。

ҮНЗАД - Хурлын уншлагыг толгойлогч, 带头诵经的喇嘛。

УЛАА - Албан хэргээр явахад ардын хөрөнгөнөөс унах эдлэх эрхийг олсон хүний хэрэглэх уналга, 指官府信使出于公事而征用平民的骑乘。

ҮҮРГЫН УЛАА - Аль тохиолдсон адуунаас морь барьж хэрэглэх, 官府信使征用的平民马匹。

УЛАА БАРИХ - Уналга хөсгийг албадан хэрэглэх, 指官府信使征用平民马匹的行为。

УЛАА НЭХЭХ - Уналгаа авахаар дагах, 官府信使每隔一段距离换一次马匹。

УЛАА ШҮҮС - Уналгаа Элчийн хоол унд, 官府信使人员的食品。

УЛААНЫ ЗАР - Улаа хэрэгсэх үнэмлэх бичиг, 官府人员用的证件。

УРИН - үр үр хилэн, 生气，怒气。

ҮТЭЛ МУНХАГ - Сул дорой, энгийн, 普通，弱小。

ҮСЭД ХОЛ - Үзүүлж алас хол, маш хол, хэтэрхий хол /Субашидаас/, 特别远。

ЦЭРГИЙН ЗАСАЛ СҮЛБЭРХИЙ - Бэлтгэл сургууль дутуу, (军队) 缺乏训练。

ХАВАН - Зангиин хавсрэгч, 军队长官的助手、副职领导。

ХАМБА ЛАМ - Шашны хурал номын хамгийн дээд хэргэм, 堪巴喇嘛，宗教会议上最高等级者。

ХАНГИРЧ - Одох, өнгөрөх, 度过、经过。

ХАРИН ТАТАХ - Гэнэт эргэж буцан дайрах, огцом эргэж буцаж одох, 战斗中佯装逃跑，突然回击的战术。

ХАРГАНА ЗОРЧИЛ ЗОРЧИХ - Бут сөөгөөр ургадаг харгана мэт цөөн хүнтэй бүлгүүд таруу байдлаар давших, 战场上，小部分人采取类似公牛顶犄角的阵型战术。

ХИЛС - буруу, ташаа, 错误。

ХОНЖИН - Төрийн хууль сахиулагч, төрийн бодлогыг тайлбарлан таниулах эрх бүхий албан тушаалтан / Баярсайхан Б. "Монгол Улсын арван буянт номын цагаан түүх" УБ 2002 41-р тал/, 古代遂行捍卫和解释国家法律的官员。

ХУНТАЙЖ - Юань төрийн үед хаан ширээ залгамжлах хөвгүүд, 元朝时期对王位继承人的称谓。

ХЭВТҮҮЛ - Шөнийн манаач, 守夜人，打更人。

ХИШИГТЭН - Ээлжийн харгалзагч, 护卫。

ХОРЧИН - Нум сум агсагч, 发射箭的装置。



ХОХЬ ТАЙЖ - ᠬᠥᠬ ᠮᠻᠳᠥᠱ Ядуу тайж, 贵族中的家境贫困者。

ХУТАГТ - ᠬᠥᠮᠤᠯᠥᠱ Далай лам, манжийн хаанаас олгосон цол, 呼图克图, 活佛称谓。

/1.Жалханз 2.Ялгуусан (бүрмөсөн дийлсэн) 3.Хамба 4.Нарванчин 5.Наран 6.Номунхан 7.Шиваа ширээт 8.Чин сужигт 9.Зая бандид 10.Эрдэнэбандид 11.Эрдэнэ мэргэн ноён 12. Ялгуулсан (Ялгасан)13. Жавзандамба/

(Дилав хутагт Жамсранжавыг Япончууд баривчлаад "Гадаад Монголын тагнуул" гэж хэрэг хүлээлгэх гэхэд "Би шашны хутагт хүн" гэжээ. "Тэгвэл тэр шидийг чинь үзье" гээд мод овоолж байгаад шатаасны хойно "Тий, тий яласан хүйтэн юм бэ" гээд дээлийнхээ үнсийг сэгсрэн босч ирсэн гэдэг. Энэ яриа үнэн эсэхийг бид мэдэхгүй. Харин 1966 оны аюултай үер болоход гэр маань урсаад явчихсан, ганц авдар л үлдсэн байсан. Тэгэхнээ Жамсранжав ахаас үлдсэн хэдэн судар, дөрвөн шил архи отгхон ч нороогүй байсан тухай тэр их хүний зээнцэр дүү Ш. Чагнаадорж Өдрийн сонини 2014.04.08 №085-д бичжээ)

ХАВАН - ᠬᠥᠮᠤᠯᠥᠱ Манжийн албанд зүтгэсэн харц хүн, хяа нарын дарга, 满清时期平民中有低级别官职的人。

ХАН - ᠬᠥᠮᠤᠯᠥᠱ Аймгийн хан Цэцэн хан, Түшээт хан, Сайн ноён хан, 汗, 蒙古人对统治者的称谓。

ХАРГАМ - ᠬᠥᠮᠤᠯᠥᠱ морины хондлой, 马脊背的末尾处。

ХҮРЦ БУЛХА БУЛХАЛДАН - ᠬᠥᠮᠤᠯᠥᠱ, ᠬᠥᠮᠤᠯᠥᠱ /Шируүн дайтах, 战争, 侵略。

ХУРМАСТ - ᠬᠥᠮᠤᠯᠥᠱ 33 тэнгэрийн хамгийн дээдэх, Эсруа ч гэдэг, 33层天的最顶层。

ХУВИЛГААН - ᠬᠥᠮᠤᠯᠥᠱ Өөр зүйлд хувилж чадах оюуны увдист хүн, 活佛。

Оюуны увдис: Хүний оюуны увдис агуу их гэдэг. Оюун бол амьдралын нэвтэрхий толь мэт шаардлагатай мэдээллээр ухааныг хангаж байдаг. Оюуныхаа хүчээр хүн далд байгаа, нүдэнд өртөхгүй, үл харагдах зүйлийг ч олж харах чадвартай байдаг. Ийм хүмүүсийг үзмэрч гэдэг.

[*Шинжлэх ухаан гэж бидний нэрийддэг танин мэдэхүйн арга маань өөрийн хүрээ хязгаараас хальсан ойлголтод туйлын харгис хатуу хандаж, хүний дотоод мөн чанар, орчлон хорвоогийн нууцыг таньж нээсэн үзэл номполыг "шашны бурангуй үзэл" гэдэг нэрийн доор хавчин хяхсаны улмаас өнөөгийн хүн төрөлхтөн байгаль ертөнцөө хөнөөгч хар хүчин болж хувираад буй энэ цаг үед далд ертөнцийг шимтэн судлах нь туйлаас чухал болж байна]*

- Оюуныхаа хүчээр хүн далдыг сонсох, далд зүйлийг эрж хайгаад олох чадвартай болдог. Ийм хүмүүс "очир гүйлгээд" хулгайчид алдсан, гээсэн зүйлийг хайж олдог байжээ.
- Оюуныхаа хүчээр хүн биеэ хөнгөрүүлэн хөөргөх чадвартай болдог. Энэтхэгийн физикч Махаришийн шавь нар лянхуа суудлаасаа газраас 1-2 метр хөөрч 50 метр газрыг 23 секунтэд туулсан гэдэг.
- Оюуныхаа хүчээр хүн өөрийгөө хоромхон зуурт алс газарт шилжүүлэх чадвартай. Ийм хүмүүсийн нэг нь гоц чадвартан Uri Геллер юм. Ийм хүнийг монголчууд "газар товчилдог" хүн гэж ярьдаг. Дэмчиг лам гэдэг хүн "бороо хариулдаг" төдийгүй, газар товчилдог байсан гэдэг.
- Оюуныхаа хүчээр хүн элдэв саадыг нэвтрэх чадвартай. Энэтхэгийн алдарт йогч Трайланга ямарч бат бэх цоож, харуултай шоронд орсон ч гадаа гарчихсан дуртай газраа гүйж явдаг тухай "Далд ухамсын чанагш" номын 67 дугаар талд бичсэн байдаг.
- Оюуныхаа хүчээр хүн эд юмсыг хөдөлгөх чадвартай. Энэ тухай алдарт Марко Пологийн "Орчлонгийн элдэв сонин" номын 82 дугаар талд бичихдээ "... Ордны гол танхимд их хааны морилох 8 төөөндөртэй ширээнээс 10 алхмын



хол зайтай газарт өрөөстэй хоосон аягануудыг мэргэн домч нар нь шившмэгц дүүрэн сүү, архи дарсаар бялхан аяганууд өөрөө хөөрөн хааны өмнө хүрч очдог байсныг миний адил түмэн хүн харсан хуудуугүй, чин үнэн болой..." хэмээжээ.

- Оюуныхаа хүчээр хүн бусдын бодлыг унших, бусдад бодол санаагаараа нөлөөлөх, ирээдүйгээ мэдрэх чадвартай.
- Гоц чадварыг эзэмшүүлдэг элдэв арга ухаан, онол сургаал байдгийн нэг нь нууц тарнийн ухаан юм. Энэ ухаанд нэвтэрч шидийг олсон хүнийг оюун билгээс хэтийдсэн буюу "билгийн чанад хязгаарт хүрсэн" гэж нэрлэдэг. Энэ нь таван сэрэл мэдрэхүйг сэтгэлээр жолоодон, гүн бясалгалаар сэтгэхүйг нэгэн зүйлд чиглүүлэн удирдахаар ухамсын эгэл төвшнөөстасран гоц мэдрэхүйд шилжих үзэгдэл бололтой. Товчоор хэлбэл биеийг сэтгэлээр захирна гэсэн үг ажээ.
- Төвдийн нууц тарнийн ухаанд мэргэшиж шидийг олсон лам нарыг туршихаар далай ламаас зөвшөөрөл авсан америкийн эрдэмтэд өвлийн шөнийн хүйтэнд тэднийг цасан дээр нүүцэн суулгаж, биеийг нь нойтон алчуураар ороогоод бясалгал хийлгэхэд нойтон даавуу нь хатаж байжээ.
- Их нууц тарнийн ухаанд нэвтэрч шидийг олсон их тарничид бидний адил гурван хэмжигдэхүүнт орчлонд хашигдаж байдаггүй, олон хэмжигдэхүүнт орчлонд орж чаддаг гэж үзэх бөгөөд тэд нисэж, агшин зуур алсад одож, ирээдүй, өнгөрсөн цагт очих, харь гараг, сансрын уудам дахь бусад орчлонд зорчиж болдог гэх бөлгөө. /Д.Төмөртогоо Тарниар эмчлэхүй УБ 2006 7-р тал/

Энэ мэтчилэн хүнд нуугдмал их уvdис байдаг боловч хүн бүр түүнийг ашиглах арга ухааныг эзэмшиж сураагүй байдаг

ажээ.

Профессор Ц.Няндаг /Оюун ухааны тухай өгүүлэл УБ. 2004/

ХИА - ᠬ ᠤ ᠥ Ноёдод үйлчлэх доод тушаалтан, 古代官府人员的最低职位，衙役。

ХҮЖ БАРИХ - ᠭ ᠤ ᠥ Ах дүүс болох, 结拜。

ХҮРЭЭЛЭХ - ᠭ ᠤ ᠥ Дайсан довтлох үед тэрэг хөсгөө хүрээлүүлэн, шивээ хаалт босгоод, хориглон тулалдах, 战斗中防御 敌军进攻的一种阵型，即用车把部队围起来，全员聚拢。

ХӨЛГӨН - ᠭ ᠤ ᠥ Бурхны шашны сургаал ёсоор эрдэм ухааныг гэгээрэлд хүргэх хөлөг, уналга гэж үзэж байснаас үүдсэн нэршил, 佛教术语，意为将启发人比作给予人骑乘。

ЦАДИГ - ᠭ ᠤ ᠥ санскр ЖАТАКА / бурхны зохиолын өвөрмөц төрөл зүйл, 古代佛教著作。

ЦАХАР - ᠭ ᠤ ᠥ XIY-XVII зууны Дорнод Монголын Зүүн гурван түмний нэг. Хаад ноёдын тортон цэргийн нэр. Манж нар Өвөрмонголыг эзлээд Цахарыг 8 хошуу болгон хуваасан, 察哈尔，古代蒙古族部落名称。

ЦАНИД - ᠭ ᠤ ᠥ Буддын гүн ухаан, 研究世间万物规律的佛教学说。

ЦАЦАЛ - ᠭ ᠤ ᠥ Цагаан идээг өргөх / 1. цацал цацаж, ӨЧИЛ ӨЧИХ-хатуу ундаа өргөх 2. Юмыг бутартал хаях, цацах -шороо, будаа, ус гм/, 使用奶食进行的祭拜仪式。

ЦОГЧИН - ᠭ ᠤ ᠥ Залбирал, уншлага голлосон хурал, 诵经，祈祷。

ЦҮҮЦЭН ХАТГАЛДАА ХАТГАЛДАХ - ᠭ ᠤ ᠥ / ᠭ ᠤ ᠥ Цүүцээр цөм хатгах мэт дайсны цэргийн жагсаалыг цөмлөн сэтлэх арга, 战争中，部队使用类似凿子插入一样的攻击阵型，穿插战斗。

ЦУЦАР - ᠭ ᠤ ᠥ шантар, 畏惧。

ЦЭН - ᠪ / 4 грамм, 重量计量单位 , 4克。

ЦУН - ᠪ Уртын хэмжээ /1,5-3 см/, 寸, 长度计量单位 (1.5-3厘米)。

ЦӨЛИЙДӨХ - ᠭ ᠤ ᠥ доройтох, буурах, 衰弱，衰减。

ХЭЛХ - ᠪ хамаг, бүгд, нийт, даяар, хотол, 全体，所有，全部。

ЧАРАЛБАА - ᠭ ᠤ ᠥ буруу номтон, (宗



教) 异端。

ЧАГУУРАХ - چاگۇرال ئايىن دايىند موردوخ,
启程。

ЧЕРБИ, ЧИНСАН - چەربى · چىنسان سайд,
领导。

ЧОЙГО - چۆگۈز نومىن хувцас буюу
биеэсээ салгалгүй авч явах зүйл, 喇嘛不能
离身的物品。

ЧОЙЖИН - چۆجىن نومىن сахиус буюу
шашны бөө, 萨满。

ЧИН УЛС - چىن یولىت ارىيۇن ىللىق, 清朝 ,
满清。

ЧИНСАН - چىنسان شادар сайд, 副职领
导。

ЧИЛЭЭРХЭХ - چىلەرھەخ Өвдөх, 疼痛。

ЧИВЭЛТ - چىۋەلت ھۇغىلەت, 有罪的。

ШАХАА - چەخى ئىسىر سىزگى بىشىرلىكىن
холбогдолтой нэгэн зүйл цээрлүүлэл, 一种
惩戒方式。

ШИРЛЭХ - چىرلەخ Толгойг нь ил гарган
нойтон ширэнд боож үдээрээр үднэ, 用牛
马潮湿的皮包住头的行为。

ШАР ШУВТЛАХ - چەر چەپتىلاخ Шашны
ёсыг зөрчсөн лам хүрээ хийдээс бүрмөсөн
хөөгдөхийг хэлнэ, 将违反教规的喇嘛驱逐
出寺庙的行为。

ШАНЗДУБА - چىنچىن تامгатай хутагтын
шавь нарыг захирах албан тушаал, 寺庙中
负责管理学徒的职务。

ШАВРАН - چەپىرەن Угсаа залгаагүй,
цолгүй хувилгаан, дахин төрөл ологч, 级
别较低的活佛。

ШАР ФЕОДАЛ - چەر چەپтەن лам, 喇嘛。

ШАШТИР - چەپتەن судар, түүх, ном, зөвийг
ухуулан таниулах, 著作, 创作。

ШИВШҮҮР - چەپتەن гаанс 烟斗。

ШИЛЖИРЧ - چەپتەن ئايىسۇي, 接近。

ШАЛБУУР - چەپتەن Өмд, 裤子。

ШҮҮС - چەپتەن Үүц, 羊的臀部。

ШИВЭРГЭЛ - چەپтەن ЭМЭГТЭЙ хүний
сулжсан гээг, 女性发辫。

ЭР ТӨӨЛӨХ - چەر چەپتەن 18-60 насны
эрийг 3 жил тутам нэг удаа бүртгэхийг
хэлдэг. 18至60岁的男性每3年进行一次兵
役登记制度。

ЭРДЭНИЙН ТОВЧ - چەپتەن چەپ / چەپتەن

Монголын түүхийн сурвалж бичиг.
Ордосын Саган сэцэн 1662 онд зохиосон,
蒙古历史学著作，由历史学家 Саган сэцэн
于1662年编纂。

ЭРДЭНИЙН ЭРИХ - چەپتەن چەپ / چەپ
Монголын түүхийн сурвалж бичиг. Халхын
түүхч Галдан 1841 онд зохиосон, 蒙古历史
学著作，由历史学家嘎拉登于1841年编纂。

ЭРДЭНЭ ШАНЗДУДБА ЯАМ - چەپتەن
چەپتەن چەپ / چەپ
Төр шашны хэргийг хослон
эрхэлсэн шашны захиргааны газар. Их
шавийн яам ч гэдэг, 处理国家和宗教事務
的机构。

ЭЭП - چەپтەن Хааны хүргэн, 驹马。

ЭРВЭЭЛЖ - چەپтەن Әмәэл, 马鞍。

ЭСЭНЛЭХ - چەپтەن төрөхийн хүндэтгэл /
Мандухай хатнаас 7 Болд эсэнлэв/, 生孩子的
的敬语。

ЭТҮГЭН - چەپтەن газар дэлхий, 世界。

ЭТҮҮЖ - چەپтەن үүдэж, 产生, 缘起。

ЯВДАГ ХЭЛТ - چەپтەن چەپтەن Ховч, хутган
үймүүлэгч, 造谣者, 告密者。

АВАЛДАЖ - چەپтەن /барилдаж/

чамд ялагдааас Унасан газраасаа бүү
боссугай, 摔跤。

ОНТУСАЖ - چەپтەن /сүр харваж/,
射箭。

чамд **ГАРТВААС** - چەپтەن /дийлдэх,
ялагдах/, 失败。

Эрхийгээ оттолж **ООРСУГАЙ** -
چەپтەن /орхих, гээх, хаях/, 丢弃、抛弃。

ДҮГНЭЛТ

1. Монголын түүх, соёлыг сайтар
ойлгож ухааraphын тулд хуучирсан
үг хэллэгийн утгыг зайлшгүй мэдэх
ёстай. Тиймээс Монголын түүх,
соёлыг танъж ухааraphад нэн тустай.
2. Хуучирсан үг хэллэг нь орчин
цагийн Монголын утга зохиолын
хэлэнд хүндэтгэлийн утгаар
хэрэглэгдэх болсон.
3. Хүндэтгэлийн үгийг түлхүү хэрэглэх
чадварыг эзэмшивэл найруулга төгс
болно.

**Ашигласан материал:**

- | | | |
|----|--|---------|
| 1. | Арьяасүрэн Ч, Нямбуу Х. Монгол ёс заншлын бага тайлбар толь | УБ 1990 |
| 2. | Арьяасүрэн Ч, Нямбуу Х. Монгол ёс заншлын дунд тайлбар толь | УБ 1991 |
| 3. | Бат-Ирээдүй Ж, Арьяасүрэн Ч. Монгол ёс заншлын их тайлбар толь | УБ 1999 |
| 4. | Болод Д, Эх хэлний утга найруулга, соёл | УБ 2016 |
| 4. | Намжав Д. Ардын алтан сургаал | УБ 2009 |
| 5. | Цоодол И.Монгол ардын уламжлалт ёс, зан үйлийн дээж | УБ 1991 |
| 6. | Янжиндолгор А. Монгол хэлний хураангуй тайлбар толь | УБ 2009 |



ТЭНЦВЭРГҮЙ ДАЙНЫ ОНОЛ, ХҮЧИН ЗҮЙЛС БА ЧИГ ХАНДЛАГА

Б.ЭНХБАТ /УБХИС-ийн ЦНС-ийн АДХТ-ийн
ахлах багш, доктор, дэд хурандаа/

Түлхүүр үг: Хүч тэнцвэргүй дайн, хүчин зүйлс, зэвсэгт тэмцэл, дайны зарчим,
мэдээллийн дайн, зөрчилдөөнт байдал, агаарын довтолгооны хэрэгслүүд, пуужингийн
цогцолбор, цэргийн нисэх хүчин, тэнгисийн флот

Key words: Asymmetric war, factors, armed struggle, principles of War, Information warfare,
contradictionmissile system, Air attack means, missile complex, Air Force, navy.

Шинжлэх ухаан техникийн хөгжил улам бүр ахин дэвшиж, хөгжлийн түвшин нэг шатнаас дараа дараагийн шинэ шатандaa ээлж дараалан шилжиж байгаа өнөө үед энэхүү хөгжил дэвшил нь улс орны хөгжил, улс төр, эдийн засгийн байдал, хүмүүсийн ахуй амьдралын орчин, нийгмийн нөхцөл байдалд өөрийн нөлөөлөл, тусгалаа олж өөрчлөл, шинэчлэлд хүргэсээр байгаа билээ. Энэ бүхэн нь улс орнуудын Зэвсэгт хүчний болон бусад цэргийн бүлэглэлүүдийн хүчин чадал, тэдгээрийн хооронд явагдах дайн байлдаан, зэвсэгт тэмцлийн шинж чанарт өөрийн нөлөөллөө үзүүлдэг байна.



Зураг 1. Дэлхийн улс орнуудын хөгжлийн түвшинг тодорхойлж буй хүчин зүйлс

Орчин үеийн дайн байлдаан, зэвсэгт тэмцлийд нь улам бүр ээдрээтэй бөгөөд улс төр, эдийн засаг, газар нутаг, хүн хүч гэх мэт олон хүчин зүйлсийн хувьд харилцан адилгүй нөхцөл байдалд явагдах болсон.

Asymmetric war буюу тэнцвэргүй дайн нь төрийн болон төрийн бус шинж чанартай харилцан адилгүй хүчин чадал бүхий талууд үндэсний болон олон улсын

хэмжээнд бие даан эсвэл хамтын хүчээр тавьсан зорилгоо биелүүлэхдээ зэвсэгт тэмцэл, хүч хэрэглэх замыг сонгох үед бий болно.

Дараах ёгт зургаар тэмцэлдэгч талуудын хүч тэнцвэргүй байдлыг дүрслэн харуулж болох юм.



Зураг 2. Тэмцэлдэгч талуудын хүчний харьцаа

Тэмцэлдэгч талуудыг хүч тэнцвэргүй болгоход дараах хүчин зүйлс нөлөөлнө.

Хүч тэнцвэргүй болгох хүчин зүйлс:

- Цэргийн чадавхийн ялгаанууд;
- Бэлтгэл сургуулилт, туршлагын зөрүү;
- Эдийн засаг, санхүүгийн боломж харилцан адилгүй;
- Улс орны хөгжлийн түвшин өөр;
- Олон улсын ямар нэгэн байгууллага, холбооны гишүүн эсэх;
- Холбоотон, түншлэгч эсвэл дэмжигч улсуудын хүчин чадал;
- Хэвлэл мэдээллийн хүчин чадал харьцангуй;
- Шинэ эмзэг байдал, давуу ба сул талуудтай;
- Хохирол амсах магадлал харилцан



адилгүй;

- Ёс суртахуун, үзэл бодлын зөрүүтэй Г.М.

Харин тэнцвэргүй дайн нь дараах хэлбэрүүдээр явагдаж болно.

Хүч тэнцвэргүй дайны хэлбэрүүд:

- Харилцан адилгүй хүчин чадалтай Зэвсэгт хүчинүүдийн хооронд явагдах дайн тулаан, зэвсэгт тэмцэл;
- Хувьсгал хийх;
- Бослого гаргах;
- Одоогийн засгийн газрыг огцруулах;
- Партизаны дайн явуулах;
- Террорист ажиллагаа;
- Улс төрийн дайн;
- Мэдээллийн дайн г.м.

Сүүлийн хэдэн арван жилд болж өнгөрсөн дайн тулаан, зэвсэгт тэмцлийн туршлага, сургамжаас үзэхэд тэнцвэргүй дайны үед дараах зарчмууд үйлчилдэг байна.

Хүч тэнцвэргүй дайны зарчмууд:

- Төрийн хүчинд найдах;
- Дотооддоо бусдын дэмжлэгийг авах;
- Олон улсын дэмжлэгийг авах;
- НҮБ-д хандах, дэмжлэг авах хүсэлт гаргах;
- Улс төрийн аргыг хэрэглэх;
- Ард түмний дэмжлэгийг авах;
- Партизаны дайн явуулах;
- Террорист ажиллагаа явуулах;
- Мэдээлэл, сурталчилгаа явуулах;
- Кибер халдлага явуулах, эсвэл түүний эсрэг кибер аюулгүй байдлыг хангах тэмцлийг явуулах гэх мэт.

Тэнцвэргүй дайны онцлог шинж чанарууд, хүч тэнцвэргүй болгож буй хүчин зүйлс, баримтлах зарчмуудыг сүүлийн үеийн зарим нэг дайн байлдааны жишээн дээр товчхон авч үзье.

Америк - Вьетнамын дайн /1956-1975/

Вьетнам улс нь Ази тивд байрлалтай бөгөөд Номхон далайд гарцтай, хойд талаараа Хятад улс, баруун талаараа Лаос, Камбодж улсуудтай хил залгаа оршино. Харин 1950-иад оны эхээр Вьетнам нь өөр өөрийн үзэл баримтлал, цаашдын хөгжлийн замыг сонгосон Хойд ба Өмнөд

Вьетнам болон хоёр хуваагдсан байна.

Хойд Вьетнамын цэргийн хүч нь албан ёсны Зэвсэгт хүчин ба сайн дурын нэгдсэн бүлэглэл болох Улс төрийн фронтоос бүрдэж байсан баттүүнийг ЗХУ, Хятад улсууд идэвхтэй дэмжиж, Лаос, Камбодж улсуудын зүгээс дэмжих байр суuriyg баримтлаж байв. Харин Өмнөд Вьетнамын цэргийн хүчийг албан ёсны Зэвсэгт хүчин бүрдүүлж, АНУ, Солонгос,, Тайланд, Австрали, Шинэ Зеланд улсууд нь түүнийг дэмжиж байлаа.



Зураг 3. Вьетнамын газарзүйн байрлал

Хойд Вьетнамын үзэл баримтлал:

- Нэгдсэн Вьетнам улсыг байгуулна.
- Коммунист намын удирдлаган дор хөгжинө.
- Социалист орнуудтай хамтын ажиллагаа явуулна.

Өмнөд Вьетнамын үзэл баримтлал :

- Хойд талынхаас бие даасан байдлаа хадгалж үлдэнэ.
- Коммунизмын эсрэг тэмцэнэ.
- АНУ-ын дэмжлэгийг авч хөгжинө.

Дайны эхэн үед Америкийн цэргийн хүчин идэвхтэй газрын болон агаарын дайралтуудыг үр дүнтэй явуулж Хойд Вьетнам ихэд хохирол амссан байна. Гэвч тун ч удалгүй тэд нь хурдан хугацаанд дайны цагийн байдалд тохирсон өөрсдийн тактикийг боловсруулан



хэрэгжүүлж, туршлагажин партизаны дайныг амжилттай явуулж эхэлсэн. ЗХУ нь зэвсэглэл техникийн дэмжлэгийг тулхүү үзүүлж, бие бүрэлдэхүүнийг сурган дадлагажуулж байсан нь ч дайны нөхцөл байдлыг эргүүлэхэд их нөлөө үзүүлжээ. Ялангуяа Америкийн цохилтын гол цөм болох Агаарын довтолгооны хүч хэрэгслийдийн эсрэг тэмцэх боломжийг олгосон "С-75" загварын зенитийн пуужингийн цогцолборыг нийлүүлж байсан нь шийдвэрлэх үр дүнгээ өгсөн гэж үздэг байны явцад тухайн цогцолбороор АНУ-ын том жижиг нийт 1200 гаруй онгоцыг устгасан тоо баримт байдаг байна.

Дайны дунд үеэс эхлэн Америкийн цэргийн амсах хохирлын тоо улам бүр нэмэгдэж, цэргүүдийн ч урам зориг, байлдах итгэл үнэмшил үгүй болсон. Нэг өдөр амь үрэгдсэн дайчдын тоо 300 хүрч байсан тохиолдол ч гарч байв. Мөн Америк улсад дайны ажиллагааг зогсоох эсэргүүлийн жагсаал цуглаан улам бүр идэвхжиж, бослого гарахад бэлэн болсон байлаа. Энэ бүхэн нь Америк улс дайнд ялагдал хүлээж, цэргээ татахад хүргэжээ.



Зураг 4. Амь үрэгдсэн америк цэргүүдийн цогцсыг буцаан илгээж байгаа нь

Ийнхүү Америк-Вьетнамын дайнд АНУ ялагдсан шалгааныг шинжлэн үзвэл дараах дүгнэлтийг хийж болох юм.

АНУ ялагдал хүлээсэн шалтгаан:

- Дэлхий нийтэд Вьетнамд явуулж буй дайныг зөвтгөн тайлбарлаж чадаагүй /мэдээллийн дайнд ялагдсан/.

- Төрийн ард түмэнд дайны зорилгыг тайлбарлаж чадаагүй тул ард түмний дэмжлэгийг аваагүй.

- Цэрэг дайчиддаа мэдээлэл сурталчилгаа явуулаагүй /суртал ухуулгын/.

- Вьетнамын дайчид эх оронч сэтгэлээр итгэл үнэмшилтэй тэмцсэн, өөрсдийн тэмцлийн зорилго үнэн зөв гэдэгт итгэл дүүрэн байсан.

- Орос улс зэвсэглэл техник, мэргэжлийн боловсон хүчинээр тусалсан.

Орос - Украина зэрчилдэөн

1990 оны эхээр урьдын дэлхийд тэргүүлэх том гүрний нэг болох ЗХУ задран унасан ба үүний үр дунд олон бие даасан тусгаар улсууд үүсэн бий болжээ. Энэ цаг үеэс эхлэн ЗХУ-ын суурийг хадгалан үлдсэн Орос улс ба түүнтэй хил залгаа шинээр бие болсон Украина, Гүрж зэрэг улсуудын хооронд зөрчилдөөнт байдал, үл ойлголцол гарч эхэлсэн байна.



Зураг 5. Украина улсын газарзүйн байрлал

Украинд ард түмний бослого, хөдөлгөөн удаа дараа гарч, эмх замбараагүй байдал үүссэн ба энэ нь эцэстээ үндсэргэг үзэлд хөтлөгдсөн иргэний дайн гарахад хүргэжээ. Үндсэргэг үзэлд автсан хөдөлгөөн газар авч улсын харьяанд орших орос удам гаралтай иргэдээ хавчин гадуурхаж, орос үндэстэн давамгайлан орших хот, мужуудын эсрэг байлдааны ажиллагаа явуулж эхэлсэн байна.

Харин ОХУ-ын зүгээс энэ байдлыг эрс шийдвэртэйгээр эсэргүүцэж байсан бөгөөд энэ ч үүднээс 2014 оны 3 сард ерөнхийлөгч В.В.Путини шийдвэрээр Украина орос гаралтай иргэд давамгайлан амьдардаг



Крымын хойгийг тус улсын харьяалалаас салган ОХУ-ын бүрэлдэхүүнд оруулан нэгтгэх цэргийн ажиллагааг амжилттай явуулжээ /Зураг 6/.

Энэхүү цэргийн ажиллагаа нь орон нутгийн хүчний байгууллагуудын зүгээс болон Украйны зүгээс ямар нэгэн эсэргүүцэлтэй тулгараагүй бөгөөд харин ч нутгийн иргэд оросын цэргийн цувааг өөрийн үндэстний уламжлалын дагуу талх, давс барин халуун дотноор угтан авсан байна.



Зураг 6. ОХУ-ын зүгээс явуулсан Крымын хойгийг нэгтгэх цэргийн ажиллагаа

Үүний дараахан дээрх цэргийн ажиллагааны талаар ОХУ-ын ерөнхийлөгч дараах тайлбарыг өгчээ.



Зураг 7. ОХУ-ын ерөнхийлөгч В.В.Путин хэвлэлийн бага хурал дээр

- Крымыг ОХУ-ын бүрэлдэхүүнд тухайн нутгийн ард иргэдийн сайн дурын үндсэн дээр нэгтгэсэн.
- Украйны шинэ засгийн газар улсынхаа өмнөд болон зүүн хэсгийг тогтвортгуй болгосон, ард иргэдээ үндсэргэг

үзэлд автсан иргэний дайнд татан оруулж. байна.

- Украйнд хүний эрх зөрчигдэж, иргэд амь насаараа хохирч байна.

- АНУ нь НҮБ-ын тушаал шийдвэр байхгүйгээр эсвэл шийдвэрийг мушгин гүйвуулах замаар Афганистан, Ирак, Ливи улсуудад ашиг сонирхлын төлөө байлдааны ажиллагаа явуулсан гэж мэдэгдсэн байна.



Зураг 8. Крымын хойг нь ОХУ-ын бүрэлдэхүүнд нэгдэн орсон болохыг телевизийн сувгаар мэдээлж буй нь

Өөрөөр хэлбэл Орос улс нь мэдээллийн дайныг амжилттай явуулж чадсан ба дээрх цэргийн ажиллагаа нь ОХУ-ын зүгээс үндэс нэгт ах дүү нараа өөрийн нөмөр нөөлөг дор авч хамгаалах зорилготой болохоос бус бусдын газар нутагт халдан орж, нутгийн зарим хэсгийг тасдан өөрийн харьяалалд нэгтгэсэн үйлдэл биш юм гэдгийг дэлхий нийтдэд үнэн зөвөөр ойлгуулан тайлбарлаж чаджээ.

Газар нутгийн хувьд авч үзэхэд Крымын хойг нь Хар тэнгист гарцтай бөгөөд энэ тэнгист өөрийн флоттой Оросын хувьд / ОХУ-ын ЗХ-ний Хар тэнгисийн флот/ стратегийн чухал ач холбогдолтой газар болох нь тодорхой юм.

Чечений I дайн /1994-1996/

1990 оны эхээр ЗХУ-ын ерөнхийлөгч М.С.Горбачёвын санаачлан явуулсан өөрчлөн байгуулалт нь үнэндээ хөгжил дэвшилд бусхарин их гүрнийг задран унахад хүргэжээ. Чечений Бүгд Найрамдах Улс ч бас энэ боломжийг алдсангүй. Албан ёсны засаглалын зэрэгцээ урдын ЗХУ-ын ЦНХ-ний генерал асан Дудаевын толгойлсон



үндэстний бие даасан засгийн газар үйл ажиллагаагаа явуулж эхлэв. Таатай нөхцөл байдал үүсмэгц тэд зэвсэглэн хөдөлж улсын бүх чухал обьектууд, захирагааны удирдлагын байруудыг эзлэн авсан ба хойшид Оросын харьялалд орохгүй бие даасан тусгаар улс болсноо зарлан мэдэгдэв.



Зураг 9. Чечений газарзүйн байрлал

Харин энэхүү дураараа үйлдлүүд нь тухайн үеийн Орос улсын ерөнхийлөгч Ельцинд таалагдсангүй. Тэрээр 1994 оны 12 сард Чеченийг зэвсгийн хүчээр буцааж нэгтгэх шийдвэр гаргажээ. Түүний ойрын дэмжигч болох Батлан хамгаалахын сайд Павел Грачёв шийдвэрийг уриалгахан хүлээн авч Чеченийг ердөө л хоёр долоо хоногийн дотор эзлэн авах амлалт өгөв. Гэвч тэд нөхцөл байдалд үнэн зөв дүгнэлт хийгээгүй болох нь дараагийн болж өнгөрсөн үйл явдлуудаас илт болсон. Урьдын хүчирхэг улс орон байхгүй болсон ба түүний хүчирхэг арми ч мөн үгүй болсон гэдэгт төр, цэргийн удирдагчид бодит үнэлэлт дүгнэлтийг өгөөгүй байна.

Ийнхүү хоёр жил амжилтгүй тэмцэл явуулсаны эцэст ерөнхийлөгчийн биеийн байдал ч доройтох, түүний оронд шинэ залуу ерөнхийлөгч В.В.Путин томилогджээ. Шинэ ерөнхийлөгч байдлыг дүгнэн үзээд дайныг хойшид үргэлжлүүлж болохгүй гэсэн дүгнэлтэнд хүрч Чеченээс цэргээ татах зарлиг гаргаснаар дайн төгсгөл болсон. Орос улс Чечений 1-р дайнд ялагдахад дараах хүчин зүйлс нөлөөллөө үзүүлсэн байна.

Оросын армийн сул талууд:

- Урьдын их гүрэн ЗХУ задран

унасаны дараа цэргийн олон хашир туршлагатай дарга нар болон дайчид оросын армиас гарч өөрийн харьялалын дагуу шинээр үүсэн бий болсон тусгаар улсуудын Зэвсэгт хүчний бүрэлдэхүүнд орсон.

- Орос улсад хямрал, эмх замбараагүй байдал газар авснаас болж оросын армийн албан хаагчид ч их хэмжээгээр албаа орхиж хувийн салбарт ажиллах болсон, тэдгээрийн зарим нь тухайн үед олноороо бие болж байсан дээрмийн бүлэглэлүүдэд элсэн орсон.

- Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн цөөрсөн тул шинээр цэрэг татлагыг өргөн хүрээтэй явуулсан боловч тэдгээрийг зохих бэлтгэл сургуульд хамруулалгүйгээр шууд халуун цэгт илгээсэн байна. Иймд Чечений байлдааны ажиллагаанд оролцож буй дайчдын ихэнхийг туршлагагүй шинэ байлдагчид бүрдүүлж байжээ.

- Ухуулга сурталчилгааны ажил дутмаг явуулж байсан тул цэргүүд юуны тулд байлдаж байгаагаа үл ойлгох, тэмцлийн үнэн зөвд итгэл алдарч санаа сэтгэлээр унах нь цөөнгүй байлаа.

- Улс орны эдийн засгийн доройтол, авилгал газар авсан байдлаас болж цэргийн хангарт доройтсон, зэвсэглэл техникийн сэлбэг материалын хангарт муу, засвар үйлчилгээг зохих түвшинд явуулахгүй байснаас эвдрэл гэмтэл их гарч байсан зэрэг нь болно.



Зураг 10. Итгэл үнэмшил, урам зориг нь алдарсан Оросын армийн байлдагчид /1995 он/

Чечений дайчдын давуу талууд:

- Газар нутгийн баримжаалал сайтай тул шөнийн цагаар болон үзэгдэх орчин хязгаарлагдмал нөхцөлд ажиллагаа



явуулах чадвартай, мөн өөрийн орны уулархаг, битүү ой бүхий газар орны онцлогийг чадварлаг ашигладаг.

- Газар орноо сайн мэддэг нь тэдэнд тагнуул, туршуулыг амжилттай явуулах боломжийг олгоно.
- Орон нутгийн иргэдтэй хэлхээ холбоо сайтай, тэдэнтэй нягт хамтран ажиллаж тэдний дэмждэгийг авдаг.
- Дайчдын дунд олон хашир туршлагатай, ахмад настай, байлдааны ажиллагаанд болон ан авд сурмаг хүмүүс байсан.
- Үндэстний шинж чанартай ухуулга сурталчилгаа сайн явуулдаг, өөрсдийн тэмцлийн үнэн зөв гэдэгт итгэл үнэмшил дүүрэн байсан зэрэг нь болно.



Зураг 11. Байлдааны ялалтандaa урамшсан Чечений дайчид /1995 он/

Харин Чечений хувьд дайн хэдийгээр дууссан боловч улс оронд амар амгалан байдал бий болсонгүй. Дудаев, Басаев нарын толгойлсон цэргийн бүлэглэлүүд өөрийн улсад ноёрхлоо тогтоож нутгийн энгийн иргэд, оршин суугчдыг цэргийн хангалтыг бүрдүүлэх нэрээр дур зоргоороо дээрэмдэх болов. Цэрэг татлагад хамрагдах хүсэлгүй эрчүүдийг цаазлах нь ч бий болсон байна. Урьдын үндэстний баатрууд ард иргэдийнхээ нүдэн дээр дээрмийн толгойлогчид болон хувирчээ. Дайны үед эхлүүлсэн орос цэрэг, иргэнийг барьцаалж ар гэрээс нь мөнгө нэхэх үйлдлээ ч зогсоохыг хүссэнгүй. Ялангуяа энэ нь Оросын хөрш мужуудад нөлөөлж аймшигт автуулж байлаа. Энэ бүхэн нь Орос улс Чечений эсрэг дахин байлдааны ажиллагаа явуулахад хүргэжээ.

Чечений II дайн /1999-2009/

Чечений дээрмийн бүлэглэлүүд хүн барьцаалах нь улам ихсэж энэ нь хүний наймаа эрхлэх нэгэн төрлийн бизнес болон хувирав. Тэд зөвхөн оросын иргэдийг төдийгүй Чеченд ажиллаж амьдарч байгаа гадаадын иргэд, бизнесменүүд, түүнчлэн тухайн бүс нутагт ажиллаж байгаа гадаадын сэтгүүлчид, хүмүүнлэгийн ажилтнуудыг олзлон мөнгө нэхэх болсон байна. Мөн бусдын нефтийн цооногуудаас нефть булаан дээрэмдэх, хар тамхи үйлдвэрлэн Орос болон бусад хөрш тусгаар улсуудад хил давуулан борлуулах, хуурамч мөнгөн дэвсгэртүүдийг үйлдэх замаар санхүүжиж байлаа. Чечений нутаг дэвсгэрт дайчдыг бэлтгэх лагерүүдийг байгуулж түүндээ өөрсдийн иргэдээс болон гадаадаас хүмүүсийг элсүүлэн гадаадын мэргэжилтнүүдийг хөлслөн сургалт явуулж эхэлсэн байна.

Хөрш зэргэлдээх Оросын мужууд руу дайрч довтлох нь улам нэмэгдсэн нь Оросын зүгээс шийдвэртэй алхам хийхэд хүргэжээ.

Ийнхүү 1999 оны 9 сарын 29-нд Оросын ЦНХ-ний агаарын дайралт явагдаж Грозный хот болон түүний эргэн тойронд хүчтэй бөмбөгдлөт явуулсан ба маргааш нь буюу 30-ны өдөр цэргийн бүлэглэлүүд Чечений нутаг дэвсгэрт довтлон оров. Мөн оны 12 сар гэхэд Чечений нийслэл Грозный хотоос бусад нутгийн бүхэл тэгш тал газрыг оросууд хяналтандaa авсан байлаа. Сарын сүүлээр Грозный хотыг бүслэн авч дараа оны 2 сарын 6-нд бүрэн эзлэн авчээ.



Зураг 12. Дайны бэлтгэл хангагдсан ОХУ-ын Зэвсэгт хүчин



Дайн үргэлжлэх дараагийн жилүүдэд Чечений зэвсэгт бүлэглэлүүд ээлж дараалан бут цохигдоор 2009 оны 4 сарын 16-нд дээрмийн дэглэм бүрмөсөн нуран унаж, Оросын зүгээс ч цэргийн ажиллагаагаа зогсоосон байна.

Орос улс Чечений II дайныг амжилттай явуулсан шалтгаан:

- Орос улс нь Чечений 1-р дайны алдаанаасаа суралцан зохих дүгнэлтүүдийг хийсэн.

- Дайны бэлтгэлийг сайн хангасан, үүнд бие бүрэлдэхүүний сургалт явуулж, зэвсэглэл техникээ шинэчлэн сайжруулсан, дайны төлөвлөгөөг багагүй хүч хөдөлмөр, цаг хугацааг зарцуулж, сайн бодож тооцоолон боловсруулсан.

- Цэргийн хангалттай том бүлэглэлийг дайнд оруулсан, 100 мянган хүнтэй армийн хүчээр довтолсон ба үүний дунд тусгай бэлтгэгдсэн бүлгүүд ч байсан.

- Тусгай бүлгүүд нь ээдрээтэй нөхцөл онцгой даалгавар биелүүлэхэд ашиглагдаж байсан ба үүргээ ч амжилттай биелүүлж байв. Онцгой ач холбогдолтой объектуудыг устгах буюу тэр үеийн хэллэгээр "Чухал ан агнах" үүргийг тэдэнд даалгадаг байжээ.

- Байлдааны ажиллагаанд цэргийн заль мэхийг амжилттай хэрэгжүүлж байсан, давшилтын чиглэлийн талаар төөрөгдүүлэн хууран мэхлэх, гэнэтийн цохилтуудыг хийн хохирол учруулах, дайсныг хууран минийн талбайд оруулах, дайсны ар талыг гэнэдүүлэн эзлэх Г.М.



Зураг 13. Одоогийн Чечений нийслэл Грозный хот

- Сэтгэл зүйн дайралтыг амжилттай явуулсан. Дайсны урам зоригийг мохоож,

суртал ухуулгын ажлыг сайн явуулснаар Чечений бүлэглэлүүдийн багагүй хэсгийг өөрийн талд элсүүлж чадсан байна.

Дайны дараа Чечень улс нь шинэ ерөнхийлөгч Рамзан Кадыровын удирдлаган дор Орос улстай сайн харилцаатайгаар хөгжлийн шинэ замдаа орж өнөө үед Европын хөгжиж буй улс орнуудын нэгэн болж чадсан билээ.

Кибер дайн, кибер халдлага

Орчин үеийн дайн байлдааны бас нэгэн чухал талбар нь Кибер орон зай болжээ. Энэ талбарт кибер халдлага, түүний эсрэг кибер аюулгүй байдлыг хангах тэмцлээс үүдэлтэй кибер дайныг явуулах болсон ба түүнийг амжилттай явуулсанаар дайны ялалтанд хүрэх боломжийг бүрдүүлж өгнө. Энэ нь цахим орчин, цахим сүлжээг дэлхий нийтээрээ бүх салбарт ашиглан хэрэглээ болгосон төдийгүй цэргийн хэрэгт ч тулхүү ашиглах болсонтой холбоотой юм. Кибер халдлагыг бусдын сүлжээнд зөвшөөрөлгүй нэвтрэн орж мэдээлэл хулгайллах, мэдээллийг устгах зэрэг замаар явуулна. Энэхүү халдлагыг дайны бэлтгэл үед болон явцад үйлдэх ба үүний үр дүнд сөрөг талд их хэмжээний хохирол амсуулах, эсвэл тийм боломжийг олгох тохиолдлууд олонтоо гарч байсан билээ. Үүний нэг томоохон жишээ нь АНУ-ын зүгээс Иракийн цөмийн туршилтын лабораторид явуулсан кибер халдлага болно. Лабораторид вирус нэвтрүүлсэнээр түүний хэвийн ажиллагааг алдагдуулан Иракийн цөмийн зэвсэг гаргаж авах зорилгоор явуулж байсан олон жилийн хүч хөдөлмөр, хөрөнгө санхүү зарцуулсан ажлын үр дүнг талаар болгосон байна.



Зураг 14. Иракийн цөмийн туршилтын лаборатори



Мэдээллийн дайн

Мэдээллийн дайн нь орчин үеийн дайны бас нэгэн үр дүнтэй хэлбэр юм. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн боломж бололцоо, хүчин чадал өндөр болсон өнөө үед мэдээлэл нь дайнд амжилтанд хүргэх хүчин зүйлсийн нэгэнд зүй ёсоор тооцогдоно. Мэдээллийг асар богино хугацаанд хүргэх эсвэл болж буй үйл явдлыг газар дээрээс нь шууд дамжуулан нэвтрүүлэх боломжтой болсон нь түүний бас нэгэн давуу тал болно. Өнөө үед мэдээллийн дайн нь олон зорилгоор явагдах болсон. Жишээлбэл, тухайн улс орны явуулж буй бодлогыг зөвтгөж, эсвэл буруутгган харуулах боломжтой. Ингэхдээ дэлхий нийтэд нэр хүндтэй хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглах нь зохих үр дүнгээ өгдөг байна. Тэдгээр нь өөрсдийн мэдээллийн үнэн зөв болох талаар баталгаа гаргаж өгөх ба хүмүүс ч тийм нэр хүндтэй телевизийн сувгууд болон интернэт сайт, сонин хэвлэл, бусад мэдээлийн эх сурвалжид илүү их итгэн хүлээж авна.

Мэдээллийн дайн нь зөвхөн зэвсэгт тэмцлийн хүрээнд төдийгүй үзэл бодол, улс

Ministry of Propaganda



Зураг 15. Олон улсын нөлөө бүхий телевизийн мэдээллийн сувгууд

төр, нийгэм, эдийн засгийн талбарт явагдах өргөн хүрээтэй ойлголт юм. Аливаа нэгэн үзэл бодлыг сурталчилсан суртал ухуулга, сонгуулийн сурталчилгаа, далдын санаа зорилго агуулсан бусад мэдээлэл, реклам, зар сурталчилгаа зэрэг нь түүний олон талт хэлбэрүүд болно.

Ийнхүү орчин үеийн дайн байлдаан нь олон хүч тэнцвэргүй хүчин зүйлсийн нөлөөн дор өвөрмөц хэлбэрээр явагдах бөгөөд тухайн тохиолдол бүрт өөрийн болон серөг талынхаа давуу ба сул талуудад бодитой үнэлэлт дүгнэлтийг өгч оновчтой шийдвэр гаргахад амжилтын үндэс оршино.



АГААРЫН ЦЕЛИЙН МЭДЭЭЛЛИЙН БОЛОВСРУУЛАЛТАНД ОРЧИН ҮЕИЙН ПРОГРАММЫГ АШИГЛАХ НЬ

Ц.БАТБАЯР /ЦНС-ийн АЦТ-ийн багш, докторант, хошууч/

Түлхүүр үг: Агаарын довтолгооноос хамгаалахын төр, Ерөнхий цагийн байдлын планшет, олон улсын иргэний нисэхийн хяналтын программ

Key words: Air defense mesh, notification tablet, flight radar

Үндэслэл. Өнөөдөр агаарын цэргийн зэвсэглэл техник хуучирсан ч сургалт, дадлагад орчин үеийн мэдээллэлийн технологийн ололт амжилтыг бүрэн ашиглах боломж нээлтэй байна. Өнөөгийн нөхцөл байдалд шинэлэг технологийг цэргийн сургалтанд нэвтрүүлж, инновацын бүтээл хийн тулгамдаж байгаа асуудлуудыг Монгол инженер техникийн ажилтануудын бүтээлүүдээр өөрийн орны нөхцөлд тохируулан ашиглах боломжтой юм.

Тухайлбал агаарын цэргийн сургалтад олон улсад ашиглаж байгаа иргэний нисэхийн хяналтын програмуудыг уламжлалт аргатай хослуулан сургалтад ашиглах нь сургалтын үр дүнг дээшлүүлэх үндэслэл болж байна.

Зорилго. Сургалтад орчин үеийн технологийн амар хялбар шийдлүүдийг нэвтрүүлсэнээр дадлагын зардал багатайгаар бодит цагийн байдалд дөхүүлсэн сургалт болж, мэргэжилийн ур чадварыг нэмэгдүүлэх арга замыг санал болгоно.

Зорилтууд

1. Агаарын цагийн байдлын мэдээг боловсруулж байгаа өнөөгийн байдал
2. Олон улсын иргэний нисэхийн хяналтын програмуудад аппликаейшинд судалгаа хийж, программыг ерөнхий цагийн байдлын планшеттай хослуулан ашиглах боломжийн судлах
3. Хослуулан ашигласанаар гарах үр дүн

1 дүгээр зорилтын хүрээнд: Агаарын цагийн байдлын мэдээг боловсруулж байгаа өнөөгийн байдал

Радиолокацын мэдээг боловсруулж, дамжуулах дараалал

РЛС-ын тусламжтайгаар оператор агаарын байны байрлалыг алс D, азимут β-аар тодорхойлон радиолокаторын ротын планшетчинд дамжуулна.

Ротын планшетчин агаарын байны байрлалыг планшет дээр буулгана.

Уншигч планшет дээр буусан мэдээг АДХ-ын торд шилжүүлэн радиотелеграфчинд дамжуулна.

Радиотелеграфчин хорооны командын байр руу мэдээг холбооны сувгаар дамжуулна.

Агаарын байны мэдээг хорооны командын байранд радиотелеграфчин хүлээн авч хорооны планшетчинд дамжуулна.

1. Хорооны командын байрын планшетчин агаарын байны мэдээг хорооны планшет дээр буулгаж, байлдааны удирдлагын офицер (оперативын жижүүр) агаарын байны мэдээнд дүн шинжилгээ хийнэ. Эдгэр үйлдлүүдийн дунд агаарын байны нэг цэгийн байрлал тодорхойлогддог.

Радиолокацийн мэдээ дээрх олон шат дамжлага дамждаг тул мэдээний хувьд хугацааны хоцрогдол үүсдэг. Энэ хугацааны хоцрогдол:

- Радиолокацийн станцаас 1 минутаар
- Ротын удирдах байранд 1-2 минутаар
- Радиотехникийн хорооны Командын байранд 3-4 минутаар
- АДХЦ-ын командын байранд 4-6 минутаар
- Байлдааны идэвхтэй хэрэгсэлийн ангийн командын байранд 1-2 минутын хоцрогдолтой мэдээ дамжигдаж байна.



Радиолокацийн мэдээ нь АДХЦ-ийн зенитийн пуужин-артиллериийн салбарыг газраас агаарын байнд, онгоц аэродромоос-агаарын байх хүртэлх тодорхой алсад, байлдааны идэвхитэй хэрэгслүүдийг радиолокацын мэдээгээр тасралтгүй хангаж байх үүрэгтэй. Энэ үүргээ биелүүлэхийн тулд радиотехникийн анги салбаруудад радиолокацийн мэдээг алс зайд түгээх шаардлага тавигддаг.

Агаарын цагийн байдлын мэдээллийн боловсруулахад дараах ерөнхий шаардлагууд тавигддаг.

- Тодорхой зорилгод тэмүүлэх эрмэлзэл
- Тасралтгүй байдал
- Идэвхитэй ажиллагаа
- Оператив чанар буюу бага хугацаанд мэдээг боловсруулахыг эрмэлзэх зэрэг хамрагддаг.


2 дугаар зорилтын хүрээнд: Олон улсын иргэний нисэхийн хяналтын програмуудад аппликацийнд судалгаа хийж, программыг ерөнхий цагийн байдлын планшеттай хослуулан ашиглах боломжийг судлах

Олон улсын иргэний нисэхийн хуваарыт нислэгийг хянах мэдээлэл авч болох цөөнгүй сайт, программ, ухаалаг утасны программ аппликашиunuуд байна.

<https://www.flightradar24.com/>

<https://www.esky.com/>


<https://www.radarbox24.com/>



Flightradar24.com



eSky.com



Flightradar21



AirNav.RadarBox24.com

РЛС болон programmaас агаарын целийн талаар авч болох мэдээлэлүүд

Үзүүлэлт	Радиолокацын станцаар	Программаар
Иргэний нисэхийн онгоцноос бусад нисэх хэрэгсэлийг илрүүлэх	+	-
Нисэгийн хурд	+	+
Чиглэл	+	+
Маршрут	-	+
Нислэгийн дугаар тогтоох	-	+
Өндөр	-	+
Харьяалалыг тогтоох	-	+
Нисэх хэрэгсэлийн загварыг тодорхойлох	-	+

Эндээс үзэхэд РЛС-аас авч болох агаарын целийн тухай мэдээлэл интернет орчин дахь олон улсын иргэний нисэхийн хяналтын програмууд дээрх мэдээллээс бага байгаа нь харагдаж байна. Мэдээллийн энэхүү эх сурвалжийг уламжлалт аргатай хослуулсанар агаарын целийн тухай илүү их мэдээлэл боловсруулах боломж бидэнд байна.

Иймд би дараах аргыг санал болгож байна. Интернет орчинд холбогдсон компьютерыг дэлгэцтэй холбон олон улсын



З дугаар зорилтын хурээнд:

иргэний нисэхийн хяналтын программыг ажиллуулаж, тунгалаг уян слайд дээр хийгдсэн ерөнхий цагийн байдлын планшетийг дэлгэц дээр байрлуулсанаар хялбар шийдэж болох юм. Ингэснээр уламжлалт планшет дээр буулгах агаарын целийн мэдээлэл дээр олон улсын иргэний нисэхийн хяналтын программаас авсан мэдээллийг нэмж хослуулан ашиглах боломжтой болж байгаа юм.

Дүгнэлт

Хослуулан ашигласанаар гарах үр дүн

1. Жижүүрлэлтын радиолокацийн пост нь зөвхөн батлагдсан хуваарийн дагуу РЛС-ыг ажиллуулж жижүүрлэлт хийдэг бол энэхүү программын тусламжтайгаар байнгын агаарын хяналтыг хийх боломж олдож байгаа юм.

2. Олон улсад ашиглаж байгаа иргэний нисэхийн хяналтын програмуудыг, уламжлалт аргатай хослуулан сургалтад ашиглах нь сургалтын үр дүнг дээшлүүлэх үндэслэл болж байна.

3. Сургалт болон жижүүрлэлтэд ашиглахдаа агаарын цагийн байдлын талаар бичлэг хийн баримтжуулах дахин үзэж, бичлэгийг гүйлгэж целийн хурдыг өөрчлөх дадлагын үр дүнг тооцох.

4. Манай улсын агаарын хилийн орон зайг ихэвчлэн олон улсын иргэний нисэхийн онгоцууд ашигладаг бөгөөд тэдэнд хяналт тавьж нягтлан шалгахад дөхөм болно. Хэрэв РЛС-ийн дэлгэц дээр цель илрээд, программ дээр гарахгүй бол орон нутгын, тусгай нислэг эсвэл өөр төрлийн агаарын цель байна гэж ойлгогдоно.

5. Энэхүү программ нь нислэгийн чиглэл, дугаар, хурд, өндөр, ямар загварын, аль авиа компаний онгоц болох нь тодорхой харагдагаараа давуу талтай юм.

6. Байлдааны жижүүрлэлтийг ахлаж хоносон жижүүр ангийн захирагч дээр хүлээлцэхдээ ерөнхий цагийн байдлын слайд дээр буусан чухал цэлүүдийг танилцуулж болно.

Ашигласан материал:

1. Зенитийн артиллериийн дивизион, батарейны тагнуул ба холбоо УБ 1973
2. Зенитийн артиллериийн батареины байлдааны ажиллагаа УБ 1973
3. Зенитийн артиллериийн салбаруудын байлдааны ажиллагаа УБ 1974
4. Агаараас эсэргүүцэн хамгаалалт УБ 1974
5. Агаарын довтолгоноос хамгаалахын топ

Интернет сайтууд

1. <https://www.flightradar24.com/>
2. <https://www.esky.com/>
3. <https://www.radarbox24.com/>

ХЭЭРИЙН НӨХЦӨЛД СУУДЛЫН АВТОМАШИНЫ АВТОМАТ ХУРДНЫ ХАЙРЦАГНЫ ШИНГЭН СОЛИХ ЗӨӨВРИЙН БАГАЖ

Ч.БЯМБАЦЭРЭН /АБС-ийн ИМТ-ийн багш, магистр/

Түлхүүр үг: Автомат хурдны хайрцаг, шингэн, хөтлөх диск, хөтлөгдөх диск, шингэний хөргөх систем, дамжуулгын хоолой

Key words: Automatic gearboxes, fluids, fluid cooling systems, transmission pipes

Хураангуй. Авто тээврийн үндэсний төвийн 2017 оны мэдээгээр манай улсад нийт 860 гаруй мянган тээврийн хэрэгсэл ашиглагдаж байна. Эдгээр авто машины 76% орчим хувийг автомат хурдны хайрцагтай авто машин эзэлж байна. Орчин үед цэргийн техник хэрэгслийн цөөнгүй хэсэг нь автомат хурдны хайрцгаар тоноглогдсон ба манай улсад аль хэдийн нэвтэрсэн. Автомат хурдны хайрцаг нь удирдахад хялбар, автомашины хөдөлгөөн үйлдэх үед араа хоорондын шилжилт хийхэд тохируулга шаардахгүй биед амар зэрэг давуу талтай. Харин хугацаанд нь техникийн үйлчилгээ хийж, шингэнийг нь сольж байхгүй бол эдэлгээний хугацаа бодиносох, араа солигдох нь удаашрах, солигдоо болих зэрэг эвдрэл үүсэх шалтгаан болдог. Ингэснээр түлш зарцуулалт ихсээд зогсохгүй эвдрэл гэмтэлийг засах эд ангийг сайжруулан сэлгэхийн тулд эдийн засгийн хохирол бий болдог. Автомат хурдны хайрцагт үйлчилгээ хийж шингэнийг нь шинээр солихын тулд тусгай зориулалтын багаж хэрэлдэг ба тэрхүү багаж нь гадаадаас импортлон оруулж ирдэг өндөр үнэтэй, 220 вольтын цахилгаан гүйдлээр ажилладаг багаж байдаг учир зөөвөрлөж, хээрийн дадлага, сургалтын үед ашиглах боломжгүй байдаг. Энэхүү бидний зохион бүтээсэн багаж нь дээрх асуудлыг хямд төсөр аргаар шийдэх аргыг бий болгож байгаа бөгөөд сайжруулан хөгжүүлж зах зээлд нэвтрүүлэх, гарааны бизнес эхлүүлэх боломж олгож байна. Мөн улс орны аюулгүй байдал, салбарын хэмжээнд гадаадын багаж, тоног төхөөрөмжөөс хараат бус байхад бага ч гэсэн хувь нэмэр болж байна гэж үзэж байна.

Шинэлэг тал. Автомат хурдны хайрцагны шингэн сольдог багаж нь үнэ өртөг өндөртэй, 220V гүйдлээр ажилладаг тул цахилгаан хэрэглээ өндөртэй багаж байдаг. Үүнийг авто машины 12V-ийн гүйдлээр ажилладаг болгож шийдсэнээр хээрийн нөхцөлд үйлчилгээ хийх боломжтой боллоос гадна эдийн засгийн хувьд хэмнэлттэй болно. Мөн хийцийн хувьд харьцангуй хялбар овор хэмжээ багатай тул үнэ өртөгийн хувьд ч хямд байхаас гадна зөөврийн байдлаар техникийн үйлчилгээ хийж болно.

Зорилго. Автомашины автомат хурдны хайрцагны шингэнийг тодорхой хугацаа, гүйлт километрийн дараа техникийн үйлчилгээ хийж сольдог. Солихдоо 220V гүйдлээр ажилладаг, үнэтэй тусгай багажаар, өндөр ажлын хөлстэйгээр сольдог. Мөн үүнээс гадна орон нутагт ашиглаж буй авто машины хурдны хайрцагны шингэнийг солихын тулд хот суурин газрын багаж, тоног төхөөрөмж сайтай газрыг зорих хэрэг гардаг. Энэ асуудлыг шийдэж хямд төсөр аргаар автомат хурдны хайрцагны тосыг солих арга олохыг зорьлоо.



Зураг 1. БНХАУ-д үйлдвэрлэсэн багаж.
Үнэ дунджаар 1,5 сая төгрөг.



Зураг 2. БНСУ-д үйлдвэрлэсэн багаж.
Үнэ дунджаар 2,5 сая төгрөг.



Зорилт

- Автомат хурдны хайрцагны ажиллах зарчмыг судлах.
- Автомат хурдны хайрцагны шингэн солих багажны загвар, хийц, үнэ өртөг, ажиллагаа болон шингэнийг солих арга зэргийг судлах
- Багажийг зохион бүтээх оновчтой аргыг тодорхойлох үнэ өртгийг тооцоолох.



Зураг 3. Багаж зохион бүтээж байх үйл явц



Зураг 4. 2002 онд үйлдвэрлэсэн Toyota corolla авто машин дээр багажаа турсан байдал

Автомат хурдны хайрцагны ажиллах өрөнхий зарчим. Хөтлөх дискний эргэлтээр (хөдөлгүүрийн эргэлт) шингэнийг даралтанд оруулж даралттай шингэний хүчээр хөтлөгдөх дискэнд (явах



Зураг 5. Автомат хурдны хайрцагны зарим төрөл

анги) эргэх хүч өгч ажилладаг.


Автомат хурдны хайрцагны шингэнийг солих. Автомат хурдны хайрцагны шингэнийг солихдоо 220V-оор ажилладаг тусгай багажийг авто машины хурдны хайрцагны шингэнийг хөргөх системийн дамжуулгын хоолойд залгаж нэг талаар нь хуучин тосыг суллан авч нэг талаар нь шинэ шингэн шахаж оруулах замаар сольдог. Ингэхдээ авто машиныг асаалттай арааны байрлал "N" буюу Netral (сул ажлын горим) дээрээ байх ёстой. Энэ ажиллагаа нь гоожиж байгаа хуучин тосны өнгө шинээр солигдтол үргэлжилнэ.

Хээрийн нөхцөлд автомат хурдны хайрцагны шингэнийг солих багажны ажиллагаа. Энэ багаж нь 220V-ын гүйдлээр ажилладаг багажтай ажиллах зарчмын хувьд төстэй ба хуучин шингэнийг нэг талаар нь суллан авч, шинэ шингэнийг хурдны хайрцагт шахаж оруулах, хурдны хайрцагны насосны тусламжтайгаар богино эргэлт хийж шүүрээр шингэнийг шүүж буцаан хурдны хайрцагыг цэвэрлэх зарчмаар ажиллана. Хурдны хайрцагнаас гарч буй хуучин шингэн шинээр солигдтол үргэлжилнэ.


Шахаж оруулахдаа хийн даралтын хүчийг ашиглана. Алдарт физикч Блез Паскаль (1623-1662) даралтын хуулийн дагуу хийн, шингэн нь савны хэлбэрийн дагуу тархах ба даралт шингэний гадаргуу дээр жигд үйлчилнэ.

$$P = F / A$$

Энд: P - даралт, F - хүч, A - талбай



Зураг 6. Багажны ажиллах өрөнхий зарчим.



Зураг 7. Багажны ажиллагааны бүдүүч схем

Үнэ өртөг /төг/

Үндсэн баллон	5000
Шингэн дамжуулах хоолой	12000
Дээд доод хошуу	4000
Будаг	5000
Хоолой холбогч	8000
Хөл	2000
Комочка	6000
Шүүлтүүр	8000
Датуур	6000
12V-ийн насос	60000
Бусад	30000
Нийт	146000

Дүгнэлт. Энэхүү зохион бүтээсэн Хээрийн нөхцөлд суудлын авто машины автомат хурдны хайрцагны шингэн солих зөөврийн багаж нь:

- Үнэ өртгийн хувьд хямд
- Овор хэмжээний хувьд авсаархан болох боломжтой
- Цахилгаан тоггүй газар 12вольт дугуй хийлэгч ашиган ажиллуулах боломжтой
- Зөөврийн байдлаар ашиглаж болох гэх мэт маш олон давуу талтай байгаад зогсохгүй оюутан залусын онолын мэдлэгийг бататгах, дадлага эзэмшүүлэх ач холбогдолтой гэж үзэж байна.

Мөн авто машины бусад тос тосолгооны материалыг шинээр сольход нарийн багаж шаарддаггүй ба энэ багажны тусламжтайгаар хямд төсөр зардлаар ТҮЗ-ын төв нээж ажиллуулах боломж бүрдэж байна.

Ашигласан материал:

1. Н.Ганболд. "Хүнд машин механизмын засварчин" Улаанбаатар 2015 он
2. Г.Энхбаяр. Т.Нигамет "Түвш тосолгооны материал" Улаанбаатар 2016 он
3. Д.Готов, И.Базаррагчaa "Автомашин" Улаанбаатар 2012 он
4. Б.Дарханцэцэг "Хий шингэний хөтлүүр" Улаанбаатар 2010 он



ХОЛБООНЫ ЦЭРГИЙГ БЭХЖҮҮЛЭХЭД С.ГАНГААНЯМЫН ГҮЙЦЭТГЭСЭН ҮҮРЭГ

Лха.БАЯР /БХЭШХ-ийн ЭША, доктор (Ph.D), дэд хурандаа/

Түлхүүр үг: Цэргийн холбоо, инженер, зэвсэг техник, холбооны сүлжээ
Key words: Military communication, engineer, weapon, , communication network

С.Гангааням 1944 онд Офицерын сургуульд элсэн суралцаж маршал Х.Чойбалсангийн нэрэмжит цалинтай төгсөөд, 1952 онд Цэргийн Ерөнхий сургуулийг жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит цалинтай дүүргэн эх орноо батлан хамгаалах их үйлсэд зүтгэж эхлэсэн байна. Ийнхүү холбоочин гэх мэргэжил эзэмшин Хороо, Бригадад холбоо салааны дарга, холбооны тусгай рот, тусгай батальоны захирагч, Ардын Цэргийн Жанжин Штабын холбооны хэлтсийн орлогч дарга, МАА-ийн Жанжин Штабын хэлтсийн дарга зэрэг албан тушаалуудад 1975 он хүртэл 20 гаруй жил ажилласан байна. Түүний Монгол Ардын Армийн холбооны цэргийн үүх түүх, хөгжил, бэхжилтэй холбогдсон дээрх он жилүүдэд холбооны цэрэг хэмээх төрөл мэргэжлийн цэргийн хөгжлийн түүхийг тоймлон авч үзье.

Дэлхийн II дайнд ЗХУ ялалт байгуулж манай орны гадаад байдал өөрчлөгджэх, хөрш орнууд тайван амьдралд шилжив. БНМАУ-ын тэр засгаас ард түмнийхээ аж амьдрал, соёлын хэмжээг дээшлүүлэх зорилт тавьж Батлан хамгаалах зардлаа эрс бууруулав.

Цэргийн Явдлын Яамны сайд, Бүх Цэргийн Жанжин маршал Х.Чойбалсангийн 1945 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн 00158 дугаар тушаалаар МАХЦ-ийн зохион байгуулалтыг тайван цагийн орон тоонд шилжүүлж 6, 8 дугаар морьт дивиз болон бусад анги, салбарыг татан буулгаж, зарим анги, нэгтгэлийг өөрчлөн байгуулжээ. Энэхүү арга хэмжээний хүрээнд холбооны тусгай хороог холбооны дивизионтой нэгтгэж сумангуудаас бүрдэж байсныг

батальоны зохион байгуулалтад оруулж хороо нь радио батальон, телефон, телеграфын батальон, бага даргын суман, авто техникийн анги, ажил анги, холбооны засвар, зэвсэг, эмнэлэг ангиас бүрдэх болжээ.

Мөн онд моторжуулсан хуягт бригадыг механикжуулсан нэгдүгээр тусгай хороо болгон зохион байгуулсан бөгөөд түүний холбоо суманг радио салаа, штабын салаа, техникийн тасаг зэргээр бүрдүүлэн байгуулсан байлаа. Бүх цэргийн жанжны орлогчийн 1947 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 0179 дүгээр тушаалаар холбооны тусгай хороог шинэчилсэн орон тоонд шилжүүлжээ.

Хошууч генерал С.Гангааням бол ХХ зууны хоёрдугаар хагасын МАА-ийн түүхэн хөгжлийн нэгэн тодорхой ўе шатанд буюу 1950-иад оны эхнээс мотобуудлагын цэрэг үүсч, арми төрөл, мэргэжлийн анги, салбаруудтай болж эхэлсэн тэр онцлог цаг ўед орчин үеийн зэвсэг, техникийг ажлуулж, ашиглах нарийн мэргэжлийг эзэмшсэн цэргийн холбооны анхны ижenerуудийн нэг билээ.

С.Гангаанямын холбооны цэрэгтэй холбогдон ажиллаж байсан түүхийг:

- Цэргийн холбоочны мэргэжил эзэмшсэн ўе (1950-1952 он)
- Салаа, салбарын захирагчаар ажиллаж цэргийг сурган бэлтгэж, хамт олныг удирдах арга барилыг эзэмшэн төлөвшсөн ўе (1953-1959, 1967-1970 он)
- Цэргийн дээд боловсрол, холбооны инженерын мэргэжил эзэмшсэн ўе (1961-1967 он),
- Холбооны цэргийн дээд удирдлагад



ажиллаж байсан ўе (1970-1975 он),
- Холбооны цэргийн гадаад харилцааг бэхжүүлж, цэргийг зүтгэлтэн болж төлөвшсөн ўе (1975-1989 он) гэж хувааж үзэж болох юм.

С.Гангааням 1952-1953 онд холбооны тусгай батальонд радио буудлын даргаар ажиллаж байв. Армийн анги, нэгтгэлүүдийг татан буулгах ба цомхотгосоор 1953 оны 6 дугаар сард Мотомеханикжуулсан бригад нэртэй ганц нэгтгэл Улаанбаатарт үлдэхэд холбооны тусгай батальоныг суман болгон тус бригадын бүрэлдэхүүнд оруулсан байна. Энэ ўед С.Гангааням энэхүү тусгай ротод радио салааны даргаар томилогдсон байна.

Энэ бригад нь мотобуудлагын батальон 1, танкийн батальон 1, их бууны дивизион 1-тэй байсан ба эдгээр нь холбооны салаатай байв. Улмаар 1954 оны 4 дүгээр сард тус бригадыг танкийн хороо болгон багасгахад бригадын холбооны салбар нь тус хорооны бүрэлдэхүүнд орж улджээ. **Энэхүү өөрчлөлтийн ўед буюу 1954-1956 онд С.Гангааням тус танкийн хорооны штабын ротод радио салааны дарын албыг хашиж байжээ.** 1956 онд танкийн хороог татан буулгаж, мотобуудлагын тусгай хороо болгосон бөгөөд түүнд холбооны тусгай рот буй болжээ.

Цэрэг ба Нийгмийг аюулаас хамгаалах хэргийг эрхлэх яамны сайдын орлогч бөгөөд Ардын цэргийн командлагчийн 1956 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 045 дугаар тушаалаар **Холбооны тусгай ротыг шинээр зохион байгуулж, Ардын цэргийн командлагчийн 1956 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 049 дугаар тушаалаар **ахлах дэслэгч С.Гангаанямыг тусгай ротын анхны даргаар томилжээ.** Тусгай ротын анхны даргаар З жил буюу 1959 онд хүртэл ажилласан байна.**

1953 оноос 1959 онд хүртэлх 6 жилийн хугацаанд залуу офицер

С.Гангааням цэрэг, түрүүч нарыг цэргийн холбооны мэргэжилд сургаж дадлагажуулах, тэднийг удирдан чиглүүлэх, салаа, салбарын сургалт, цэргийн алба, хээрийн дадлага сургууль, жигдрэлтийг зохион байгуулах зэрэг анхан шатны нэгжийг удирдан, зохион байгуулах ажлын дадал, туршлагыг эзэмшин сонгосон мэргэжлээрээ цаашид өсөн дэвших боловсон хүчин гэдгээ хамт олон, цэргийн удирдлагад харуулсан он жилүүд байлаа.

С.Гангааням гуай 1959-1961 онд Ардын цэргийн жанжин штабын холбооны хэлтсийн орлогч даргаар томилогдон ажиллаж байв

1960-аад оны дунд ўеэс зэвсэглэлд нэвтэрч эхэлсэн шинэ зэвсэг техникийг эзэмшиж, ашиглалт, үйлчилгээг зохион байгуулах чадвар бүхий өндөр мэргэжлийн боловсон хүчинийг ЗХУ-ын цэргийн академи, дээд сургуулиудад суралцуулах бодлого барьж байлаа.

Энэ цаг ўед цэргийн холбооны мэргэжил эзэмшсэн, мэргэжлээрээ салаа, салбарыг удирдан зохион байгуулах ажлын дадлага, туршлага хуримтлуулсан ахмад С.Гангаанямыг 1961 оноос ЗХУ-ын Ленинград /одоогийн Санкт-Петербург/ хотын цэргийн холбооны академид явуулж суралцуулсан юм. Тэрбээр 1967 онд төгсөж цэргийн дээд боловсрол, холбооны инженерийн мэргэжил эзэмшин холбооны цэргийг бэхжүүлж хөгжүүлэх үйлсэд хоёргүй сэтгэлээр хүчин зүтгэсэн байна.

Холбооны цэргийн академи төгсөөд ирэхэд түүнийг холбооны тусгай батальоны захирагчаар томилсон байна. Энэхүү тусгай батальоныг Ардын цэргийн командлагчийн 1965 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 76 дугаар тушаалаар холбооны тусгай батальон болгон өргөжүүлсэн бөгөөд энэ ўеэс цэргийн холбооны хөгжлийн нэгэн шинэ ўе эхэлж байгаа юм.

С.Гангааням дарыг холбооны тусгай батальоны захирагчаар 1967-1970



онуудад ажиллах хугацаанд тайван цагийн орон тоо 3 удаа өөрчлөгдсөн нь армийн өргөжилтийн цар хүрээ, холбооны зохион байгуулалтын онцлог, холбоонд техник хэрэгсэл шинээр нэвтрэх үйл явцтай холбоотой байсан ажээ. Тухайлбал, тусгай батальоны захирагчаар томилогдсон тэр жил нь тус батальоны АЦХЭЯ-ыг холбоогоор үйлчлэх груптыг өргөтгөж, 1967 оны 1 дүгээр сарын 12-нд АЦХЭЯ-нд үйлчлэх холбооны тусгай ротыг тусгайлсан байгуулсан байна.

БНМАУ-ын БХЯ-ны сайдын 1968 оны 5 дугаар сарын 6-нд баталсан орон тоогоор холбооны тусгай батальоны зохион байгуулалтад доорх өөрчлөлт оржээ. Үүнд:

1. Радио ротын Р-102 радио станцын салаанд энэ төрлийн радио станц З-тай байнсны нэгийг хасч хоёртой болгосон.
2. Мөн ротод радио хүлээн авах аппаратурын салааг /Р-450 радио зангилаа болон радио тасагтай/ шинээр байгуулсан.
3. Радиорелей, телефон-телеграфын ротын кабель шугамын салаанд шугамын тасаг хоёрыг нэмж З тасагтай болгосон.
4. 15 хүнтэй хэрэгслийн салааг хөдөлгөөнт хэрэгслийн холбооны тасаг, агаарын дохионы постын бүрэлдэхүүнтэйгээр шинээр зохион байгуулсан.
5. АЦХЭЯ-нд үйлчлэх холбооны тусгай ротын радио болон телефон-телеграфын салаадын тасаг, тоотуудын бүтцэд зарим өөрчлөлт орж, 1967 оны орон тоогоор батлагдсан холбоо нууцлах аппаратын салааг татан буулгасан, Р-110 радио станц зэвсэглэлээс хасагдсан зэрэг шалтгааны улмаас тус ротын хүний too 1968 онд 115 болж 1967 оны оос (149 байсан) 34-өөр багасжээ. 1968 оны орон тоогоор холбооны тусгай батальон нь офицер 42, түрүүч: улирсан 49, хугацааны 42, байлдагч: улирсан

4, хугацааны 292, албан хаагч 19, ажилчин 4, бүгд 452 хүнтэй болов.

1970 онд холбооны тусгай батальоны зохион байгуулалтад хийсэн зарчмын өөрчлөлт нь:

1. 30 хүнтэй байсан сургуулийн салааг өргөтгөн зохин байгуулж 96 хүнтэй сургуулийн рот болгосон.
2. Радиорелей, телефон-телеграфын ротод радиорелейний салаа нэгийг /Р-401-5, Р-403-1/шинээр байгуулсан.
3. Хөдөлгөөнт хэрэгслийн салаанд экспедиц гэдэг нэгжийг бий болгосон.
4. АЦЖШ-ыг холбоогоор үйлчлэх тусгай ротод нэвтрүүлэх радио төвийг бий болгосон.
5. Радио рот, радиорелей, телефон, телеграфын ротод холбооны техникийн орлогчийн орон тоог шинээр нэмэгдүүлж, хугацааны түрүүч байсан зарим албан тушаалыг улирсан ахлагч болгожээ. 1970 оны 4 дүгээр сарын 2-нд баталсан энэхүү орон тоогоор АА-ийн тусгай батальон нь **офицер-51, түрүүч: улирсан 52, хугацааны 48, байлдагч: улирсан 5, хугацааны 334, албан хаагч 23, бүгд 513 хүнтэй болж өргөжсөн байна.**

Тусгай батальоны захирагчаар ажиллаж байх хугацаанд нь тус ангийн байлдааны бэлэн байдал, холбоочдын сургалт бэлтгэлд чанаарын ахиц гарч 1968-1969 оны сургуулийн жилийн командлалын шалгалтаар 87,6 хувийн сурлагын амжилт үзүүлж, онц тэргүүн сурлагатан 76, онол, улс төрийн сургуулийн тэргүүний бүлэг 8 гарч, өмнөх сургуулийн жилээс ихээхэн ахицтай дүн үзүүлжээ.

1965 оноос эхэлж 1970-аад оны сүүлч хүртэлх цэргийн холбооны хөгжил бол түүний үндсэн анги болох холбооны тусгай батальонос холбооны цэрэг хэмээх МАА-ийн нэгэн тусгай мэргэжлийн цэрэг болтлоо хөгжин бэхжих үндэс суурь бүрэлдэн



буй болсон үе байлаа.

Яг энэ цаг үед С.Гангааням тусгай батальоны захирагч, холбооны цэргийн дээд удирдлага болох МАА-ийн Жанжин Штабын хэлтсийн орлогч дарга болон даргаар ажиллаж байв.

МАА-ийн холбооны цэрэг нь энэ үед АА-ийн Жанжин Штабын холбооны хэлтэс, холбооны тусгай батальон, шугам, барилгын тусгай рот, Жанжин Штабын тусгай рот, Армийн холбооны засвар, склад, цэргийн шуудан станц, Армийн зэвсэглэл техникийн нэгдсэн засварын газрын холбооны цех, тасаг, холбооны нисэх тусгай эскадрил, нэтгэл ангиудын холбооны алба, салбарууд, ЦЕДС-ийн холбооны кафедр, салбартай болтлоо өргөжин бэхжсэн байна. **Өөрөөр хэлбэл тусгай мэргэжлийн цэрэг болох үндэс суурь нь тавигдах тэр үеийг С.Гангааням генерал удирдаж байжээ.**

1970-аад он бол МАА-ийн зэвсэглэлд орчин үеийн зэвсэг техник, түүний дотор холбооны шинэ төрлийн техник, хэрэгсэл олноор ашиглагдаж эхэлсэн үе юм. Ийм техник, хэрэгслийг АЦЖШ-ын анги, нэтгэлүүдэд ашиглах, холбооны анги, салбаруудын байлдааны бэлэн байдлыг хангах, хээрийн дадлага, сургуулийг зохион байгуулах, АЦЖШ-ын анги, нэтгэлүүдийг олон сувгийн найдвартай холбоогоор хангаж, цэргийн дээд Командлалын үүрэг, даалгаварыг цаг хугацаанд нь гүйцэтгэх зэргийг биелүүлж байв.

ЗСБНХУ, БНМАУ хооронд агаарын байнгын шугамаар Цагааннуур-Ташанта, Улаангом-Хандгайт, Завханы Тэс-Эрзин гэсэн З чиглэлээр холбогдох асуудлаар 1970 оны 12 дугаар сард Улаанбаатарт болсон хоёр орны БХЯ хоорондын хэлэлцээрт МАА-ийн Холбооны хэлтсийн дарга С.Гангааням, мөн хэлтсийн утсан холбооны офицер Д.Цэнд-Аюуш нар оролцож байжээ.

1972 оны 9 дүгээр сарын 5-14-нд Москвад болсон социалист оронуудын

радио албанда долгион хувиарлах асуудал хэлэлцсэн ээлжит зөвлөгөөнд Холбооны яамны сайд, дарга нарын хамтаар Холбооны хэлтсийн дарга С.Гангааням оролцож өөрийн санал, санаачлагaa хэлж байсан байна.

ААЖШ-аас 1972 онд зохион байгуулсан эрдэм шинжилгээний бага хуралд холбооны хэлтсийн дарга дэд хурандаа С.Гангааням "Эхлээд ердийн, улмаар YOX3 хэрэглэсэн нөхцөлд бэлэн байгаа хүч хэрэгслээр оперативын чухал чиглэлд цөмөрсөн дайсныг улсын хил халхлахын зэрэгцээгээр армийн гол хүчийг задлан Зөвлөлтийн цэрэгтэй харилцан ажиллагаатайгаар устгах үед холбоо зохион байгуулах нь" сэдвээр хавсралт илтгэл тавьж байсан байна.

1974 онд болсон Армийн штабын ажилтны 2 дугаар зөвлөгөөнд холбоочдоос ажил үйлсээрээ шалгарсан 24 төлөөлөгч оролцож байснаас хэлтсийн дарга дэд хурандаа С.Гангааням уг зөвлөгөөнд "Холбооны хэрэгслийг чадварлаг ашиглах нь штабуудын нэг гол үүрэг мөн" гэсэн сэдвээр уг хэлжээ.

Холбооны цэрэг бол удирдлагыг тасралтгүй, найдвартай холбоогоор хангах үүргийнхээ дагуу бэлэн байдлаа өдөр, хоногоор бус цаг, минут, секундээр шалгуулж байдаг онцлогтой цэрэг юм. Тиймээс холбоо хангалаа биш удирдлагын бүрэлдэхүүн хэсэгт тооцогдог билээ. Дэд хурандаа С.Гангаанямыг холбооны хэлтсийн даргаар ажиллаж байх тэр он жилүүдэд зэвсэглэлд шинээр нэвтэрсэн техник хэрэгслийдийг хүчин чадлынх нь дээд хэмжээнд, түүнээс ч илүү үр дүнтэйгээр ашиглах оролдлого хийж байсны нэг илрэл бол 1974 онд явагдсан холбооны тусгай тактикийн болон армийн хээрийн сургуулиудад Р-401М станцаар 100 км шууд холбоо тогтоох, 3-4 дундын станцтайгаар 300-400 км зайд радиорелейний холбоо хангах, маршийн үед богино долгионы станцаар сонсголын телеграфын холбоог нэтгэл, ангиудтай товолсон цагуудад тогтоон ажиллах, нисдэг тэрэг дээр хэт богино



долгионы Р-105 радио станцыг байрлуулж дамжуулан нэвтрүүлэг хийснээр 40-60 км-т радио холбоо барих туршилтыг анх удаа явуулж, тэр нь амжилттай болж байсан байна.

Холбооны анги, салбарууд, нийт холбоочид сурсан мэдсэнээ амьдрал дээр хамгийн бодитойгоор шалгуулдаг үе нь армийн хээрийн болон команд штабын хээрийн сургууль юм. Тухайн үед МАА-ийн хэмжээнд цэрэг, штабуудын бэлтгэлээр жил бүр бүх шатны штабуудтай команд штабын болон команд штабын хээрийн сургуулийг нэг удаа; байлдааны буудлагатай хээрийн сургуулийг бүх ротын гуравны нэгтэй; хороо, тусгай батальон бүртэй гурван жил тутам нэг удаа тактикийн хээрийн сургууль хийдэг уламжлалт тотолцоо бий болсон байв. Тухайлбал, 1970-аад онд Ардын цэргийн бүх нэгтгэл, анги салбаруудыг оролцуулан явуулсан хээрийн сургуулиудад холбооны 013 дугаар анги, 1мббр-ын болон бусад нэгтгэл, ангийн холбоочид үүргээ сайн биелүүлсний төлөө тэдэнд АЦЖШ-ын даргын тушаалаар баяр хүргэж, холбоочдын сургалт бэлтгэл, хээрийн дадлага, чадвар өсч, анги, салбаруудын байлдааны бэлэн байдлын тэмдэглэж байжээ.

Холбоочид, армийн нэгтгэл, ангиудыг өргөнөөр оролцуулсан "Хэрлэн-73" хээрийн сургуульд холбоог сайн дүнтэйгээр зохион байгуулж, хангасан байна. "Хэрлэн-73" хээрийн сургуулийн үед нам, засгийн удирдагчид, төрийн яамдын сайд, тусгай газрын дарга нар, сургуулийн удирдлагын холбоог хээрийн байрлалаас Улаанбаатартай утсан ба радиорелейний шугамаар, Москва хоттой улсын холбооны сүлжээгээр хангаж байв. Энэ нь цэргийн холбоочдын түүхэнд анх удаагаа алс зайнаас радиорелейний шугам ашиглан хот, олон улсын сүлжээгээр холбоо хангасан түүхийн эхлэл байв. Энэ цаг дор С.Гангааням цэргийн холбооны хэлтсийг удирдаж байсан юм.

С.Гангаанямыг хэлтсийн даргаар ажиллаж байх хугацаанд БХЯ, ЗХЖШ, Холбооны хэлтсийн төлөвлөгөөгөөр зохион байгуулж байсан удирдах бүрэлдэхүүний оперативын болон даргын бэлтгэл цугларалтуудаас гадна холбооны тодорхой мэргэжил эзэмшүүлэх, дээшлүүлэх урт, богино хугацааны сургалт дамжаа нь холбооны шинэ техник хэрэгсэл олноор ирсэн тухайн үед холбоочдыг сургаж бэлтгэхэд ихээхэн ач холбогдолтой байлаа.

Холбооны цэргийн удирдлагаас холбоочдын сургалт бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгох, удирдах бүрэлдэхүүн, салбар салааны захирагч, нийт офицер, ахлагч нарын мэдлэг чадвар, дадлага, заах арга зүйг дээшлүүлэх, сургалтын материалаг баазыг бэхжүүлэх талаар авч хэрэгжүүлсэн бүхий л арга хэмжээ нь сургалтын чанарт тодорхой ахиц өөрчлөлт гарч байсан байна. С.Гангааням гуай ч холбоны цэргийн техник хэрэгсэл, станцуудуудыг ашиглах дүрэм, заавар, эмхэтгэл, гарын авлагуудыг мэргэжил нэгт нөхдийн хамт боловсруулан бичиж хэвлэн гаргаж байсан байна.

С.Гангааням 1975-1980 онуудад БХЯ-ны гадаад харилцааны хэлтсийн даргаар ажиллаж байхдаа ч холбооныхоо цэргийг бэхжүүлж хөгжүүлэх үйлсэд хүчин зүтгэсээр байсан юм. Тухайлбал, 1970-аад оноос МАА-ийн Холбооны цэргийн удирдах бүрэлдэхүүн, анги, салбарууд ЗХУ-ын Зэвсэгт хүчний холбооны цэргийн удирдлага, Алс дорнодын байлдааны ажиллагааны театр, Өвөр байгалийн цэргийн командлал, Монгол байрлаж байсан 39 дүгээр армийн холбооны цэргийн удирдлага, холбооны цэргийн ангиудтай найрсаг харилцаа, ажил хэргийн нягт уялдаа холбоотойгоор хамтран ажиллаж, бие биенээс харилцан суралцах, тусламж дэмжлэг үзүүлэх ажил арга хэмжээг бүхий л хэлбэрээр өргөн зохиодог уламжлал тогтсон байлаа¹.

¹ Цэргийн холбооны түүхийн тойм. УБ., 2001.т.290



Цэргийн холбоочдын эгнээнээс төр, цэргийн нэрт зүтгэлтэн, ард олондоо дуурсагдах алдар гавьяатнууд олноор төрөн гарсан билээ. Эдгээр хүмүүсийн нэгэн томоохон төлөөлөгч нь Армийн холбооны дарга, ААЖШЫН Холбооны хэлтсийн дарга, БХЯ-ны Гадаад харилцааны хэлтсийн дарга, БХЯ-ны Гадаад харилцааны хэлтсийн дарга, БНМАУ-аас ЗСБНХҮ-д суух Элчин сайдын яамны Цэрэг-агаарын цэргийн аташше, БНМАУ-ын СнЗ-ийн тусгай хэлтсийн орлогч дарга асан хошууч генерал Сайжрахын Гангааням гэдгийг

онцлон тэмдэглэж байна. Тэрээр ажил амьдралынхаа ихэнх жилүүдийг холбооны цэргийг бэхжүүлэн хөгжүүлэх үйлсэд шууд болон харьялан удирдаж мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, цэрэг-улс төрийн хүнд нөхцөлд холбооны цэргийг өргөтгөн зохион байгуулж, бүтцийг нь боловсронгуй болгох, анги, салбаруудыг шинэ техник хэрэгслээр хангаж аж ахуй, зохион байгуулалтын хувьд бэхжүүлэх, бие бүрэлдэхүүнийг сургаж дадлагажуулах үйл хэрэгт үнэтэй хувь нэмэр оруулсан төр, цэргийн зүтгэлтэн, эрдэмтэн, сурган хүмүүжүүлэгч байсан юм.

Ашигласан материал:

1. Монгол цэргийн түүхийн товчоон УБ., 1996
2. С.Гангааням. Монголчууд тусгаар тогтолцоо хамгаалахаар тэмцэн нь. УБ., 1993
3. Цэргийн холбооны түүхийн тойм. УБ., 2001
4. Цэргийн эрдэм судлалын 50 жил. УБ., 2009
5. Б.Равжаа. Эрдэм шинжилгээний бүтээлийн дээж. УБ., 2018
6. Б.Равжаа. Дурсамж дүүрэн амьдрал минь. УБ., 2018 ЭНХИЙ ҮЙЛСЭД т.302 ,298



МОНГОЛ УЛСЫН МАРШАЛ Г.ДЭМИДИЙН ЦЭРГИЙН БОЛОВСРОЛ СУРГАЛТЫГ ХӨГЖҮҮЛЭХЭД ГҮЙЦЭТГЭСЭН ҮҮРЭГ

X.ОРХОНЧИМЭГ /УБХИС-ийн Нийгэм Хүмүүнлэгийн тэнхим,

доктор (Ph.D), дэд профессор/

Түлхүүр үг: Боловсрол, сургалт, цэрэг

Key words: Education, training, soldier

ХХ зууны эхэн хагас нь Монгол ардын хувьсгалт цэргийн хөгжилтийн нэгэн шинэ үе байсан юм. Аливаа улсын оршин тогтонохиын гол баталгаа болсон цэрэг батлан хамгаалах бодлого, цэргийн сургалт бол хэзээд чухал асуудал байсаар ирсэн билээ. 1930-аад оны эхэн үе бол Ази Дорно дахинд дайны нөхцөл байдал бүрдсэн түгшүүртэй болж байсан цаг юм.

Манжуурт үссэн цэрэг дайны нөхцөл байдалтай уялдан манай улсын цэрэг батлан хамгаалах салбарын боловсон хүчин цэргийн чадавхийг нэмэгдүүлэх нэн шаардлагтай болж байсан тухайн цаг үед Бүх цэргийн жанжин Г.Дэмидийн цэргийн боловсрол сургалтын талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг тодруулан гаргаж тавих нь Монголын

цэргийн боловсрол сургалтын түүхэнд чухал ач холбогдолтойгоос гадна хойч үеийнхэнд үлгэр авахад нэн тустай билээ.

Г.Дэмидийн намтар түүхийг нилээдгүй судалжээ. Тухайлбал Г.Дэмидийн намтрыг тухайн үед гарч байсан хэвлэлүүдэд гаргасан байна. Энэ тухай С.Ганболд Дэмид судлалын тоймыг гарган тавьжээ.¹ "1930 оноос Г.Дэмидийг хувьсгалт цэргийн зөвлөлийн тэргүүлэгчээр томилогдсоны дараахан түүний албан ёсны дэлгэрэнгүй намтрыг хэвлэн гаргаснаас хойш түүний тухай нилээд хэдэн удаа зохих ном хэвлэлүүдэд"² гарчээ. Г.Дэмидийг судлаачид нилээдгүй судалжээ. Г.Дэмидийн тухай анхны өгүүлэлийг эрдэмтэн А.Маамуу³, 70 насных нь ойгоор Ж.Наадгай⁴, 85 жилийнх нь ойгоор

¹ С.Ганболд Монгол улсын өрлөг жанжин Гэлэгдоржийн Дэмид.УБ.,2000. тал 6-17

² Хувьсгалт улаан цэргийн бодлого сэргүүл.1930.No5, Ардын хувьсгалын 10 жилийн ой.Альбом.УБ.,1931, Үндэсний хувьсгалын 13 жилийн ой ба Бүгд Найрамдах засгийн 10 жилийн ойн түүх зургууд.УБ.,1934, Хүндэт удирдагч Дэмидийн түүх.Улаан од сочин.1934.07.11.No37.Ардын үндэсний эрх сочин.1937.07 сар.No56, үндэсний хувьсгалт улаан цэргийн манлай удирдагч бөгөөд баатарлаг байлдагч, хүндэт нөхөр Дэмидийн бие саяхан Улсын бага хурал ба Засгийн газраас цусан гавьяаны улаан одон тэмдэгээр шагнагдав. Улаан од сочин.1934.11.23.No67, Манай үндэсний хувьсгалт улаан цэргийн манлай удирдагч бөгөөд баатарлаг байлдагч, хүндэт нөхөр Дэмидийн бие саяхан Улсын бага хурал ба Засгийн газраас цусан гавьяаны улаан одон тэмдэгээр шагнагдав. Улаан од сочин.1934.11.23.No67, Манай үндэсний хувьсгалт улаан цэргийн манлай удирдагч бөгөөд баатарлаг байлдагч, хүндэт нөхөр Дэмидийн бие саяхан Улсын бага хурал ба Засгийн газраас цусан гавьяаны улаан одон тэмдэгээр шагнагдав. Улаан од сочин.1934.11.23.No67, Х.Чойбалсан. Монгол ардын үндэсний хувьсгалт цэргийн агуу хөгжилтийн товч зам.УБ.,1935. тал121-127, Д.Лосол. Өрлөг жанжин нарт өвгөн партизанаас баярыг хүргээ. Үнэн сочин.1936.No35, Ардын үндэсний эрх сочин.1937. №77-83, Үнэн сочин.1937.No95-98, Улаан од сочин.No41, 57, 58, БНМАУ-ын 17-р онц бага хурлын илтэл, тогтоол,УБ.,1932, Хувьсгалт намын 3-р онц бүгд хурал дээр нөхөр Дэмидийн шүүмжилсэн шүүмжлэл, Үнэн сочин.1932.07.09.No157, Улсын долдугаар их хурлын илтгэл ба тогтоол.УБ.,1935, Цэргийн яамны сайд, Бүх цэргийн жанжин,нөхөр Дэмидээс улсын 18-р бага хуралд эрдүгээгүй гадаад дотоодын онц чухал байдлаас авч шүүмжлэн хэлсэн үг.Улаан од сочин.1934.04.07.No19, МАХН-ын IX их хурал.Дэлгэрэнгүй тайлан.УБ.,1984, Намын есдүгээр их хурал дээр хүндэт нөхөр Дэмидээс шүүмжилсэн шүүмжлэл.УБ.,1934

³ А.Маамуу.Ардын хувьсгалт цэргийн нэрт жанжин.Үнэн сочин.1965.06.29.No180, Улаан од сочин.1965.No77

⁴ Ж.Наадгай. Хувьсгалт цэргийн нэрт жанжин Г.Дэмид.Ардын арми сэргүүл.УБ.,1970.No4, тал 58-63

⁵ Д.Гомбосүрэн. Маршал Дэмид.Улаан од сочин.1985.06.29.No52, Дэмид жанжин консервт хордож үхсэн нь худлаа.Ардчилал сочин.1997.12 сар.No18, Маршал Дэмидийн үхлийн талаар өгүүлэх нь.Өнөөдөр сочин.1998.08.13.No155, Маршалын үхлийн талаарх эргэцүүлэл.Соёлбо сочин.1988.4 сар.No15, Стalin бид хоёр мотобригад өгнө, Дэмид авахгүй.Ням гараг сочин.1997.11.16.No46, Монгол улсын зэвсэгт хүчиний байгуулалтын түүх.(1921-1956).Тэргүүн дэвтэр.УБ.,1998, Монгол цэргийн түүхийн товчоон.Дэд дэвтэр.УБ.,1996, Монголын нисэх хүчин.УБ.,1995



Д.Гомбосүрэн⁵, О.Пүрэв⁶, Л.Зоригт⁷ нар судалж өгүүлэл бичжээ. Нам төрийн ахмад дайчдын дурсамж, дуртгалууд нилээд байна. Тухайлбал 1985 онд хэвлэгдсэн Монгол ардын журамт цэргийн дуртгал⁸, мөн цэргийн түүхийн баримт бичгүүд⁹, Ч.Дашдаваа¹⁰, С.Баатар¹¹, С.Гангааням¹², Э.Лувсанбалдан¹³, О.Батсайхан¹⁴, Б.Даваасүрэн¹⁵, Ш.Агаан¹⁶ С.Ганболд¹⁷, Л.Бат-Очир¹⁸, Ц.Батбаяр¹⁹ нар өгүүлэл болон нэг сэдэвт бүтээлүүд бичжээ. Мөн Г.Дэмидэд зориулсан эрдэм шинжилгээний хурлын материал, түүний төрөл төрөгсөдтэй нь уулзсан ярилцлага нилээд гарчээ"²⁰. Судлаач И.Чинбат²¹ Соёмбо-БХИС сонины 2015 оны №10 дугаарт Маршал Дэмидийн цэргийн сургалтанд суралцагч төвтэй сургалт буюу мэдлэг бүтээх идэвхтэй сургалтын аргыг нэвтрүүлэхийг чухалчилж байсан

тухайд холбогдох баримтыг БХТА-аас олж сонирхолтой өгүүлэл нийтлүүлжээ. Эдгээр бүтээлүүдэд түүний намтар түүхийг нилээдгүй судалсан боловч түүний цэргийн боловсролд оруулсан хувь нэмрийг судалсан нь бага байна. Иймд энэхүү өгүүлэлд түүний цэргийн боловсрол сургалтанд оруулсан хувь нэмрийг тодруулан гаргахаар зорьлоо.

Г.Дэмид 1900 онд Сайн ноён хан аймгийн Сэцэн чин вангийн хошуу одоогийн Архангай аймгийн Их Тамир сумын нутагт малчин ардын гэрт төрсөн бөгөөд 1921 онд Ардын журамт цэрэгт сайн дураараа элсэж, гадаадын түрэмгийлэгчдийг эх орноосоо хөөн гаргаж, ардын хувьсгалын ялалтыг хангах үйл хэрэгт идэвхтэй оролцсон юм.

Г.Дэмидийн тухай Өлзийбатын бичсэн "Бүгд Найрамдах Монгол Ард Улсын

⁶ О.Пүрэв. Монгол ардын хувьсгалын түүхэнд холбогдох нутаг, газар усны нэрийн товч тайлбар толь. УБ.,1983. Тал 97

⁷ Л.Зоригт. Өрлөг жанжин Дэмид.Улаан од сонин.1988.04.23.No23

⁸ Комиссаруудын дуртгал.УБ.,1971, МАХН-ын ахмад ажилтан гишүүдийн дуртгал. I дэвтэр, УБ.,1978, Монгол ардын журамт цэргийн дуртгалууд.I,II,III дэвтэр.УБ.,1982, 1985, 1986, Н.С.Соркин.Анхны хэвлэл. УБ.,1972

⁹ Монгол ардын арми 50 жил.УБ.,1971, МАХЦ-ийн түүхэнд холбогдох баримт бичгүүд.(1921-1945). Эмхтгэсэн.Ц.Чойндон.УБ.,1974

¹⁰ Ч.Дашдаваа.Өрлөг жанжныг сталинизм егүүтгэсэн.Улаан од сонин.1990.03.14.No21

¹¹ С.Баатар.Үнэн гавьяат өрлөг жанжин.Улаан од сонин.1990.03.17.No22

¹² С.Гангааням.МАХЦ-ийн дээд удирдлага.цаг үе хүмүүс.(1921-1940) УБ.,1991.тал 92-95

¹³ Э.Лувсанбалдан. Дэмид жанжин баруун хилд.Ардын эрх сонин.1993.09.21.No149

¹⁴ О.Батсайхан.К.Ворошилов.Дэмидийн үхэл тун сэжиглэл бүхий явдал.Ардын эрх сонин.1996.09.10. №180

¹⁵ Б.Даваасүрэн. Г.Дэмид. Илтгэл, өгүүлэл, хэлсэн үг.эмхэтгэл.(1930-1937), Ч.Дашдаваагийн хамт. УБ.,1991, МАХН-аас цэргийн боловсон хүчин бэлтгэх талаар явуулсан бодлого, үйл ажиллагаа. (1921-1940). УБ.,1990

¹⁶ Ш.Агаан. Х.Чойбалсан ба Дотоод явдлын яам.УБ.,1991, Маршал Дэмид.УБ.,1994,

¹⁷ С.Ганболд.Хасагийн дээрэмчийг утгасан нь.Тусгаар тогтолц сонин.1994.,10.1-10.No28, Монголд 1932 онд гарсан зэвсэгт болсого.(Цэрэг түүхийн шинжилгээ),докторын диссертаци.УБ.,2000, Бүх цэргийн зөвлөл.(1921-1934).Баримтын эмхэтгэл. Д.Гомбосүрэн, Н.Хишигт нарын хамт.УБ.,1997, Монгол улсын өрлөг жанжин Гэлэгдоржийн Дэмтд.УБ.,2000

¹⁸ Л.Бат-Очир. Чойбалсан. Намтрын балархайг тодруулахуй.УБ.,1996

¹⁹ Ц.Батбаяр. Монгол ба Япон ХХ зууны эхэн хагаст.УБ.,1998

²⁰ Монгол улсын төр цэргийн зүтгэлтэн маршал Г.Дэмид.Г.Дэмидийн мэндэлсний 95 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл.УБ.,1996, Н.Н.Литвинов. 1930-аад. оны үеийн Монгол улсад интернационалч үүрэгтээ үнэнч. Дуртгал өгүүллийн эмхэтгэл.УБ.,1987.тал 105-106, Ч.Сүрэнжав. Өрлөг жанжны тухай өгүүлэх минь. Тусгаар тогтолц сонин.1992.No30.Маршал жанжин Дэмид. ярилцлага.Үнэн сонин. 1994.01.11.No3, А.Думбурай. Ямар ч нөхцөнд нам төрдөө тэрсэлж болдоггүй юм шүү.Н.Элбэгийн дурсамж. Залхаан цээрлүүлэлт.УБ.,1997. тал 43-47, У.Амарсайхан.Дэмид жанжны нуудгай хүү.Н.Авирмэдтэй хийсэн ярилцлага.Засгийн газрын мэдээ сонин. 1995.07.11.No79, Жанжин Дэмидийнхийн удам тасраагүй. Я.Чимэдбумаатай хийсэн ярилцлага. Зууны мэдээ сонины хавсралт.24 цаг сонин.2000.02 сар.No34, Б.Батжаргал. Жанжин Дэмидийнхэн.Д.Оюунтай хийсэн ярилцлага.Өнөөдөр сонин. 1999.12.18.No294, БХЭШХ. Монгол улсын төр цэргийн гарамгай зүтгэлтэн Гэлэгдоржийн Дэмид. Монгол улсын маршал Гэлэгдоржийн Дэмидийн мэндэлсний 100 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл.УБ.,2001

²¹ И.Чинбат. Маршал Г.Дэмид: Аль ч талаараа заах аргын үлгэртэй сургуулийг олж авах ёстой.Соёмбо-БХИС.2015.No10 (51)



улаан цэргийн улс төрийн сургуульд суралцах дэвтэр" хэмээх бүтээлд "Улаан цэргүүдийн өөрийн удирдагч нөхөр жанжнаас үлгэрийг авагтун" хэмээх гарчгийн дор Нөхөр Дэmid бол бол Архангай аймгийн яду ардын хүү бөгөөд анх партизан отрядын жинхэнэ жагсаалын цэргээс эхлээд Цэргийн яамны сайд хувьсгалт цэргийн зөвлөлийн тэргүүлэгч бүх цэргийн жанжны тушаал хүртэл дэвшиж ирсэн хувьсгалын замтай байна.

Нөхөр Дэmid бол бол хуучин Цэцэрлэг мандал аймгийн Хан-Өндөр уулын хошууны харьяат яду ард Гэлэгдоржийн хүү аргын 1902 (1900) онд төрсөн байна. Нөхөр Дэmidийн эцэг нь гэр яду тул үр хүүхдээ хүмүүжүүлэх ба амь зуухын эрхээр баян ноён феодал этгээдийн хүнд хар ажлыг хийж хүчээ үнэлүүлж явсан ажгуу. Нөхөр Дэmid арван нас хүртэл эцэг эхийн асрамж тэтгэмжинд байгаад эцгийн хүнд ажилд туслалцах болсон цагаас эхлэн феодалын мөлжөлгийн хүнд хохирлыг өөрийн биеэр үзэж ард түмэн нь хятадын сөнөхүй худалдаачин хөрөнгөтөн ба хар шар харгис том феодалын дарлалыг хүлээж буй байдлыг таньснаас бага насандаа эрх чөлөөний суртал бодлогыг шингээж чадсан тул Монгол Улсын 11-р онд Үндэсний хувьсгалын хөдөлгөөн 18 насандаа өөрийн сайн дураар улаан партизаны отрядад элсэн ороод амь биелг хайлалгүй идэвхтэйгээр тэмцэж баатарлаг гавьяа өөрийн нөхдөд сайн үлгэрийг үзүүлж явсан ба цагааны этгээд хийгээд ард түмнийг дарлагч этгээд хар шар харгис феодал, хятадын шунахай хөрөнгөтөн нар лугаа ардын эрх чөлөөний төлөөнөө эрс зоригтойгоор байлдаж явсан болно"²² гэжээ.

Улмаар тэр цагааны цэргийг дараахад идэвхтэй оролцсон байна. Энэ тухай Өлзийбат бүтээлдээ "Нөхөр Дэmid бол бол Идэр Чулуутай, Цэцэрлэг зэргийн газар

байсан цагааны отрядыг сөнөөн арилгах хэрэгт чухал хэргийг бүтээж ард түмнийг дээрэмдэн авсан цагааны этгээдийн ихээхэн хөрөнгө хогшигийг булаан авсан баймуй. Үүний дараагаар нөхөр Дэmid нь Сүхбаатараас дуудсан ёсоор Улаанбаатар хотноо ирж Сүхбаатарын хамтаар Сэлэнгэ зэрэг газраар цагааны этгээдүүдийн үлдэгдлийг бүрмөсөн арилгахаар явсан атал уул ажлыг амжилттайгаар гүйцэтгэж ирсэн болно. Үүний дараагаар Алтанбулаг хотноо цагааны отрядуудын үлдэгдлийг устгах ба хил хязгаарыг хамгаалахаар очиж ажиллахдаа сахилга журмыг нэн хатуугаар сахиж сайн чанарыг илэрхийлэн бусдад үлгэр дууриалал болж байсан"²³ гэжээ.

Г.Дэmid цэрэг ардыг сурган боловсруулахад өөрийн биеэр үлгэр болохын хамт сайн сургагч байжээ. Тухайлбал "Нөхөр Дэmid бол бол Улаанбаатар хотноо Цэргийн ерөнхий сургуулийн есөн сарын курсыг төгсөж тэднээс курсын даргын үүргийг хүлээж аваад сахилга журмыг хатуугаар сахиж санаачлага оролдлого идэвх хичээлийг дүүрнээр гаргаж салаан даргын үүргийг сайнаар гүйцэтгэсэн тул суман даргын туслах болсон ба мөн дараагаар нь суман даргын тушаалд дэвшиж таван жилийн хугацааны дотор суман дарга явахын завсар улаан цэргийн дотор олон тооны хувьсгалч дарга нарыг хүмүүжүүлэн гаргахын хамтаар ерөнхий сургуулийн нам улс төрийн ажлыг удирдан явуулж байсан байна"²⁴ гэнээс харахад тодорхой байна.

Мөнтүүний тухай "Ерөнхий сургуулийн дотор нөхөр Дэmidийг тэргүүн морины сайн даргад тоолж ямагт хүндэтгэн үзэж байсан болмуй. Монгол Улсын арван зургадугаар онд нөхөр Дэmid СССР-ийн Тверь хотноо морин цэргийн сургуульд томилогдон очиж уул сургуулийг сайнаар

²² Өлзийбат. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын улаан цэргийн улс төрийн сургуульд суралцах дэвтэр. УБ.,23-р он (1933).тал 39

²³ Өлзийбат. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын улаан цэргийн улс төрийн сургуульд суралцах дэвтэр. УБ.,23-р он (1933).тал 40

²⁴ Өлзийбат. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын улаан цэргийн улс төрийн сургуульд суралцах дэвтэр. УБ.,23-р он (1933).тал 41



төгсөөд Хорин есдүгээр онд ажлын чухалд дуудан ирүүлж Цэргийн ерөнхий сургуулийн дарга комиссараар томилсонд хувьсгалт улаан цэргийн дарга суртлын албан хаах үндэсний шинэ хүчинийг бэлтгэх ба улаан цэргийг хүмүүжүүлэн боловсруулж хувьсгалын бат нэгдлийг бэхжүүлэх хэрэгт их ажлыг хийж дэлхийн ажилчин ба дарлагдсан ард түмний ашиг тусыг хамгаалж буй СССР-ийн улаан цэргийн дотор сурч боловсорсон эрдэм чадварыг бусдад өгөхийг оролдох хятадын шунахай хөрөнгөтөн ба цагааны хулгай дээрэмчин хийгээд хар шар харгис феодалуудтай ард түмний эрх чөлөөний төлөөнөө байлдан тэмцэж явсан үлгэр туршлагаар улаан цэргүүдийг хүмүүжүүлэн боловсруулж байсан байна²⁵ гэснээс харахад Цэргийн ерөнхий сургуулийн захидал байхдаа цэргийн сургуулийн сурагчдыг сурган боловсруулах, цэргийн сургалт тогтолцоог бэхжүүлэхэд ихээхэн анхаарал тавьж байжээ. Тухайлбал тэр Бүх цэргийн ерөнхий сургуулийн бүтцэд 1929 онд зарим өөрчлөлт оруулжээ. Үүнд: "Бүх цэргийн зөвлөлөөс 1929 оны 09 сарын 20-нд "Монгол ардын хувьсгалт цэргийг өөрчлөн байгуулах тухай" нууц 45 тоот тушаал гаргав. Энэ тушаалын 2-р зүйлд Цэргийн ерөнхий сургуулийн газраа байвал зохих аngiud нь мөн газар, жагсаалын анги, сурах анги, улс төрийн суртлын анги, жагсаалын канцеляри, ажил анги, мөн сумангийн хамтаар эмнэлгийн анги, малын эмнэлэгийн анги, морин цэргийн тасаг, намын анги, Сүхбаатарын сургууль ба хөгжим эдгээр болмой. Техникийн суманг татан буулгаж мөн албан хаагчдыг тус газрын морин тасаг, дивизын их бууны хороо хийгээд цэргийн яамны харилцах холбооны сумангуудын орон тоог тус тус нөхөн гүйцэтгэвээс зохимой"²⁶ гэжээ. 1924 ба 1929 оны

төсвийг харьцуулан үзсэн судалгаанаас үзэхэд Цэргийн ерөнхий сургуулийн төсөв "1924 онд цалин бүх төсвийн 36,4%-ийг эзэлж байсан бол 1929 онд 67%-д"²⁷ хүрч хоёр дахин нэмэгджээ. Мөн 1929-1932 оноос Цэргийн ерөнхий сургуульд дараах 14 мэргэжлээр сургагч багш, мэргэжилтэн урьж ажиллуулжээ. "Ерөнхий сургагч Криченко, улс төрийн сургагч Сидельников, Штабын дарга Баторун, тактикийн багш Руденко, пулеметын багш Навроцкий, хуягт танкийн багш Головин, артилерийн багш Дзавин, холбооны багш, топографийн багш, биеийн тамирын багш Егоров, сургуулийн эмч Опилат, туслах эмч, малын бага эмч Тимошков, Козаков"²⁸ нарыг ажиллуулсан бөгөөд гадаадын мэргэжилтэн нарыг урьж ажиллуулснаар тухайн үедээ цэргийн сургалтыг сайжруулахад хувь нэмэрээ оруулжээ.

Г.Дэmid цэргийн боловсрол сургалтыг явуулахын чухлыг гүнзгий ойлгож байжээ. Тэр "Хэрэв бид нараас өөрийн цэргээ сурган боловсруулан тэд нарын улс төрийн ба байлдааны бэлтгэлийг нэмэгдүүлэхгүй буюу хатуу чанга байгуулалт хийхгүй ахул нам ба улсаас Ардын хувьсгалт цэрэгт зориулсан зүйлийг бөөн цусаар хариулахад хүрнэ"²⁹ хэмээн цэргийн боловсрол сургалтын чухлыг тодорхойлж байжээ.

Г.Дэmid Монгол ардын хувьсгалт улаан цэргийг анх байгуулагдсанаас хойш 10 жилийн ойн баярт зориулж "Улаан цэргийн хөгжсөн түүх" хэмээх бүтээлийг бичсэн бөгөөд энэхүү бүтээлийн гуравдугаарт байх Бүгд Найрамдах Монгол Ард Улсын зэвсэгт хүчиний байгуулалтын тухай бүлгийн дотор "Тус улаан цэргийн байлдааны сүр боловсрол хэрхэн хөгжсөн тухай" бичжээ. Үүнд: "10 жилийн ойн баярын үед тус улаан цэргийн

²⁵ Өлзийбат. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын улаан цэргийн улс төрийн сургуульд суралцах дэвтэр. УБ.,23-р он (1933).тал 41

²⁶ БХТА.Ф1.Д1.ХН169.тал 1-10.Монгол улсын батлан хамгаалахын их сургууль.УБ.,2001.тал 44

²⁷ БХТА.Ф1.Д1.ХН178.тал 122-123.Монгол улсын батлан хамгаалахын их сургууль.УБ.,2001.тал 54-55

²⁸ БХТА.Ф5.Д1.ХН115.тал 5-6.Монгол улсын батлан хамгаалахын их сургууль.УБ.,2001.тал 59

²⁹ БХТА.Ф1.Д1.ХН183.тал 42. С.Ганболд Монгол улсын өрлөг жанжин Гэлэгдоржийн Дэmid.УБ.,2000. тал 28



улс төрийн зэрэг боловсрол ихээхэн хөгжилтэй болсны хамтаар техникийн боловсрол нэгэн адил хөгжсөн нь бэлхнээ нүдний өмнө илэрхий амой. 10 жилийн их баярын үед тус хувьсгалт улаан цэргийн зөвлөлөөст тус Монгол Улс нь туйлын их бус боловч техникийн боловсрол бүхий улаан цэрэгтэй болсон хэмээн харьят олон түмэн ардуудад урамтайгаар мэдүүлж чадах болой. Тус улаан цэргийн тоо төдий л нэмэгдсэнгүй боловч түүний байлдааны хүчин 2-3 хувьд хүртэл нэмэгдсэн амой. Энэ 1931 онд харьят Засгийн газраас батлан нийтэлсэн хуулийн ёсоор нутгийн цэргийн эрдэмд боловсруулсаар баймой. Энэ жилд энэ ажлыг шалган үзэхэд уул хэрэг бүтээмжтэй болжээ. Харьят олон ардуудыг тэдгээрийн аж ахуйгаас удаан хугацааны дотор холдуулахгүйгээр цэргийн эрдэмд боловсруулах арга замыг нэгэнт олж авчээ. Нутгийн түр сургуулийн янз маяг нь зохих насны ардуудыг тус тусын сууж буй аймгийн дэвсгэрийн дотор байгуулагдсан хороонд татан ирүүлж цэргийн сургуулийн таван жилийн дотор үйлдүүлэх үүнд анхдугаар жилийн сургууль нь 4 сар, бусад 4 жил бүрт хоёр хоёр сараар сургууль үйлдүүлэх тул 5 жилийн дотор сургууль үйлдэх сар нь 12 болох бөгөөд энэхүү хугацаа нь морьт цэргийг бэлтгэх явдалд хүрэлцэх болно. Үлэмжхэн нарийн техник бүхий тусгай боловсролтой цэргийн ангийг жинхэнэ бүх цэргийн үргэлжид байх ангид цэргийн албыг хаалгах тухай зарласан нийтийн дүрмийн ёсоор татан ирүүлж сургуулилах болно. Нутгийн түр сургууль үйлдүүлэх маяг нь олон ардуудаас цэргийн албыг хийх явдлыг хөнгөлөн нөгөөтэйгүүр дайн байлдаан болох цагт бүх цэргийн тоог нэмэгдүүлэх болно"³⁰ гэжээ.

Эндээс харахад тэрбээр цэргийн энчнээ сургалтын арга хэлбэрийг амжилттай хэрэгжүүлж байжээ. Энэ нь тухайн үедээ хамгийн оновчтой сургалтын хэлбэр байсан нь маргаангүй юм.

Тэрбээр цэргийн албан хаагчдын бичиг үсгийн боловсролын тухайд анхааран ажилласан нь хэрхэн үр дүнд хүрсэн тухайгаа "Дайны аюул ба БНМАУ-ын ард нийтийн гүйцтгэх үүргүүд илтгэлдээ" цохон тэмдэглэснээс үзэхэд "1931 онд цэргийн албанаас бүрмөсөн халагдагсдын бичиг үсгийн тухай" хэмээн тодорхойлон хэлэхдээ "Энэ жилд есөн хороодоос хугацаа дуусч халагдсан цэрэг ба бага тушаалын дарга нарын дотор бичиг үсэг үл мэдэх хүмүүс хэд байсныг тодорхойлоос сайн ба дунд бичигтэй 60%, бага мэдэх 36%, бичиг мэдэхгүй 4%. Эвлэлийн гишүүдийн соёл боловсролын дэвшилт, латин, монгол бичиг үсгийн тухай мэдээгээр баримталбал хувьсгалт улаан цэрэг нь олон түмэн ажилчин ардын ба ангийн чанартай бөгөөд нам, засаг хийгээд намын ерөнхий шугамыг батлан хамгаалах үндсэн тулгууртай ба тус улсын олж авсан хувьсгалын гүн хэргийг бат итгэлтэйгээр хамгаалж чадах жинхэнэ олон түмэн ардын ангийн чанартай болжээ"³¹ хэмээн дүгнэжээ.

Эндээс харахад тэрбээр ард иргэдийг бичиг үсэгт тайлах улсын чухал ажлыг өөрийн салбарт үр дүнтэй биелүүлж байжээ.

Тэрбээр цэргийн албан хаагчдыг тусгай мэргэшүүлэн бэлтгэсэн тухайд анхааран ажилласан нь хэрхэн үр дүнд хүрсэн тухайгаа "Дайны аюул ба БНМАУ-ын ард нийтийн гүйцэтгэх үүргүүд илтгэлдээ" цохон тэмдэглэснээс үзэхэд "1931 онд улаан цэргийн боловсон хүчнийг бэлтгэсэн тухай тодорхойлон хэлэхдээ" Цэргийн албанаас бүрмөсөн халагдах цэргүүдийн дотроос 5 жилийн төлөвлөгөө ба хамтралын байгуулалтын гүйцэтгэхийн тулд боловсон хүчнийг бэлтгэх тухай намын анхдугаар бага хурлын тогтоолын ёсоор энэ жилд биеэр гүйцэтгэх явдлыг олж чадсан бөгөөд дээр дурдсан 9 ангиудаас (8 хороо, нэг суман) бүгд халагдах 698 цэргүүдийн дотроос

³⁰ Г.Дэмид. Илтгэл, өгүүлэл, хэлсэн үг.(1930-1937). УБ.,1991.тал 51-52

³¹ Нийгэм журмын сэтгүүл.УБ.,1931.No41-42. Г.Дэмид. Илтгэл, өгүүлэл, хэлсэн үг.(1930-1937). УБ.,1991. тал 63



432 хүнийг элдвээр тодорхойлвоос 432 хүмүүсээс 41,5% нь хамтрын байгуулагч сургуулийг үйлдсэн, 21,5% нь кооперативийн худалдагчдын сургуулийг үйлдсэн, 14% нь хамтрын нягтлан бodoх, бичгийн сургуулийг үйлдсэн, 16% нь нам эвлэлийн ажлын сургуулийг үйлдсэн, 3% нь үйлдвэрчний ажлын сургуулийг үйлдсэн, 1% нь цахилгаан мэдээ авагчдын сургуулийг үйлдсэн. Үүнээс үзвэл цэргийн албан хаагчдаас халагдагсын дотроос боловсон хүчнийг бэлтгэх явдалд олонхи тоо нь оржээ. Эдээр сургуулиудаас үйлдэж гарагдаас тус тусын байгууллагуудаас төв кооператив ба хамтрын төв хороодоос сургуулийг үйлдсний тухай үнэмлэхүүдийг авч хөдөө нутагтаа одож тус тусын тусгай боловсролоор ажиллах болжээ.

Улаан цэргийн албанаас халагдагсад нь хөдөө нутагтаа одож тус тусын тусгай боловсролоор ажил хийвэл зохих хүмүүсийг зохих ажилд томилсон элссэн тухайн тоог хувьсгалт цэргийн зөвлөлөөс мэдэж үл чадна. Түүнээс гадна Бүх цэргийн улс төрийн газар нь халагдсан цэргүүдийн дотроос зохих газруудын ажилд шууд явуулсан хүмүүс 180 болохоос Худалдаа үйлдвэрийн яамны аж үйлдвэрийн газарт 58, Монголтрансад 19, цагдан сэргийлэхэд 61, засан сайжруулах газар 10, Монголын төв кооперативт 11, хотын намын хороогоор уламжлан хувьсгалт залуучуудын ажилд 5, мөн төв хороогоор уламжлан 7, хотын намын хороогоор уламжлан хувьсгалт залуучуудын ажилд 5, мал тариалангийн яаманд 3, цахилгаан мэдээ ба телефон утасны ажилд 2 эдгээр хүмүүсийн тоог үзвээс зууны 42,7% нь аж үйлдвэрийн газар явсан байна. Үүнээс гадна энэ жилд мөн улс төрийн газар нь халагдсан цэргийн дотроос сургуульд явуулсан хүмүүс 56 болохоос эв хамт намын Дорно зүгийн КҮТВ-ын сургуульд 28, Рабфакт 8, дотоодын олон сургуульд 20 хүмүүсийг тус тус явуулсан байна. Гаргах санал нь 5 жилийн төлөвлөгөө ба хоршоо, хамтрын байгуулалтыг

гүйцэтгэхийн тулд шинэ боловсон хүчнийг бэлтгэх тухай намын 1 дүгээр бага хурлын зааврыг ерөнхийд нь энэ жилд бүх цэргээс хангалттайгаар гүйцэтгэсэн гэж тооцвоос зохино³² гэжээ. Үүнээс хараад тухайн үедээ мэргэжилтэй ажилчин бэлтгэх боловсролын үйл хэрэгт цэргийн сургалтын оруулсан хувь нэмэр чухал байсан төдийгүй энэ үйл хэрэгт Г.Дэмидийн гүйцэтгэсэн үүрэг ихээхэн байсныг илтгэж байна.

Тэрбээр Монгол улсын тусгаар тогтолцд МАХЦ-ийн үүргийг онцлон, улсыг батлан хамгаалахад цэргийн сургууль боловсролын үүрэг оролцоог чухалчлан үзэж байсан тухайгаа "Улсыг хамгаалах улаан цэргийн идэрчүүдийн түр сургуулийн зорилгыг эрчимтэйгээр биелүүлье" илтгэлдээ" цохон тэмдэглэсэн байна. Тухайлбал "...Байлдааны ба техникийн хүчээр боловсрон хөгжиж бүхий Монголын ардын үндэсний хувьсгалт улаан цэрэггүй бол Монголын үндэсний тусгаар тогтоносон улс төр ба ардын эрх чөлөөт байдал нь аюулд орно... Иймийн тул Монголын олон түмэн, идэр залуучууд нь байлдааны ба техникийн эрдэм боловсролд цэрэгжин боловсрох явдал нь

1. Өөрсдийн эрх чөлөөт тусгаар тогтоносон улс төрөө батлан хамгаалж, хувьсгалт улаан цэргийн сүр хүчийг улмаар зузаатгах
2. Өөрийн биеийг монгол бичиг үсэг болон улс төрийн боловсролоор хүмүүжүүлэх
3. Нийт ардын аж ахуй ба соёл боловсролыг дээшлүүлэх, шинэ хүчнийг төрүүлэн бэлтгэх
4. Цэрэг ба ард түмний хэлхээ холбоог улмаар зузаатгах ийм ихээхэн ач тустай болно.

Учир ийм дээрээс ардын хувьсгалт засгийн газраас харьят олон түмэн идэр эрчүүдээ жил бүр цэргийн түр сургууль байгуулж хуралдуулан цэргийн эрдэм сургуульд хүмүүжүүлэн боловсруулснаар

³² Нийгэм журмын сэтгүүл.УБ.,1931.№41-42. Г.Дэмид. Илтгэл, өгүүлэл, хэлсэн үг.(1930-1937). УБ.,1991. тал 64



ирсэн удаа журмын ёсор энэ 23 он (1933) зуны цагт идэр эрчүүдийг цэргийн түр сургуульд боловсруулах бодлогыг гаргахдаа олон түмэн ардуудад боогдол чирэгдэлгүй хамгийн нэгдүгээр хөнгөн дайчилгааны төлөвлөгөөгөөр явуулах бөгөөд үүнд 22-30 нас хүртлэх идэр эрчүүдийг сургуулилах боловч нийтээр нэг адил татаж сургуулилах бус болох ба негөө талаар бүх сургуулийн бүхий л хоол хүнсийг орон нутгийн ард түмнээс албачлан гаргуулах биш улсын сангаас үнийг гаргаж зохих газруудаас нийлүүлэн хэрэгжүүлэхийн дээр түр сургуулийн цэргүүд нь хувьас буюу бусдаас морьд хэрэглэх боловч түүний хөлс, морь нэг бүр 10 төгрөгийн зохих хөлс олгуулж хохиролгүйгээр гүйцэтгүүлэх гэсэн байна. Олон түмэн ардуудаас хувьсгалт улаан цэргийн эрдэм сургуульд боловсрох нь улс төрийн талаар ба өөрийн биеийн хүмүүжил боловсролын талаар онц ашиг тустай чухлын чухал хэрэг гэгчийг танин мэдэж өргөнөөр туслалцан оролцож гүйцэтгэх бизээ хэмээн уриална"³³ гэжээ.

Тэрбээр цэргийн сургуулийн үүрэг оролцооны тухай 1934 оны 3 сарын 5-нд болсон Монгол Ардын хувьсгалт улаан цэргийн намын 2 дугаар зөвлөгөөний хуралд тавьсан "Би цэргийн ерөнхий сургуулийн тухай цөөн зүйлийг тэмдэглэх хэлнэ" хэмээх гарчигтай илтгэлдээ "Цэргийн ерөнхий сургуульд бол хувьсгалт цэргийн зөвлөлөөс шаардаж буй шаардлага тун их юм. Бүх улаан цэргийн манлай, мөрийг үзүүлэх зайлшгүй байгууллага нь Ерөнхий сургууль болно. Улаан цэргийг удирдах дарга, улс төрийн ажилчнийг иөрж үржих, нэмэгдэл үржил нь шууд ерөнхий сургууль дулдуйдан гүйцэтгэсээр ирсэн байна. Одоо хир Ерөнхий сургуулийн дүнг үзвээс өөрийн чухам эзэлбэл зохих суурин дээр дэвшиж эзэлвээс зохих байрыг авч чадаж байна. Хэдий тийм боловч түүний дотор мөн олон зүйлийн хоцрогдол, дутагдал байх бөгөөд үндсэн цэргэгтэй

шадарлан тулгарч өдөр бүр харилцаж, цэргүүдийг эхчлэн хүмүүжүүлэх ба тэд нар лугаа гар бие хамтарч ажил хийх бага дарга нарыг сургаж боловсруулан гаргах үүргийг хүлээсэн байгууллага мөн амой. Манай үндэсний хувьсгалт улаан цэргийн зөвлөлөөс бага дарга нарын хугацааг хоёр жил болгосон бөгөөд хугацааг богино болгоходоо хүнд шаардлагыг тавьсан байна. Бага дарга нарын хугацааг хоёр жил болгохын хамт эдгээрийн хариуцлагын яс чанарыг сайжруулах, мөн тэдний дотроос сайн дураар хоцрох бага дарга нарыг сайшааж, урамшуулж хөгжүүлэх явдлыг чухалчлах хэрэгтэй. Бага дарга нарыг өөрсдийн ногдсон ажилд дүүрэн гүйцэд хариуцлагатай бөгөөд цэрэг нийтийн өмнө хүндтэй болгох нь чухал болой. Манай бага дарга нар нь өөрийн суурийг олж, эзэлж чадаагүй байна. Иймд бага дарга нарын асуултыг эрх биш онц нэгэн зүйл болгон үзэж, улс төрийн ажилчид ба нам эвлэлийн байгууллагуудаас өөрийн анхаарлын төвд агуулж энэ тухай нэхэмжлэлийг тавих явдал чухал болон холбогдоно"³⁴ гэжээ.

Тэрбээр цэргийн албан хаагчдын бичиг үсгийн боловсролын тухайд анхааран ажилласан нь хэрхэн үр дүнд хүрсэн тухайгаа "Дайны аюул ба БНМАУ-ын ард нийтийн гүйцэтгэх үүргүүд илтгэлдээ" 1931 онд цэргийн албанаас бүрмөсөн халагдагсын бичиг үсгийн тухай хэмээн тодорхойлон хэлэхдээ "Энэ жилд есөн хороодоос хугацаа дуусч халагдсан цэрэг ба бага тушаалын дарга нарын дотор бичиг үсэг үл мэдэх хүмүүс хэд байсныг тодорхойлоо сайн ба дунд бичигтэй 60 %, бага мэдэх 36%, бичиг мэдэхгүй 4% гэж илтгэж байсан бол Ардын хувьсгалт намын төв хорооноос 1936 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр гаргасан 44 тоот тогтоолыг хэрхэн биелүүлсэн ба улс орныг батлан хамгаалах хийгээд энэ 1937 онд ардын хувьсгалт цэргээс гүйцэтгэх байлдааны ба улс төрийн бэлтгэлийн

³³ Ардын үндэсний эрх сонин. 1933.05.23.№40. Г.Дэмид. Илтгэл, өгүүлэл, хэлсэн уг.(1930-1937). УБ.,1991. тал 84-86

³⁴ БХТА.Улаан од сонин.УБ.,1934.№13.18. Г.Дэмид. Илтгэл, өгүүлэл, хэлсэн уг.(1930-1937). УБ.,1991.тал 103-104



тухай тавьсан илтгэлдээ "Эдүгээ жилд бичиг үсэгт сургах явдлыг нам улс төрийн ажлын талаар туйлын чухалчилж явуулсан бөгөөд 15 жилийн ойн баярт 6 дугаар сард татагдсан цэргүүдээс бусад хуучин цэргүүд нь 93% бичиг үсэг мэдэх болсон амой. Цэргийн дотор бичиг үсэг үл мэдэх явдлыг арилгах зорилт нь гагцхүү цэргийн бус харин нийт улсын чанартай болсон байна. Жишээлбэл 14 багш нарыг манай засгийн газраас одон тэмдэгээр шагнасан болно"³⁵. Мөн Улс төрийн хичээл сургуулийн тухай "Улс төрийн хичээлийн үндсэн бодлого Бүгд Найрамдах Монгол Ард улс бол манай эх орон, Монгол Улс ба Холбоот улс, Японы эзэрхэг түрэмгий нар бол Монгол Улсын дайсан хэмээх эдгээр зүйлүүд дээр зохион байгуулж явуулсан болно. Өнгөрсөн жилийн дотор улс төрийн хичээлийг ерөнхий эрдмийн нэгэн зэргээр чармайлтыг гаргаж явуулан гүйцэтгэсэн байна. 1936 оны намар цагт тусгай шалгалтыг явуулж үзвээс улс төрийн хичээлийг хангалттайгаар таньсан нь илүү байсан боловч тохиромж бүхий ном дэвтэр үгүйн харгайгаар хэд хэдэн дутагдлуудыг гаргасан тул энэ 1936, 1937 оны сургуулийн жилийн эхэнд улс төрийн хичээлийн дэвтруудийг шинээр зохион гаргасан байна"³⁶

Мөн Шинэ хүчнийг бэлтгэх ажлын тухай "Өнгөрсөн жилд шинэ хүчнийг бэлтгэх ажлыг нэлээд өргөнөөр явуулсан бөгөөд янз бүрийн курст 146 багш нарыг давтан сургаж гаргасны дээр, бэлтгэл улс төрийн ажилчин 18 хүмүүсийг тусгай курсээр бэлтгэн хороо ангиудад явуулсан ба Бүх цэргийн ерөнхий сургуулиас 20 хүмүүсийг бэлтгэн гаргаснаас гадна кино зургийн ажилчин 25, манай эх орон хэмээх ерөнхий зүйлийг илтгэгчид 8-ыг тус тус бэлтгэж ажиллуулсан байна. Бас

нэгэн жилийн дотор 3 удаа нам, эвлэлийн үүрийн нарийн бичгийн дарга наарт тусгай семинарыг өгч гүйцэтгэсэн ба эдүгээ жилд дивиз бүгдэд улс төрийн удирдагчдын нэгэн сарын курст бүх комиссеруудыг давтан сургасан байна. Эдгээр курс сургуулиуд нь улс төрийн ажилчдын ерөнхий эрдэм улс төр ба тусгай боловсролыг нэлээд нэмэгдүүлсэн хэмээвээс зохино."³⁷

Мөн илтгэлд 1937 дугаар оны сургуулийн зорилгын тухай "1. Энэ оны үндсэн зорилго нь улс төрийн ажлын чанарыг улмаар сайжруулах ба нийт цэргийн албан хаагчдын мэдрэлийг дээшлүүлж өөрийн орны аж ахуй, улс төр, соёл боловсролын асуултууд хийгээд гадаад дотоодын байдлыг сайтар таниулаас гадна өөрийн орны тусгаар тогтносон ба чөлөөт байдлыг Японы эзэрхэг түрэмгий нараас хамгаалах хэрэгт байлдагч цэргүүдийн нэгдэл хүчнийг улмаар хуралдуулах ба тус улсын ард түмний эрх чөлөөт байдлыг хамгаалахад Холбоот улс ямар тустай болохыг таниулах явдал болно. 2. Ерөнхий эрдмийн бэлтгэлийг улмаар гүйцэтгүүлэх ба ялангуяа дарга нарыг сайтар сургах хийгээд хувьсгалын 16 жилийн ойн баярт бичиг үсэг үл мэдэх хүн нэг ч үгүй болгох..."³⁸ гэжээ.

Ийнхүү Г.Дэmid улсын VII их хуралд хэлсэн үгэндээ "манай ганзага богино, санхүү нимгэн тэр бүрт тусгай сургууль байгуулахад шинэ хүчнийг гаргана хэмээхэд нэн бэрхтэй бөгөөд зардал ба зааж сургах багш ховор тул манай улаан цэргээс гагцхүү зааж боловсруулах ба хүмүүжүүлэн төрүүлэх нь чухал байна"³⁹ гэж үзэж байв.

"Г.Дэmid техник боловсрол хөгжих тутам цэргийн байгууллага нарийн болж ийм болох тутам цэргийн тактик хувирч ерөөс цэрэг бол тогтсон намагтай адил

³⁵ МАХН-ын төв архив. Ф1.Д6.ХН21.тал 128-144. Г.Дэmid. Илтгэл, өгүүлэл, хэлсэн уг.(1930-1937). УБ.,1991.тал 124

³⁶ МАХН-ын төв архив. Ф1.Д6.ХН21.тал 128-144. Г.Дэmid. Илтгэл, өгүүлэл, хэлсэн уг.(1930-1937). УБ.,1991.тал 125

³⁷ МАХН-ын төв архив. Ф1.Д6.ХН21.тал 128-144. Г.Дэmid. Илтгэл, өгүүлэл, хэлсэн уг.(1930-1937). УБ.,1991.тал 126

³⁸ МАХН-ын төв архив. Ф1.Д6.ХН21.тал 128-144. Г.Дэmid. Илтгэл, өгүүлэл, хэлсэн уг.(1930-1937). УБ.,1991.тал 127-128

³⁹ Г.Дэmid. Илтгэл, өгүүлэл, хэлсэн уг.(1930-1937). УБ.,1991.тал 100



байж болохгүй цэргийн эрдэм нь өдөр ирэх тутам оргилж явах ёстой гэж сурган сургалтанд хэрэглэх төрөл бүрийн дүрэм заавар, гарын авлага зэргийг шинээр боловсруулан гаргажээ.⁴⁰

"Г.Дэмид Хэрэв байлдааны бүх техникийн хүчээр боловсон хөгжиж бүхий ... цэрэггүй бол Монголын үндэсний тусгаар тогтоносон улс төр ба ардын эрхт чөлөөт байдал нь алдагдаж дийлгэдэнэ⁴¹ гэж үзэн МАХЦ-ийг орчин цагийн европын янз байдал бүхий цэрэг болгох бодлого баримталжээ. Тэр их буу, хуягт танк, холбооны хороо болон нисэх, хуягт бригад зэрэг шинэ төрөл мэргэжлийн ангийг байгуулж морьт дивизүүдийг өргөтгэн байгуулснаар МАХЦ-ийн байлдааны хүч чадал улам нэмэгдсэн байна. Тэр техникийн цэргийн эзлэх хувийг нэмэгдүүлэхэд анхаарч уламжлалт морьт цэрэгтэй хосолсон механикжсан цэргийг бэхжүүлэх бодлого баримталж Техникжсэн морьт цэрэгт хэмээн шинэ төрлийг бий болгож энэ тухайгаа 1931 онд МАХЦ-ийн хөгжилтийг туйлийн их бус боловч техникийн боловсрол бүхий улаан цэрэгтэй болсон гэсэн бол 1934 онд Манай улаан цэргийн 60% нь техникжжээ хэмээн тодорхойлж байжээ.⁴² Энэ бол тухайн үедээ техникжсэн морьт цэргийн тогтолцоог бий болгон бэхжүүлсэн нь цэргийн сургалтын тогтолцоонд гарсан дэвшилтэд зүйл байсан бөгөөд Монгол ардын хувьсгалт цэргийн чадавхийг бэхжүүлэхэд ихээхэн хувь нэмрийг оруулсан болно.

"Цэргийн удирдах тушаалын дарга нарт цэргийн дээд боловсрол олгох зорилгоор 1932 онд Цэргийн ерөнхий сургуулийн дэргэд академийн түр сургуулийг байгуулжээ. Энэ сургуулийг хороо, дивиз, корпусын удирдлага, Цэргийн яам, жанжин штабын газар, хэлтсийн дарга зэрэг удирдах албан тушаалын олон зуун дарга нар суралцаж төгссөн. Г.Дэмид академийн энэ сургуулиар улаан цэргийн

байлдааны бэлтгэлд ихээхэн хувиралт, дэвшилтийг гаргаж чадах чадамгай боловсон хүчин төрж бэлтгэгдэж байна хэмээн өндөр үнэлж байв.⁴³ Академийн сургуулийг 1933-1937 онд 384 дарга нар б сарын хугацаагар суралцаж төгсчээ. Г.Дэмид цэргийн боловсон хүчиний зөвхөн дотооддоо бус ЗХУ-ын цэргийн академи, дунд сургуулиудад явуулж сургахад онцлон анхаарч байсан юм. Зөвхөн 1931-1934 онд ЗХУ-д цэргийн төрөл бүрийн мэргэжлээр 244 хүнийг явуулж суралцуулсан байх бөгөөд жилд дунджаар 50 орчим хүн төгсөн ирж байжээ.⁴⁴ Ийнхүү цэргийн дээд мэргэжилтэй боловсон хүчинийг бэлтгэхэд анхаарсан нь цэргийн боловсрол сургалтанд ихээхэн ач холбогдолтой зүйл болсон билээ.

Ийнхүү Г.Дэмид "Ардын хувьсгалын партизан явж, 1921 онд Алтанбулаг хотод МАХН-д гишүүнээр элсч, 1922-1923 онд нийслэл хүрээний цэргийн даргын сургуульд, 1926-1929 онд ЗХУ-ын Тверь хотын морин цэргийн сургуульд суралцаж цэргийн эрдэм, улс төрийн боловсрол эзэмшжээ. Г.Дэмид 1923-1926 онд их даргын сургуулийн морин цэргийн ангид курсийн дарга, сумангийн туслах, сумангийн дарга, 1929-1930 онд Цэргийн ерөнхий сургуулийн захираг бөгөөд комиссараар ажиллаж, Монгол ардын хувьсгалт цэргийн даргалах боловсон хүчинийг бэлтгэхэд хувь нэмрээ оруулсан байна. Г.Дэмид 1930 онд хуралдан МАХН-ын VIII их хуралд төлөөлгөөр оролцож тус хурлаас сонгогдсон Намын төв анхдугаар бүгд хурлаас МАХН-ын Төв хорооны тэргүүлэгч гишүүнээр сонгогджээ. Г.Дэмид 1930 онд Цэргийн зөвлөлийн тэргүүлэгч, Цэргийн Яамны сайд, Бүх цэргийн жанжнаар томилогдон ажиллаж байв"⁴⁵. Чухамхуу тэрбээр төр цэргийн салбартаа амь биеэ хайрлалгүй зориулахдаа цэргийн боловсрол сургалт, боловсон хүчинийг бэлтгэхэд үнэлж баршгүй хувь нэмрийг

⁴⁰ С.Ганболд Монгол улсын өрлөг жанжин Гэлэгдоржийн Дэмид.УБ.,2000. тал 31

⁴¹ Г.Дэмид. Илтгэл, өгүүлэл, хэлсэн үг.(1930-1937). УБ.,1991.тал 84

⁴² Г.Дэмид. Илтгэл, өгүүлэл, хэлсэн үг.(1930-1937). УБ.,1991.тал 52

⁴³ Г.Дэмид. Илтгэл, өгүүлэл, хэлсэн үг.(1930-1937). УБ.,1991.тал 101

⁴⁴ Б.Даваасүрэн. МАХН-аас цэргийн боловсон хүчин бэлтгэх талаар явуулсан бодлого үйл ажиллагаа (1921-1940).УБ.,1990.тал 49. С.Ганболд Монгол улсын өрлөг жанжин Гэлэгдоржийн Дэмид.УБ.,2000. тал 39



оруулсныг тэмдэглэх хэрэгтэй юм.

Энэ тухай түүний хамтран зүтгэгч Өлзийбат "Одоо нөхөр Дэмидийн удирдлагын дор Монгол ардын үндэсний хувьсгалт улаан цэрэг нь өөрийн улс төрийн ба байлдааны бэлтгэлийг сайжруулж техник зэвсгийн дадал мэргэжлийг олж сахилга журмыг чангатгаж өөрийн үндэсний шинэ хүчинийг түрүүлж байлдааны онц чадлыг зуваатгаж баймуй. Нөхөр Дэмидийн удирдлагын доор үндэсний хувьсгалт улаан цэргийн жагсаалын дотор ард түмний ашиг тусыг хамгаалагч хувьсгалч цэргүүд ба тус орны аж ахуй соёл байгуулалтын хэрэгт идэвхтэйгээр оролцогч нам засагт үнэнч шударгаар байлдагч нар төрөн гарч байна.⁴⁵ хэмээн бичжээ.

Энэ бүхнийг эцэст нь дүгнэхэд Г.Дэмид нь Монгол ардын хувьсгалт цэрэгт ардын хувьсгалын партизанаас эхлэн зүтгэж Бүх цэргийн жанжин хүртэл дэвшин ажиллахдаа Монголын цэргийн боловсрол сургалтанд ихээхэн хувь нэмрийг оруулжээ. Тухайлбал Г.Дэмид цэрэг ардыг сурган боловсруулахад өөрийн биеэр үлгэр болохын хамт сайн сургачг байжээ. Цэргийн ерөнхий сургуулийн захидал байхдаа цэргийн сургуулийн сурагчдыг сурган боловсруулах, цэргийн сургалт тогтолцоог бэхжүүлэхэд ихээхэн анхаарал тавьж байсан нь дээрх үйл хэргүүдээс тодорхой харагдаж байна.

Тэрбээр цэргийн эчнээ сургалтын арга хэлбэрийг амжилттай хэрэгжүүлж байжээ. Энэ нь тухайн үедээ хамгийн оновчтой сургалтын хэлбэр байсан нь маргаангүй юм. Г.Дэмид цэргийн албан хаагчдын бичиг үсгийн боловсролын тухайд анхааран ажиллаж бичиг үсэгт тайлгадагсын хувь хэмжээг 90 гаруй хувьд хүргэсэн байна. Тэрбээр Монгол улсын тусгаар тогтолцод МАХЦ-ийн үүргийг онцлон, улсыг батлан хамгаалахад цэргийн сургууль боловсролын үүрэг оролцоог чухалчлан үзэж дорвитой өөрчлөлтүүдийг хийжээ. Тухайлбал техникиксэн морьт цэргийн тогтолцоог бий болгон бэхжүүлсэн нь цэргийн сургалтын тогтолцоонд гарсан дэвшилтэд зүйл байсан бөгөөд Монгол ардын хувьсгалт цэргийн чадавхийг бэхжүүлэхэд ихээхэн хувь нэмрийг оруулсан болно.

Мөн дэмжлэгтэйгээр Цэргийн удирдах тушаалын дарга наарт цэргийн дээд боловсрол олгох зорилгоор 1932 онд Цэргийн ерөнхий сургуулийн дэргэд академийн түр сургуулийг байгуулжээ. Энэ нь цэргийн дээд мэргэжилтэй боловсон хүчинийг бэлтгэхэд анхаарсан нь цэргийн боловсрол сургалтанд ихээхэн ач холбогдолтой зүйл болсон байна. Ийнхүү Монгол улсын маршал Г.Дэмидийн цэргийн сургалтыг хөгжүүлэхэд гүйцэтгэсэн үүргийг үнелж баршгүй билээ.

Ашигласан материал:

1. БХТА.Ф1.Д1.ХН16
2. БХТА.Ф1.Д1.ХН178
3. БХТА.Ф5.Д1.ХН115
4. БХТА.Ф1.Д1.ХН183
5. МАХН-ын төв архив. Ф1.Д6.ХН21
6. Г.Дэмид. Илтгэл, өгүүлэл, хэлсэн үг.(1937-1930). УБ.,1991
7. Өлзийбат. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын улаан цэргийн улс төрийн сургуульд суралцах дэвтэр.УБ.,-23р он (1933)
8. Б.Даваасүрэн. МАХН-аас цэргийн боловсон хүчин бэлтгэх талаар явуулсан бодлого үйл ажиллагаа (1940-1921).УБ.,1990
9. С.Ганболд Монгол улсын өрлөг жанжин Гэлэгдоржийн Дэмид.УБ.,2000

⁴⁵ Г.Дэмид. Илтгэл, өгүүлэл, хэлсэн үг.(1930-1937). УБ.,1991.

⁴⁶ Өлзийбат. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын улаан цэргийн улс төрийн сургуульд суралцах дэвтэр. УБ.,23-р он (1933).тал 39-42



МОРЬТОН ДАЙЧНЫ ТУГ



Э.ЦЭГМЭД /ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн "Археологийн судалгааны төв"-ийн ЭША/

Монгол Улсын Шинжлэх Ухааны сургууль, Нийгмийн Ухааны сургууль төгссен. Археологич мэргжилтэй.

2015-2018 Улаанбаатарын Их сургууль, Түүхийн факультет. "Эртний нүүдэлчдийн урлагийн дурсгал үнэт зүйлс болох" сэдвээр магистарын зэрэг хамгаалсан.

2016 оноос эхлэн ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн "Археологийн судалгааны төв"-ийн эрдэм шинжилгээний туслах ажилтнаар ажиллаж байна.

Түлхүүр үг: Хадны зураг, символизм, морь, туг, сулд

Key words: Gare paintings, symbolizm, horse, flag, badge

Энэхүү өгүүлэлд, хадны зураг, морьтонгууд, тэдгээрийн дүрслэл, агуулгын талаар хөндөн оруулсан болно. Uriat тугийн тухай угсаатан зүйн болон археологи, сурвалжийн мэдээнд тулгуурлан нягтлан үзлээ. Хаттууртай далбаа барьсан морьтон дайнчиний сийлбэрт зураг Монгол ба төв Азийн нутагт Хүннүгийн үед үүсэн бий болсныг оршуулгын баримтаар мэдэж болох ба Түрэгийн үеийн хадны зурагт түгээмэл тархсан бодит-реалист аргаар урлан хийж гүйцэтгэж байжээ. Иймд хадны зурагт буй тугтай дайчин манай улсын түүхэнд онцгой байр суурь эзлэх нь дамжиггүй юм.

Тугийг ихэвчлэн овгийн шүтээн эсвэл цэрэг дайны явцад эв нэгдэл, хүндэтгэлийн журмаар хэрэглэх тохиолдол байдаг. Энэ нь нэг үндэстэн бүрэлдсэн түүх дэлхийн ихэнх ард түмний дунд байдаг нийтлэг нэгэн үйл явдал төдийгүй нэгдмэл нягтралын иш үзүүр болж байдаг онцлогтой. Хадны зурагт үзэгддэг тугтай дайчин Цагаан толгойн 18 дугаар зурагт, Баян-Өлгий аймгийн хар салаагийн голын хадны зурагт, Дунд хярын хонд хадны зурагт, Якут улсын Кураны хадны зураг, Ой-Жаяляя-ийн хавцлаас олдсон хадны зураг, Цагаан толгойн үзүүрийн 18 дугаар зураг, Кулжабасы хадны зураг, Дорж гуай 1972 онд хэвлүүлсэн Баян-Өлгийн

аймгийн Бугат сум Баян-Энгэрийн хадны зураг, Шышикны хадны зураг, Бичигтийн амны гэх мэт олон газруудаас одоог хүртэл илэрч олдсоор байгаа "тугтай дайчны" зургуудын талаар өгүүлж байгаа билээ.

Монголчууд дунд Халимаг, Буриад, Захчин, Урианхай зэрэг угсаатнуудын туг бүр нь ялгаатай, овог аймгийг төлөөлдөг Уриа, Ухайтай тухай угсаатан зүйн мэдээ бий. Энэ мэдээнээс үзвэл эдгээр угсаатнууд зах хязгаарыг сахин хамгаалдаг овог аймгууд болох нь сурвалжийн мэдээгээр баталгаажиж байна. Буриад овгийн уриа нь онгон шүтээнээ буулгах, туг сүлдээ тахих, хэнгэрэг дэлдэхэд, нэг овгийнхон ... эртний хүмүүсийн холбоо харилцаан нэгэн төрөл хэллэг, дохионы уламжлал гэлтэй¹. Тэгвэл тугтай дайчны зураг хадны зураглалд үлдсэн нь тугаа эрхэмлэн сүсэглэж, түүнийг ариун зүйлд тооцон дээдэлж байсан илрэл нь эдгээр дүрслэлүүдэд тусжээ. Туг бүрийг нэг овог аймгийн нутаг дэвсгэр юм гэж санаа дэвшүүлбэл 15 гаруй газарт өөрийн өөрийн характеристик / дүр төрхийг илэрхийлэх онцлог шинжтэй болохыг өгүүлж байна.

Д. Цэвээндорж, Оюу толгойгоос зүүн хойш Цагаан толгойн хийдийн баруун урд талд бургасны голын өргөн сайр уруу түрж орсон жижгэвтэр хошуу хадны Цагаан

¹ Бадамхатан С. Монголын угсаатан зүй. ШУА-ийн түүхийн хүрээлэн. Уб 1999.Боть I,II, III. 19т.



толгойн зураг гээд дээрх хавтгай хадны хойд талд бахим том бие, дөрвөлжин хоншоортой, урд бүдүүн хүзүү, нарийн урт сүүлтэй морь унан, урт модонд уянсан дөрвөн бүчтэй дөрвөлжин дарцаг барьсан хүнийг урласан² байна гэжээ. Энэ морьтны унасан морийг сайн ажиглавал соотон чихтэй, богиновтор хөлтэй, урт нарийн сүүлтэй, дөрвөлжин дүү урт биетэй юм. Биеийн байдлыг сайн ажиглавал магадгүй хуягласан байж болно³. Гэтэл цагаан толгойн үзүүрийн морьтой дайчин маань тугийн сүүл хэсгээс барьсан тугаа урагш чиглүүлэн давшингүй шинжийг зааж байна. (Зураг 1.) Холбоо морьтны зураг хадны зурагт дүрслэгдэх сонирхолтой тохиолдол болно. Тус хадны цогцолбор газар 28 тооны зохиомжид хадны зураг байлдагч мөөгөн хэлбэрт дуулга, сэлэм барьсан хүний дүрс, морь унаж тут барин давхиж буй хүний дүрсийг урнаар дүрсэл зэрэг үйл хөдлөл, бүхий сэтгэл хөдөлгөсөн баатарлаг шинжтэй байгааг үзвэл туг барьсан дайчны зураг гол онцлох сэдэв нь болж байна. Хүннүгээс түрэгийн үеийг 1000 гаруй жилийн хугацаанд соёлын өөрчлөлт, хувьсалд⁴ тэсрэлт болж, үүнийг дагаад зэр зэвсэг, тулаан арга барил овог аймгийг дайчид зэргийг сэргээж болохуйц баримтыг нэмэгдүүлж чадсан юм гэж үздэг боловч угтаа 500 жилийн дотор асар хурдацтай огцом эргэлт гарсан гэж хэлж болохоор байна. Учир нь ялалт гэдэг бол оршин тогтох буй дэглэмийг үүрд өөрчлөөд зогсохгүй ёс заншил, зан үйл, амьдралыг хэм маягийг өөрчлөн, шинэ соёлоор цус сэлбүүлж байдаг нэгэн супер хүчин юм.

Кадыктас ууланд дахь Ой-Жайлау-

ийн хавцлаас опдсон морь унасан дүрс бүхий хадны зургийг К.М.Байпаков, А.Н.Марьяшив нар 2004 онд илрүүлэн⁵ судалсан хадны зурагт хаттуур хэлбэрт далбаатай морьтон дайчинг сийлбэрлэжээ. Далбааны хэлбэр судлаачдын анхаарлын төвд бий гээд энэ чонын толгойг санагдуулан дундаж хэмжээ, харьцаатай, гурвалжин хошуу нь далбааны дүр төр юм гэжээ⁶. Түрэг-モンгол ард түмэн эрт үеэс чоныг өвөг дээдсийг сүлд гэж оршож ирсэн уламжлал тугийг орой дээр байсан байхыг угүйсгэж боломгүй юм. Кулжабасын хадны зургийг нэг онцлог нь хадны зурагт дайчин маань тугаа урагш чиглүүлэн барьж буй төрх харагдана. (Зураг 11.) Зургаас үзвэл бүх талбайгаар цохиж хийсэн ул мөр байх бөгөөд дайчны хөл хүртэл үзэгдэж болохуйц боловч морины эх бие хөл хоёрыг давхарлан сийлсэн аж. Өөдөөс нь нум сум агссан харваж буй хүн байх авч зарим судлаачид үүнийг сүүл үеийнх тул холбоогүй гэж маргадаг. Морьтны ар нуруу хэсгээс доошоо харсан гурвалжин дүрсээр илэрхийлж, морийг эх бие, хөлийг урт нарийхан дүрсэлжээ. НТӨ500-1200 жил холбогдуулан авч үздэг байна. Энэ зургийн зохиомжид буй далбаа Согдын далбаатай яагаад ч юм нэлэн төсөөлөг харагдахуйц ижил юм. (Зураг 14.)

Ц.Дорж 1972 оны өгүүлэлд: Баян-Өлгий аймгийн Бугат сум Баян-Энгэрийн хадны зураг⁷ гэж товч тодорхой тоймлоод орхисон нэгэн архивын баримт үлдээсэн байна. (Зураг 2.) Энэ зураг дээрх дайчин гэхээсээ илүүтэй туг барьсан хүний дурс хамгийн түрүүнд буух бөгөөд энэ хүн морь унасан тутгай зохиомж үзэгдэж

² Цэвээндорж Д. 2010. Ханбогдын хадны зураг. // ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн. Ред: Б. Цогтбаатар. // УБ 2010. 44 т. ISBN 978-99929-78-85-6.

³ Цэвээндорж Д. 2010. Ханбогдын хадны зураг. // ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн. Ред: Б. Цогтбаатар. // УБ 2010. 46 т. ISBN 978-99929-78-85-6.

⁴ Соёлын хувьсалд өөрчлөлт орсоныг мэдэж болох ба түүнийг дагаад зэр зэвсэг өөрчлөгдсөн гэж үзсэн нь оновчгүй санаа юм. Чжан со Хо зэрэг гадаад орны судлаачид материалист зөрчилдөөний онолыг урталь болгон авч үзэн таагүй хэрэг болжээ. Монголын 2008. Монголын Говь-алтайн хадны зураг. Солонгос зүүн хойд азийн түүхийн сан. МУШУА-ийн Археологийн хүрээлэн. Сөүл 2008. т 109.

⁵ Байпаков К. М., Марьяшив А. Н. Петроглифы в горах Кульжабасы. МОИИР казакстан институт археологии им. А.Х. Маргулан.: Алматы 2004. с 12. ISBN 9965-9459-9.

⁶ Байпаков К. М., Марьяшив А. Н. Петроглифы в горах Кульжабасы. МОИИР казакстан институт археологии им. А.Х. Маргулан.: Алматы 2004. С 25. ISBN 9965-9459-9.

⁷ Д. Дорж.Петроглифы Монголии. УБ. 1975. Часть I.



ажээ. Одоогийн байдлаар зургийн тайлбарт санаа оноо алга. Д.Доржийн авсан зурагт бүгд хөвөөлөн цохиж хийсэн болов уу гэмээр гэмтэлтэй цаас бий. Өөр нэг зурагт Бичигтийн хаданд буй нэг морьтон урагш чиглүүлсэн жадаа тэнгэр өөд тэмүүлэн барьсан байх аж.

2003 онд Монгол Алтайн зүүн биеэс эх аван урсан хар салаагийн голын эхнээс хүрэл зэвсгийн үед холбогдох хадны зургийн томоохон бүлэг дурсгалыг шинээр илрүүлэн олж бүртгэн авсны дотор манай орны нутгаас урьд өмнө олдож байгаагүй гартаа туг барьсан морьтон хүний зураг сүндэрлэн байжээ. Энэ зураг тус хадны зургийн цогцолборт хамаарагдах ба зүүн гартаа түүний цээжний харалдаа дугуй болцуутай сэрээ хэлбэртэй зэв бүхий сум дүрсэлсэн бөгөөд морины толгой бага зэрэг тонгойсон, цулбуураар нэгэн явган хүн хөтөлсөн зураг буй. Үүнийг судлаачид Сибирийн болон төв азын хадны зурагт ихэд өргөн дэлгэрсэн арга болохыг тэмдэглэжээ⁸. Хар салаагийн хадны зураг болбоос морь унасан дайчны далбааг мандуулсан байдалтай зүүн гартаа бамбай эсвэл хэнгэрэг дэлдсэн байхыг үгүйсгэхгүй юм. Гэсэн хэдий ч нэг гартаа бамбай, нөгөө гартаа хэнгэрэг мэт зүйлийг барьсан ба дайчин тэмцэгч чанарыг харуулахыг зэрэгцээ, бүсэндээ бороохой зэвсэг зүүсэн зайдан морьтой хүнийг дүрсэлж (Зураг 3), морины чих, толгойг ихэд гоёмсгоор үзүүлж морины сүүл, хөлийн туурай, сагагийг хүртэл оновчтой нарийвчлан гаргасан байна. Энэ хүний унасан морийг нэг гартаа бороохой барьсан явган хүн хөтөлж яваа байдлаас үзүүлсэн морь жолоодох үйл хэргээс чөлөөт ангид гэдгийг илтгэх төдийгүй эрх мэдэлтэй хүн тул морио хүнээр хөтлүүлсэн, зан үйлийн шинжийг давхар батална. Морь нь хүнийг жирийн

хүн биш, тухайн үеийн цэрэг байлдааны туг, дохио хэнгэрэг гэсэн гурван холбоост холбож өгсөн төдийгүй эрхэм хүндтэй, нэр төртэй үүрэг гүйцэтгэгч гэдгийг тодотгон харуулахын тулд зориуд гартаа бороохой мэт зэвсэг агсан явган хүнээр зам заалган төлөөлүүлэн харуулжээ.

Энэ зургийг хал салаагийн голын эхэн хэсэгт баруун тийш харсан хавтгай хаданд бүх талбайгаар нь хонхойлгон цохиж монгол ба төв азын нутагт хүрэл зэвсгийн үед түгээмэл тархсан бодит аргаар урлаж⁹, их хэнгэрэг дэлдэж сурийг бадраах зорилготой эвсэл бөө тэнгэр шүтээн лүгээ дуудах зан үйлийн шинжтэй, овог аймгийн хамгийн хүндтэй хүнийг сийлэн үлдээсэн бодит дүрслэл, туг сүлдийг эгц дээш нь залж, мандуулах ёсполын шинжийг агуулсан зураг байж болно. Гэвч судлаачид түрэгийн үеийн хадны зураг олныг хамарсан ан ав, баатарлаг тулаан, дайчин эрийн алдар гавьяаг мөнхлөн дурсгах ялалтын бэлгэдэлтэй¹⁰ холбогдог байжээ гэх санааг энд оруулах зэв юм.

2000 онд Баянхонгор аймгийн Баянлиг сумын нутаг бичигтийн амны олон зурагтай хаднаас зүүн тийш 1 км зайд ловон нуурын хаданд нэгэн хавтгай хаднаас (Зураг 5.) Монголын эртний тугийн сэжүүр сонин содон дурсгалыг нээн олж судалжээ¹¹. Морь нь босоо чихтэй, уртлаг биетэй, гоёмсог толгойтой, шавхнуун гэдэстэй, өтгөн сүүлтэй, урт хөлтэй, хүн урт нарийхан хүзүүтэй, өвөрмөц хэлбэрийн малгайтай, уужуу сугатай, өргөн хормойтой дээл өмссөн хоёр гартаа хоёр тийш ялимгүй өргөж дэлсэн, нэг гартаа туг барьж нөгөө гарaa ар тийш сунгаж хоёр хөл морины хэвлий доор унжиж буйгаар дүрсэлжээ. Морины дэлийг зэрэгцээ олон богино, нарийн зураасаар морины сүүлийн хялгасыг мөн урт, нарийн зураасаар, хазаар жолоо цулбуур, морины эрүүнээс

⁸ Еврей, түрэг, монгол судлаач. Худяков С. Ю. Образ воина в наскальном искусстве южной сибири и централь-азии. Новосибирск 1986. 187-190 с.

⁹ Д.Цэвээндорж 2014. 380-389 т.

¹⁰ Батболд Н. / Монголын говийн бусийн хадны зургийн судалгаа / ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн. Ред: Д. Цэвээндорж. УБ 2014. т 114.

¹¹ Д.Цэвээндорж 2008.



унжсан унжлага мөн нарийн зураасаар үйлдجээ¹². Говь-алтай аймгийн Баян-ул сумын дунд хондын хадны зурагт тугаа эгц дээш мандуулан барьсан хүн байх ба араас сэлгээ морьтой байж болмоор шиг. Уг зургийг хүнийг хөтөлгөө морь тусгасан гэж судлаачид үздэг. Хэрэв хөтөлгөө морьтой¹³ ач хөсгөө тодорхой зайд авч явдаг гэвэл алслалтын зарчмаар зурагдсан хөтөлгөө морьтой хүн тусгай алба гүйцэтгэх үүрэгтэй гэх санаа урган гарч ирэх юм. Ийм боломж буй эсэхийг түүхийн баримтаас нягтлан харах хэрэгтэй болов уу.

Горно-Алтай муж улс Елангеш-ийн хадны зураг гэж онцгой сайхан зураг бий. Харвалдаж буй морьтон хүний зурагт¹⁴ өөдсөө харваж байдлаар эрт дунд үеийн хадны зургийг хонхойлон цоолборлох арга болон графикийн буюу зураасан урлагтай хослуулах техникээр хийгджээ. Хүннүгийн үеийн зураасан урлаг нэлэнх хөгжих байсан гэдгийг бид мэдэх билээ. Тэгвэл түрэгт энэ урлаг байсан гэвэл их содон тохиолдол болж байгаа юм. Хүннүгийн үеийн оршуулгын далбаа¹⁵ гэж нэрлэгдэг гурвалжин, хараацай хэлбэрийн олон далбаа ноён уулын б-р булшнаас гарсан далбаа гурвалжин дуу, З салаа эсвэл 2 салаатай туг байна.(Зураг 8)

Харьцуулж харвал: Морины дэл З ширхэг өтгөн дэл үзэгдэх Говь-Алтай аймгийн Баян-Уулын зурагтай ижил төсөөтэй, толгой нарийхан, хүзүү урт ба дайчны маань өөдөөс нум сумтай хүн зэргээр өөр боловч, дайн байлдааны дүрсэлсэн өгүүлэмжтэйгээ ижил, морь уруу харан зогссон байгаа мэт дээрээс

уруу чиглэсэн биеийн төрхөөр эрс өөр, чиглэл харагдах төдийгүй дайчны хуяг дуулга өмсөн, дуулганы залаа(хөхөл?), тут хүртэл харагдахуйц дээр ижил байгаа зэрэг нь сонирхол татаж байна.

Эрхүү мужийн Хачуга тойргийн ойролцоо Лена мөрний адагт дахь нэгэн зургийг нэрт эрдэмтэн монгол судлаач Окладников судалж Курьканы хадны зураг гэж нэрлэжээ¹⁶. Уг хадны зураг Енисей киргизын язгууртан овог болон курькан нарын үлдээсэн дурсгал мөн гэж үзсэн ба далбааны хэлбэр байдал З салаа гурвалжин хэлбэрт байгаа нь тооны хувьд ямар ач холбогдолтой зэрэг талаар бичээгүй байна. Цэргийн нэр хүнд гэдэг төрийн далбааг эрхэмлэх үүртэй ч эртний нийгэмд далбаа (Зураг 6)-г тайлбарлахад "дэлхий дээрх амьдрал болон дараа төрөл хооронд холбогч өвөг дээдсийн сүр сүлд юм"¹⁷ гэж үзжээ. Цыбикдоржиев цааш нь Сүлд гэдэг нь Монголчуудын хувьд өргөн утгаараа хүний сүнсийг нөгөө ертөнцөд хүргэж өгөх холбоос гэж тайлбарласан байна. Гэвч үнэн чанартай сүлд гэдэг нь хүний шашны харизаматик-удирдагч шинжтэй төдийгүй дээдлэн хүндлүүштэй тангараг юм. **Эх орон** гэдэг овог аймагтай үнэнч байх түүнийг өмнө хүлээсэн үүргээ нэртэй биелүүлхээс эхлэж байсан бололтой.

Үүнтэй ижил зураг Хакасын нутагт олдсон ленна далбаа буюу шышкины гэж Окладников нэрлэж, тугийг цэргийн зориулалтаар хэрэглэх болсны гэрч баримт хятад сурвалжид бий гээд муу ёрын сүнсийг зайлцуулах бөө нарын хэрэглэлээс үсжээ хэмээн тайлбарлажээ¹⁸.

¹² Монголын 2008. Монголын Говь-Алтайн хадны зураг. Солонгос зүүн хойд азиин түүхийн сан. МУШУА-ийн Археологийн хүрээлэн. Сэул 2008.

¹³ Батболд Н. /Монголын говийн бусийн хадны зургийн судалгаа/ ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн. Ред: Д. Цэвээндорж. УБ 2014. т 114.

¹⁴ Черемисин Д. В. Несколько наблюдений над граффити горного алтая. / Древнее искусство в заркале археологии. К 70-летию Д.Г. Савинова. – Кемерово 2011. Вып VII. с 155. ISBN 5-202-00402-8.

¹⁵ Эрмитаж дахь Ноён уулын эрдэнэс. ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн. Хамтын бүтээл. Ред: С. Чулуун. УБ 2018.

¹⁶ Окладников А.П. Шишклинские писаницы. Памятник древней культуры Прибайкалья. Иркутск 1959. – Дашибалов Б. 1995. Археологические памятники курькан и хори (к всемирному археологическому). с 151.

¹⁷ Монгол судлаач, буриад эртний түүхээр дагнан бичдэг. Ахай-шулуун буюу шишканий хадны зургийн талаар хэдэн уг. Цыбикдоржиев Д. В. 2008. Генезист культа знамени у монгольских народов. Древние и средневековый кочевники центральной азии. Барнаул 2008.



(Зураг 9.) Байгал Сибирийн эртний хадны зурагт дээрх жишээтэй адил зураг бий. Үүнийг бол минусийн хадны зурагт буй харваж буй тутгтай морьтон дайчин юм¹⁹. (Зураг Зураг 7г.) Дайчдын далбаа түүний морьд зогсож буй мэт дүрслэл зэрэг нь агуулгын хувьд баяжмал юм. Морины нэг хөл нь зурагдаагүй эсвэл морьд жолоодож амын татаж буй зэрэг юм. Эдгээр морьтын далбаа тугийн унжлага, З салаат зэрэг бидний мэдэх хэлбэртэй, морь унасан морьтон хуягтай, хуяггүй гэсэн маргалдаан буй ч дуулга өмссөн гэж тооцогдох морьтон Шишконо, Куриканы хадны зургууд²⁰ манайхаас эрс ялгаатай байна. (Зураг 7а, 7б, 7в. Шишконо, манхай) Дуулга өмссөн арагш унжуулах хөхөл буюу залаа ижилхэн байна. Шиконгийн хадны зурагт тэмээ жингийн тухай байдаг. Гэвч энэ удаад зөвхөн морьтой дайчны зургийг онцгойлон авч үзлээ.

Тамгалын Зүүн гарын хотгорт орших хадны зурагт Морьтой дайчны дүр бий. (Зураг 10). Тамгалын хэмээх газар нь Кульжабасы, Цагаан толгой, Хар салаангийн зурагтай ижил хөдөлгөөн гүймэл зургуудаад дүүрэн юм. Тамгалын IV-цогцолбор газарт уг дурсгал оршин байна²¹. Тамгалын 200 орчим зурагтай бол Цагаан толгой 300 орчим, Хар салаа 250 орчим гүймэл хөдөлгөөнт дүрсэл байна. Тамгалы хоёр тутгтай дайчинг нэгэн доор оруулжээ.

Жадыг олон угсаатан үндэстэн дайнд, хамгаалалтын болон ан агнуурын, сүсэг бишрэлийн гэх мэтээр олон төрлийн

зорилгоор эрхэмлэн сүслэж байжээ. Монголын нууц товчоонд жад гэж харь уг²² дурдах бөгөөд голцуу урианхай аймгийг гажуудуулан түүх бичлэг эсвэл сурвалжийн төөрөгдөл болжээ. Жад хэмээх аймаг нь язгуурын монгол аймаг эсвэл төрөл бололтой. Жад хэрэглэж байсан үеэс далбаа уруу хэдий үед шилжин орсон бэ? гэсэн асуулт хөндөгдөөгүй шахам тас хөлдүү сэдэв байсаар байна. Туг сүлдийн буюу сүлдэд тэнгэр ба сүлд одыг тахидаг овоог сүлд овоог гэнэ. Сүлд овоог хамгийн өндөр газар болгоно²³ хэмээнээс үзвэл лавтайяа 13 зуунаас өмнө байсан болж таарах гээд байна. Хадны зурагт буй туг барьсан дайчны дүрийг бүгд зүүн зүг тал уруу цохиж үйлдсэн байх ба З хадны зурагт баруун тал уруу харуулан дүрсэлсэн байдаг. Үүнтэй нэгэн ижил зан үйл түрэгийн тахилын байгууламжид байдгийг манай ахмад үеийн эрдэмтэн Д.Баяр өгүүлэхдээ: Хүн чулуун хашлагын зүүн хананаас 90см зйттай нүүрээр азимутын 71°-т чиглэх анхны байрлал байна. Үүний өмнө азимутын 74°-ийн чиглэлд байрлал чулуунууд бий²⁴ гэж бичсэн байдаг нь ертөнцийн зүг чигийн талаар нэлээд сонин төсөөлөл өгч байна. Мөн хүрээлэн буй орчны байдал хадны зүг чигийг үзвэл "Тамгалы" өмнө зүг уруу, Елангиш хойд зүг уруу чиглэлтэй бүтээгдсэн болох нь одоо нэгэнт ил болжээ.

Далбаат туг 1-3 салаа унжлагатай байдал Богд хаант Монгол улсын үеийн З салаатай тун ижил түүхэн уламжлал гэлтэй. (Зураг 15). Угсаатныг өртөө зангидан

¹⁸ Якутын төрийн далбаа. Тэрээр хори түмдийн овог аймгуудтай холбон тайлбарлаж байна. Хэрэв хорь түмэдийн овог аймгуудтай холбоотой гэж үзвэл Монгол овгууд шууд хамааралтай болж таарж байна. Ушницикий В. В. Наскальное изображение всадника со знаменем в качестве государственного герба республики саха (Якутия). Наскальное искусство в современном обществе. Кемерово 2011. С 185, 207. ISBN 978-5-202-01025-5.

¹⁹ Зураг Сулем Улук-Куртуяк. Худяков С. Ю. Образ воина в наскальном искусстве южной сибири и центральной азии. Новосибирск 1986. 187-190 с.

²⁰ Курикан овог аймгуудын үлдээсэн дурсгал тул Куриканы хадны зураг гэж нэрлэгджээ. Уг аймаг нь Капчак, хорь түмэд, тува, дархад, якут зэрэг овог аймгуудыг холбоо байсан бололтой. Окладников А.П. Шишкинские писаницы. Памятник древней культуры Прибайкалья. Иркутск 1959. – Дашибалов Б. 1995. Археологические памятники курикан и хори (к всемирному археологическому). с 151.

²¹ Рогожинский А.Е., Аубекеров Б.Ж., Сала, Р. Памятника казакстан. Памятника накального искусства Центральный азии. Алматы 2014. Каталоги. С45-47

²² Цэрэнсодном, Бира Ш. 2005. Монголын нууц товчоо эхлэл булэг. 40- тал.

²³ Даваацэрэн Д. / Туг сүлдийн гарал үүсэл ба төрөл. / Буурал богд сүлдийн тахилга. УБ 2010. т 63.

²⁴ Баяр Д., Бихумар К. нар 1992. Өвөрхангай аймгийн нутагт буй түрэгийн үеийн хүн хөшөөний тухай // Studia archaeologica. Tom XII. Fac 4. УБ 1992., т 29-52.



барьдаг хамаарал буюу адеинтит дайн байлдаан болон цаг уурын өөрчлөлтийг тэсэн гарч ёс заншлын өөрчлөх, залуурдах динамик хүчин зүйлийг өөртөө тээдэг. Энэ нь шинээр олон овог аймгуудыг төлөвшүүлэх, туг сүлдээ залгамжлуулах үлдээх онцгой үүрэгтэй билээ. Цагаан голын толгойн хадны зураг, хар салаагийн хадны зураг, Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын хадны зураг, дунд хярын хадны зураг, куриканы хадны зургууд зурагт үзүүлснээр бүгд зүүн тар уруугаа харуулах ба дээрх жишээнээс цөөн тохиолдолд баруун тал уруугаа харуулан бодит байдлаар урлан бүтээсэн бах нь харагдана. Тугаа эгц өөд нь мандуулсан тохиолдол хар салаагийн зураг, дунд хярын хадны зураг, бүгд ижилхэн байх нь үүнд ганц тайлбар оногдох болно. Тухайн овог аймаг ялалтыг тэмдэглэж эзэн шутээн хаднаа сийлэн үлдээжээ. Учир эдүгээгийн ихэнх орон тугаа мандуулах ёслол, хүндэтгэлийн өдөртэй түүнийг илэрхийлэх дэг жаягтай адил нь нөгөөх бөө мөргөлийн үлдэц, түүний хувирал хөгжил юм. Тугаа урагш чиглүүлсэн тохиолдол цагаан толгойн зураг Елангаш, Кулжабас, Ленна далбаа байна. Урагш чиглүүлэх нь давшиж буй дохио болно.

Ар байгальн нутагт НТ II мянган жилийн эхнээс морины ба морьт оршуулга үлдээгчид нутаглах болсон нь эрдэмтдийн дунд бас нэгэн маргаан дагуулах болжээ. Ихэнх судлаачдын үзэж буйгаар өмнөх крыканчуудад эл уламжлал байхгүй учраас орон нутгийн бус ирмэл нүүдэлчидтэй холбон тайлбарладаг²⁵. Усть-талкины соёл ангар, куда, лена мөрий голын сав нутгаар тархсан байдаг судлаачид тэдний монгол хэлтэн, ойн монголчууд, түрэгүүд гэх зэрэг маргалдаар иржээ.

Гэсэн хэдий ч морийг бүхлээр

дагалдуулан оршуулах эсвэл хэсэглэн буюу адууны аль нэг хэсчлэн дагалдуулан оршуулах гэсэн хоёр төрөл байдаг. Адууг бүхлээр нь дагалдуулах заншил зөвхөн төв азийн хэв шинжид ордог. Харин хэсчлэн дагалдуулах хэв шинж өрнийн хэв шинжид орно. Үүнийг нэг жишээ нь Хүннүгийн морьтой оршуулга юм. Салхитын амны 19-р булшинд морь дагуулсан булшын хэлбэр байгаа нь сонирхол татаж байна²⁶. 1990 онд Говь-Алтай аймгийн Алтай хотын дүүрэгт малтсан нэгэн булшинаас Түрэг (VI-VIII зууны) үеийн булшинд хүний толгойг баруун урагш чиглүүлэн нуруугаар нь хэвтүүлж, баруун талд нь толгойг нь зүүн хойд зүг хандуулан тавьсан бүтэн адту дагалдуулж²⁷ байжээ. Үүнтэй ижил олдворыг зураг Киданчуудын уран зураг зурагт тусгагдсан байдаг (зураг 15.) бол Кубарев 2005 онд олдсон ба VI-VIII зууны үед одоогийн хакасын нутаг худалдаа арилжаа ихэд хөгжсөн дундад азиас Согдууд ихээр ирдэг байсантай холбон соёлын холбоо бий гээд тэдний сууршилтай хамааруулан үзэн тайлбарлаж байв²⁸. (Зураг 13) 2011 онд Увс аймгийн Бөхмөрөнд малтсан Шанагын морьтой оршуулга НТ VIII зуун гэж гарсан²⁹ ба асарга бүс, саадаг сүм, оршуугын хэв шинж зэрэг нь алтай хотод малтсан оршуулгатай бараг ижил байна.

Монгол угсаатан үүсэн бие болохыг өмнө Морьтой оршуулгын талаар одоо болтол бүрэн шийдгүй байгаа билээ. (Ялангуяа хэзээ Монгол хэл аймгууд нэвтэрсэн тухай). Эрт үеэс соёлын талаар холбоо сүлбээ байгаа нотлон харуулсан нь чухал амжилт болох юм. Байгал нуурын савд Хори, буриад, урианхай, киргиз, монгол зэрэг олон аймаг холилдон сүлэгдэж байсан энэ үеийг нарийвчлан зааглан үзэх хэрэгтэй байна.

²⁵ Өлзийбаяр С. Монголь морьт оршуулгын нэгэн хэлбэр. // Journal of archaeology, history and humanitarian. Vol. 12(11). УБ 2016. 51-56 т.

²⁶ Өлзийбаяр С. 2016 Хүннүгийн морьтой оршуулгын хэлбэр. Древние культуры Монголии, Байгальской сибирий и северного китая. 117с.

²⁷ Наваан Д. Ховд аймагт явуулсан археологийн судалгаа. УБ 2018. т 9.

²⁸ Кубарев Г.В. Культура древних тюрок Алтай. (по материалам погребальных памятников) // Новосибирск: 2005. 400 с. ISBN 5-7803-0145-X.

²⁹ Ц.Төрбат. Шанагын морьтой оршуулга. Антоон монстаэрт төв. Оюуны хэлхээ. УБ. Т 69.



ДҮГНЭЛТ

Манай судалгаанд түүх, археологи, угсаатан судалгааг хадны зурагтай харьцуулан үзсэнээс гадна Монгол болон бусад орон нутгийн мэдээнд тулгуурлан он цагийн тогтоож чадсан юм.

Туттай дайчны зураг Монголоос нэлээн олдсон байх боловч туг барьсан морьтон дайчны зураг цөөн юм. Харьцуулсан судалгааны үр дүнд хадан дээр сийлэгдсэн морьтой, морь унасан туттай дайчид НТ 200 оны үед холбогдохоор байна. Өөрөөр хэлбэл Енисейн киргикийн үеийн хадны зураг, Усуны үеийн хадны зураг, мөн монголоос олдсон хүрэл төмрийн түрүү үеийн хадны зурагтай харьцуулсан үндсэн үр дүнгээс үзвэл Түрүү Түрэгийн улсын үед сонгодог хэлбэртээ орсон болов уу. Энэ үе НТ 200-НТ 500 гэх он цаг гарч ирж байна. Эдгээр зураг нь түүхэн шинжтэй зураг юм. Ийм төрлийн зураг хадны зургийн хөгжлийн төсгөл үед үзэгдэг байна. Түүхэнд хүнд эсвэл түүхэн үйл явдалд зориулан босгосон зураг гэдгээрээ ач холбогтой юм. Хараацайн сүүлийг санагдуулам салаа далбааг дэлхийн олон орон "cavalry guidons" цэргийн туг гэдэг байна. Просопографит зургийг гэдэг даамжиггүй юм. Өөрөөр хэлбэл судлаачдын хэлдэг угсаатны өмнөх үе буюу Шишкины хадны зураг НТ 1200 он Усуны буюу Тамгалы НТ 500-1200 гэсэн он цагаас үзвэл энэ зураг НТ 500 онд

гэсэн баталгаатай он цаг гарч ирж байна.

Хүннүгийн булшнаас гарсан "cavalry guidons" - хэлбэрийн хараацайн сүүлт тугийн Богд хаант Монгол Улсын үеийн Зцацлага зэрэг нь утгаа нэг угшилтай байж болно.

Тугаа эгц өөд, урагш урагш чиглүүлсэн гэсэн хоёр төрөл буйг илрүүлэв. Жад хэрэглэх явдал дэлхийн олон оронд байсан ч нүүдэлчин ард түмний хувьд зовлон, жаргалaa морьтойгоо холбодог. Иймд туг гэдэг морь хоёр хамт байна гэдэг агуулгын хувьд өндөр ач холбогдолтой юм. Цэрэг эрсийн сур хүчийг илэрхийлэх нэгэн баримт бол туттай дайчин. Дайн байлдааны үйл явцад бус нутагт түрэг угсаатан овог аймгийн соёлын ололт талт ижил хэлбэржин бэхжиж байсан байна. Түрэгийн үеийн морьтой оршуулга тухайн үеийн нөхцөл байдлыг тодруулахад ихэд дөхөм болж өгч байна. Судалгаагаар "сонгодог морьтой" оршуулгын соёл түрэгийн үед хэлбэржин бий болжээ. манлай цэргийн статус зураг хадны зурагнаа мөнхрөн үлдсэнээр давхар баталж байна.

Хүннүгээс Түрэг-ээс Монгол хүртэл урт удаан хугацааны түүхийн жимд улс төр цэрэг армийн холбоо, шүтлэг бишрэл, бөө мөргөлийн шалтгаантай тугийг тахих, түүнийг сүнктэй хэмээн хүндэтгэлийн уламжлал байна. Иймд Түрэг гэдэг утгаа Түрэгжэн монгол аймаг бололтой.




Ашигласан материал:

1. Баяр Д., Бихумар К. нар 1992. Өвөрхангай аймгийн нутагт буй түрэгийн үеийн хүн хөшөөний тухай // *Studia archaeologica*. Том XII. Fac 4. УБ 1992., т 52-29.
2. Бадамхатан С. Монголын угсаатан зүй. ШУА-ийн түүхийн хүрээлэн. УБ 1999. Боть III. т 19.
3. Байпаков К. М., Марьяшив А. Н. Петроглифы в горах Кульжабасы. МОИНР казакстан институт археологи им. А.Х. Маргулан.: Алматы 2004. с 25. ISBN 9-9459-9965.
4. Батболд Н. / Монголын говийн бүсийн хадны зургийн судалгаа / ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн. Ред: Д. Цэвээндорж. УБ 2014. т 114.
5. Даваацэрэн Д. / Туг сүлдийн гарал үүсэл ба төрөл. / Буурал бодг сүлдийн тахилга. УБ 2010. т 63.
6. Ушницкий В. В. Наскальное изображение всадника со знаменем в качестве государственного герба республики саха (Якутия). Наскальное искусство в современном обществе. Кемерово 2011. с 207. ISBN 5-01025-202-5-978.
7. Кубарев Г.В. Культура древних тюрок Алтай. (по материалам погребальных памятников) // Новосибирск: 400 .2005 с. ISBN -0145-7803-5X.
8. Өлзийбаяр С. Монголь морьт оршуулгын нэгэн хэлбэр. // *Journal of archaeology, history and humanitarian*. Vol. 11(12). УБ 56-51 .2016 т.
9. Өлзийбаяр С. 2016 Хүннүгийн морьтой оршуулгын хэлбэр. Древние культуры Монголии, Байгальской сибирий и северного китая. 117с.
10. Черемисин Д. В. Несколько наблюдений над граффити горного алтая. / Древнее искусство в заркале археологии. К -70летию Д.Г. Савинова. – Кемерово 2011. Вып VII. с 155. ISBN 8-00402-202-5.
11. Наваан Д. Ховд аймагт явуулсан археологийн судалгаа. УБ 2018. т 9.
12. Монголын 2008. Монголын Говь-алтайн хадны зураг. Солонгос зүүн хойд азийн түүхийн сан. МУШУА-ийн Археологийн хүрээлэн. Сеул 2008. т 109.
13. Окладников А.П. Шишкинские писаницы. Памятник древней культуры Прибайкалья. Иркутск 1959. – Дашибалов Б. 1995. Археологические памятники курыкан и хори (к всемирному археологическому). с 151.
14. Худяков С. Ю. Образ воина в наскальном искусстве южной сибири и централь-ази. Новосибирск 190-187 .1986 с.
15. Цэвээндорж Д. 2009. Монголчуудын өвөг дээдсийн далбаа. / Монголын археологийн судалгаа. УБ 143 .2009 т.
16. Цэвээндорж Д. 2010. Ханбогдын хадны зураг. // ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн. Ред: Б. Цогтбаатар. // УБ 2010. т 44,46. ISBN 6-85-78-99929-978.
17. Цыбикдоржиев Д. В. 2008. Генезист культа знамени у монгольских народов. Древние и средневековый кочевники центральной азии. Барнаул 2008.



ХАВСРАЛТ ГЭРЭЛ ЗУРАГ



Зураг 1. Д. Цэвээндорж., 2010. Цаган толгой хадны зураг.

Зураг 2. Д.Дорж., 1975.

Зураг 3. Баян-Өлгий аймгийн Цэнгэл сум.

Зураг 4. Дунд хярын Хондын хадны зураг. Миний оруулснаар.

Зураг 5. Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын нутагт дахь хадны зураг.

Зураг 6. А.П.Окладников., 1955. Якут. Курыйканы хадны зураг.


Зураг 7. Ю.С.Худяков. Байгал-Сибирийн хадны зураг.

Зураг 8. Д.В.Черемисин., 2011 Горно-Алтай. Елангаша.

Зураг 9. В.В. Ушницкий., 2011. Шишкины хадны зураг.

Зураг 10. А.Е. Рогожинский., 2002. Тамгалы (Чу-Илийские горы). Тамгалы Цогцолбор газар. Өнгөт.


Казакстан Зүүн гарын хотгор.




Зураг 11. Кулжабасы З. Древнетюрский период.
500-1200 гг.н.э
R. Sala:2011
Зүүн гарын хотгор.




Зураг 26. Д.Дорж 1972 он. Бичигтийн хадны зурагт оруулсан байдлаар




Зураг 12. А. Хүннүгийн түг. Ноён уулын 6-р буулшинаас гарсан оршуулгын түг. Елихина:2012.



Зураг 12. Б. Хүннүгийн түг. Ноён уулын 6-р буулшинаас гарсан оршуулгын түг. Елихина:2012.



Зураг 15. Богдаант Монгол ард улсын түг.
[https://mn.wikipedia.org/wiki/
Olnoo_өргөгдсөн_Монгол_улс#/media/File:Flag_of_Bogd_Khaanate_Mongolia.svg](https://mn.wikipedia.org/wiki/Olnoo_ergegdsen_Mongol_uls#/media/File:Flag_of_Bogd_Khaanate_Mongolia.svg)



Оросын түүх судлаач, зураач М.В.Горилекийн бүтээл дэхь Зүүнгар-Ойрадын түг далбаа.



Зураг 13. Нэхэн сэргээсэн зураг. Д. В. Позднякова. Эртний түрэг. Кубарев 2005. Балык-Соока.



Зураг 9. Д.В. Цыбикдоржиевийн
Нэхэн сэргээсэн зураг.



Зураг 14 . Рустемамида ханын зураг.
Тажикстан улсаа с олдсон ханын зурагийн VII-ээсгг. Танхим 41. Согдуудын үлдээсэн зураг.
Эртний педжикент хотоос олдсон. Эрмитажийн музейд хадгалагдаж буй. Цаг үе: V-р зуун.
Буддын шашны эрин үе. Өндөр 92-105 см.
http://hermitage--www.hermitagemuseum.org/wps/wcm/connect/c5f24ba2-a16d-457a-bf3d-9cec746267fb/WOA_IMAGE_1.jpg?MOD=AJPERES&CACHEID=d68a7e52-061d-47b6-8865-8e47fde040a5



Кидан династын үеийн зураг 15а.



Кидан династын үеийн зураг 15б.
"Eighteen Songs of a Nomad Flute: The Story of Lady Wen-chi. A Fourteenth" хавтасны зураг.
НТӨ 1113